

БЭСТСЭЛЛЭР ЗОХИОЛЧ

ЖОН БИВЭР

Бурханд ОИРТ

Бурхантай дотно амьдрахуй



Хүндэт найз минь,

Библи нь бидний амьдралыг өөрчлөх хүчин чадалтай, сүр жавхлантай үнэн амлалтаар дүүрэн ном боловч, Бурхан таныг дотно таньж мэдэхийг улайран хүсдэг нь магадгүй хамгийн гайхамшигтай нэгэн амлалт нь байх.

Иаков ном дээр "Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно" (Иаков 4:8) гэдэг хамгийн аугаа урилга бий. Түр зогсоод ертөнц, дэлхийг оршин суугчидтай нь бүтээсэн Бурхан таныг дэргэдээ байлгахыг хүсдэг гээд бод доо. Дэргэдээ байлгахаар барахгүй, дотно байхыг хүснэ. Учир нь Бурхан тантай харилцаатай байхыг хүсэмжилдэг гэдэг.

Ертөнцийн Бүтээгч бидэнд Өөрийг нь алс холоос зан үйл, үгээрээ хүндэтгэх бус, харин та Бурханы зүрхийг мэддэг, Бурхан таны зүрхийг мэддэг, утга төгөлдөр, дотно харилцаатай байх урилга өгчээ.

Найз минь, би таныг энэ урилгыг хүлээн аваад, Бурхан Аавтай дотносож, зүрх рүү нь ойртох гайхамшигтай сайхан аялалд гарахыг уриалж байна.

Христийн доторх




MessengerX

Жон Бивэр ахаас чинь
JohnBevere@ymail.com

 **Messenger**
INTERNATIONAL

Бурханд ойрт

Бурхантай дотно амьдрахуй



ЖОН БИВЭР

Drawing Near, (Mongolian), by John P. Bevere
© 2022 Messenger International
MessengerInternational.org
Originally published in English as Drawing Near
ISBN 978-1-599-51009-5

Additional resources in Mongolian are available for free download and video streaming at MessengerX.com and on the MessengerX app

To contact the author : JohnBevere@ymail.com

This book is a gift from Messenger International and is NOT FOR SALE

Printed in Mongolia

Бурханд ойрт: Бурхантай дотно амьдрахуй, Жон Бивэр
© 2022 Мессенжер Интернэйшнэл
MessengerInternational.org

Номын англи нэр: Drawing Near
ISBN 978-1-599-51009-5

Монгол хэл дээрх бусад хэрэгтэй материалаа
MessengerX.com and on the MessengerX app -аас
шууд үзэх эсвэл утсандаа татаж авах боломжтой.

Зохиогчтой холбогдох имэйл: JohnBevere@ymail.com
Энэхүү ном нь Мессенжер Интернэйшнэл байгууллагаас Монголчууддаа өгч буй бэлэг.
ХУДАЛДАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.

Монгол улсад хэвлэв



App Store бол Apple ХХК-ийн АНУ болон олон улсад бүртгэлтэй худалдааны тэмдэг.

Google Play болон Google Play лого нь Google ХХК-ийн худалдааны тэмдэг.

АГУУЛГА



<i>Танилцуулга</i>	7
<i>Бүлэг 1: Хамгийн аугаа түүхэн урилга</i>	11
<i>Бүлэг 2: Бурханы нэхэл</i>	21
<i>Бүлэг 3: Бурханаар цангаж яв</i>	35
<i>Бүлэг 4: Бурханы оршихуйг улайран хүсэх</i>	49
<i>Бүлэг 5: Хөшигний цаана</i>	61
<i>Бүлэг 6: Бурханы анд нөхөр</i>	75
<i>Бүлэг 7: Жинхэнэ дотнослын садаа</i>	95
<i>Бүлэг 8: Жинхэнэ хүндэтгэл</i>	117
<i>Бүлэг 9: Бурханы оршдог хүн</i>	131
<i>Бүлэг 10: Ариун Сүнстэй дотносох</i>	143
<i>Бүлэг 11: Аавын амлалт</i>	163
<i>Бүлэг 12: Дотнослын хэл</i>	187
<i>Бүлэг 13: Итгэлийн бүрэн баталгаа</i>	209
<i>Бүлэг 14: Бурханд ойртох</i>	229
<i>Хавсралт А</i>	239
<i>Хавсралт Б</i>	243

ТАНИЛЦУУЛГА



1 991 онд Бурхан надад: “Хүү минь ээ, Би чамаар ном бичүүлмээр байна” хэмээн маш тод айлдаж билээ.

Би ч хэд хоног баахан тээнэгэлзэв. Нэг талаас намайг чинь айдас заамдаж байгаад л элдэв бүтэлгүйтлийн бодлоор толгой түрийгүй бөмбөгдөв ч, нөгөө талаас дотроос гижигдэн, инээд ч хүрэх шиг. Би чинь юм бичих ясны дургүй! Сургуульд зохион бичлэг хийх даалгавар өгөнгүүт л хоосон цаасаа хэдэн цагаар гөлрөөд суучихна. Тэгээд ч ЭсЭйТи аман шалгалт дээрээ уначихна. Тийнхүү хэл, уран зохиолоос зугтсандаа коллежид инженерийн ангийг сонгож явлаа.

Гэтэл ийнхүү Бурхан намайг ном бич хэмээв. Үгүй байлгүй дээ! Тэгээд би л буруу сонсож хэмээн дүгнэв. Тийнхүү хэдэн сар мартагнав. Гэтэл Бурхан надад хоёр долоо хоногийн зайтай хоёр өөр мужид, хоёр өөр эмэгтэйгээр нэг ижил үг дайлгав. Тэр хоёр бүсгүй хоёулаа “Жон,

хэрэв чи Эзэний бичээрэй гэсэн номыг бичихгүй юм бол, Эзэн өөр хүнээр бичүүлэхдээ л бичүүлнэ. Харин чиний хувьд бичээгүйнхээ төлөө шүүгдэнэ” хэмээн хатуу анхааруулах нь тэр.

Энэ үгийг хоёр дахь эмэгтэйгээс дуулсан даруйд Эзэнээс эмээхүй намайг айдас, бичих дургүйцэл хоёроос минь хүчтэй дэлсэв. Тэгээд эхэллээ дээ. Эзэний үгэнд орох шийдвэр гаргамагц, юу болсныг санадаг юм. Өмнө эргэцүүлэх юмуу сонсож мэдэж яваагүй бодлууд ар араасаа түрэн, тархиар дамжин хурууны минь өндгөөр шивэгдэн буув. Би ч эдгээр нь миний бус, Бурханы бодрол болохыг дорхноо л ухаарав. Тэр цагаас хойш арван хоёр жил өнгөрч, Бурханы номон хэлбэрээр өгсөн үг нь эдүгээ хорин таван хэл дээр сая, сая хувиар дэлгэрчээ.

Эхнийхээ номыг бичсэнийхээ дараа би Бурханд зүгээр л өөрийнхөө нэр дээр номтой болохын төлөө бус, харин Бурхан бичээрэй гэсэн нөхцөлд л ном бичихээ амлаж билээ. Тэгээд ч амлалт маань аль зэргийн чанартай болох нь бас л шалгагдсан. 1992-1999 оны хооронд Бурхан надад жил бүр бичих Үг өгсөн болов ч, *Батлан хамгаалалт дор* номыг бичсэний дараа Бурхан гурван жил бичих Үг өгөлгүй, чимээгүй болж, би ч бичих үггүй таг гацав. Ном эрхлэн гаргагч нар ч ямар ном шинээр гарах гэж байна, хэвлэмээр байна хэмээн байн байн нэхэв ч, надад дараачийн нүүдэл нь байсангүй. Бурхан Үгээ өгөхгүй юм чинь.

Тэгж тэгж гурван жилийн дараа Бурхан надад таны барьж буй Үгийг өгсөн болой. Ном хойшлогдсон нэгэн шалтгаан нь Ариун Сүнс энэ номыг зохих ёсоор гаргахаасаа өмнө, урьдаар миний дотор хийх ёстой ажлаа зүй ёсоор гүйцэлдүүлэх ёстой байсан байх гэдэгт би итгэдэг. Миний бие Есүст итгээд хорин таван жил болсон атлаа эдүгээх шиг ингэтэл Бурхантай дотно байхын хүслэн болж явсангүй. Сүүлийн жил хагасын хугацаанд Бурхантай урьд хожид байгаагүйгээрээ л үй зайгүй дотносож явна. Энэ арван найман сар амьдралдаа уйлж үзээгүйгээрээ л усан нүдэлж явна. Залбиралд төвлөрөхөөрөө л зочид буудлын өрөө, онгоц, албан өрөө, унаа тэрэг, орон гэр, агаар салхи - ер нь хаа ч байсан, шууд л хайлаад унана. Бурханы ийм бодитой, биетэй оршихуйг би ингэтэл мэдэрч үзээгүй.

Ном маань Ариун Сүнсний олон жилийн дасгалжууллын эмхэтгэл бөгөөд үр хүүхэд болсон - эрхэм тантай дотно байх гэсэн Бурханы чин зүрхний урилгыг агуулж байгаа гэдэгт эргэлзэх нь утгагүй. Тиймээс номдоо орохоосоо өмнө хамтдаа залбирбал, ямар вэ? Дараах үгийг чин сэтгэлээсээ хэлэхдээ, миний бие номоо бичиж байхдаа, таны төлөө энэ л үгээр чангаар залбирч байсныг минь мэдээрэй. Есүс бидэнд “Та нараас хоёр чинь ямар нэгэн зүйлийг гуйх талаар газар дээр санаа нийлбэл

тэнгэр дэх Эцэг минь үүнийг чинь тэдэнд үйлдэх болно” (Матай 18:19)
хэмээн амласан буюу.

За залбирцгаая:

Аав аа, энэ номын үгийг унших үед харах нүд, сонсох чихийг минь нээж, ойлгож, хүлээж авах зүрхийг Есүсийн нэрээр хайрлаарай. Би Тантай алдаг оног бус, харин цаг үргэлж ойр дотно байхыг үнэн голоосоо хүснэ. Таны зөвлөгөө, хүсэл, нууц, зүрхний хүслэнг мэдэж, Оршихууд тань амьдрахыг хүсч байна. Энэ үг надад ойлголт өгөөд зогсохгүй, амьдралыг минь Таны хайрт Хүү, миний Эзэн - Есүсийн дүр төрх рүү хувирган өөрчлөх хүчтэй байх болтугай. Яагаад гэвэл Есүс Тантай дэндүү дотно байсныхаа ачаар л Өөрөөрөө дамжуулан алдрыг тань төгс мандуулдаг байсан. Үүнтэй адил би ч бас Ариун Сүнсээр дамжин Есүстэй дотно явж, Түүний алдрыг төгс мандуулмаар байна. Энэ бүхнийг Тандаа даатгая. Таны Үгд анхаарч бас сонсож байгаа миний амьдралыг сууриар нь өөрчлөх үйл хэрэгт тань баярлалаа. Энэ бүхнийг Таны зарц Жон Бивэртэй санаа нэгдэн залбирлаа. Амень.

Харин одоо Бурхан таны чин зүрхний залбирлыг биелүүлнэ гэдэгт итгэн, таларх. Ариун Сүнс таны залбирлыг хэдийнээ хүний амин хүсэл бүрийг жинхэнээсээ хангадаг, ариун Нэгэний ариун сэнтий рүү зөөвөрлөн, таныг Бурхантай дотносох байр суурин дээр гаргаж эхэлсэн гэж бодохоор л догдлох юм. Та Бурхан Аав, Эзэн Есүс, Ариун Сүнстэй хамгаас дотносох болтугай!

Хүндэтгэсэн
Жон Бивэр
2003 оны 11-ээр сар

Нэгдүгээр бүлэг

ХАМГИЙН АУГАА ТҮҮХЭН УРИЛГА



Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно.
Иаков 4:8

Юунд чи Надтай ойр дотно байж болох байсаар байтал, Надгүйгээр сэтгэл ханаж, Надаас дөлнө вэ? Энэ бол Бурханы зүрхнээс гардаг дуудлага биш ээ. Энэ бол хашхираа юм.

Бидний биширдэг, дотносохыг эрмэлзэж явдаг найз нөхөд юмуу хүмүүс эргэн тойронд маань байж л байгаа. Бидний хувьд гоц гойд хүмүүс болох тэдний дэргэд байх нь бидэндээ чухам жаргал юм. За тэгээд тэднээс урилга хүлээж авах юм бол, бүр гараад өгнө. Тэдэнтэй уулзаж учирна гэхээс байж суун, баясан догдлон, бөөн баяр болно. Тэр л урилгын төлөө бусад бүх ажлаа шууд цуцална.

Иаков ном дээр “Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно” (4:8) гэсэн хамгийн аугаа урилга бий. Түр зогсоод: ертөнцийг, газрыг амьд амьтадтай нь бүтээсэн Бүтээгч Өөрөө таныг урьж байна гээд бодоод үз дээ. Урихаар барахгүй, бүр дотносохыг хүснэ. Учир нь “... хардагч нэртэй ЭЗЭН нь хартай Бурхан билээ (Тэр болбоос чамтай тогтоосон харилцаандаа улайрдаг Бурхан болой (Гэтлэл 34:14, ЭнЭлТи Библи) гэдэг.

Бурхан үүнийг бат хүсдэг. Бурхан хүүхдүүддээ Өөрийгөө таниулахыг хүсдэг учраас, Өөрөө ч урилгаа санаачилсан. Гэвч хүмүүний нүглээс болж харамсалтай нь, олон мянган жилийн ээдрээтэй бэлтгэл, асар их үнэ төлөөсөөр л ийм харилцаанд үүд нээгдсэн байна. Есүсийн дотно нөхөр Иохан:

Бурханыг хэн ч хэзээ ч хараагүй. Харин Эцэгийн өвөр дэх (дотно оршихуй дахь) цор ганц Төрөгч болох Бурхан нь Түүнийг таниулсан юм (Түүнийг илчилж, үзэгдэх газар дээр гаргасан; Түүнийг таниулж, мэдүүлсэн болой) (Иохан 1:18) хэмээн мэдэгдсэн байдаг.

Адам Эзэнийг нэвт шувт мэддэг байсан ч, нүглээсээ буюу дуулгаваргүй явдлаасаа болоод Бурханы яруу алдарт оршихуйгаас тасар татуулсан бөгөөд тэр л хувь тавилан даяар хүн төрөлхтнийг нөмрөв гэнэ. Тэгтэл Бурхан Аав бидэнтэй тогтоосон нөхөрлөлөө тэр аймшигт салан тусгаарлалаас авран сэргээхийн түүс болон, энэлэн шаналсаар байжээ. Тэгээд үүний шийдэл болгон, Есүсийг Эзэнээ болгохоор шийдсэн хүмүүсийг харанхуйгаас чөлөөлж, Өөртэйгээ эвлэрүүлэхийн төлөө анхнаасаа л Өөрийнхөө дэргэд суусан Хүү Есүсээ махан биет хүмүүний дүрээр илгээсэн юм.

Тийм болов ч бид Бурхантай нэгдсэн энэ нэгдлийнхээ тухай бүрэн гүйцэт номлох ч үгүй, үр шимийг нь бүрэн төгс эдлэх ч үгүй явна. Бид Есүс биднийг нүгэл, үхлээс чөлөөлснийг л цохон тэмдэглээд байдаг атлаа биднийг чөлөөлсөн Чөлөөлөгчтэйгээ дотно амьдрах талаар ярьдаггүй. Үүнээс маань болоод олон хүн Бурхантай дотно амьдрахын сайн сайхныг үздэггүй болохоор, бидний энэ хайхрамжгүй үйлдэл өндөр өртөгтэйгээр барахгүй, онц аюултай гэж хэлж болно. Энэ эмгэнэлийг Хуучин гэрээнд Абрахамын үр садад тохиолдсон үйл явдал харуулдаг.

ТЭНГЭР, ГАЗАР ШИГ ХОЁР СЭДЭЛ

Нэг талаас Мосе ба түүний шадар туслахууд, нөгөө талаас Израилийн хүүхдүүдийн эрс ялгаатай хандлага, зан үйлдлийн дадал хэвшлийг үзэхдээ, би үргэлж гайхдаг юм. Гэтлэл ном нь Абрахамын үр сад харгис хатуу дарлал дор шар махтайгаа хатаж буй үйл явдлаар эхэлнэ. Тэд Египетэд дөрвөн зуугаад жил аж төржээ. Уг нь тун жаргалтай эхэлсэн болов ч, төд удалгүй боолын боол болж, харгислуулж эхэлсэн байна. Гай зовлонд автсан тэр хүмүүс аврал эрэн Бурхан руугаа хашхиралдав.

Тэдний залбирал ч Эзэнийг хөндөж, Эзэн ч Мосе хэмээх чөлөөлөгчийг илгээв гэнэ. Мосе Еврей хүн атал боолчлолоос сугаран, Фараоны өөрийнх нь ордонд, ач хүү нь аятай торнижээ. Египетийн ханхүү Мосе хэдий төрөл нэгтнийхээ төлөө эмтэрсэн боловч, амиа авран цөл рүү одоод, олон жилийн дараа Бурханы Үг, хүчээр Израилийг Египетийн дарлалаас чөлөөлөхөөр эргэн ирдэг.

Египетийн дарлалаас чөлөөлөгдсөн Израилийн чөлөөлөлт нь нүглээс чөлөөлөгдсөн та бидний түүхтэй хоршдог. Израиль нь чуулганыг төлөөлдөг шиг, Египет нь дэлхийн системийг төлөөлнө. Та бид дахин төрөхдөө, дэлхийн дарангуйлал, дарлалын системээс чөлөөлөгдсөн билээ.

Израилийн үр садыг Египетийн иргэд яаж ашиглаж, хүчирхийлж байсныг төсөөлөхүйеэ бэрх. Тэд ядуусын сууринд толгой хорогдож, хог хаягдлаар хооллож, зоо нурууг нь Фараоны даамлууд ташуураараа урна. Египет эздээ л баяжуулж хөгжүүлэхийн төлөө махран зүтгэх тэр боолуудад боолын тавилангаас өөр өв залгамжлал үгүй. Фараоны зарлигаар нялх нярай хөвгүүдийг нь мянга мянгаар нь хядаж байхад ч тэд уйлахаас өөр юу ч хийж чадаагүй юм.

Гэхдээ ингэтэл тарчилж байсан хүмүүсийн ой санамж тун богино байсныг нь бараг л биширмээр. Учир нь тэд Египетээс чөлөөлөгдсөн хойноо өчүүхэн бэрхшээл үзэв үү үгүй юу “бид Египетэд *хавьгүй дээр* байж шүү, Египетээс дэмий гарч...” хэмээн гаслан халаглаж ирээд л эрх чөлөөний төлөөх залбирал, тэмцлээ няцааж байв. Бүр “Цөмөөрөө тэргүүлэгчийг томилоод Египет уруу буцацгаая” (Тооллого 14:4, тодруулгыг нэмэв) хэмээн том, том ярьцгаасныг нь яана.

Гэтэл Мосе тэгээгүй. Үнэндээ Египетэд утгаараа жаргаж байсан цорын ганц Еврей хүн нь Мосе л байв. Түүн шиг жаргаж байсан хүн Египетэд байтугай, дэлхий даяар ч байгаагүй биз. Тэрбээр энэ дэлхийн туйлын баян хүний ивээл дор өсч, хүний амьдардаггүй тансаглал дунд амьдарч, хүний иддэггүйг идэж, өмсдөггүйг өмсөж, аль шилдэг боловсролд нэвтэрсэн хүн. Мосегийн хүсэл - зарц нарынх нь тушаал. Тэрбээр эд баялгийн ч, амлалтын ч аль дээдийг өвлөх хувь тавилантай хүн байв. Гэвч Мосе энэ бүхнийг хүслээрээ хаяж явсан бөгөөд үүндээ Израилийн үр сад шиг хорогдоо ч үгүй, харуусаа ч үгүй.

Тэгэхээр, ялгаа нь юундаа байна? Хариулт нь: Мосе Бурхантай уулзжээ. Тэрбээр гал үзээд, ойртож очсон! Мосе Синайн галт бутан дунд амьд Бурхантай уулзсан бол, Израиль уулзаагүй! Эзэн өөрийг нь дуудах үед Мосе ойртож очсон. Гэтэл хожим Эзэн Израилийн үр садад бүр ч илүү гайхамшигт урилга өгөх үед тэд ухарсан билээ (Гэтлэл 20:18-21-ийг үзнэ үү).

Би чуулгануудаас нэг зүйлийг байнга асуудаг юм: “Мосе Израилийн үр садыг хааш нь аваачих гэж Египетээс гаргасан бэ?” Чуулганууд ч голдуу “Амлагдсан газар тийш” гэж хариулдаг. Гэхдээ байна шүү, үгүй юм аа. Мосе тэднийг Хороб буюу Синай уул руу дагуулсан. Бурхан Мосегоор Фараонд “Миний ард түмнийг явуул. Тэд цөлд Надад үйлчилнэ” (Гэтлэл 7:16) гэж хэлүүлснийг санаж байна уу? Бурхан “Миний ард түмнийг явуул. Тэд амлагдсан газрыг өвлөж авна” хэмээн айлдаагүй. Яахаараа Мосе Израилийн үр садыг эхлээд үе үеийн хүслэн болсон Амлагчтай нь танилцуулаагүй байж, шууд Амлагдсан газар руу дагуулна гэж? Эхлээд Амлагдсан газарт нь авчирчихбал, Израильчууд Амлагчийг Өөрийг нь хайрлах бус, амлалтыг нь хайрлаад унах байсан бус уу? Мосе өөрийнхөө Бурхантай уулзсан тэр газартаа Израилийг авчрах гэж тэсэн яджээ.

Өнөөгийн бид ч ер нь бол чуулгандаа яг л ийн үйлддэг. Есүсийг номлохоосоо илүүтэй, Тэр бидний төлөө юу хийж чадахыг нь л номлоно! Үүнээс болоод Бурханыг Өөрийг нь биширч үйлчилдэг бус, ашиг харж үйлчилдэг хүмүүс чуулганаар дүүрчээ. Яг л мөнгө харж гэрлэж байгаа хүүхэнтэй адил. Тэрбээр эр нөхөртэйгээ ижилдэн жаргахаар бус, харин нөхрийнхөө мөнгөөр хэрхэн амьдрахаа тооцоолон гэрлэжээ. Яахав, тодорхой хэмжээгээр хайрладаг байх л даа. Гэхдээ буруу шалтгаанаар л.

Бурхантай тогтоох харилцааг үл хайхарч, Бурханы ерөөл дээр анхаардаг хүмүүс нь Бурханыг Өөрийг нь хайрлаж биширдэг бус, Бурханаас юм салгачих гэсэн дагалдагч нарыг л бий болгоно. Гэтэл бидний Бурхантай эгнэх, Түүний гайхамшигт дөхөж очих амьгүй юм байтугай, амьд амьтан ч үгүй болой. Мосе шиг Бурхантай нэгэнт учирсан хүний хувьд амлалтууд нь зүгээр л алс хэтдээ болох ёстой юмс л болдог. Бидний Бурхан чинь Өөрөө юуг ч - тэр байтугай ерөөлөө ч дагуулашгүй, жинхэнэ Гайхамшиг болой.

Бурхан Израилийг чөлөөлөхдөө, Өөрийгөө мэдүүлж, Өөрийгөө хайрлуулах гэсэн ганц л үндсэн зорилготой байжээ. Бурхан Израильд Өөрийгөө мэдүүлэхийг л хүсч. Бурхан тэдэнд “Би... та нарыг бүргэдийн жигүүр дээр тээсэн” (Гэтлэл 19:4) хэмээн айлдсан боловч, Израиль тэр хувь тавилангаа алдсан юм.

Хүмүүстэйгээ дотносох гэсэн Бурханы энэ санаашрал буураа ч үгүй, өөрчлөгдөө ч үгүй бөгөөд Үгэн дотроос нь илчлэгдэн ундарсаар, Паулын чин зүрхний залбирал дотор ч тусгагджээ.

[Учир нь миний бие...] бидний Эзэн Есүс Христийн
Бурхан, алдрын Эцэгт, Тэрбээр та бүхэнд Түүнийг [гүн

бөгөөд дотночлон] мэдэхүйд цэц ухааны бөгөөд илчлэлийн [нууцлалд ба нууцад нэвтрэх ухаарлын] сүнсийг батлан соёрхохыг [...үргэлжид залбирнам] (Ефес 1:17, ЭйЭмПи Библи, *тодруулгыг нэмэв*).

Бурхан зүрхэн хүслээ мэдүүлжээ. Дахин төрсөн хүүхэд болгон нь Өөрийг нь гүн гүнзгий, дотно мэддэг байхыг Бурхан хүсэх! Та үүнд баярлахгүй байна юу? Баярлахгүй байвал, түр зогсоод, энэ гайхамшигт автагдана уу.

Бид үр хүүхдийнхээ төлөө зүрх юугаараа энэлж явдаг Бурхан - Аавдаа хүчин зүтгэдэг. Аав маань амьд харилцаатай Бурхан бөгөөд биднээс ч амьд харилцааг л хүсдэг. Паул ч Коринтын будилуу итгэгч нарт “Та нар харьтан байхдаа *хэлгүй* (“*ганц үг ч хэлж чадахгүй*” *ТиЭлБи Библи*) шүтээнүүдэд хөтлөгдөж, төөрөлдсөн байснаа мэдэх билээ” (1Коринт 12:2-3) хэмээн сүйхээчлэн цохоод, харин бидний Бурхан ярьдаг чанараараа бусад худал бурхан, шүтээнээс ялгардгийг тэмдэглэв!

“ХАЖУУ РУУ ЭРГЭХ”

Саяхан намайг давхиж явтал Ариун Сүнс “Чамтай ярих юм байна. Замын хажуу руу эргээтэх” хэмээн айлдруун.

Бурхан юм хэлж байхад, тухайн үедээ хичнээн шальгүй юмуу түвэгтэй санагдаж байсан ч, шууд үгэнд нь орох ёстой байдгийг би сурсан билээ. Эзэн анхаарлыг нь татах үед Мосе цөлийн ар гүнд хадам аавынхаа сүргийг хариулж яваагүй сэн билүү? (Бурхан бидний анхаарлыг янз бүрээр татах юм даа.) Бурхан бутан дунд залраад, бутыг галдан шатаалгүйгээр галджээ.

Мосе “Бут яагаад шатахгүй байгаа энэ гайхамшигт үзэгдлийг очиж (хажуу руу эргээд) харья байз” (Гэтлэл 3:3) хэмээн дотроо өөртэйгээ ярих нь бараг л сонсогдох шиг. *Хажуу руу эргэх* гэдэг үг нь *кувр* хэмээх Еврей үгээс гаралтай аж. Бичээсийн эх хэлний мэргэжилтэн Жэймс Стронг энэ үгийг “унтраах” гэж тодорхойлжээ. Мосе өөрийг нь даллан дуудсан Ариун Нэгэнд хариулахын тулд зориуд төлөвлөгөөт үйлдлээсээ хажуу руу эргэжээ.

Мосег хариу үйлдмэгц дараах үйл явдал өрнөв: “Тэрээр харахаар эргэснийг ЭЗЭН үзсэн агаад бутан дундаас түүнийг Бурхан дуудан — Мосе! Мосе! гэсэнд тэрээр —Би энд байна гэж хэлэв (Гэтлэл 3:4).

Бурхан Мосег хажуу руу эргэхийг нь үзэж байж л, нэрээр нь дуудсан

байх юм. Мосе хариу үйлдээгүй бол, Эзэн ч цаашаа хөдлөхгүй байх байж. Бурхан Мосег хэдэн хонио туугаад харьчихсан хойно буюу ая тухтай цагт нь дуудаагүй. Мосе “Хонио үлдээчихбэл, талаар нэг тараад, буцааж хураах гэж өдөржин юм болно. Нэг ажлаа дуусгачихаад л, ая заваараа байгалийн тэр жигтэй үзэгдлийг очиж сонирхъё байз” хэмээн бодсон бол, ижил үр дүн гарах байсан болов уу?

Зарим хүн Бурханыг үүнээс ч илүү ер бусын юм үйлдэж чадах л байсан хэмээн бодож байж болох ч, Бурхан савгануур этгээд биш. Жишээ нь, Тэргүүн тахилч Елид болоод түүний хөвгүүдэд хүчин зүтгэж байсан Самуелыг авч үзье л дээ (1Самуел 3-аар бүлгийг үзнэ үү). Нэгэн орой жаалхүү Самуел унтахаар хэвтэж байхдаа “Самуел аа, Самуел аа!” хэмээн дуудахыг сонсжээ.

Самуел Ели дээр гүйж очоод: “Та намайг дуудсанд, би ирлээ” гэсэн.

Гэтэл Ели: “Би чамайг дуудсангүй. Буцаад орондоо ор” гэж хариулав.

Самуел хоёр дахь удаагаа нэрээ сонсоод, мөн л гүйж очсон боловч, тахилчаасаа мөн л хариуг сонсжээ. Энэ явдал гурав дахисан тул адагтаа тахилч ухаараад, хэрхэн хариу үйлдэх ёстойг нь зааварлав. Тэгээд Самуел дөрөв дэх удаагаа “Самуел аа, Самуел аа!” гэх дууг сонсохдоо, хэрхэн үйлдэхээ мэддэг болсон тул: “Үгээ айлдана уу, зарц тань сонсож байна” гэжээ. Тэр цагт Эзэн Самуелд үгээ айлдаж, айсуу хүсэл, нууцлалуудаа харуулдаг.

Бурхан өөрөөр үйлдэж чадах л даа. Яахав, хоёр дахь удаагаа дуудахад нь ойлгоогүй Самуелд “Самуел аа, битгий Ели рүү шогшоод бай. Эзэн Бурхан чинь чамайг дуудаад, чамтай ярихыг хүсээд байна” хэмээн зарлигдаж чадах л байсан. Гэвч Бурхан ингэдэг гэж үү? Бурхан Өөрийг нь хүсээсэй, таниасай, мэдээсэй л гэж хүсдэг. Сүнс дотор залгахыг мэдэхгүй, хичээнгүй эрэн хайдаг, мөрдөн мөшгидөг хүмүүсийг л Бурхан хүсэн хайдаг.

Сайн мэдээнээс ч мөн л ижил загварыг харж болно. Есүс таван талх, хоёр загасаар таван мянгыг хооллож дуусаад, дагалдагч нартаа завиндаа суугаад, нуурын нөгөө эрэг дээр түрүүлж очоод хүлээж байхыг даалгажээ. Тэгээд Өөрөө Аавтайгаа уулзахаар уул өөд гарсан. Тэр оройноо дагалдагч нар нууран дундуур салхины өөдөөс сэлүүрдэж явтал, дараах үйл явдал болжээ:

Салхи сөрөн явж байсан тул шавь нар нь сэлүүрдэн хүчээ барж буйг Есүс хараад, шөнийн дөрөв дэх манааны үеэр нууран дээгүүр алхаж, тэднийг зүглэн ирж байв.
Тэдний хажуугаар өнгөрөхөөр явж байтал... (Марк 6:48, тодруулгыг нэмэв).

“Тэдний хажуугаар өнгөрөхөөр явж байтал” гэдэг үгийг тэмдэглэнэ үү. ЭнЭйЭсБи Библи дээр “Тэрбээр тэднийг өнгөрөх санаатай байлаа” гэдэг. Гэтэл дагалдагч нар нь Есүсийг үзээд, хашхиралдсан тул Есүс “Урамтай сайхан байцгаа! Бүү айцгаа. Би л байна шүү дээ” хэмээжээ. Есүсийг завинд орж суумагц, салхи ч намжив. Дагалдагч нар хашхиралдаагүй бол, Есүс цаашаа яваад л өгөх байж. Есүсийг дэргэдүүр нь өнгөрч байхад, дагалдагч нар хашхиран дуудаагүй бол, Есүс хүчээр тэдний дэргэд үлдэхгүй л байсан болов уу.

Бурхан яг л ийм арга загвараар бидэн рүү алхам хийдэг бөгөөд биднийг хариу үйлдэх аваас, Бурхан бидэн рүү дахин нэг алхам хийж, улам ойртдог мэт. Харин хариу өгөхгүй байгаад байвал, Бурхан гуравдагч этгээдийн дүрээр хөндлөнгөөс дайрахгүй. Мосе хажуу руу эргээгүй байсан бол, Бурхан Мосег Самуелыг хүлээсэн шиг, Есүс дагалдагч нараа хүлээсэн шиг хүлээх байсан эсэхийг хэн мэдлээ? Бурхан ихэвчлэн биднийг хариулахаас өөр аргагүй болтлоо ангаж цангатал минь хүлээдэг.

Нөгөө замын хажуу руу эргэсэн түүх рүүгээ эргэж орё. Би Бурханыг юм хэлэх үед замын хажуу руу эргэж зогсоогүй байсан бол яах уу? Бурханыг алдах байсан болов уу? Мэдээж би тийм алдаа гаргаж л явсан. Гэхдээ тэр өдөр км хэртэй яваад хурдны замын хажуугийн түр зогсоол байж таарсан юм. Намайг машинаа зогсоомогц, Бурханы Сүнс “Тасралтгүй залбир” (1Тесалоник 5:17) гэж хэлээгүй билүү Би чамд?” хэмээн зүрхэнд шивэжнэв.

Би ч: “Тийм ээ Эзэн минь, Та хэлсэн” л гэлээ.

Тэгтэл Эзэн: “Залбирал ганц хүний илтгэл үү, харилцан яриа юу?” хэмээн лавшруулж асуув.

Би ч: “Хоёр хүний хооронд өрнөдөг, харилцан яриа Эзэн минь” л гэлээ.

Гэтэл Эзэн ч шууд л: “Тасралтгүй залбирал гэдэг чинь Би чамтай тасралтгүй ярилцах хүсэлтэй байна гэсэн үг бус уу?” хэмээв.

Миний баярласан гэж. Бурхан надад юу гээчийн гайхамшигтай боломж хайрласныг ухаарсандаа тэр л дээ. Үнэндээ ганц надад бус, Бурханы хүүхэд болгонд олгогдсон боломж шүү дээ.

Тэгэхээр, та: “Бурхан надтай зогсоо зайгүй ярьдаг хэрэг үү?” гэж асуух байх. Бурхан миний зүрхэнд ийм утгаар хэлээгүй, харин надтай тасралтгүй харилцах хүсэлтэй гэдгээ л ойлгуулсан юм. Үг бол харилцааны олон хэлбэрийн нэг нь л байх. Жишээ нь гэргий минь юу ч дуугаралгүй, ганц харцаараа л надад санаагаа ойлгуулдаг. Би ч тэр ганц харцнаас нь бүтэн гурван хуудас ухаарал буулгаж чадна. Яагаад?

Бурханд ойрт

Хориод жил амьдарсан хүнийхээ харилцааны арга зам, хэв маягийг суралгүй дээ. Тэгвэл яг тэр эгшинд бид хоёртой нэг өрөөнд сууж байсан танд манай эхнэрийн тэр харц юу ч илэрхийлэхгүй байж болох. Яагаад? Яагаад гэвэл та миний гэргийг миний мэддэг шиг мэдэхгүй. Үнэндээ гэрлэсэн эхний хэдэн жилдээ би өөрөө ч тэр харцыг ойлгодоггүй явж билээ. Харин хорин нэгэн жил хамт амьдарсныхаа дараа, эдүгээ гэргийнхээ харилцааны арга ухааныг зах зухаас нь ойлгодог болсон.

ОЙРТОХ ДУУДЛАГА

Энэ номыг “хэрхэн” хэмээх гарын авлагатай бус, харин бидний туйлын зогсоол болох Бурханы зүрхэнд хүргэх газрын зураг, хөтөчтэй зүйрлэж болох юм. Тухайлбал, надад эзгүй арал дээр булаатай байгаа эрдэнэст хүргэх замыг заасан газрын зураг байлаа гээд, би өөрийн биеэр тэр эзгүй арал дээр аялж очоод, олзоо олохын төлөө газар оронтойгоо танилцаж, туулах ёстой бартаагаа туулж, авирах ёстой хадандаа авирч, хөндий талыг хөндлөн гулд туучихгүй бол, юуны нэмэр. Миний зүгээс гарах ёстой үнэ төлөөс, эрч хүч, хүчин зүтгэл нь гарах л ёстой. Газрын зураг надад зам зааж, шаардлагагүй хүчин зүтгэл, эрэл хайгуулаас сэргийлж, ил далдын урхи хавхнаас хамгаалах л үүрэгтэй. Энэ ном ч тийм л газрын зураг. Бурханы зүрх рүү аялуулах хамгийн гайхамшигтай, догдолмоор адал явдалд нэгдэхийг уриалан дуудсан урилга. Эдгээр хуудас дээрх Бурханы үгс таныг замын садаа - нүх сүв, урхи занга, аюулаас сэргийлж, эрч хүчээ шал дэмий асуудалд гарздахаас хамгаална.

За бэлэн бол, эхэлцгээе!

СУДЛАХ АСУУЛТ

1. Амьдралд чинь тохиолдсон ямар үйл явдлаас болж та энэ номыг уншихад хүрсэн бэ?
2. “Бурхан руу ойртох” урилгын дараах хэдэн жишээг үзнэ үү:
 - Мосе галт буцыг үзээд, учрыг нь олохоор хажуу эргэсэн. Ингэснийх нь дараа Бурхан түүнийг дуудсан.
 - Самуел “Зарц тань сонсож байна, айлдана уу” гэж хэлэхээсээ өмнө дөрвөн удаа дуу хоолой сонссон.
 - Дагалдагч нар Есүсийг зөрж өнгөрөхөөр усан дээгүүр явахыг нь үзээд, хашхирч дуудсан.

Бурхан танд эдгээрийн алинтай нь төстэй урилга өгч байсан бэ? Та хүлээж авсан уу? Хүлээж авсан бол, ямархуу чанарын хариу өгсөн бэ?
3. Залбирлыг хоёр талт харилцан яриа гэж нэрлэх юм бол, Бурхан танд аман болоод аман бусаар юу гэж айлдсаар ирсэн бэ?

Хоёрдугаар бүлэг

БУРХАНЫ НЭХЭЛ



Эзэн надад “Би чамайг Өөрөөсөө дээгүүр үздэг” хэмээв.

Библи том, том сэдвийг өгүүлдэг бөгөөд эдгээр үнэн Эхлэлээс Илчлэл хүртэл хөвөрдөг. Тэдгээрийн нэг нь Бурхан хүмүүний хүслэн бөгөөд нэхэл болдог гэдэг үнэн болой. Бид Бурхантай дотносохыг хүсэхээсээ илүү Бурхан бидэнтэй дотносохыг хүсдэг нь баримт!

Бурхан үнэндээ биднийг мөрөөсдөг (Иаков 4:5-ыг үзнэ үү). *Мөрөөсөх* нь “машид санаашрах” гэсэн утгатай. Үүнийгээ Бурхан цаг хугацааны эхлэлээс л хамаг зүрхээрээ хүссээр иржээ. Адамыг нүгэл үйлдсэн хойно ч Бурхан шууд л шүүж, зарлигдсан үг унагалгүй, “Адам, чи хаана байна?” гэсэн. “Чи юунд Надаас нуугдана вэ?” гэсэн Бурханы зүрхний мэгшлийг сонсож байна уу? Бурханы энэ үлэмжийн санаашралыг түүхээс гүйлгэж үзье л дээ.

АДАМЫН ДӨРӨВДҮГЭЭР ҮЕИЙН АЧ ХӨВҮҮН

Адамын дөрөвдүгээр үеийн ач хөвүүнийг Енох гэнэ. Енох нэг л өдөр өндөр өвөө Адамаасаа Еденд аж төрж байсан үүх түүхийг нь шалгаасан л байгаа. Амьд Бурхантай алхалж, амьдарна гэж юу болохыг мэдэхийг хүссэн л байгаа. Енох яаж яваад дөрвөн үеийнхээ өвөгтэй уулздаг билээ

хэмээн гайхаж байна уу? Хариулъя: 930 насалсан хүн чинь дөрөвдүгээр үеийн ачтайгаа уулзалгүй яахав. Енохыг мэндэлж байхад Адам дөнгөж 622 настай байжээ.

Жаран таван настай Енох Адамтай ярилцах үед Адам 687 настай байсныг математикийн аргаар Библиэс тогтоочихно. Үүнийг Енох 365 наслахдаа гурван зуун жилийг нь Бурхантай хамт алхсан гэдэг Эхлэлийн тэмдэглэлээс хасч тооцоолов.

Метуселаг төрүүлснээс хойш Енох гурван зуун жил Бурхантай хамт явж, үр хүүхдүүдтэй болжээ. Енох гурван зуун жаран тав наслал (Эхлэл 5:22-23).

Тиймээс Енох 65 насандаа өвөг Адамынхаа уруулаас ерөөл, зүрхэн хүслийг сорох үед амьдрал нь орвонгоороо эргэсэн байж болзошгүй.

Үүнийг батлах баримт байхгүй л дээ. Зүгээр миний хувийн төсөөлөл. Адам өвөөгийн хувьд өнгөрсний тухай өгүүлэх зовиуртай л байсан байгаа. Тиймд Енохын хувьд ч алдарт өвгөөсөө Едений талаар асуух гэж магадгүй олон жил зүрх зоригоо чангалж байж л хууч хөөрсөн байх. Энэ түүхийг Адамынхан удмаараа мэддэг байсан болохоор Енохыг бага балчраас нь энэ тухай өндөр өвөгтэйгээ ярихгүй байхыг анхааруулж өсгөсөн байх.

Адам цэцэрлэгээс хөөгдсөнийхээ дараа сэтгэл санааны өвчинд нэрвэгдсэн тухай Еврей түүхэн бичвэрүүд хэлдэг. Зүгээр нэг өвчин бус, харин тэсэхүй еэ бэрх хүнд өвчин. Адам, Ева хоёр болж өнгөрсөн явдлын шившигт автсандаа, хоёр биенээ ч харж чадахгүй, харанхуй агуйд суусан тухай зарим бичвэр хэлдэг. Адам сүр жавхлангаа алдсан. Бурхантай хамт алхах амлалтыг сонсох нь нэг хэрэг бол, Бурханы биет алдар дотор бодитоор амьдрах оршихуйгаа алдах нь тэс өөр хэрэг юм. Адам үгээр илэрхийлэшгүй алдагдал хүлээсэн бол, Енох зориг гарган, Адамын хуучны зүрхний шаналанг өөрийн болгоод, үүнийгээ итгэл, хүсэн хүлээлт хоёртой хольжээ. Адамын бусад үр сад нь үе уламжлан өвөөгийнхөө гарзад гонсгор байгаагаа шивэр авир хийж байхад, Енох харин “Би Бурхантай хамт алхана” гэдэг амлалтыг өвлөжээ.

Адам, Енох хоёрын уулзалтыг би төсөөлж байна аа. Енох дагжсан боловч, эцэстээ айдас нь хүсэл тэмүүлэлдээ дийлдсэн. Енох ямарваа нэгэн том юмны гэрэл гэгээд итгэсээр, ялагдлын чичиргээт сүүдэр дундуур давшжээ. Енохын хувьд Адамын түүх нь алдааны домог бус, илүүтэй хүмүүнтэй хамт алхах гэсэн Бурханы туйлын хүслийн илчлэл байв. Адам Еден цэцэрлэг доторх амьдралынхаа дурсамж дотроос

олдох алсарсан ерөөлийг Енохт дамжуулж байхдаа, Енохын дотор бадрах галыг олж үзээ болов уу хэмээн гайхах.

Адам зүрх зүсэм түүхээ нулимс унаган өгүүлсэн байх аа: “Енох оо, би Бурханы алдар дотор... Бурхантай хамт алхдаг байлаа. Чиний харж буй бүхнийг бий болгосон, ертөнцийг Бүтээгч Эзэн надтай хамт алхаж байсан гээд бод! Бурхан надтай эх гарынхаа төлөвлөгөөний нарийн нандин цэц ухааныг хуваалцаж, ертөнцийн оддыг хуруугаараа байр байранд нь товлон өлгөснөө хуваалцана. Тэр л хуруу намайг бүтээж, гараас минь атгасан юм шүү дээ. Бурхан од нэг бүрт нэр хайрлаж, тэдгээрийг орон зүйн байршил, улирлын тэмдэг болгосон. Бурхан газрын татах хүч, цахилгаан соронзон орноор дэлхийг тэнцвэржүүлэн, төгс цаг уурыг бүтээснээ харуулсан. Бурхан надад үрийн нууцыг тайлж, үр болгон өөрийнхөө төрөл зүйлийн амийг ургуулж бас дэлхий даяар стратегитай байршуулсан гүний булгаар тэтгэгдэн, ургадаг тухайгаа хуваалцсан. Енох минь, Бурхан надад таван тэрбум гаруй төрөл зүйлийн амьтанд нэр өгөх завшаан хайрласан! Бид хамтдаа хэлэлцсэн л дээ. Гэхдээ эцсийн сонголтыг Бурхан надад өгсөн!”

Енох Адамын өгүүлэлд автсаар, эцэстээ энэ цангаандаа автжээ. Енох Адамтай адил Бурхантай хамт алхана. Енох санасандаа хүрнэ.

Түүгээр барахгүй Енох Адамын ч өвлөөгүй нэгэн зүйлийг буюу өвлөсөн бөгөөд Адамын тоос газартаа шингэсэн бол, Эхлэл дээр “Енох Бурхантай хамт явж байсан ба түүнийг Бурхан авч явсан учир тэрээр дэлхийд байсангүй” (Эхлэл 5:24) гэдэг. Енох энэ дэлхийгээс үхлийг үзэлгүйгээр явчихжээ.

Енох амьд ахуйдаа аугаа зөнч байсан. Енох тухайн цаг үеийнхэндээ ч, манай үеийнхэнд ч эш үзүүлсэн. Тэрбээр эцсийн өдрүүдэд нигүүлслээр аврагдсан мэт авирлахаар барахгүй, улмаар үүндээ итгэж, цуглаан дотор хүчээ авах хуурамч дүртнүүдийн талаар мөн тэд хожим хэрхэн шүүгдэх талаар ч эш үзүүлсэн (Иаков 1-15-ыг үзнэ үү). Енох Бурханы шүүхийн үзэгдлийг үзэж, Эзэнийг онгон бүсгүйгээс мэндлэхээс хаа байсан хэдэн мянган жилийн тэртээ бүр Түүний хоёр дахь ирэлтийг ч тунхагласан байдаг.

Тэгвэл Эзэн яагаад Енохыг дөнгөж 365 настай байхад нь авчихсан юм бол? Аугаа эш үзүүллийн үйлчлэлээс нь болоод тэр үү? Үгүй юм аа. Учир нь Енох “Бурхантай хамт алхсан” бөгөөд энэ нь “Бурханд таалагдсан” хэмээн Еврей ном хэлдэг (Еврей 11:5).

Намайг буруугаар ойлгуузай. Енох Бурхантай алхахтай маш үр дүнтэй, хүчирхэг үйлчлэлийг бүтээсэн боловч, үнэндээ Енохын Бурханыг дотно таньж мэдэх гэсэн гал хүсэл нь л Эзэнд таалагдсан

болой. Енох Бурханы зүрхэнд оршдог хүмүүстэй дотно харилцаатай байх гэсэн хүсэл, биднийг гэх санаашрлыг нь хөндөж чаджээ.

ЭРИН ҮЕИЙГ ӨРТӨӨЛӨН ЦУУРАЙТСАН БУРХАНЫ ЗҮРХНИЙ ХАШХИРАА

Цаг хугацааны уртад Бурхан нэг л юмыг хүсч! Юуг? Хүмүүнийг хүсэх Бурханы хүслийн хариуд Бурханыг мэдэх хүсэлтэй хүмүүсийг! Енохоос хойш Ноа гэдэг нэгэн хүн гарч иржээ. Ноа ч бас Бурханы зүрхийг хөндөж чадсан, өөр нэгэн ач хүү. Эхлэл дээр “Ноа Бурхантай хамт алхсан” (Эхлэл 6:9) гэдэг. Ноа Бурханы нөхөрлөх хүсэлд хариу үйлдэж, Бурхан руу ойртжээ. Ноаг ойртоход, Бурхан ч Ноа руу улам ойртож, айсуй юмсыг анхааруулав. Дэлхийг гэнэт арчсан шүүх нь анхандаа Ноа, Бурхан хоёрын хоорондын нууц байжээ. Бурханыг мөшгидөг, Бурханд итгэхийг зүрхэлдэг, Бурхантай дотносоход тэмүүлдэг хүмүүст Бурхан хариулдаг гэдэгт Ноа баг итгэсэндээ, Бурхантай дотно нөхөрлөсөн байна.

Үүнийг “Чи Миний өмнө яв” (Эхлэл 17:1) хэмээн Абрахамд айлдсан Бурханы урилгаас дахин харж болно. Энэ урилга цааш сунаж, Исаак, Иаков руу тэлсэн бөгөөд Иаковыг төрөхөөс хаа холын эртэд Бурхан “Би Иаковыг хайрласан...” (Ром 9:13) хэмээсэн байдаг. Эзэн яг л бидний амьдралд үйлдсэн шигээ, Өөрийг нь сайн мэддэг ч үгүй Иаковын араас түрүүлж хөөцөлджээ. Иаков ахаасаа оргож зугтаж явахдаа, өөрийг нь олзлохоор отож буй Бурхантай учирсан. Бурхан чулуу дэрлэн унтаж буй Иаковт нэгэн шатаар тэнгэрэлч нар нэг уруудаж, нэг авирч байгаа зүүд зүүдлүүлжээ. Ийнхүү Бурхан, хүн хоёрын хоорондох тэнгэрлэг холбоо илчлэгдсэн байна.

Дөрвөн зуун жил дарлагдсан Иаковын үр сад - Израилийн хүүхдүүд өөрсдийг нь боолчлолоос чөлөөлсөн Бурханы амин зорилгыг ойлгоогүй. Тэд Амлагдсан газрыг өвлүүлэхийн төлөө л чөлөөлсөн гэж бодтол, Бурхан түүнээс нь том зорилготой байжээ. Бурханы хамгийн том зорилго нь тэдэнтэй дотносох явдал байв. Энэ санаагаа ч Израильд хандсан чин зүрхний, уран яруу Үгээрээ тов тодорхой мэдэгдсэн:

Би Египетчүүдэд хэрхэн хандаж, та нарыг бүргэдийн жигүүр дээр тээн, *Өөртөө яаж авчирсныг* та нар өөрсдөө харсан (Гэтлэл 19:4, тодруулгыг нэмэв).

Тийм боловч, Бурханы энэ хүсэл Израилийн хүүхдүүдийн үгд тусгалаа олоогүйгээр үл барам, тэд тэс өөр сэдлээр урван тэрсэлснийг

Бурханы нэхэл

үзэж болно: “Чи биднийг сүү зөгийн бал урсан нутагт аваачиж, тариалангийн талбай, усан үзмийн цэцэрлэгийг бидэнд хувь болгоод өгчихсөн юм уу?” (Тооллого 16:14) Тэд *Хэнийг* бус, харин *юуг* өвлөж авах гэж байгаа дээрээ л анхаарчээ.

Мосе Абрахамын үр садад хандсан Бурханы хүслийг ахин дахин цохон тэмдэглэсэн бөгөөд үүний нэг нь энэ:

Учир нь Тэрбээр та нартай тогтоосон харилцаандаа харам
Бурхан болой (Гэтлэл 34:14, ЭнЭлТи Библи).

Бурхан даяар Израильд “Би та нарыг хайрласан” гэсэн. Гэтэл хатуу зүрхтэй, хайхрамжгүй Израильчууд өдөөс нь “Та биднийг яг яаж хайрласан юм?” (Малахи 1:2) гэж өрвөлзсөн. Бурхан өөрсдийг нь хүсээд байна гэдэг үнэнд таг сохор тэр хүмүүс Бурханы сунгасан мутрыг шүүгч гар байна хэмээн андуурчээ.

Ахин дахин дуулгаваргүй авирлах тэр хүмүүсийг Бурхан хүссэн хэвээрээ л байв. Иеремиа амьд ахуйдаа “Мөн эртнээс ямагт ярин Би та нарт хэлсэн боловч та нар сонсоогүй, Би та нарыг дуудсаар байсан боловч та нар хариулаагүй” (Иеремиа 7:13) хэмээн хашхирсан байдаг. Бурхан Израилийг Египетээс гаргаж ирсэн өдрөөсөө энэ өдрийг хүртэл ийнхүү тэдний араас явснаа мэдүүлжээ (Гэтлэл 7:25-ыг үзнэ үү).

Энэ дунд Бурханы хайр нэг ч ганхаагүй бөгөөд биднийг гэх Бурханы энэ төгс хүслийг Есүсийн дотроос ч олж болно. Есүс Өөрөө ч үүнийгээ тайлбарласан: “Хүний Хүү алдагдсаныг *хайж*, аврахаар ирсэн билээ” (Лук 19:10, тодруулгыг нэмэв). Есүс дайснаа ч аврахаар төдийгүй, *хайхаар* ирсэн!

ГАНЦ ХҮНД ХАНДСАН БУРХАНЫ БОДОЛ

Бид санасан хүнээ өдөр шөнөгүй боддоггүй гэж үү? Өдрийн бодол маань байс хийгээд л тэдний зүг эргэж, шөнө зүүдэндээ ч тэдэн рүү тэмүүлнэ. Тэр хүн бидний эмзэг тал болж, түүнийг зогсоо зайгүй бодож, уулзаж учрахыг хүсч байгаагаа хүмүүст яриад л баймаар. Тэгвэл Бурханы хувьд ч ялгаагүй. Бурхан бидэнд хэрхэн ханддаг тухайгаа Давидад өгүүлсэн. Ганц хүнд хандсан Бурханы бодлыг Давид хайлтал шүлэглэжээ:

Аяа Бурхан, надад хандсан бодлууд тань
Хичнээн нандин бэ!

Нийлбэр нь хичнээн их вэ!

Би тэдгээрийг тоолбол

Тэд элсний ширхгээс ч даван гарна.

Сэрэхдээ ч би Тантай хамт билээ (Дуулал 139:17-18).

Бурхан энэ дэлхий дээрх ганц л хүнийг дэлхийн гадарга дээрх бүх элсэн ширхэгийн нийлбэрээс ч олон боддог гэхээр бидний ухаан хүрэхгүй байх! Бодол л доо. Дэлхий хэмээх гариг дээрх усны эрэг дээрх, цөлийн, нуурын, далай, тэнгисийн ёроол дахь тэгээд мэдээж гольфын талбай дээрх бүх элсэн ширхэгийг төсөөлөх гээд үз л дээ. Зүгээр л ганц гольфын талбай дээрх хэсэгхэн элсэн хонхор дээр л хичнээн ширхэг элс байгааг тоолох нь байтугай, төсөөлөхөөс ч цуцмаар. Гэтэл Бурхан дэлхий дээрх бүх элсэн ширхэгийн нийлбэрийг ярьж л байх! Хязгааргүй тоо л гарна! Өнгөрсөн хорин нэгэн жилийн хугацаанд би гэргийгээ мөн ч их энхрийлэн бодсон хэдий ч, хамгийн олон удаа бодож гийгүүлсэн өдрөө ч жижиг зөөхийний шил ч дүүргэчих хэмжээнд бодоогүй л байх.

ХҮН ҮНЭ ЦЭНЭТЭЙД ТООЦСОН ЗҮЙЛТЭЙГЭЭ Л ХӨӨЦӨЛДДӨГ

Хүн хайртай, санагалздаг, ойр байхыг хүсдэг хүнийхээ талаар л ингэж боддог байх! Тэгэхээр, Бурхан таныг яаж хайрладгийг зах зухаас нь ойлгож эхэлж байна уу одоо? Та гэдэг хүн Бурханд ийм л ач холбогдолтой болохоо ер нь бодож үзэж байсан уу? Бид дэлгүүр хэсэхдээ, янз бүрийн үнийн шошготой бараан дундуур тэнэдэг. Зарим бараа нь хямдарсан бол, зарим нь үнэтэй; бүгд өөрийнхөө үнэ цэнийг илэрхийлсэн үнийн дүнтэй. Тийм боловч мэргэн худалдан авагч нь өөрийнх нь төлж байгаа мөнгөн дүнд зохицсон юмуу давсан үнэ цэнэтэй зүйлийг л худалдаж авна.

Амьдралын бүх зүйл үнэ цэнэ тээж ирдэг. Тэдгээрийн үнэ цэнийг худалдан авагч хүний үзэл бодол тодорхойлно. Хэдэн жилийн өмнө нэг бэйсболын бөмбөг зарагдаж билээ. Гэвч зүгээр нэг бөмбөг биш, харин Марк МкГвайрын 17 дахь хоум ранаа (home run) цохихдоо хэрэглэсэн бөмбөг байв. Тэр үед Марк ганц улирлын тоглолтоороо хамгийн олон хоум ран цохилт хийснээрээ, лигийн томоохон рекорд тогтоосон юм. Тэр бөмбөг 2.7 сая доллараар зарагдсан! Надад тийм мөнгө байсан ч, би тэр бөмбөгийг тийм мөнгөөр худалдаж авахгүй байв. Яагаад? Яагаад гэвэл тэр бөмбөг надад ямар ч үнэ цэнэ илэрхийлэхгүй. Гэтэл тэр үед завшаан нь таарсан бол, түүнээс ч их мөнгөөр худалдаж авахад бэлэн

хүмүүс байсан тухай уншиж байснаа санаж байна. Харин өнөөдөр тэр хоум ран рекордыг хэдийнээ эвдсэн бөгөөд нэгэн цагт тэнгэрийн үнэтэй байсан нөгөө бөмбөгийг эдүгээ тал үнээр нь ч худалдаж авах амьтан байхгүй л байх. Бөмбөгний үнэ цэнэ навс унажээ.

Тэгэхээр: “Нийгэм биднийг юу гэж үнэлж байна?” гэж асуух буруу ажээ. Ингэж асуубал, янз бүрийн хариулт гарна. Хүмүүс чинь хүний амийг ч дураараа үнэлдэг шүү дээ. Хараахан мэндлээгүй байгаа үрээ зүгээр л хөнөөчихдөг сая сая эцэг, эх бий. Тэдний хувьд тав тух нь үрийнх нь амиас үнэтэй аж. Миний цаг зав, эрч хүчийг хүртэх үнэ цэнэгүй гэж үзсэндээ, олон эрчүүд эхнэр хүүхдээ хаяад явдаг. Түүнд биеийн жаргал, тохь тух нь хань ижил, үр хүүхдийнх нь амьдралаас чухал юмсанж. Өөрийнхөө биеийг үнэлж борлуулдаг хүмүүс байна. Гэх мэтчилэн энэ жагсаалт дуусахгүй. Үүний урхагаар нийгэм ч эрэмдэг зэрэмдэг хүмүүсээр дүүрчээ. Өөрийгөө хүний нүдээр үнэлдэг учраас, надад хэн ч хайргүй, би хэнд ч хэрэггүй гэж үздэг хүмүүс ч бий.

БУРХАН ААВДАА ЯМАР ҮНЭ ЦЭНЭТЭЙ ВЭ?

Тэгвэл бид Бурхан Аавдаа ямар үнэ цэнэтэй вэ? Эндээс л бид жинхэнэ үнэ цэнээ олно. Энэ ертөнц дээр үнэ цэнийн жишгийг хүмүүн бус, Бурхан Өөрөө тогтоодог болой. Учир нь “Хүмүүсийн эрхэмлэдэг зүйлс нь Бурханы өмнө жигшмээр юмс байдаг” (Лук 16:15).

Есүс “Учир нь хүн бүх ертөнцийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ? Эсвэл амийнхаа оронд тэр юугаа өгөх билээ?” (Матай 16:26) гэсэн. Дэлхийн бүх баялгийг төсөөлж чадах уу? Хэдэн сая долларын орд харш, үнэт чулуу, металл, тансаг машин, завь, онгоц, урлагийн бүтээл гэмээр боловсронгуй электрон хэрэгслийг төсөөлөх гээд үз дээ. Энэ чинь энэ дэлхий дээрх “хачин гоё юмсын” өчүүхэн л хэсэг нь шүү дээ. Ер нь бол энэ дэлхий дээр хүний ухаан санаад ч багтахааргүй олон үнэт юмс бий. Саяхны нэгэн судалгаагаар дэлхийн нийт бүтээгдэхүүний эцсийн дүн нь 35.8 триллион Америк доллар болно гэсэн тооцоо гарсан байдаг. Бичгээр буулгавал ардаа арван нэгэн тэгтэй тоо гарна. Энэ чинь асар их баялаг. Дээрээс нь үүнд чинь үл хөдлөх хөрөнгийн дүн багтаагүй байгаа. Гэтэл Есүс хүн энэ их баялгаар амиа солих нь маш муу наймаа хэмээв!

Тэгэхээр, Бурхан биднийг дэлхий дээрх, дэлхий доторх хамаг баялгаас дээгүүр үнэлсэн юм бол, бид жинхэнээсээ Бурханд чухам ямар үнэ цэнэтэй юм бол? Иохан 3:16 дээр “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласандаа цорын

ганц Хүүгээ өгсөн” гэжээ. Адам биднийг Люсифер гэдэг хорон санаат ханхүүгийн гарт өгчихсөн учраас, бид Люсиферийн захиргаан дор байв (Лук 4:6-г үзнэ үү). Адамын дуулгаваргүй чанар бүх хүнд халдварлаж, бид нүгэлдээ ч, Люсиферт ч дарлуулсан. Люсифер биднийг эзэгнэх эрхээ мэдэгдэж, хэзээ ч тавьж явуулаагүй. Бид чөлөөлөгдөх ямар ч найдваргүй, түнэр харанхуй руу л унах тавилантай улс байв. Гагцхүү хэн нэгэн нь биднийг худалдаж аваад, өөрийн болгосон нөхцөлд л бид чөлөөлөгдөх байсан ч, үүнийг хийх чадал нь ч, мэдэл нь ч хүмүүнд байсангүй.

Тиймээс Бурхан бидний төлөөст Есүсийг явуулжээ. Бурхан “Учир нь амийн төлөөс нь үнэ цэнэтэй, Түүнийг мөнхөд төлж баршгүй” (Дуулал 49:8) хэмээн айлдсан учраас, Есүсээс өөр биднийг худалдаад авчих хэн ч, юу ч байгаагүй. Бурхан бидний сэтгэлийг Есүсийн амийн зэрэгтэй хэмээн өндрөөр үнэлжээ. Паул “Та нарыг үнэтэйгээр худалдан авсан тул биеэрээ Бурханыг алдаршуул” (1Коринт 6:20) гэжээ. Түүнчлэн “Түүний нигүүлслийн баялгаар бидэнд Түүний дотор цусных нь золилт, гэм нүглийн маань төлөөх уучлал бий” (Ефес 1:7) гэж ч хэлдэг.

Бурханы хувьд энэ дэлхий дээр Хүү Есүсээс нь үнэ цэнэтэй юм байтугай, хүн ч байхгүй. Гэтэл энэ наймаагаараа Бурхан биднийг Өөрийнх нь хамгийн үнэт зүйлээс ч үнэтэйг илэрхийлжээ. Энд нэгэн гайхамшигтай зүйл байгаа юм: Хэрэв бид Есүсийн үнэ цэнээс ганц центээр л хямдхан байсан бол, хэзээ ч ашиггүй наймаа хийдэггүй Бурхан Аав маань бидний төлөөст Есүсийг хэзээ ч өгөхгүй байх байв! Хямд барааг өндөр үнээр авах чинь угаасаа ямар ч ашиггүй наймаа. Тэгэхээр, та өөрийгөө Бурхан Аавдаа аль хэр үнэтэй болохоо харж байна уу? Есүс ч үүнийг батлан айлдсан: “Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд Надад өгсөн сүр жавхланг тань Би тэдэнд өгсөн билээ. Би тэдний дотор, Та Миний дотор. Ингэснээр тэд бүрэн төгс нэг болж, Та Намайг илгээсэн, *Намайг хайрласны адилаар тэднийг хайрласныг* ертөнц мэдэх болно” (Иохан 17:22-24, тодруулгыг нэмэв). Аав Есүсийг хайрладаг шигээ л биднийг ч хайрладгийг Есүс маш энгийнээр мэдэгдэв! Сонсож байна уу? Тэгэхээр, та өөрийнхөө жинхэнэ үнэ цэнийг харж байна уу? Бурхан Аав яагаад тантай хөөцөлдөөд байгааг ойлгов уу?

“ТИЙМ Л ДЭЭ. ГЭХДЭЭ БИ ЧИНЬ ТҮМНИЙ Л НЭГ”

Зарим чинь “Тийм ээ, Бурхан энэ бүхнийг нийт хүн төрөлхтний төлөө үйлдсэн. Надад тэдний дундаас онцгойроод байх юм байхгүй” гэж ирээд л маргах байх. Тэгвэл, та энэ дэлхий дээр амьдардаг цорын ганц хүн

байсан ч, Бурхан таныг ийм өндөр үнээр аврах л байсан гэж хариулъя. Үүнийг Есүсийн үйлчлэлээс ч тодорхой харж болно. Есүс өдөржин Бурханы Хаанчлалын талаар олон түмэнд заасан. Есүс ядарсан. Гэхдээ Түүнд хойшлуулж болохгүй нэгэн зүйл байв. Ариун Сүнсний удирдамжаар, Есүс дагалдагч нартаа завиараа Галил нуурын нөгөө эрэг рүү явцгаая хэмээв. Нуурын дунд хүрч явтал, дагалдагч нарынх нь амь насанд осолтой, хүчит шуурга дэгдсэн. Гэвч Есүс ядарсандаа унтаж байсан. Ухаан алдталаа айсан дагалдагч нар Есүсийг сэрээгээд, аюулыг зайлуулахыг гуйхад, Есүс давалгаа, салхинд намжихыг тушаасан.

Тэд шөнөжин явсаар, осолтой нуурыг гатлав. Ийнхүү нөгөө эрэгт хүрээд, одоо л жаал алжаалаа тайльюу гэтэл, өөдөөс нь чөтгөрт автсан галзуу хүн гараад ирдэг. Тэр хүн хадан булшин дунд амьдарч, гинжинд ч номхролгүй, өдөржин, шөнөжин хадан булшин дундуур хашхичин, чулуугаар биеэ сийчэж явдаг аж (Марк 5:3-5-ыг үзнэ үү).

Өнөөдөр байсан бол, хөөрхийг галзуугийн эмнэлэгт ганцаарчлан хорих байсан байх. Гав ганцааранг нь байлгаж, элдэв эм тариа шахах байсан байх. Алчих нь хуулиар хориотой учраас, нийгмээс тусгаарлаад, амьтай төдий л байлгах байх. Тийм хүн нийгэмд өчүүхэн ч хэрэггүй. Тэр юу ч биш. Маш цөөхөн хүн л түүнд санаа тавих биз.

Тийм боловч, яг тийм галзуу хүн Аав, Есүс, Бурханы Сүнс гуравт асар үнэ цэнэтэй байсан юм. Есүс түүнд хүч чадалтайгаар үйлчилсэн. Тэр их хүчирхэг чөлөөлөлтийн ачаар мөнөөх хүн нар жаргахаас өмнө Есүсийн дэргэд хувцас хунартай, саруул ухаантай болоод сууж байв. Тэгэхээр, хамгийн онц сонирхолтой нь: “Есүс завиар нөгөө эрэгт *дахин* гаталж иржээ” (Марк 5:21) гэдэг хэсэг болно. Бурхан надад үүнийг ухааруулсан тэр өдрийг би хэзээ ч мартахгүй. Салаад уначих шиг л болсон доо. Нийгэмд хог шаар мэт үзэгдсэн, галзуу солиотой ганц хүнийг аврахын төлөө Есүс өдөржин үйлчлээд, шуургачиж унатлаа ядарсан атлаа шуурган дундуур тэмцэн байж нуурыг гаталж очоод, эргээд завиндаа суугаад буцаад явсныг нь ухаарахдаа, би зог тусч билээ. Ганцхан хүний төлөө шүү дээ! Тэгээд бүр галзуу хүний төлөө!

Энэ ойлголтоос хойш энэ дэлхий дээр надаас өөр хүн байхгүй байсан ч, Есүс намайг хайсаар ирээд, төлөөсийг минь төлөөд, надтай нөхөрлөх байжээ гэдгийг бүрэн ухаарч билээ. Есүсийг мэндэлсэн орой тэнгэрэлч нар дэлхий дээр тогтох энх тайван, хүн төрөлхтөнд ирэх сайн сайхныг тэмдэглэн дуулж байсан нь ийм л учиртай! Бурхан биднийг гэх зүрх сэтгэлээ дэлхийд илчилсэн байв!

ЕСҮС ХҮН НЭГ БҮРИЙГ ХЭРХЭН ҮЗДЭГ ТУХАЙ

Итгээд удаагүй байхдаа би Эзэнээс энэ талаар нэгэн хүчирхэг илчлэл хүлээн авч билээ. Машинаа бариад, Эзэнтэй ярилцаж явтал, Эзэний огцом айлдсан нэгэн үг миний сэтгэлгээг цочир өөрчилсөн юм. Тэрбээр зүрхэнд минь: “Жон, Би чамайг Өөрөөсөө дээгүүр үнэлдгийг чи мэдэх үү?” хэмээв.

Би ч энэ үгийг сонссон даруйдаа тэрүүхэн хооронд чухам ямар ч утгагүй, тамаас гарвалтай, жигшүүртэй, хийсвэр санаа л гэж үзэв. Тэгээд золтой л: “Сатан аа, миний ард гар!” гээд хэлчихсэнгүй. Гэхдээ зүрхнийхээ угт Эзэнийхээ дуу хоолойг таниад л байлаа. Тэгээд аюулгүй байдлыг баталгаажуулдаг бат аргаа хэрэглэв: “Эзэн минь, энэ чинь итгэхүйеэ бэрх үг байна. Тэнгэр газрыг бүтээсэн Эзэн Есүс минь, Та над шиг горьгүй хүнийг Өөрөөсөө чухалд тооцох нь цээртэй мэт санагдах. Тиймд Та наад үгээ Шинэ гэрээний гурван эшлэлээр баталсан нөхцөлд л би энэ санааг хүлээж авъя.”

Ингэж хэлснийхээ дараа Бурхан таатай байгааг мэдэрсэн бөгөөд тэр даруй зүрхэндээ “Филиппой 2:3 дээр юу гэдэг сэн билээ?” гэхийг сонслоо.

Би энэ эшлэлийг мэдэх учир: “Юуг ч аминч санаархал эсвэл ихэрхэг зангаар бүү хий. Харин даруугаар бие биенээ өөрөөсөө дээр гэж үз” хэмээн чангаар хэлэв.

Эзэн ч надад: “Энэ эхний эшлэл чинь” хэмээлээ.

Би ч өөдөөс нь: “Эзэн минь, энэ чинь Филиппойн итгэгч нарт бие биеэ өөрөөсөө дээгүүр үзэхийг сургасан Паулын үг. Энэ чинь Та, бид хоёрын харилцааны тухай биш” гэж ирээд л үгээр тулав.

Гэснээ тэр даруй: “Хүү минь, Би Өөрөө хийдэггүй юмаа хүүхдүүддээ тушаахгүй!” гэхийг нь сонслоо. Тэгээд дараа нь Эзэн надад олон олон гэр бүлийн асуудлыг харуулав. Аав ээжүүд өөрсдөө сахидаггүй зүйлээ үр хүүхдээсээ шаарддаг бол, Эзэн Өөрөө үлгэрлэн харуулдаггүй юмаа биднээс шахан шаарддаггүй.

Би ч санааг нь ойлгов. Гэхдээ л Бурхан намайг Өөрөөсөө дээгүүр үздэг гэдэгт нь бас л үнэмшиж өгсөнгүй. Тэгээд: “Эзэн минь, энэ чинь ганц л эшлэл. Дахиад хоёрыг хэлнэ үү” гэлээ. Энэ маань үл хүндэтгэсэн бус, болгоомжилсон явдал байв.

Тэгтэл Эзэн надад: “Жон, загалмай дээр хэн өлгүүллээ, чи юу Би юу?” хэмээн асуултаар хариулсан нь миний зүрхийг бэмбэгнүүлэв.

Миний сайн мэддэг тэр үнэн энэ удаа намайг дэлсээд авахдаа,

хавьгүй бодитой болж буусан тул би шууд л: “Та, Есүс ээ” хэмээн үг дуугүй зөвшөөрлөө.

Эзэн цааш нь: “Загалмай дээр чи өлгүүлэх ёстой байсан ч, чиний нүгэл, шүүх, эмгэг, өвчин, зовиур, ядуурлыг Би үүрсэн. Би чамайг Өөрөөсөө дээгүүр үздэг учраас л тэр” хэмээв.

Би ч Эзэнийхээ үгийг сонсохдоо, бэмбэгнэж байлаа. Түүний Үг бүх эргэлзээг туув. Үнэндээ Эзэн тэгэх ёсгүй байсан. Эзэн маань зөвт бөгөөд гэмгүй байсан. Миний санаанд 1Петр 2:24 буув: Биднийг нүгэлд үхүүлж, зөвт байдалд амьдруулахын тулд Тэр Өөрөө бидний нүглийг модон дээр биедээ үүрсэн. Учир нь та нар Түүний шархаар эдгээгдсэн билээ.

Эзэн үнэхээр намайг Өөрөөсөө дээгүүр үздэг болохыг одоо би бат мэдэв. Тэгээд асгартал уйлан, хүндэтгэлээ. Дотроо гуравдугаар эшлэл айсуу гэдгийг мэдэж байсан бөгөөд Эзэн ч зүрхэнд минь: “Ром 12:10 дээр юу гэдэг билээ?” хэмээн айлдлаа.

Мөн л танил эшлэл байсан тул: “*Ах дүүсийн хайраар бие биенээ хайрла. Бие биенээ өөрсдөөсөө дээгүүр дээдлэн хүндэл*” хэмээн цээжээр хэлэв.

Гэтэл Эзэн: “Би ах дүүсийнхээ Ууган нь бус уу? (Ром 8:29). Би ахан дүүсээ Өөрөөсөө дээгүүр үздэг” хэмээв.

Есүс бидэнд хайртай байсан гэдэг үгийг би зөндөө л сонсож явсан. Гэхдээ Эзэн надтай ингэж ярилцсаны дараа Бурханд ганц хүн хичнээн онцгой байдгийг бодитоор ухаарсан юм. Үнэндээ, Бурхан гэр бүлийн гишүүдээ Миний эрдэнэ гэдэг. Биднийг онцгой гэдэг. Нүдний минь алим гэдэг. Үүнийг ойлгох гээд хичээгээд үзнэ үү: Бид Бурханы мэлмийн баясал! Тийм ээ, доорх үзэсгэлэнт үнэнийг сонсоно уу: “Чиний Бурхан ЭЗЭН, аврагч дайчин, Та нарын дунд байна. Тэр та нарын дээр баяр хөөртэйгөөр баясна. Тэр хайр дотроо чимээгүй байна. Тэр та нарын дээр баярын уухайгаар баясах болно” (Зефаниа 3:17).

ХҮН ГЭЖ ЮУ ВЭ?

Сүр жавхланта, ариун Бурхан эгэл хүмүүст анхаарахыг нь тэнгэрэлч нар сонирхон ажина. “Таны мутрын бүтээл тэнгэрсийг, Таны цогцлоон байгуулсан сар, оддыг Би тунгаан бодму. Хүн гэгч юу болоод Та түүнд санаа тавьж, Хүмүүн гэгч юу болоод Та түүнийг анхаарна вэ?” (Дуулал 8:3-4). Энэ үгийг Давид бичсэн боловч, Эзэн Давидад Өөрийнх нь сэнтийг хүрээлэн орших, хүч чадалт тэнгэрлэг оршигчдын бодол

санааг сонсгожээ гэмээр. Хүч чадалт Бурхан ертөнцийг туурвихыг нь тэнгэрэлч нар үзсэн. Солигдох эгшин бүр Бурханы цоо шинэ алдрыг илчлэн гийгүүлэх тул, тэнгэрэлч нар улам бүрий Бурханыг биширсэндээ, нэг ч амсхийлгүйгээр “Ариун, ариун, ариун” хэмээн өнийн мөнхөд өөр хоорондоо дуу уралдуулан магтахаас өөрийг хийж эс чадна. Тэдний тэнхээ мэдэн хашхиралдах дуунд сэнтийн өрөөний (энэ нь дор хаяж арван сая хүний суудалтай танхим шүү!) үүдэн хаалга нь доргих. Гэтэл энэ ер бусын, цог жавхлант, яруу алдарт Бурхан юуны учир хүмүүнийг бодож явдагт тэнгэрэлч нарын гайхаш төрнө. Хүмүүнд хандсан Бурханы хайр, сайн сайхан бодол нь газрыг хучсан элсэн манхан далайнаас ч аугаа учир, тоолох ч боломжгүй гэх. Тэнгэрийн тэр элч нар үүнд гайхах!

Хүмүүн - бид Бурханы хамгийн үнэт хөрөнгө нь; хайж хайж Өөрийн болгосон эрдэнэс нь - Бурханы орших дуртай сүмийг бүтээгч амьд чулуунууд болой. Бурхан яагаад биднийг ийн үздэг юм бол? Бид ийм хайрыг хүртэх юу хийсэн юм бол? Энэ бол хамгийн аугаа үнэн. Бид Бурханы ийм хайр, нэхлийг хүртэхээр ёстой юу ч хийж гийгүүлээгүй билээ. Яагаад гэвэл биднийг нөгөө л алийгаа алдсан, төөрсөн нүгэлтэн - дайсан байхад л Бурхан Өөрөө биднийг эрэн хайсаар, олж авсан юм. Бурхан биднээс гагцхүү Бурханы хайр л олж харж чадах зүйлийг олж харжээ. Тэр их ялзрал, нүгэл, завхрал дундаас Бурхан эрдэнийн чулууг олж үзжээ. Хүний хямдхан юмуу эсвэл бүр сохор зоосны ч үнэгүй хэмээн тооцохоор юмыг Бурхан үнэтэй хэмээн худалдаж авчээ. Бурхан бидний байж байгаа царайг нэвтлэн хараад, нигүүлслээр бүтээж болох үр дүнг нь үзжээ.

Тэгэхээр, одоо бид “Та нарыг үнэтэйгээр худалдан авсан юм. Хүмүүсийн боол бүү бологтун” (1Коринт 7:23) гэдэг Бичээсийн үгийг арай бодитой ойлгохоор боллоо. Ийм өндрөөр үнэлэгдэж, хайрлагдсан атлаа жинхэнэ үнэ цэнийг минь цөлмөгч, адлагч, боолчлогч тэр хуучин систем рүү эргэхийг хүсдэг хүн байх уу?

Бидний Бурхан даяар ертөнцийн хамгийн алдар суутай Нэгэн атлаа бидэнтэй улайран хөөцөлддөг, бидний хамгийн дотно Нэгэн болохыг мэдсэн хойно ч Бурхантай дотносох урилгаас татгалзах хэрэг үү? Гагцхүү хамгийн бодлогогүй этгээд л ингэж магадгүй тул Бурханд татгалзаж болохгүй.

(Чухал тэмдэглэгээ: Бурхан бидний араас явдаг хэдий ч, бид Бурхантай харилцаа тогтоохын тулд Түүнд хариулах ёстойг Бичээс заадаг. Та өмнө Есүс Христийг өөрийнхөө Эзэн бөгөөд Аврагчаар хүлээж аваагүй бол, яг одоо тус номын арын нүүрэн дээрх А Хавсралтыг үзнэ үү.)

СУДЛАХ АСУУЛТ

1. Израилийн үр сад Египетийн дөрвөн зуун жилийн дарлалаас чөлөөлөгдөхдөө, тэднийг чөлөөлсөн Бурханы гол зорилгыг ойлгоогүй. Эзэн “Би та нарыг Өөр дээрээ авчирсан” гээд байхад л, Бурханы амласан газрыг л хүссэн тэр хүмүүс гомдол гарган гонгиносон. Тэдний зүрх Хэнийг бус, юуг өвлөх дээр төвлөрөөд байсныг зохиолч хэлжээ.

Бурхан таныг Өөр дээрээ авчрахын тулд нүглийн хүлээсээс чөлөөлсөн. Та гомдол гарган, гонгинож үзсэн үү? Хэн гэдгийг юу гэдэгтэй андуурч явсан уу?

2. Энэ бүлэг дээр “Ийм өндрөөр үнэлэгдэж, хайрлагдсан атлаа жинхэнэ үнэ цэнийг минь цөлмөгч, адлагч, боолчлогч тэр хуучин систем рүү эргэхийг хүсдэг хүн байх уу?” гэж асуусан. Энэ асуултад та юу гэж хариулах вэ?
3. Зохиолч аврагдсаныхаа дараах нь Эзэний мэлмийд хичнээн үнэ цэнэтэй болох талаар Бурхантай ярилцсан тухайгаа хуваалцсан. Та бол “хайж хайж олж авсан, өндөр үнэтэй эрдэнэ” гэдэг мэдлэг нь таны амьдрал, харилцааг хэрхэн өөрчлөх бол?

Гуравдугаар бүлэг

БУРХАНААР ЦАНГАЖ ЯВ



Юугаар тэжээгдэнэ - түүгээрээ өлсөнө.

Аврагдаагүй хүн амьд Бурхан руу ойртохоос өмнө, Эзэн Өөрөө түүн рүү ойртох ёстой. Эй. Даблю Тозер гуай “Нүгэлт хүн Бурханы зөв бодлыг бодож чаддаг болохоос өмнө түүн дотор гэгээрлийн ажил өрнөх ёстой” гэжээ (*The Pursuit of God* номын 11-ээр хуудас). Есүс Өөрөө “Намайг илгээсэн Эцэг хэн нэгнийг тагахгүй л бол хэн ч Над уруу ирж чадахгүй” (Иохан 6:44) хэмээн айлдсан. Тиймээс л Есүсээр дамжин Бурхантай харилцаа тогтоогоогүй хүмүүсийн төлөө зуучлан залбирах нь амин чухал байдаг. Хэдийгээр Бурхан Өөрөө “бүх хүн аврагдаж, үнэний мэдлэгт ирэхийг” (1Тимот 2:4) үнэн голоосоо хүсч, түүхэн эхлэлээс өдийг хүртэл үүнтэй л хөөцөлдөж яваа ч, үр хүүхэд нь ч бас Аавынхаа зүрхний хүслэнг өвлөж аваад, төөрөгсдийн төлөө энэлэн залбирдаг байгаасай гэж хүснэ. Тиймдээ ч Есүс “Ургац арвин ч ажилчид цөөн байна. Тиймээс ургацдаа ажилчид явуулахыг ургацын Эзэнээс гуйцгаа” (Матай 9:37-38) хэмээсэн.

Есүсийн илчлэлээр нэгэнт аврагдсан бид Бурхан руу чөлөөтэй нэвтрэх эрхтэй болдог. Бурхан ч Өөрийнхөндөө “Над руу ойрт” гэдэг. Бурхан хамгийн аугаа түүхэн урилгаараа эхний алхмыг хэдийнээ хийсэн билээ. Бут шатаж байна... Бурхан бидний нэрийг дуудаж байна... Эзэн завины гадна байна! Бидний хариуг хүлээж байна!

Саяхан нэгэн итгэгч: “Жон, нас явах тусам, Бурханд үйлчлэх тусам

нэг зүйлийг ойлголоо. Бурхан биднийг Өөртөө хэдий чинээ ойртуулна - бид төдий чинээ л Бурхантай дотносдог болтой” гэж билээ.

Тэгэхээр нь би: “Наадах чинь буруу” хэмээн хариу довтлов.

Тэгтэл мань хүн “Аав хүнийг татахгүй л бол, хэн ч Түүн рүү ирж чадахгүй” гэсэн Есүсийн үгийг эшлэж байна аа.

Би өөдөөс нь: “Тийм ээ, наадах чинь үл итгэгчдийн хувьд үнэн. Гэхдээ Бурхан таныг Өөрийнхөө гэсэн. Тэгээд “Надад ойртох аваас, Би чамд ойртоно” гэдэг. Бурхан биднийг хэзээ л бол хэзээ түрүүлж ойртож болно гэсэн байна шүү дээ” гэж хариулсан юм.

Тийм ээ, заримдаа үнэхээр Бурхан бидэнтэй яаралтай уулзахыг хүсбэл, Өөрөө санаачлан уулздаг. Гэхдээ, энэ нь бид Бурхан руу түрүүлж ойртож болохгүй гэсэн үг биш. Бид чинь Бурхан Аавтайгаа харилцаа тогтоосон үр хүүхэд нь. Аав - хүүгийн эрүүл харилцаанд заримдаа аав нь хүүгээ дуудаж холбогддог бол, заримдаа хүү нь аавыгаа дуудаж холбогддог бус уу?

ЯАГААД ОЛОН ХҮН БУРХАНЫ УРИЛГАД ХАРИУЛДАГГҮЙ ВЭ?

Нэгэн ярвигтай асуудал бий: Яагаад үй олон итгэгч хүн Бурхантайгаа өнгөц харилцаатай байдаг вэ? Яагаад бид Бурхантайгаа гүн гүнзгий, бат бөх харилцаанд нэвтрэхгүй байна вэ? Юу хойш нь татна вэ? Яавал дүрэлзэж, Бурхантай дотносох дуудлагад хариулах вэ? Хариулт нь тун энгийн: Хамаг учир нь ердөө л Бурханаар цангах үгүйд л оршиж байгаа байхгүй юу. Давид:

Бурханаар, амьд Бурханаар

Сэтгэл минь цангамуй

Би хэзээ явж, Бурханд бараалхах вэ?

Хүмүүс надад

“Чиний Бурхан хаана байна?” гэж өдөржин хэлэхэд

Нулимс минь өдөр шөнөгүй миний хоол болов.

Урьд нь би баяр тэмдэглэж буй олон түмний дунд явж,

Баяр хийгээд талархал өргөх уухайгаар

Тэднийг Бурханы өргөө уруу

Цуваагаар дагуулдаг байлаа.

Эдгээр зүйлийг л би санаж,

Сэтгэлдээ шаналан өвдөж байна

Бурханаар цангаж яв

(Эдгээрийг санахдаа би дотор сэтгэлээ уудлах юм)
(Дуулал 42:2-4) хэмээн уйлсан байдаг.

Цааш явахаасаа өмнө дээрх эшлэлийн үг бүрийг шингээн, тогтож уншина уу. Давид “Эдгээрийг *санахдаа* би дотор сэтгэлээ уудлах юм” гэжээ. Санахыг Еврейгээр *закар* гэнэ. Тэгвэл Грек үг нь Англитай адил зүгээр нэг “санах” бус, харин “бодолдоо тээж, хадгалах” гэсэн утга агуулдгийг Даблью. Ий. Уайнс хэлжээ. Давид ч ийм утгаар л өгүүллүүн. Тэрбээр үнэндээ “*Бодол дотроо Бурханыг хүссээр байх минь* намайг дотор сэтгэлээ уудлахад хүргэх юм” гэжээ. Энэ бодол Давидыг Бурханаар ханашгүйгээр цангахад хүргэж! Энэ цангаа л биднийг сүнсний, оюуны, биеийн - алив саад тотгорыг үл ажран, Бурхан руу ойрт хэмээн далладаг. Тиймээс Бурханаар цангаж явах төдийгүй, цангаагаа ахиулах нь чухал ажээ.

ЭЗЭН МИНЬ, МИНИЙ ЦАНГААГ АХИУЛААЧ!

Олон хүн “Эзэн минь, миний цангааг ахиулаач” гэж залбирдаг. Гэвч энэ нь оновчтой санаа биш юм. Цангааг Бурхан биш, бид өөрдсөө л шийднэ. Манай Америк эд хөрөнгө, зугаа цэнгэл, таашаал, баялгийн оргилдоо тулжээ. Тэгвэл Бурханаар цангах цангаагаа гүнзгийлж, хамгаалах ганц зам нь сэтгэлээ ямар юмаар дүүргэхээ шийдэн, хамгаалж явах арга юм. Сургаалт үгс 27:7 “Цатгаланд сархинагийн бал ч амтгүй, өлссөнд гашуун юм ч чихэрлэг” гэдэг. Товчхондоо сэтгэлээ зовнил, таашаал, эд баялгийн хайр, энэ дэлхийн хүслээр дүүргээд байвал, бялуурсан сэтгэл чинь Бурхантай тогтоох нөхөрлөлийн сархинагийн бал мэт амтыг жигшинэ.

Талархлын баярыг аваад үзье л дээ. Америк айлууд халуун бүл, найз нөхдөөрөө цуглаад найр хийдэг. Олон хүн орой найрлахын тулд өглөөний хоолоо ч өнждөг. Найр эхэлнэ: том цацагт хяруул, хачир, чихэрлэг төмс, ногоо, цангисийн сүмс, жигнэмэг тэргүүтэн өрөөстэй. Хоолны дуршил нэмэгдсэн учраас, бид ч цүдийтлээ иднэ. Идэж дуусаад ёлно. Жинхэнэ утгаараа гэдэс гарна! Тэгээд хэдэн цагийн дараа хамаатныдаа зочилно. Дахиад л сүр жавхлантай найрын ширээ! Энэ удаа бүр ч тансаг зоогоор дайлсан ч, бид дурлан зооглохын оронд ярвайж, татгалзана. Өмнөх хоолоо шингээж чадахгүй, яая гэж яваа бид тэр тансаг зоогийг нэг хараад л болих минь гэж бодно. Зоогийн амт чанар өндөр байхаас үл хамааран, бид жигшинэ. Сургаалт үгс чухам үүнийг л хэлжээ.

Цаашаа явахаасаа өмнө энэ ойлголт пропорционал гэдгийг мэдэх хэрэгтэй. Амьдралын дур хүслээр цүдийж унжсан сэтгэлтэй хүн найрын ширээний тансаг зоогийг жигшдэггүй юм аа гэхэд, ядаж

ойшоож үзэхгүй. Хоёр цагийн өмнө түнтийтлээ чихэлгүй, тааруулж идсэн хүн ч хожмын тансаг зоогийг жигшдэггүй юм аа гэхэд, зүгээр л амсах юмуу талархаад өнгөрөх байх. Миний бие аль нэг хотод айлчлах үеэрээ үнэтэй сайхан ресторанд уригдахдаа, хоёр цагийн өмнө юм идээд, өлсөөгүй явж байвал, эелдгээр татгалзаад л өнгөрдөг. Талархлын баярын зоогийн түүх шиг учиргүй дургүйцэхгүй ч, зүгээр л идэх хүсэлгүй учраас, иддэггүй. Тэгвэл хоёр хоног хоолгүй явсан хүнийг тэр зоогоор дайлбал, тэрбээр шал өөрөөр хандана. Тэр хүн таны үл тоох хоолонд шунан дурлана. Тэгэхээр, хүн амьдралын аахар шаахар юмст автсан хэмжээнийхээ хэрээр л Бурханы дуудлагад хариулдаг ажээ.

Чуулганы хүмүүс Бурханы юмсыг хүсч эрмэлзэх явдлыг ойшоохгүй байх нь олонтаа. Яахав, ихэнх нь Бурханы оршихуйг жигшихгүй ч, өмнө нь өрөөтэй байгаа найрын ширээний зоогт өлсөж цангасан хүн шиг шунан дурлахгүй. Аргагүй л дээ. Хоёр цагийн өмнө дэлхийн ширээнээс цадтал хооллочихсон юм чинь. Бурханыг хүсч байна гэж ярих нь ярьдаг ч, үйлдэл нь үгээсээ урваад байдаг. Та ч бас Бурханыг улам ихээр хүссэндээ л энэ номыг барьж авсан байх. Гэхдээ сэтгэл чинь Бурханыг хүсч байна уу? Та олон хоног хоолгүй өнжсөн хүн шиг эсвэл олон өдөр архины бараа хараагүй архичин шиг эсвэл яаралтай мансуурах хэрэгтэй донтогч шиг улайрч байна уу?

ҮЛ ОЙШООГЧ ЧУУЛГАН

Илчлэл ном дээрх сүүлчийн чуулганд айлдсан Есүсийн үгийг нарийн шинжлэх аваас, нэгэн гайхмаар баримтыг олж үзнэ. Нэгдүгээрт - Азийн долоон чуулганд дайсан Есүсийн үг нь тэдгээр түүхэн чуулганд төдийгүй, бидэнд ч хандсан үг юм. Эс бөгөөс Бичээст тэмдэглэхгүй байх байв. Бичээс дээр тэмдэглэгдсэн л бол, өнөөгийн бидэнд хүчин төгөлдөр хэрэгжих, эш үзүүллийн чанартай үгс гэсэн үг.

Эш үзүүллийн үг нь олон төрлийн хэрэгжилт, утга, биелэлтэй байдаг бөгөөд ийм байх нь ч олонтаа. Чуулган нэг бүрт хандсан захидал болгон нь бидэнд хамаатай үгс бөгөөд Есүсийг яг эргэж ирэхийн өмнө үеийн чуулганы нөхцөл байдлыг хөндсөн гэдэг утгаараа сүүлчийн чуулганд хандсан үгийг хамгийн сүүлд оруулсан байх магадлалтай. Захидлынхаа төгсгөлд Иохан “Эдгээрийн дараа би хартал, нээлттэй нэгэн үүд тэнгэрт байлаа. Анх надтай ярьсан *бүрэн дуу* мэт сонсогдсон тэр дуу —Нааш гараад ир. ...гэлээ” (Илчлэл 4:1, тодруулгыг нэмэв) хэмээсэн нь энэ утгыг төгөлдөршүүлж байх шиг. *Бүрээ* гэдэг үгийг тэмдэглэнэ үү. Эцсийн

өдрүүдэд Эзэн Өөрийнхэн дээрээ “тушаалын уухай, тэргүүн тэнгэрэлчийн дуу ба Бурханы *бүрэнээр* тэнгэрээс бууж ирэхийг” (1Тесалоник 4:16-17, тодруулгыг нэмэв) бид мэднэ. Дээрх чуулганд хандсан үг нь чухам бидний амьдарч буй энэ цаг үеийг онцгойлон хамаарна гэдэгт би итгэдэг.

Есүс тус чуулганы царцуу нөхцөл байдлыг мэдэгджээ. Одоогийнхоор бол час хийсэн хүсэлгүй, Бурханы чухалчилдаг юмсыг ойшоож үздэггүй, Бурханд таалагдахын төлөө амьдардаггүй гэсэн үг. Юунаас болж энэ вэ? Энэ чинь өөрөө өөрсдийгөө тодруулсан, Бурханы хүлээн зөвшөөрдөггүй чуулган бус, харин Есүсийн Өөрийн биеэр тодорхойлсон чуулган шүү дээ. Тэгвэл хариулт нь тэдний амьдралыг үзэх үзэлд орших ажээ. Есүс “Яагаад гэвэл чи “Би баян, хөрөнгөжсөн тул дутах зүйл ер байхгүй” гэдэг” (Илчлэл 3:17) гэсэн. Энэ үг тэдний үлбэгэр байдлаас нь урвуу байна - тэдний сэтгэл Бурханд бус, юмст ханажээ.

ӨНГӨЦ ОНОШ

Зарим хүн тэдний асуудлыг хэтэрхий их мөнгө, материаллаг эдээс болсон гэж үздэг. Гэвч энэ нь Есүсийн үгийг өнгөц дүгнэж байгаагаас цаашгүй юм. Жишээ нь Давид асар баян хүн байсан. Үнэндээ Давид Соломонд “зуун мянган талант алт, нэг сая талант мөнгө, жинлэж барахааргүй маш их хэмжээний хүрэл ба төмөр мөн мод болон чулуу” (1Шастир 22:14) гардуулж өгсөн атлаа өөрийгөө “Аяа ЭЗЭН сонор тавин надад хариулаач. Учир нь би *зовж, гачигдаж (ядуу бөгөөд дутуу гачуу)* байна” (Дуулал 86:1, тодруулгыг нэмэв) гэсэн байдаг. Давид өөрийгөө ядуу бөгөөд дутуу гачуу гэх! Тэнгэрээс эхтэй үгс нь худалгүй учраас, Давид энд эв найрамдлыг бодож ингэж хэлээгүй нь тодорхой. Давид жинхэнээсээ өөрийгөө ядуу бөгөөд дутуу гачуу гэж үзсэн бөгөөд энэ нь ч тэнгэрлэг цангаагаас төржээ. Түүний хашхирааг дахин нэг үзнэ үү. “Аяа ЭЗЭН сонор тавин надад хариулаач...” Давид Эзэнээс аргаа баран хариу гуйжээ. Давид дотнослоор цангах! Тиймээс л ийм халуунаар өгүүлдүүн: “Хүмүүс надад “Чиний Бурхан хаана байна?” гэж өдөржин хэлэхэд нулимс минь өдөр шөнөгүй миний хоол болов” (Дуулал 42:3).

Лаодикийн чуулганы асуудал нь материаллаг юмс бус, харин материаллаг юмсаар сэтгэлээ цатгасанд нь оршиж байв. Давид ийм юмыг хэзээ ч зөвшөөрөөгүй. Давид үлэмж баялгаараа сэтгэлийн дур хүслээ цатгаагүй. Гэтэл эд баялгаараа Давидад хол хаягдах Лаодикийн чуулган өчүүхэн юмандаа хахтал цадчихжээ. Энэ нь ч тэдний Бурханы оршихуй, нөхөрлөлд улайрах хүсэл тэмүүлэлд нь саад болжээ.

ЭРС ТЭС ЯЛГАА

Би ийм явдлыг өнгөрөгч хорин жилийн хугацаанд багагүй харсан. Нэг удаа Канадын Хойд нутгаар амьдардаг Крий гэдэг уугуул омгийнхон дээр зочлов. Тэд нутаг заалган суурьшсан сүүлчийн Хойд Америкийн уугуул омгийнхон. Үнэндээ тэр сайхан хүмүүс хорьхон жилийн өмнө л урцандаа амьдран сууж, хандгайн жимээр нүүдэллэдэг байжээ. Хөрөнгө чинээгүй, эгэл жирийн л хүмүүс. Тэд арваад жилийн өмнөөс л даруухан сууцандаа зурагт гэдэг юмтай болж эхэлжээ.

Цуглаанд маань мянгаад хүн оролцов. Би тэнд хэдхэн хонохдоо, нэг хачин үзэгдлийг анзаарч билээ. Тэнд байсан хориос дээш насныхан нь бараг бүгдээрээ Бурханы юмсаар ер бусаар цангасан хүмүүс байв. Хойд Америкийн бусад хүмүүстэй харьцуулах юм биш. Бурханыг таньж мэдэхийн бөөн бөөн хүслэн. Гэтэл хориос доош насныхан нь юугаар ч цангасан янзгүй, бүр нэг үл ойшоосон янзтай.

Нэг цуглаан дээр үгийн маш хүчирхэг тосолгоо буув. Том майхан дотор байсан хүмүүс ч зогсолтгүйгээр залгилж байлаа. Гэтэл нэг харсан чинь майхны гадна бас араар баахан үл тоосон, залхсан залуус. Яахав, залхмаар номлол байдаг л даа. Гэхдээ энэ тэс өөр тохиолдол байлаа. Ариун Сүнс ер бусын хүчээр Бурханы Үгийг тунхаглаж байв. Тэгсэн би нэг л мэдэх нь ээ, өөрөө ч мэдэлгүй, өлссөн хүмүүсийн эгнээн дундуур зүссээр майхны захад байгаа залуус дээр оччихсон зогсож байлаа. Тэгээд хүрч ирээд сонсохыг гуйж гувшсан боловч, тэд намайг яг л амьдрал мэдэхгүй, маанаг амьтан гэх шиг л ширтэж зогссон юм.

Яг тэр үед л би тэдний чөлөөт цамц, саравчтай малгайг анзаарав. Өмсгөл дээрх бичээс нь товойж гэрэлтээд унах шиг л болж билээ. Хувцас нь мэргэжлийн сагсан бөмбөг, Америк хөл бөмбөгийн олон янзын багийн лого тэмдэгтэй байлаа. Тэр хүүхдүүд зурагтаар үзэж байгаа юмсдаа цадаад, самуурч явдгийг нь Ариун Сүнс надад харуулав. Залуус өөрт ямар ч ашиггүй юмсаар сэтгэлийнхээ цангааг дарж явдаг нь даанч гунигтай! Гэтэл арай ахмад хүмүүс нь зурагтын дуршлаар өсөөгүй. Энэ явдал надад хориос дээш болоод доош насны хүмүүсийн ялгааг ухааруулж билээ.

Миний санааг зөвөөр ойлгохыг хичээгээрэй! Бидний өсөлт, цангаанд зурагт гэхээсээ зурагтын дуршил маань л хор хөнөөл болдог шүү. Манай гэр одоо зурагттай л даа. Гэхдээ гэрлээд олон жил зурагтгүй амьдардаг байлаа. Би чинь зурагтын олон төрлийн нэвтрүүлгээр боловсорч, гэгээрдэг хүн. Зурагтын ачаар л даян дэлхийн хэрэг явдалтай хөл

зэрэгцүүлдэг. Гэхдээ зурагт намайг тэжээж, цатгадаггүй. Зурагт миний дуршил биш. Би зурагт үзэв ч, Бурханы юмсыг үгүйлсээр, Ариун Сүнстэй харилцсаар байдаг. Хар бор амьдралтай тэр залуу хүүхдүүд дуршлаа ямар ч ашиггүй юмд өгчээ.

Энэ аяллын дараа би Америкийн баруун хойшоо аялсан юм. Намайг Тав дахь өдрийн орой номлохыг хүсэв. Цуглаан зөвхөн чуулганы хүрээнд болсон ч, тэнд өсвөр насны 500-700 хүүхэд оролцсон нь намайг алмайрахад хүргэв. Цуглааны дараа намайг хэдэн арван хүүхэд бүсэлж аваад л, сүнслэг юмсын талаар шалгааж билээ. Цагаа нэг хартал шөнө дунд болж байлаа. Тэгэхээр, би цуглаан тарснаас хойш Бурханы талаар маш удаан ярьсан байв. Эцэстээ би эрхгүй: “Ямар сайхан юм бэ! Та нар Бурханаар үнэхээр цангаж!” хэмээн дуу алдаж билээ.

Хүүхдүүд намайг маргааш явахаас минь өмнө хоолонд урив. Би татгалзаж чадаагүй учраас, хүүхдүүд рестораны дээд давхрын томуу өрөөг захиалаад, тэнд бидний яриа үргэлжилсэн юм. Үнэхээрийн сэтгэл сэргээм, шинэлэг үзэгдэл байв! Баруун Хойд нутгийн эдгээр залуус Улаан арьст залуусаас хавьгүй их юмтай атлаа Бурханаар хавь илүү цангаж байсан нь тэр хоёр бүлэг залуусын цочир ялгааг харуулах шиг.

Тэгвэл Баруун Хойд нутгийн чуулганы хориос дээш насныхан нь харин эсрэгээрээ залуус шигээ өлөн биш байв. Тэд яагаад намайг бүчсэнгүй вэ? Яагаад өсвөр насныхан нь томчуудаасаа олон байв? Магадгүй томчуудынх нь сэтгэл амьдралын зовнил, таашаалдаа дарагдчихсан байсан байх. Есүст итгэдэг гэгдэх тэр хүмүүсийн хувьд Бурханы юмс нь амьдралынх нь нэгээхэн хэсэг л болохоос биш, оройн дээд хүсэл нь байсангүй.

Гэтэл цуглааны дараа тус чуулганы залуусын пастор, тэргүүн пастор хоёртой уулзах үед л бүх зангилаа тайлагдсан юм. Тэргүүн пастор нь өөрийгөө томчуудынхаа дунд хувилсан бол, залуусын пастор нь өөрийгөө залуусынхаа дунд хувилсан нь тодорхой болов. Тэр үед Хосеа 4:9 нүдний минь өмнө бууж билээ: “Ард түмэн ямар байна, тахилчид ч тийн байна. (Ямар тахилч байна, тийм хүмүүс байна - тахилч нар нь ёрын муу учраас, хүмүүс ч ёрын муу байна) (ЭнЭлТи Библи). Тодруулбал “Ямар пастор байна, тийм хүмүүс байна” гэж хэлж болно. Пастор нь халуун хүсэлгүй бол, хүмүүс нь ч үл ойшоогч нар байна. Харин алсын хараа, амин хүслээр бялхсан тэр залуусын пасторыг Бурхан хөдөлгөсөн бөгөөд өнөөдөр тэр эрхэм олон хотод хүчирхэг үйлчлэл хийж явна.

ҮЛ ОЙШООГЧ ЧУУЛГАНД ХЭРЭГТЭЙ ЭМЧИЛГЭЭ

Есүс Азийн чуулганд хандсан үгээрээ чуулган дотор газар авсан яг энэ хайхрамжгүй явдлыг л нэр заан цохсон буюу. Түүний үгийг сонсоно уу.

Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь дууг минь сонсоод үүдээ нээвэл, Би дотогш түүн уруу орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно (Илчлэл 3:20).

Үйлчлэгч нар Бичээсийн энэ үгийг гол төлөв аврагдаагүй хүмүүсийг дуудахдаа л хэрэглэдэгт гайхах юм. Гэтэл Есүс ингэж хэлээгүй. Есүс энэ үгээрээ тухайн чуулганд, халуун хүсэлгүй итгэгч нарт л хандсан. Есүс: “Хэн нэгэн нь... сонсоод” хэмээн айлдсан байгааг тэмдэглэнэ үү. Тэгвэл бидний сонсголд юу саад хийнэ вэ? Цатгалан сэтгэл л Бурханы дуу хоолойг сонсоход минь саад хийнэ. Бурхан Мосег Египетийн нүд хужирлаж, сэтгэл татам юмсаас зайлуулан, цөлийн ар гүн руу илгээсэн байдаг. Бурхан ганцхан учралаараа Мосегийн сонирхлыг ховх сорсон бөгөөд Мосе дахиж хэзээ ч Бурханаас сэтгэл урваагүй - Египетэд эргэж очсон хойноо ч!

Есүс “дууг нь сонсоод, сэтгэлийнхээ үүдийг нээсэн хүний дотор ороод, тэдэнтэй хамт талх хугасалж иднэ” гэсэн. Есүс Өөрөө Амийн талх учраас, бидний сэтгэлийг “Амийн талхаар” гэжээх ажээ. Нэгэн орчуулга дээр “Миний дуудахыг сонсоод, үүдээ тайлбал, Би орж ирээд, бид анд нөхөд мэт хооллоно” гэдэг (ЭнЭлТи Библи). Энэ үг надад жигтэйхэн сайхан санагддаг. Яагаад гэвэл өнөө үетэй харьцуулахад, дээр үед хамтдаа хооллох нь хүмүүсийн хамгийн дотно харилцааг илтгэдэг байлаа. Би аялахдаа, тухайн газраас явахаасаа өмнө тэр конференцийн удирдагч, пастортай заавал хооллохыг хүсдэг. Учир нь бид ингэж нөхөрлөхдөө л бие биеэ дотно таньдаг. Өөр ямар ч газраас илүүтэй хоолон дээр л хамгийн том солилцоо өрнөдөг. Тиймээс л Паул “өөрийгөө итгэгч гэх атлаа нүглээ үйлдсээр байдаг этгээдтэй хооллож болохгүй” гэжээ (1Коринт 5:11-ийг үзнэ үү). Бид хоолон дээр л зүрх сэтгэлээ нээж, дотносдог учраас, цайрчихсан тэрслүү этгээдтэй ийм солилцоо хийх нь сүнсний хувьд эрүүл бус юм.

ЮУГААР ТЭЖЭЭГДЭНЭ - ТҮҮГЭЭРЭЭ ӨЛСӨНӨ

Бурхантай дотносох хүслийн маань хэмжээг тодорхойлох гол бүтэц нь цангаа юм. Тиймээс бидний дуршлыг Бурхан бус, бид өөрсдөө л хянадаг болохыг санаж яваарай. Тэгэхээр, нэг асуулт байна: Бид ямар төрлийн дуршил хөгжүүлэх гэж байна? Учир нь хэзээ ч өөрчлөгдөшгүй сүнсний нэгэн зарчим байдаг нь:

Бид юугаар тэжээгдэнэ - түүгээрээ өлсөнө.

Миний бие 1979 онд коллежийнхаа хуурай ахан дүүсийн дотуур байранд байхдаа Есүст итгэж байлаа. Нэг удаа байрныхаа гал тогоонд идчих юм хайж байтал, “Чиний бие - Миний сүм учраас, тордоорой!” гэж хэлэхийг сонсож билээ.

Тэр үед би “түргэн хоолны мангас” байлаа. Ямар нэгэн юманд донтчихсон хүнийг *мангас* л гэвэл зохих байх. Дуртай учраас л эрүүл бус хоол иднэ. Хийжүүлсэн ундаа, чихэр, түргэн хоол, хөөмөл цагирган боов, өөх тос ихтэй хоол, цагаан гурилан бүтээгдэхүүн гэх мэт дандаа болж бүтэхгүй бүгдийг иднэ. Дуршил маань ч хамгийн л эрүүл бус гэгдэх бүхэнд хөдөлнө. Том бургер, кола, шарсан төмс л миний дурлалт хоол байлаа.

Гэтэл Бурханы тэр үгээс хойш миний бие чинь минийхээс гадна Бурханы Сүнсний гэр болохыг ухаарсан юм. Тухай нь, би үнэтэй машиндаа хэзээ ч хог хольцтой, муу шатахуун, дахин хэрэглэсэн тос хийхгүй шүү дээ. Машинаа урт удаан хэрэглэж, сайн сайхан байлгахын тулд хамгийн л чанартай шатахуун, тос хийнэ биз дээ. Тэгээд ч машиныг дахиад авч болдог бол, миний бие чинь орлуулагдашгүй, цорын ганц хувь шүү дээ. Тэгээд тэр даруй идэж уух хэв маягаа өөрчилж эхэлж билээ. Бие маань дээд хүчин чадлаараа ажиллаж, урт наслахын тулд биед минь юу хэрэгтэй болохыг асууж, судлаж гарав. Энэ бүхэн үргэлжилсэн үйл явц байсан болов ч, хэдэн жилийн дараа миний идэж уух хэв маяг бүрэн өөрчлөгдөж билээ.

Гэтэл миний мэдээгүй өөр нэгэн нэмэгдэл ашиг гарсан байв. Эрүүл хоол нь анх амнаас уначих гээд муухай санагддаг байсан ч, биед хэрэгтэй учраас, идсээр байлаа. Хэсэг хугацааны дараа миний дуршил өөрчлөгдөж эхлэв. Өмнө нь надад түргэн хоол юмуу шинэхэн ногооны салат, загас, бүхэл үрийн талх бүхий эрүүл хоол өгсөн бол, би шууд л эрүүл хоолноос таггалзаад, бургерийг нь шүүрэх байв. Харин өнөөдөр

би түргэн хоолыг нь авч хэлэлцэх ч үгүй, шууд л эрүүл хоолыг нь сонгоно. Үнэндээ өнөөдөр аялж явахдаа, түргэн хоолноос өөр хоол олдохгүй бол, би юу ч идэлгүй явчихдаг. Түргэн хоол идсэнээс өлсөж явсан нь дээр байх аа. Би түргэн хоолонд шунахаа бүр больсон! Үнэндээ шал дургүй болсон!

Тэгвэл сэтгэл тал дээр ч яг ижил зарчимтай. Сэтгэл маань тэжээгдэж байгаа зүйлдээ л шунана. Спортын дуршилтай бол, ESPN сувагт шунана. Холливүүдийн киноны дуршилтай бол, киноны суваг, сэтгүүл, ярианд л шунана. Бизнесийн ертөнц, сүүлийн үеийн үйл явдлаар тэжээгддэг бол, түүгээрээ л цангана. Гэр орон, машин, хувцас гэх мэтэд цаддаг бол, дэлгүүр хэсэх, шинэ машин авах, засал чимэглэл гэхээр л нүд чинь асах бөгөөд сүнслэг юмсын талаарх яриа ямар ч утгагүй санагдана. Бичээс унших, ганцаараа залбирах гэж үйлээ үзнэ. Харин Бурханы үгээр тогтмол хооллодог бол, залбирах цаг гаргах нь амархан, сүнслэг юмсын талаар ярих нь зовлонгүй, аяндаа л урсана. Бурханы оршихуйд шунаж, Бурхантай дотносохыг хүснэ.

ЭРҮҮЛ БУС ТУЙЛ

Гэхдээ эрүүл бус туйл руу хадуурах явдал бас гарна аа. Бид чинь бодитой бие дотор амьдардаг хүмүүс. Бидэнд үе үе эрүүл зугаа, цэнгэл хэрэгтэй. Миний бие Библийн сургуульд байхдаа, долоо хоногт дөчин дөрвөн цаг ажиллаад, хажуугаар нь баахан хичээлтэй байлаа. Нэгэн Бүтэн сайн өдөр өрөөний найз минь намайг хамт хөл бөмбөг тоглоё гэв. Би ч Библиэ уншиж, залбирмаар байсан болохоороо, татгалзлаа. Тэгээд яваад Библиэ уншаад, залбирах гэсэн чинь... таг! Бурханаас юу ч сонсдоггүй. Уншаад байгаа үг маань ямар ч утгагүй, хөндий хоосон санагдана. Өрөөний найз маань яваад цаг гаруй болжээ. Би ч: “Эзэн минь, би яагаад Бичээсээ уншиж чадахгүй, Таны дууг ч сонсож чадахгүй байна аа? Яах нь энэ вэ? Би Танд таагүй юм эсвэл гэм хийчихсэн үү?” гэж ирээд л уйлан дуу гаргалаа.

Гэтэл Эзэн надад: “Явж, хөл бөмбөгөө тогло” гэх нь тэр.

Би ч зог тусаад: “Юу! Хөл бөмбөгөө тогло оо? Тэр чинь миний итгэлийг байгуулахгүй, Тан руу ч ойртуулахгүй! Та яаж надад ийм үг хэлдэг байна аа?” л гэлээ.

Эзэн намайг дараах эшлэл дээр авчиртал, энэ эшлэл миний өмнө амилаадахаг. “Олон ном зохиоход төгсгөл үгүй ба үлэмж *их сурах нь бие махбодод халтай*” (Номлогчийн үгс 12:12, тодруулгыг нэмэв). Бурхан надад: “Хүү минь, чи биет бие дотор амьдардаг (түүний нэгээхэн хэсэг нь

тархи) бөгөөд биед чинь төрөл бүрийн амралт хэрэгтэй. Шаардлагатай амралтыг нь олгохгүй бол, Надаас сонсож, өсөх чадвараа боогдуулна” хэмээв. Тэгээд Есүс олон түмэнд үйлчилсэн дагалдагч нартаа: “Та нар зэлүүд газарт оч. Жаахан амар” (Марк 6:31) гэсэн байдгийг харуулж билээ. Товчхондоо Есүс “Салж унахгүйн тулд ажлаасаа сал” гэжээ.

Тиймээс би яваад хөл бөмбөгөө тоглосон юм. Үдээс хойш нь Бичээсээ судлах цаг гаргаж, Бурханы Үгэн дээр Ариун Сүнстэй нөхөрлөх үед Бурхан дахин миний бие рүү халин орж ирэхийг мэдэрч билээ.

ЗАВГҮЙ ЭЭ, ЗАВГҮЙ

Сэтгэл, биедээ шаардлагатай амралтыг нь олгохгүй, зогсоо зайгүй суралцах нь өнөөгийн биднийг унагадаг цорын ганц алдаа биш ажээ. Үнэндээ Бурханаар өлсөж цангахуйн хамгийн том хулгайч бол завгүй амьдрал юм. Сайхан санаа сэтгэлтэй олон олон итгэгч хүн энэ урхинд унаад, Бурхантай өнгөрөөх цагаа Христэд итгэх итгэлийн амьдралын хэв маягаар орлуулчихдаг. Гэтэл энэ ч бас мэхлэл бөгөөд үйлчлэлийн эцэс төгсгөлгүй хөдөлмөр юм.

Үүнийг ойлгуулах тун энгийн асуулт асууя л даа: Бид яагаад хоол иддэг вэ? Биедээ шим тэжээл, тамир тэнхээ өгөхийн тулд гэж л хариулах байх. Тэгвэл юм идэхгүй атлаа нөгөө л эрч хүчээрээ тултал ажиллаж амьдраад байвал, яах уу? Хэдэн өдөр хоол идэхгүй, нэмэлт цагаар унтахгүй атлаа олон цаг биеийн хүчний ажил хийгээд байвал, яах уу? Бод л доо. Муурч унана биз дээ!

Гэтэл бид сүнсний тал дээр яг л ингэдэг. Махан биеийн чанарыг хэрэгсдэг атлаа сүнсний юмсыг хэрэгсдэггүй байдал маань нэг шалтгаантай. Хоол ундгүй удаан яваад байвал, ходоод маань гомдоллож эхэлнэ. Бүр нэг бус удаа. Цаг хугацаа өнгөрөх тусам, гомдол нь улам л чангарсаар, улам л хүчижсээр байна. Хамаг бие маань: “Би өлсөж байна. Намайг хоолло!” гэж хашхирна. Тэгвэл сүнс ингэдэггүй. Харин ч эсрэгээрээ - цаг хугацаа өнгөрөх тусам, дотоод хүний маань дуу хоолой улам л намсдаг гэлтэй. Гэтэл бид сонсдоггүй. Сүнс сульдаж, бие дарангуйлж эхэлнэ.

Хүн хэсэг хугацаанд юм идэхгүй яваад байвал, дуршилгүй болдог. Таваас дээш хоног өлөн явсан хүний бие өлсөх нь багасна. Хоол дур хүсэл татахаа больж, нөгөө сайхан стэйк чинь гутал идэх гэж байгаа юм шиг л харагдаж эхэлнэ. Дотоод нөөц чинь татарч, өлсгөлөн бүрэлдэх хүртэл таны хоолны дуршил бүрэн алга болоод, эргэж ирэхгүй.

Тэгвэл Эзэнтэй өнгөрөөх цагаа завгүй амьдралаар орлуулахад, яг л ийм зүйл болдгийг би анзаарсан. Эхлээд Бичээст дурлах маань багасч, залбирах хүсэл маань суларна. Хааяа хааяа залбирах юмуу Бичээс уншлаа ч, миний оршихуй руу амь цутгахыг нэг ч мэдрэхгүй. Библи Бичээсээр тогтмол хооллодог байсан үеийнх шиг минь ярихгүй.

Махан биеийн хоолгүй явсаар байгаад, хоолны дуршилгүй болсон хүн хоолныхоо дуршлыг сэргэх хүртэл хүчээр идэхээс өөр аргагүй. Тэгвэл сүнсний тал дээр ч ялгаагүй. Би сүнснийхээ дуршлыг алдсан бол, залхуу явдлаа гэмшин, Библиэ дэлгээд, хүсэл найдлагаар дүүрэн сэтгэлээр Бурханы дуу хоолойг эрэн хайна. Тэгээд ямар нэгэн юм сонсох хүртлээ уншина! Ийнхүү үргэлжлүүлэх явцад итгэмжтэй Бурхан маань нэг их удалгүй дахин ярьж эхэлдэг. Бурхантай дахин холбогдох өөр нэг арга нь ганцаараа байх цаг гаргаад, ханатлаа Библиэ уншиж, залбирах явдал юм.

СҮНСНИЙ ХАЛУУНЫ ШИЛ

Энэ нь хүн бүхэнд байх ёстой сахилга бат. Итгэлээсээ няцах явдал нь танихгүй хүүхэнтэй нэг хөнжилд орохоос юмуу архи, порногоос салахаа больсноо олж мэдэхээс эхлэхгүй. Эсвэл хайртай хүнээ жигшиж, үр хүүхдээ хаях гэх мэт явдлаас ч үүдэхгүй. Үгүй юм. Итгэлээсээ няцах явдал нь Бичээсийг болоод Бурханы юмсыг үл ойшоохоос эхэлнэ. Бурханы юмст бус, амьдралын жирийн юмст дурладаг болохоос эхэлнэ.

Өлсөө цангаа нь сүнсний халууны шил юм. Амьдрал дээр яадаг билээ? Хүн өвдөхөөр эхлээд юу болдог билээ? Хоолны дуршилгүй болдог. Ханиад туссан хүн юм идэх дургүй болдгийг санаж байгаа биз дээ? Хавдрын эцсийн шатандаа орсон хүнийг судсаар нь хооллодог учраас, яс арьс болтлоо турсан байдаг. Өвчтэй хүнд юм идэх хүсэл бараг л байхгүй. “Хоолны дуршил сайтай” гэдэг үг байдаг. Тэгвэл сүнсний тал дээр ч ялгаагүй. Бурханы Үгийг хүсэх дуршил нь сүнсээр эрүүл байгаагийн шинж тэмдэг бол, Бурханы юмст дуршилгүй болох нь сүнсээр өвчилсний шинж тэмдэг.

Би Бурханы юмсын талаар ярихаасаа илүүтэй барилгын хөтөлбөр, шинэ машин, спортын баг гэх мэт юмсын талаар ярихаараа баясдаг үйлчлэгч нартай уулзаж учирч л явлаа. Эзэний юмсын талаар дурьдах юмуу сүүлийн үед Эзэн зүрхэнд нь юу өгүүлж байгаа талаар асуухаар, нүд нь орой дээрээ гарах шахам болно. Тэгээд дөнгөж сая барьсан шинэ байшингийнх нь талаар асуухаар нүд нь асаад л явчихна. Тэр хүмүүс Бурханыг хэрхэн хүндэтгэж байхыг нь би харсан. Гараа өргөөд, хамгийн

Бурханаар цангаж яв

хүндтэй Нэгэн дээрээ төвлөрөхийн оронд ийш тийшээ өнгөлзөөд л, хүмүүстэй яриад л эсвэл номлолын тэмдэглэлээ гүйлгэж хараад л. Энэ чинь илүү гүн асуудлын шинж тэмдэг байж болзошгүй юм.

Тийм чуулганд Бурханы оршихуй хомс байдгийг би анзаарсан. Тэгээд гэмшилд дуудах юмуу Бурхан руу ойртохыг урих цагаар Ариун Сүнс айлчлан буухад, тэд ангайдаг. Тэгээд нэг бол ухааран, бүдэрсэн газраа ухаж ойлгоно, үгүй бол үйлчлэлийн онцгой бэлэг - үзэгдэл л байна гэж үзээд, дээгүүрээ өнгөрүүлнэ. Бүр Ариун Сүнсний энэ үйл явдлыг эсэргүүцэх хүмүүс ч гарна. Гэхдээ ямар ч атугай, дотор нь алс бөглүү ч хамаагүй хүсэл байгаа бол, Бурханы оршихуй цангааг нь дахин сэргээнэ.

Исаиа Бурхан “бүдгэрсэн дэнг бөхөөхгүй” (Исаиа 42:3) гэдэг. Энд чухам тос нь ширгээд, дөл нь утаа болон суунаглах, бөхөж буй дэнгийн талаар өгүүлжээ. Бурхан сул, жижиг, нарийн, эмзэг, хэврэг зүйлийг тодорхойлжээ. Гэтэл Бурхан дөнгөж улалзах цогийг унтрааж орхилгүй, харин дахин асаадаг аж. Биднийг юу юугүй унтрах гэж байгаа цог байхад ч Бурхан бидэнд анхаарсаар байдгийг санаж яваарай. Тэгвэл бид Бурхантай гар нийлээд, хариу үйлдбэл, хичнээн сайн бэ. Учир нь Бурхан бидэнд Өөрийгөө тулгахгүй!

Би энэ явдлыг олонтаа хардаг. Олон хүний дотор унтарч байгаа галыг нь Эзэн дахин бадрахыг харсан. Гал нь ахин асч, Бурханыг эрэн хайх хүсэл нь дахин бадрах хүртэл хүмүүс өөрсдийгөө ямар хол хаягдаад байснаа ч ухаарахгүй явдгийг чуулган, конференц дээрээ ч олон ярьдаг. Хүмүүс ч зүрхээ хамгаалаагүй явснаа, эрүүл зүрхийг дагалддаг дуршлаа алдсанаа ухаардаг.

ХАМГААС НАНДИН ЗҮЙЛЭЭ ХАМГААЛ

“Юу юунаас дээгүүр зүрхээ хамгаал” (Сургаалт үгс 4:23) гэдэг. Зүрхнээс илүү сахиад, манаад, хамгаалаад байх зүйл үгүй! Энэ үгийг бодохоор л хүмүүс үнэ цэнэтэй эд зүйлсээ яаж хамгаалдаг нь санагдана. Бид хагардаггүй шилэн хорго доторх үнэт чулуун эдлэлийг үзсэн л байгаа. Тэдгээрийг жин, температурын хамгийн өчүүхэн өөрчлөлт, хамгийн нарийн зөрчил мэдрэгдмэгц түгшүүрийн дохио дуугарч, хаалга нь автоматаар түгжигддэг, чанд харуул хамгаалалттай орчинд хадгална. Хоргыг лазер туяагаар хамгаалж байдаг бөгөөд хорго хагарсан тохиолдолд зэвсэгтэй эрчүүд дайран орж ирнэ. Ийм маягаар 24/7 хамгаална. Тэр чулууг хамгаалах гэж олон мянган доллар зарцуулах!

Бурханд ойрт

Гэтэл энэ дэлхий дээрх бидний хамгийн үнэт хөрөнгө бол чулуу биш, зүрх маань гэдгийг Бурхан хэлжээ. Харамсалтай нь итгэгч хүмүүс зүрхээ ямар ч ашиггүй бүү хэл, хор хөнөөлтэй зүйлд зүгээр л өгчихдөг. Бид хөнгөн “гайгүй” нүцгэлэлтэй, хараалтай киног тоох ч үгүй үздэг. Дэлхийн сүнс нь Бурханы Сүнстэй дайсагнадгийг бид ойлгодоггүй. Энэ тал дээр дэлхийн хүмүүс арай л ухаалаг гэмээр. Учир нь тэд үнэ цэнэтэй гэж тооцсон зүйлээ нарийлж нандигнаж, хамгаалахаа мэддэг. Гэтэл итгэгч хүмүүс өөрсдийг нь жинхэнээсээ хангадаг, цорын ганц Нэгэнээр ангах цангааг нь хулгайлагч хүсэл, тачаалаас зүрхээ ер хамгаалалгүй, ажиггүй явах.

Эзэн “цангасан хүнийг хангалуун болгож, өлссөн хүнийг сайн зүйлсээр дүүргэдэг” (Дуулал 107:9). Бурхан биднийг хангахаар хүлээгээд байхад, бид Бурханы сайн сайханд бус, шал өөр юмст цаддаг. Зүрхээ өлөн байлгая. Бурханы дуудлагад хөнгөн хуумгай хандахгүй байя. Учир нь биднийг ойртбол, Бурхан бидэн рүү ойртохоо амласан!

СУДЛАХ АСУУЛТ

1. Сургаалт үгс 27:7 дээр “Цатгаланд сархинагийн бал ч амтгүй” гэжээ. Энэ эшлэлийг тунгаан бодоод, та өөрөө ямар зовнил, хүсэл, таашаалд хамгийн өртөмтгий, эмзэг байгаагаа эргэцүүлнэ үү. Энэ нь таны Бурханы “амтат сархинагийг” хүсэх цангааг хэрхэн сааруулж байна?
2. Энэ бүлэг дээр зохиолч хоёр өөр чуулганы хориос дээш болоод доош насныхны Бурханаар өлсөж цангах сэтгэлийг нь ажигласан тухайгаа хуваалцсан. Тэгвэл та өөрийнхөө сүнсний гэр бүлийг цатгалан, өлсгөлөн, үл ойшоогч гэдэг гурван ангиллын алиар тодорхойлох вэ?
3. Сургаалт үгс 4:23 дээрх “Юу юунаас дээгүүр зүрхээ хамгаал” гэдэг анхааруулга үгийн ухаарлаар дамжуулан, та өнөөдөр зүрхээ хамгаалах үүдээс ямар алхам хийж чадах вэ? Таны дуршилд хаях ёстой, орлуулах ёстой “эрүүл бус хоол” байна уу?

Дөрөвдүгээр бүлэг

БУРХАНЫ ОРШИХУЙГ УЛАЙРАН ХҮСЭХ



Бурханы оршихуй дор
Бурханы айлдсан Үг сонсогдоно.

Миний бие хорин жил үйлчлэхдээ Антарктикаас бусад бүх тив рүү аялж, Бурханы Үгийг чуулганд ч, конференцэд ч заасаар ирсэн. Мөн бүтэн цагаар аялан үйлчилж эхлэхээсээ өмнө хоёр ч чуулганд нийт долоон жил бүтэн цагаар ажилласан хувьтай хүн. Энэ хугацаандаа чуулганы дотор хоёр үндсэн бүлэг хүмүүс оршдог бөгөөд Эзэний ирэх нь ойртох тусам, тэдний бодох сэтгэх ялгааны цав нь улам л өргөсөөд байх шиг санагддаг юм. Эхний бүлэг нь Бурханы гарыг харж Бурханыг дагадаг хүмүүс бол, хоёр дахь нь Бурханыг Өөрийг нь хайрлан дагадаг хүмүүс билээ.

ИЗРАИЛИЙН ҮНДСЭН СЭДЭЛ

Энэ хоёр ялгааг Мосе, Израиль хоёроос харж болохоор. Илүү дэлгэрэнгүй судалж үзье л дээ. Израиль дарлал зовлонгоосоо чөлөөлөгдөхийн түүс болон Бурханаас өөр тэднийг чөлөөлөх амьд амьтан байхгүйг хүлээн зөвшөөрч, Бурхан руу хашхиралджээ. Абрахамын үр сад болох Израилийг Бурханы гарыг харж Бурханыг дагадаг хүмүүсийн бүлэгтэй

адилтгаж болно. Дэлхийн системийн хүлээсийг хүсдэггүй атлаа өөрөө ч мэдэлгүй энэ л системдээ боолчлуулсаар явдаг хүмүүс чуулганд бий. Тэд Есүсийг Эзэнээ хэмээн хүлээн зөвшөөрч, Түүнээс чөлөөлөлт, хангамжийг хүсдэг. Гэх атлаа Израилийн үр садтай л адил тэдний зүрх ч бас хүсэл, үйлдэл, үг, дэлхийн мөн чанараар нь дамжин ил болдог.

Израиль Бурханаас “биднийг чөлөөлж өгөөч” хэмээн бүхэл бүтэн дөрвөн зуун жил уйлан хайлан гуйсан. Тэгтэл Бурхан Мосед үзэгдээд, цаг нь боллоо хэмээгээд, гүйцэтгэх ёстой Үгээ өгөв. Мосе Фараонтай уулзахаасаа өмнө Израилийн ахмадуудтай уулзаад, Бурханы чөлөөлөлтийн амлалтыг мэдэгджээ. Ахмадууд ч энэхүү сайхан мэдээг дуулаад “... итгэжээ. ЭЗЭН Израилийн хөвгүүдийг анхаарч, тэдний зовлон зүдүүрийг харсныг тэд сонсоод, доор бөхийн мөргөлөө” (Гэтлэл 4:31) гэдэг.

Цугласан олны сэтгэл мэдрэмжийг төсөөлөх үү! Тэд айсуу Бурханы чөлөөлөгчийн тухай нэг насаараа л сонссон. Эрх чөлөө, сүү бал амтагдсан газар нутгийн найдвар хайрласан амлалт нь өвөөгөөс нь, ааваас нь л үе дамжин амьдарсаар иржээ. Гэвч өмнөх үеийнхэн нь энэ амлалтын биеллийг хэзээ ч үзэж чадалгүй амьдарсаар, талийхыг ч бас харжээ. Тиймээс ч “Бид тэр амлалтыг үзэх болов уу эсвэл үзэж амжилгүй одох болов уу?” гэдэг асуулт тэднийг шаналгаж байсан нь тодорхой. Гэтэл эдүгээ тэдний өмнө Бурханы мутрын баталгаа бүхий гайхамшгийг тээсэн, гарамгай удирдагч, Египетийн ханхөвүүн агсан зогсож байна. Өөрсдийг нь дарлах ёстой байсан хүмүүн нь өөрөө тэднийг чөлөөлөхөөр иржээ. Ийм гайхамшгийг гагцхүү Бурхан л үйлдэх! Израильчуудын зүрх нэг эмээн биширч, нэг хөөрөн баясна. Үг дуугүй Бурханыг хүндэтгэн талархахаас өөр юуг ч хийж эс чадав тэд.

Мосе тэндээс яваад, Фараонтой уулзав. Гэвч Египетийн захирагч Бурханы чөлөөлөлтийн үгийг ойшоосонгүй. Тэгээд Мосег болоод Абрахамын үр садыг дорд үзээд, зовлонг нь дааж давашгүй хүчир хөдөлмөрөөр зузаалжээ. Тэгсэн байдал алга урвуулахын дайтай л хувьсав гэнэ. Нөгөө удирдагч нар чинь эргээд Мосе руугаа түрэмгийлэн дайрч эхэлжээ. Нөгөө хүндэтгэл мөргөл хол цаашаа. Гонсойж, хатуурхсан тэр хүмүүс Мосе дээр ял шүүх дуудахдаа тулав! (Гэтлэл 5:21-ийг үзнэ үү)

Гэвчиг цаг хугацааны явцад Бурхан зүйл зүйлийн тэмдэг, гайхамшгаа гайхуулан байж, Израилийг нигүүлслээрээ чөлөөлөхдөө л чөлөөлжээ. Эцсийн дүнд Фараон зарлигаа өгөхөд, нөгөө хүмүүсийн хандлага дахин ер бусаар хувьсан өөрчлөгдөж, баяр хөөрөөр халгиад, үлэмжийн алдар, ерөөлөөр гарч явжээ. Бурханы сайн сайхан, итгэмжтэй чанарын нөмөр дор Египетээс бүжсээр гарч яваа тэр хүмүүсийн уур амьсгал ямар байсныг төсөөлж байна уу? Чөлөөлөгдөөд зогсохгүй, дүүрэн дүүрэн

алт, мөнгө, эрдэнэс тэргүүтнийг олзлон авч, Алгаслын хургын зоогоор дамжин эрүүл мэнд, хүч чадлаа нэмжээ. Боол явсан тэр хүмүүс Бурханд талархаад зогсохгүй, Мосед ч дээд зэргээр итгэж үнэмших болов.

Бурхан Израилийг Египетээс гаргамагцаа, тэднийг Улаан тэнгисийн эрэг тийш удирдан дагуулахыг Мосед зааварчилсан бөгөөд Израиль эргэж хараад, араас нь элдэж яваа Фараоныг үзжээ. Энэ үед Израилийн хандлага бас л орвонгоороо өөрчлөгдөв гэнэ. Тэд дахиад л Мосе руу хорсолтой нь аргагүй гомдоллон дайрав: “Тэд Мосед —Египетэд оршуулгын газар байхгүй болоод та биднийг цөлд үхүүлэхээр авчираа юу? Та юунд биднийг Египетээс гаргаж, бидэнд ийнхүү хандсан юм бэ? Бид Египетэд “Биднийг орхи. Бид египетчүүдэд үйлчилж л байя” гэж танд тэр үед хэлээгүй бил үү? Учир нь цөлд үхсэнээс египетчүүдэд үйлчилж байсан нь бидэнд *дээр байсан юм* гэгцгээв (Гэтлэл 14:11-12, тодруулгыг нэмэв). Израиль Египетэд байхдаа байдал бишдэх тоолонд Мосег хөөдөг байсан бол, эдүгээ дахиад л тааруухан удирдагчдаа гонсойн, гомдолложээ. Тэд өөрсдийгөө Мосе, Аарон хоёрын эсрэг л гомдоллож байна гэж бодсон боловч, Мосе тэдэнд “Тонгиноон чинь бидний эсрэг биш, харин ЭЗЭНий эсрэг юм” (Гэтлэл 16:8) гэж хэлжээ. Тэдний хувьд амин хувийнхаа хүслийг биелүүлэх нь Бурханы хүслийг биелүүлэхээс чухал байж. *Бидэнд дээр байсан юм* гэж хэлснийг нь тэмдэглэнэ үү. Тэд Бурханыг гэх гал халуун хүслээр бус, хар амиа бодсон хайраараа л дүүрсэн хүмүүс байв.

Гэвч Бурхан мөн л нигүүлслээ үзүүлэн, Улаан тэнгисийг ярж хаяад, Израилийг хуурай газраар гаргажээ. Тэгээд Израилийг дөрвөн зуун жил дарласан, дэлхийн хамгийн хүчирхэг Египетийн армийг ганц далайгаад л булшилчихав. Ийнхүү Израиль дахин хөөрөв! Тэд Эзэний өмнө баярлан бүжив. “Аароны эгч, эш үзүүлэгч Мириам гартаа хэнгэрэг авахад эмэгтэйчүүд бүгд түүнийг даган хэнгэрэг авч бүжиглэв” (Гэтлэл 15:20). Найман зуугаас нэг сая эмэгтэй хэнгэрэг цохин, бүжиглэхийг төсөөлж байна уу? Юутай ер бусын цуглаан байсан бол! Тэд ийм баяр хөөрийг үзээгүй. Гэхдээ энэ их баяр хөөр нь гурав хоногийн дараа усны хомсдол үүсэх үед дууссан бөгөөд хүмүүс мөн л хорсолтой гомдоллож, Бурхан ч мөн л найдвартай хангаж өгчээ.

Дахин хэд хоногийн дараа хоол хүнсний асуудал үүсэв. Израиль дахиад л “Бид Египетийн нутагт махтай тогооны хажууд сууж, цадталаа талх иддэг байхдаа ЭЗЭНий мутарт алагдсан бол дээр байж. Та нар чуулганыг бүхэлд нь өлсгөлөнгөөр алах гэж биднийг энэ цөлд авчирлаа” (Гэтлэл 16:3) хэмээн уйлагнасан.

Үндсэндээ нэг л загвар гүйгээд байхыг харж байна уу? Бурхан хүслээр нь

хөдөлж, хүссэн цагт нь хүссэн юмыг нь өгөх үед Израиль баяртай, Бурхан хүслээр нь хөдлөхгүй, хүссэн цагт нь хүссэн юмыг нь өгөхгүй болохоор Израиль уурлаж байна. Дарамт ирэх үед Израильчуудын өөрийгөө л бодсон аминч сэдэл нь зан авир, үгээр нь дамжин ил гарчээ. Тэдний хувьд хувийнх нь хүсэл нь Бурханы хүсэл, оршихуйгаас чухал байв.

МОСЕГИЙН АМИН СЭДЭЛ

Ийнхүү тэдний энэ зан давтагдсаар, Бурхан ч аргаа баржээ. Тэгээд Бурхан Мосед:

—Явцгаа, чи болон Египет газраас чиний гаргасан ард түмэн эндээс хөдлөн явж “Чиний үр удамд Би үүнийг өгнө” гэж Абрахам, Исаак, Иаковт Миний тангарагласан нутагт оч. Би чиний өмнө тэнгэрэлчийг явуулж, Би Өөрөө канаан, амори, хит, периз, хиви болон иебусчуудыг хөөнө. Сүү бал урссан нутаг уруу яв. Та нар зөрүүд ард түмэн учраас Би та нарыг замд хөнөөчихгүйн тулд Би дунд чинь явахгүй гэв (Гэтлэл 33:1-3).

Бурхан Мосед наад хүмүүсээ хүслэн болоод байгаа амлагдсан газарт нь аваач. Миний тэнгэрэлч нар аян замаас чинь аюулыг зайлуулж өгнө. Гагцхүү Би Өөрөө (Миний оршихуй) хамт явахгүй! гэжээ.

Бурхан энэ үгээ ганц Мосед айлдсан нь сайн хэрэг. Учир нь Бурхан энэ саналаа Израилийн хүүхдүүдэд тавьсан бол, тэд уухайн тас зөвшөөрч, найрлаж аваад, ачаа тээшээ баглаад, одох байв! Яагаад ингэж хэлж байгаа юм гэж үү? Тухгүй цөлөөс тэнгэрэлч нар ч үгүй, Бурхан ч үгүй замаар Египет рүүгээ буцахад бэлэн байгаа хүмүүс чинь тэнгэрэлч нартай амлагдсан газрыг лавтай сонгоно. Тэгвэл Мосе Бурханд хэрхэн хариулсныг үзье:

“Мосе Түүнд —Хэрэв Таны оршихуй явахгүй бол биднийг эндээс бүү явуулаач” (Гэтлэл 33:15) гэжээ.

“Энд” гэдэг нь ямар газар болохыг санаарай. Ямар ч тав тух, зугаа цэнгэлгүй, зовлонгийн газар болох шар цөл! Голдуу Бурханы ер бусын аргаар л хангагдах өдөр тутмын үндсэн хэрэгцээт юмсаас өөр баялаггүй газар. Байшин сууц, гол ус, амтархах усан үзмийн талбай, тариан

Бурханы оршихуйг улайран хүсэх

талбай, жимсний мод ч байхгүй. Дэлгүүр хэсэх, зугаа, инертэймэнт ч байхгүй (Яхав, хайртай хүмүүс чинь могойд хазуулж байгаад зугаацаж баясаггүй л юм бол.) Хуурай, шороо хоёроос өөр юу ч байхгүй. Гэтэл Мосе авах юмгүй энэ газрыг сонгоод “Баян, тансаг газарт Таны оршихуйгүй амьдарч байснаас, хэцүү ч гэлээ эндээ Таны оршихуйтай байх нь дээр!” гэж хэлжээ.

Мосегийн зүрхний дууг мэдэв үү. Бурханы оршихуй! Мосе Бурханы амлалтаас илүүтэй Бурханыг Өөрийг нь хүсчээ. Мосе Бурханы хангаж өгдөг баялгаас илүүтэй Бурханыг Өөрийг нь хүсчээ. Үүгээрээ ч Мосе Израилийн хүүхдүүдээс ангид байсан юм. Израиль үйлсэд нь болж Бурханыг эрэлхийлж байсан бол, Мосе Бурханд Өөрт нь болж эрэлхийлэв! Өнөөдөр ч тэнгэрийн энэ сэдэл итгэгч нарыг хоёр ангилдаг. Энэ ангилал урсгал чиглэл үл харгалзан түс тас хуваана. Бурханы хамгаалалт, хангамж, өсөлт дэвшилд дурлахаас гадна Бурханыг Өөрийг нь хайрлаж, Өөртэй нь дотносохын төлөө эрэлхийлж болдгийг мэддэг ч үгүй хүмүүс байна. Энэ хүн нөгөө эр хүний мөнгөнд нь болж гэрлэдэг хүүхнээс ялгагдаж байна уу? Тэр хүүхэн нөхөртөө өөрт нь хайртайдаа бус, харин бэл чадалд нь болж гэрлэжээ. Ийм сэдлийн хөрсөн дээр ямар ч дотносол цэцэглэдэггүй болохоор, энэ хоёр хүний аль аль нь гол юмаа алдана.

ШАГНАЛ

Миний бие дэлхийн хамгийн л үзэсгэлэнтэй газраар аялахдаа, өгүүлэшгүй тансаг атлаа Бурханы оршихуй үгүй учраас, ханхайсан барилгаас цаашгүй орд харшийг үзэж л явлаа. Мөн шорон, гуравдагч орон, навсархай оромж гэмээр тохь тухгүй гэмээр атлаа Бурханы оршихуйгаар цалгисан газраар ч орж явлаа. Тэгээд миний л хувьд эрдэнээр дүүрэн атлаа Бурханы оршихуйгүй ордонд байснаас тав тухгүй атлаа Бурханы оршихуйтай газар байсан нь дээр хэмээн үнэн голоосоо хэлж чадна.

Би теннисний том том тэмцээнд оролцож, улсдаа аваргалж ч явлаа. Эрдмийн шагнал хүртэж, нийгэмдээ байр суурь эзэлж, найз нөхөд, удирдагч нар, бизнесийнхэний хүндэтгэлийг ч хүлээж явлаа. Би дийлцэн хөөрхөн охидтой ч болзож явлаа. Эдгээрийг өнөөгийн хүмүүс мөрөөдөх нь бүү хэл, хамаг зүрхээрээ мөрдөж мөшгидөг. Гэвчиг энэ бүх алдар, таашаалын нийлбэр нь ч Бурханы оршихуйн гучин секундэд ч хүрэхгүй. Харьцуулах ч боломжгүй! Бичээс Мосег хэрхэн дүрсэлсэн байгааг үзнэ үү:

Итгэлээр Мосе, эрийн цээнд хүрээд Фараоны охины хүү гэж нэрлэгдэхээсээ татгалзав. Нүглийн цаг зуурын зугаанаас Бурханы хүмүүсийн хамт ад үзэгдсэн нь дээр гэдгийг тэр сонгосон юм. Христийн төлөө буруутгагдах нь Египетийн эрдэнэсээс агуу их баялаг мөн гэж тэр үзжээ. Учир нь тэр шагналыг харж байлаа. Итгэлээр Мосе, хааны уур хилэнгээс айлгүй Египетийг орхисон. Учир нь тэр үл үзэгдэх Түүнийг харж байгаа мэт тэвчсэн ажээ (Еврей 11:24-27).

Мосе ад үзэгдэхийг сонгосон байгааг тэмдэглэнэ үү. Израилийн үр садад сонголт байгаагүй. Тэгвэл Мосе өөр байр сууринд байжээ. Гэтэл Мосе гомдол гаргаагүй бол, Израилийн хүүхдүүд гаргасан. Мосе энэ дэлхий дээр байж болох хамгийн л гэгдэх баян тансаг амьдрал, хамгийн л гэгдэх өндөр хэргэм зэргийг сайн дураараа орхиод явжээ. Яагаад? Мосе өөр нэгэн шагналыг хайжээ. Мосегийн шагнал нь амлагдсан газар бус, Бурханы оршихуйн амлалт байв. Бутанд тохиосон ганцхан учралын дараагаас Мосе Бурханыг дотно таньж мэдэхээс өөр юмыг хүсэхээ больжээ.

Миний бие мянга мянган конференц, чуулганд номлож, зурагт, номоор дамжуулан сая сая хүнд үйлчилсэн. Бурхан ч биднийг олон ч удаа нүд орой дээр гартал ерөөсөн. Тийм боловч, би Бурханы энэ олон амжилтыг Бурханы Өөрийнх нь бодит оршихуйгаар солиход бэлэн байна. Бурханы оршихуйтай адил юм байдаггүй. Үй олонд номлож, сая сая ном борлуулж байснаас Бурханы дэргэд буй оршихуйг мэдэрч, миний огтоос мэдэхгүй зүйлсийг зүрхэнд минь шивэгнэн өгүүлэх Бурханы дуу хоолойг сонсохыг сонгоно. Бурханы оршихуйн алдартай дүйцэх юм нэг ч үгүй!

Амжилтын амтанд автаж, араас нь хөөцөлдөх үйлчлэгч нарыг харахаар өр өвдмөөр. Наанаа хэлэхгүй л болохоос, хүмүүст танигдаж, үнэлэгдэх нь тэдний битүүхэн зорилго. Үйлчлэлээс ач холбогдол, амжилт бүтээл хайсан хүмүүс замын дундаа цөхөрсөөр, адагтаа харанхуйн хавханд унахыг нь би харсан. Тэд нүсэр том үйлчлэл байгуулсаар яваад, энэ бүхэн нь хөндий хоосон байсныг ухаарч амжихаасаа ч өмнө ёс бус, шунаг явдалд живдэг.

Түүнчлэн хэзээ ч дээрх хүмүүс шиг амжилтанд хүрээгүй атлаа ялгаагүй эмгэнэлтэй төгссөн бүр ч олон үйлчлэгчийг би гэрчлэн харсан. Тэд чуулганаа хоёр зуу, таван зуу, таван мянгаас дээш хүнтэй болгож, зорилгодоо хүртлээ өсгөж чадаагүйдээ урам алдаж, зүрх үхдэг. Бичсэн ном нь ч бэстселлер болсонгүй, “том” конференцэд ч уригдаж

номлосонгүй. Тэд угаасаа хоосон газраас цадахыг хүсчээ. Энэ нь нийгэм дээр байр суурь, амжилт бүтээл эрэлхийлж яваа хүнээс ялаагүй юм. Энэ итгэгч нар бүтээгдсэн жинхэнэ зорилгоо гээжээ.

Тэгвэл эсрэгээрээ, нүсэр үйлчлэлтэй, нүсэр амжилттай атлаа Бурханаас өөр юм хүсдэггүй эрчүүд, эмэгтэйчүүдтэй ч би уулзаж учирч явлаа. Бурхан хүсэх аваас, тэд энэ бүх ололтоо зүгээр л орхиод, өөр үйлчлэл, ажил хийхэд бэлэн байгаагаа хэлдэг. Ихэнх нь хэзээ ч байр суурь гэдэг юмтай хөөцөлдөөгүй учраас, тавьж явуулахаас айхгүй. Бурхан л тэднийг тэнд тавьсан бөгөөд тэд ч Бурханд л таалагдахын төлөө ийн хичээж яваагаа ч хэлдэг. Зүрхнийх нь энэ дуудлага нь яриа, үйл хэргээс нь шууд л харагдана. Яг л дэлхийн хамаг баялгийг эрхшээсэн атлаа “Бурхан байхгүй бол, би дутуу гачуу, үгээгүй хүмүүн” хэмээн айлдсан Давидтай л адил.

Түүнчлэн жижиг гэмээр үйлчлэлтэй атлаа Бурханаас өгөгдсөн дуудлагаа биелүүлж яваагаа мэддэг болохоороо, жигтэйхэн амар тайван, аз жаргалтай амьдардаг хүмүүсийг ч мэднэ. Тоо, гадаад амжилт бус, Бурханыг дотночлон таньж мэдээд, Түүний ил оршихуй дор явах нь л тэдний хүсэл тэмүүлэл. Үнэндээ чухам ийм л байх ёстой юм. Бид бүгдээрээ Бурханы төлөө бүтээгдсэн бөгөөд Бурханыг таньж мэдэх, Бурханы оршихуй дотроос өөр газраас жинхэнэ ханамжийг олохгүй. Тэнд л жинхэнэ амар тайван, ханамж оршдог болой.

БУРХАНЫ ХОЁР ТӨРЛИЙН ОРШИХУЙ

Яг одоо бүгдээрээ Бичээс дээр танилцуулсан Бурханы хоёр төрлийн оршихуйг тодорхойлох хэрэгтэй байна. Эхнийх нь - *Бурханы газар сайгүй байх оршихуй*. Давид “Таны Сүнснээс би хаашаа одох вэ? Эсвэл Таны оршихуйгаас би хаашаа зугтах вэ?” (Дуулал 139:7) гэж хэлэхдээ, чухам энэ оршихуйн тухай өгүүлжээ. Газар сайгүй байх оршихуй гэдэг нь Бурханы бүх газарт орших чанарыг хэлж буй хэрэг. Давид цааш нь “Хэрэв би тэнгэр өөд очвол, Та тэнд, Хэрэв би Үхэгсдийн оронд ор дэрээ засвал, Харагтун, Та тэнд. ...Хэрэв би “Харанхуй үнэхээр намайг нөмөрнө. Намайг хүрээлэгч гэрэл нь шөнө” гэвэл Харанхуй ч Танд харанхуй биш бөгөөд Шөнө ч өдөр мэт гэрэлтэнэ. Гэрэл харанхуй адил” (8, 11-12) гэжээ. Үүнд бас биднийг хэзээ ч орхихгүй бас хаяхгүй гэсэн Эзэний амлалт ч хамаатай (Еврей 13:5). Бид энэ оршихуйг мэдрэхгүй байлаа гээд, Бурхан эс оршино гэсэн үг бус, зүгээр бид л мэдэхгүй байгаа хэрэг юм.

Бичээсийн өгүүлдэг хоёр дахь оршихуй нь Бурханы *ил оршихуй* болой. *Ил* гэдэг нь үл үзэгдэх, үл сонсогдох, үл мэдэгдэхээс харагдах, сонсогдох, мэдэгдэх байдалд оруулах гэсэн утгатай. Мосе Эзэний энэ л ил оршихуй руу хүсэн тэмүүлсэн юм. Тэнд л Бурхан Өөрийгөө бидний сүнсэнд илчлэхээс гадна оюун санаа, мэдрэмжинд минь бас мэдүүлдэг. Тэнд л Бурханы мэдлэг бидний оюун санаанд илчлэгддэг. Есүс:

“Би ч түүнийг хайрлаж, Өөрийгөө түүнд илчилнэ” (Иохан 14:21) хэмээн айлдахдаа, энэ л оршихуйн тухай өгүүлжээ.

Магтаалч энэ тухай “Баярт дууг мэддэг ард түмэн Юутай ерөөлтэй вэ! Аяа ЭЗЭН, Таны царайны гэрэлд тэд алхнам” (Дуулал 89:15) хэмээн мэдэгддэг. Петр Пентекост өдөр цангасан эрэлчдийг “Иймээс гэмшицгээ. Гэм нүглээ үгүй болгохын тулд эргэцгээ. Тэгвэл сэргээх цаг Эзэний *оршихуйгаас* ирэх бөгөөд” (Үйлс 3:19) хэмээн ятгасан байдаг.

Бурхан оршихуйгаа олон янзаар ил болгож чадна. Бичээс дээр зарим хүн Бурханыг харсан бол, зарим нь Түүнийг харахгүйгээр сонссон, зарим нь Бурхан дэргэд нь байгааг мэдэрмэгцээ, урьд өмнө хэзээ ч мэддэггүй явсан юмсаа Бурханы илчлэлээр шууд мэдсэн байдаг. Ямартаа ч нэг л зүйл тодорхой юм: Та Бурханы байгааг гүнийхээ гүнээс мэдэрч, мэднэ.

ЭЗЭНИЙГ ХАЙЖ БАЙНА УУ, ИЛЭРХИЙЛЛИЙГ НЬ ХАЙЖ БАЙНА УУ?

Бурханы оршихуйг мэдрэхийн хүслэн болсон хүмүүс төөрөлдөж явахыг би үзсэн. Тэд Эзэнийг Өөрийг нь бус, харин илрэлийг нь хайгаад давхичихдаг. Елиад үзэгдсэн хэд хэдэн нүсэр илрэлийн дунд Бурхан байгаагүй. Эхлээд маш хүчирхэг салхи дэгдсэн ч, Эзэн салхин дунд байгаагүй. Дараа нь газар хөдөлсөн ч, Эзэн газар хөдлөлт дунд байгаагүйг Бичээс хэлдэг. Эцэст нь гал гарсан ч, Эзэн мөн л галан дунд байгаагүй. Харин галын дараа намуухан, зөөлөн дуу гарсан бөгөөд тэр үед л Елиа Бурхантай Өөртэй нь нүүр нүүрээрээ учирснаа мэдсэн.

Хүмүүс эхлээд зүрхээрээ Эзэнийг хайгаад, араас нь Бурханы ил оршихуйг мэдрэхийн оронд оршихуйн төрөл бүрийн илрэл дундаас Бурханыг олно хэмээн төөрөлдсөндөө, янз бүрийн илрэлийг л хайгаад байдаг. Бурханы амьсгалтай, зүрхэнд хүрсэн номлолын дараа би хүмүүсийг Бурхантайгаа уулзахад уриалан дууддаг юм. Энэ үеэр зарим хүн анхаарал татаж, үймүүлсэн байдлаар залбиран, үйл өрнөлийн урсгалыг самарч эхэлдэг. Зарим нь инээд алдах, чичрэх зэрэг гадаад

дохио зангаа үзүүлнэ. Яагаад ингэдэг вэ гэхээр, тэд өмнө нь Бурхантай нүүр нүүрээрээ учрахдаа, Бурханы оршихуйд чичирч, уйлж, инээд алдаж байж л дээ. Тиймээс одоо ч мөн ийм л илрэл дундаас Бурханыг олно байх хэмээн найдсандаа, өөрийн мэдэлгүй мөнөөх явдлаа давтаад байгаа ажээ. Гэхдээ тийм юм болохгүй. Би хүмүүст юу ч хийлгүй, зүгээр л номхон зогсоод, зүрхээ Бурхан руу эргүүлэн, Есүсийг Өөрийг нь хайхыг л байнга ятгадаг юм. Илрэл байгаа бол, сайн л байна! Гэхдээ илрэлийн аргаар Бурханыг хайж болохгүй. Бид Эзэнийг Өөрийг нь хайх ёстой!

Гэмшлийн дуудлагад маш олон хүн хариулсан, Азийн нэгэн цуглаан санаанд орж байна. Танхимд маш олон хүн шийдвэр гаргаж, бүгдийг нь урагш нь гаргах боломжгүй байсан болохоор, би хүмүүст байр байрнаасаа залбирч, Эзэнийг эрэн хайх заавар өгсөн юм. Залбирсныхаа дараа мөн л байр байрнаасаа Эзэн рүү эргэ хэмээн зоригжуулав. Бурханы оршихуй ч танхимд пүн хийтэл буув. Бурхан Өөрөө орж ирээд, Өөрийгөө илэрхийлэх нь биширмээр байлаа. Би үүнийг олон удаа үзэж байсан ч, хэзээ ч байдаг л, болдог л юм шиг санагдаж байсангүй. Заримдаа та эргэн тойрныхоо хүмүүсээс ч илүү тод мэдэрнэ. Бурханы оршихуй бууж ирэхэд, хэсэг хүмүүс инээлдэж эхэлсэн боловч, надад гашуудал мэдрэгдсэн бөгөөд энэ маань ч төд удалгүй батлагдаж, хэдийгээр хүмүүс инээлдэж, Бурханы оршихуй байсаар байгаа мэт хашхиралдаж байсан ч, Бурханы оршихуй ирснээсээ ч хурдан буцаж өргөгдсөн юм.

Би ч тэр хүмүүс хэдэн сарын өмнө улсад нь айлчилсан Сайн мэдээ дэлгэрүүлэгчийг байх үеэр Бурханы оршихуйд болж өнгөрсөн үйл явдлыг биеэрээ давтаад байгааг нь мэдээд, зогсоогоод зэмлэв. Сайн мэдээ дэлгэрүүлэгчийн үйлчлэл хүмүүсийн “ариун инээд” гэж нэрлэдэг, хүчирхэг илрэлийг дагуулсан юмсанж. Бурханы оршихуйд хүмүүс ариун инээдээр инээлддэг гэдэгт би бүрэн итгэдэг. Үнэндээ би өөрөө ч инээж үзсэн, манай цуглаануудад ч ийм зүйл болдог. Нэгэн удаа Индонезийн нэг цуглаан дээр Бурханы Сүнс бууж ирэхэд, хүмүүс хоёр цагийн турш өнхрөлдөн, эвхрэлдэн хөхрөхийг манай орчуулагч, бид хоёр үзсэн юм даг. Энэ бүхэн уйлж байсан таван эмэгтэйгээс эхэлсэн бөгөөд мөнөөх ер бусын инээд нь чуулган даяар тархсан юм. Тэд ийм юм хэзээ ч үзээгүй гэдэг. Тэр хүмүүс Бурханыг эрэн хайж!

Гэтэл дээрх цуглааны хувьд өөр байв. Тэд Эзэн дээр бус, илрэл дээр л анхаарч байлаа. Тэд инээлдэхгүй л бол, Бурханы оршихуйн илрэл байхгүй гэж дүгнэжээ. Би ч Бурханы оршихуйд олонтаа ордог бөгөөд дотроо Бурханыг хүчтэй мэдрээд байгаа атлаа гаднаа мэдэгдэх юмгүй байх үе зөндөө л байдаг. Бурханы оршихуй дор байж, эхэр татан уйлахдаа, энэ бүхэн нь Бурханыг эрэн хайж, Түүний оршихуйд орсны л үр дүн болохыг нь ухаардаг.

Үүнийг амьдрал дээрх энгийн жишээгээр тодруулан тайлбарлая. Би өмдөө өмсөөд, халаасыг нь тэнийлгэхээр гараа шургуулсан чинь зуун доллар гараад ирбэл, яах уу? Би мөнгө олох гэж өмдөө өмсөөгүй, харин өмдөө өмсөх явц дундаа л олзтой болсон. Би хувцаслах зорилгодоо хүрэх явцдаа л гэнэтийн шагнал хүртсэн. Үүнтэй адил бид илрэлийг нь хайлгүй, Эзэнийг Өөрийг нь хайх ёстой бөгөөд илүү дутуу юмс нь бүгд нэмэгдэл ашиг юм.

Азийн чуулганы алдааг зассаныхаа дараа би тэднийг Эзэнээр өлсөж цангаж байгаа нь ойлгож байгаа хэдий ч, Бурханыг туршлагаар орлуулж болохгүйг анхааруулж хэлсэн юм. Энэ ятгалгын дараа Эзэний оршихуй ариун бишрэхүй дор эргэн буув. Энэ удаа олон хүн инээх бус, уйлав. Гэхдээ уйлсан ч бай, уйлаагүй ч бай, хамгийн гол нь Эзэнийг хайсан бүх хүнийг Эзэний гайхамшигт оршихуй хөндсөн юм.

ИЛРЭЛ ХАНГАЖ ЦАТГАХГҮЙ

Манна Израилийн хүүхдүүдийг хангаж цатгаагүйг хэзээ ч бүү мартаарай. Бурхан цөлд Израилийн үр саад манна өгсний цаад зорилго нь Өөрийнх нь оршихуйгаас өөр юу ч тэднийг хангаж цатгахгүйг ойлгуулахын төлөө байжээ. Мосе ингэж хэлсэн:

ЭЗЭН Бурхан чинь чамайг энэ дөчин жилийн турш цөлд удирдсан бүх л зам мөрийг дурсан сана. Энэ нь чиний зүрхэнд юу байсныг, тухайлбал тушаалыг нь дагах эсэхийг чинь мэдэхийн тулд мөн чамайг номхтгож, шалгаж сорихын тулд байсан юм. Хүн зөвхөн талхаар бус, харин ЭЗЭНий амнаас *гарах* үг бүрээр амьдардаг гэдгийг чамд ойлгуулахын тулд Тэрээр чамайг номхтгон, чамайг өлсгөж, чиний мэддэггүй, чиний эцэг өвгөд ч мэддэггүй байсан маннагаар чамайг хооллож байсан (Дэд хууль 8:2-3, тодруулгыг нэмэв).

Гарах гэдэг үгийг нарийвчлан үзнэ үү. Мосе *гарсан* хэмээн өнгөрсөн цаг дээр хэлээгүй, харин *гардаг* хэмээн одоо цаг дээр хэлжээ. Бурханы хэлсэн Үг Бурханы оршихуй дотор сонсогдоно! Елиа дайран өнгөрөх Бурханы илрэлд авталгүй, Бурханы оршихуйн намуухан, зөөлөн дуу хоолойг хүлээж байгаад хариулжээ. Азийн чуулган Бурханы өнгөрсөн удаагийн илрэлтэй хөөцөлдөж байсан ч, Бурхан хэдийнээ өнгөрөөд

Бурханы оршихуйг улайран хүсэх

явчихсан байв. Бурхан тэнд байгаагүй. Бурхан шинэ зүйл рүү яваад өгсөн бол, тэр хүмүүс Бурханыг байсан газраас нь хайсаар, ард хоцорчээ.

Манна Израилийн хүүхдүүдийг хэзээ ч хангаж цагтаагүй шиг, илрэл ч бидний гүний санаашралыг хангаж цагтахгүй. Эдгээртэй хөөцөлдөх нь биднийг гонсойлгож л орхино. Тиймээс хангаж цагтахгүй хоосон юмсаасаа эргээд, Бурханаас ирдэг дотнослыг л хай.

ОЮУНЫ ХАРИЛЦААГ ЭРЭЛХИЙЛЭХ

Итгэгч хүмүүс илрэлийг Эзэнээс дээгүүр өргөмжлөх үед өөр нэгэн гунигтай зүйл болдог бөгөөд энэ явдал олон хүнийг Бурханы жинхэнэ оршихуйгаас төөрүүлдэг. Илрэлтэй хөөцөлддөг хүмүүсийн хөг, хэмнэлгүй зан авирт самуурсан бусад нь сэрэмж алдан, Бурхантай оюуны харилцаа хайж эхэлнэ. Гэтэл үүнээс том хувь тавилантай бүтээгдсэн хүмүүсийн хувьд үүн шиг эмгэлэнтэй зүйл байх уу даа. Эй. Даблю. Тозер гуай итгэлээр зөвтгөгдөх доктрин нь сүүлчийн өдрүүдэд дараах янзтай болно гэжээ:

“... олны ийм маягаар тайлбарлах явдал нь үнэндээ хүмүүсийг Бурханы мэдлэгээс хорих. Шашны өөрчлөлтийн шилжилт нь тэр чигээрээ сүнсгүй бөгөөд механикжсаар иржээ. ... Хүн “аврагдсан” ч, Бурханыг гэх өлсөө ч, цангаа ч байхгүй. Үнэндээ тэрбээр багахан зүйлдээ ханаж цадан, башийхад тусгайлан сургагдсан байна (*The Pursuit of God* номын 12-13-аар нүүр).

Бурхантай тогтоох оюуны холбоо харилцаа нь сүнсгүй бөгөөд механикжсан байдаг. Бид үнэндээ Бурханы дотор онолын хувьд орших бус, харин бодитоор оршихоор бүтээгдсэн юм. Үүнийгээ ч бүрэн дүүрэн эдлэхээсээ нааш бид хэзээ ч ханаж цадахгүй. Есүс биднийг Бурханы оршихуйгаас тусгаарлаж байгаа хөшгийг авч хаяхын төлөө амиа өгсөн билээ. Иймээс ч магтаалч ингэж залбирчээ:

Аяа Түг түмдийн ЭЗЭН,
Таны оршин суудаг газар
Хичнээн тааламжтай вэ!
Сэтгэл минь ЭЗЭНий хашаа уруу тэмүүлэн эрмэлздэг.
Зүрх ба махбод минь
Амьд Бурханд баясан хашхирдаг.

Бурханд ойрт

Миний Хаан, Бурхан минь,
Түг түмдийн ЭЗЭН Таны тахилын ширээнд
Болжмор ч орших газраа,
Хараацай ч ангаахайнуудаа суулгах үүрийг олсон.
Таны өргөөнд оршигчид
Юутай ерөөлтэй вэ!
Тэд үргэлж Таныг магтдаг. Села (Дуулал 84:1-4).

Нью Кинг Жэймс Вержн Библи дээр хоёрдугаар эшлэлийг нь “Махан бие, амин зүрх хоёр минь амьд Бурханыг дуудан хашхирна” гэдэг. Зохиолч дараа нь бор шувуухай, хараацай хүртэл үүрэндээ суурьшчихсан байхад, түүний бие Бурханы оршихуйн газрыг үгүйлэн тэмүүлсэндээ, орон гэргүй мэт яваагаа мэдэгджээ. Тэрбээр Бурханы оршихуйн газар болох гэрээ л санаж буйгаа хэлсэн байна. Ямар сайндаа л “Таны оршихуйд оршигсод жаргалтай, хувьтай [бөгөөд] атаархмаар аа” гэж хэлэх үү дээ. Бурханд хайртай хүмүүс ийм л зорилготой байх! Тэд Бурханы ил оршихуйгаар цангадаг. Бурхантай ойр байх тусам, оршихуй нь улам л чангарсаар, нөлөө нь ч ихэссээр байна.

СУДЛАХ АСУУЛТ

1. Бүлгийн эхэнд зохиолч маань “Энэ хугацаандаа чуулганы дотор хоёр үндсэн бүлэг хүмүүс оршдог бөгөөд... . Эхний бүлэг нь Бурханы гарыг харж Бурханыг дагадаг хүмүүс бол, хоёр дахь нь Бурханыг Өөрийг нь хайрлан дагадаг хүмүүс билээ” гэсэн. Чин үнэнээсээ хэлбэл, та өөрийгөө аль бүлэгт нь оруулах вэ?
2. Египетээс чөлөөлөгдсөн Израильчууд байс хийгээд л нэг бол хүссэнийг нь өглөө хэмээн Бурханд талархан, хүндэтгэж, нэг бол хүссэнийг нь өгсөнгүй хэмээн Бурханд урвагнан, гомдоллож байсан. Та ч бас “цөлөөр” туулахдаа, Израилийн хүүхдүүдтэй ижил төстэй ямар хандлага гаргаж байна?
3. Магадгүй, та яг одоо “цөлөөр туулж” яваа учраас, энэ номыг уншиж байж мэдэх. Тийм бол, салхи, газар хөдлөлт, галан илрэлийг үзсэн Елиагийн үйл явдлаас юу сурч чадах вэ?

Тавдугаар бүлэг

ХӨШИГНИЙ ЦААНА



“Бурханы оршихуй л биднийг дэлхийн гадарга дээрх бусад бүх зүйлээс тусгаарладаг.”

Эзний оршихуй бидэнд Бурханыг улам бүр илчлэн таниулах бөгөөд уулзалт болгон биднийг нэг мөр өөрчилсөөр байдаг. Бид Библид нэвтрэх тусмаа, Бурханыг мөшгидөг, оршихуйг нь үзсэн хүмүүс л Бурханы арга замыг ухаж ойлгодог байсныг мэддэг.

ТУСГААРЛАХ ХҮЧИН ЗҮЙЛ

Мосе Бурханы саналаас татгалзсан тухай бид өнгөрсөн бүлгээр үзсэн. Эзэн оршихуйгүй, дан амлалтаа өгсөн. Гэтэл Мосе тэр дороо “Хэрэв Таны оршихуй явахгүй бол биднийг эндээс бүү явуулаач” (Гэтлэл 33:15) хэмээн хариулсан. Тэрбээр Бурханы оршихуйгүй амлалттай байхаасаа Бурхантай ойр байхыг урьгал болгожээ. Бараа бологч - тэнгэрэлч нараас татгалзсан Мосегийн татгалзлыг сонсоно уу:

Хэрэв Таны оршихуй явахгүй бол биднийг эндээс бүү явуулаач. Эс тэгвэл би болон Таны ард түмэн мэлмийд

Бурханд ойрт

тань тааллыг олсон нь юугаар мэдэгдэх вэ? Та бидэнтэй хамт явж байгаагаар бус уу? Тэгвэл *би болон Таны ард түмэн бид газрын хөрсөн дээр буй бүх ард түмнээс ялгагдах юм* гэв (Гэтлэл 33:15-16, тодруулгыг нэмэв).

Мосегийн үгээс “Бурханы оршихуй л биднийг газрын гадарга дээрх бусад зүйлээс тусгаарладаг” гэдэг маш хүчирхэг үнэн үнэртэж байна. Христэд итгэдэг гэдэг нэр ч биш, Библид итгэдэг чуулганд явдаг явдал ч биш, найзынхаа хүсэлтээр юмуу гэмшилд дуудах үед гэмшлийн залбирлыг хэлсэн сайхан сэтгэл, сайн зан чанар ч биш. Чухам Бурханы Өөрийнх нь оршихуй л биднийг ялгаруулж өгдөг бөгөөд (Бурхан руу тусгаарлан) ариун болгодог. Бурханы оршихуй л биднийг газар дээр оршин суудаг хүмүүст илэрхий болгодог.

Тэгвэл яагаад үй олон хүн Бурхантай оюуны харилцаанд гарын үсэг зурна вэ? Яагаад бид Христийн оршихуйгүй Христэд итгэх итгэлийг байгуулахыг зорино вэ? Бурхантай дотносолгүйгээр яаж сэтгэл хангалуун байж сураа вэ? Яагаад бид хүмүүсийн дотор Бурхан руу ойртож, Түүний оршихуй дотор амьдрах гал хүсэл байгуулахгүй Христэд итгэх итгэлийг заадаг болчихсон юм бэ? Үүнд Эй. Даблю. Тозер гуай ийн хариулжээ:

Бурхан биднийг Өөрийнх нь оршихуй руу л тэмүүлэн, насан турш тэндээ л амьдраасай гэж хүсдэг. Үүнийг ч бид ухамсартайгаар бодит үйл хэрэг болгох ёстой. Энэ нь зүгээр нэг доктрин баримтлахтай зүйрлэшгүй том хэрэг бөгөөд өдөр тутам, эгшин бүртээ эдлэх зүйтэй амьдрал болой (*The Pursuit of God* номын 34-ээр нүүр).

Олон хүн Бурхантай яг одоо бодитоор харилцалгүйгээр, оюуны мэдлэгийн хүрээндээ л Бурханд харьяалагдахыг илүү үздэг. Хэт лав суусан авралын энэ ойлголтынхоо улмаас тун цөөхөн хүн л цаашаа ахидаг байна. Тэд бүх залбирлаа хэлчихсэн бөгөөд хожим нас барахаараа Бурхан дээр очихоор явна. Харин өнөөдөр тэдний амьдралд Христ бодитоор байхгүй, бидэнтэй хамт алхах гэсэн Бурханы хүчирхэг илчлэл ч алдагджээ. Энэ бүхэн ганц удаагийн юмуу сансрын үйл явдал бус, харин Бурханы эрэлхийлдэг, маш бодитой, чин хүсэл болой. Үүнийг Бичээсээс лавшруулж үзье.

ХЭН БУРХАНЫ ОРШИХУЙГ ҮЗДЭГ ВЭ?

Бурханы оршихуй Библийн эхлэлээс төгсгөл хүртэл хөвөрч буйг үзэж болно. Цэцэрлэг дотор Адам, Ева хоёр дуулгаваргүй авираасаа болоод “ЭЗЭН Бурханы оршихуйгаас цэцэрлэгийн модон дунд нуугдах” (Эхлэл 3:8) үе хүртлээ Бурхантайгаа хамт алхсан байдаг. Гэтэл нүглээсээ болоод хүн өөрийгөө Бурханы оршихуйгаас тусгаарлажээ. Тэр хоёрын хүү Каин ч бас хатуурхсан зүрхнийхээ улмаас Бурханы оршихуйгаас улам бүр алсран холдсон юм.

Гэвч Бурхан бууж өгөлгүй, хайрласан хүнтэйгээ дотно байхыг хүссэн хэвээрээ л байв. Эцэстээ Енох, Ноа шиг хүмүүс Бурханд хариулсан бөгөөд мятрашгүй мөрдөн мөшгилтөөрөө Бурханы зүрхийг хөндөж чадсан байдаг. Үүнийхээ үр дүнд ч тэд Адам, Ева хоёрыг Еден цэцэрлэгээс хөөгдсөн цагаас хойшхи мянганы хүмүүс дундаас Бурхантай ойр явж чадсан билээ.

Абрахам амьдрах хугацаандаа Бурханы оршихуйг олонтаа үзсэн байдаг. Нэгэн удаа Бурхан Содом, Гоморра гэдэг хоёр хотын ирээдүйг хэлэлцэхээр Абрахамтай уулзсан. Хотууд дээр шүүх буулгасны дараа “Абрахам өглөө эрт босоод, ЭЗЭНий өмнө зогсож байсан тэр газартаа очив” (Эхлэл 19:27) гэдэг. Энэ бол Абрахам Бурхантай оршихуйд нь нөхөрлөсөн олон удаагийн тохиолдлын нэг нь л юм. Үнэндээ Абрахам нас дээр гарсан хойноо зарцдаа “Миний даган бишрэгч ЭЗЭН тэнгэрэлчээ чамтай хамт явуулж, аян замыг чинь амжилттай болгоно” (Эхлэл 24:40) гэж хэлсэн байдаг.

Самуелын тухайд ч “...өсөж торниход ЭЗЭН түүнтэй хамт байж, түүний үгнээс нэг нь ч хөсөр хаягдсангүй (1Самуел 3:19) гэдэг. Яахаараа энэ хүний ганц ч үг нь хөсөрддөггүй билээ? Хариултыг нь дараах эшлэлээс үзэж болно: “ЭЗЭН Ханнад айлчлан ирж, тэрээр жирэмслэн ахиад гурван хөвгүүн, хоёр охин төрүүлжээ. Балчир хөвгүүн Самуел ЭЗЭНий өмнө өсөж торнив” (1Самуел 2:21). Мөн л Эзэн оршихуй дотроо Өөрийгөө илчилсэн байхыг харж байна. Бид Бурханыг мэдэх үедээ Бурханы үгийг ярих бөгөөд бидний үг ч хөсөрдөхгүй.

Бурханы оршихуйд хайртай, оршихуйг нь мэддэг байсан Давид ч Хуучин гэрээний олон хүн шиг (магадгүй Мосег эс тооцбол) “Таны зарц Давидын гэр Таны өмнө бэхжих болно” (2Самуел 7:26) хэмээн залбирсан байдаг. Давид Мосегтэй л адил Бурханы оршихуйн үнээр амжилт олохыг хүсээгүй. Үнэндээ Давид үйлдсэн завхайрал, аллагын гашуун нүглээ гэмшихдээ, “Оршихуйгаасаа намайг бүү холдуулаач. Ариун Сүнсээ

надаас бүү аваач” (Дуулал 51:11) гэсэн байдаг. Бурханы оршихуй үгүй аваас, амьдрал нь ямар ч утгагүй, хоосон болохыг Давид мэднэ! Тэрбээр мөн “Өөрт минь Та амийн замыг таниулна Өөрийн тань оршихуйд л баяр хөөр дүүрэн Таны баруун мутарт Баяр жаргал үүрд байдаг” (Дуулал 16:11) хэмээн бичсэн ч байдаг.

Сэтгэл судлал дээр сүүлийн таван жил тогтоосон харилцаа нь хүний хувь чанарыг хэлбэршүүлдэг гэдэг. Би ч үүнтэй санал бат нийлнэ. Учир нь Бичээс “Аягүй муу нөхөрлөөн аятай ёсзүйг ялзалмуй” (1Коринт 15:33), “Мэргэнийг дагавал мэргэн. Мулгуутай нөхөрлөвөл хорлол” (Сургаалт үгс 13:20) ч гэдэг. Тэгвэл Давид яасан? Бичээс “Шахалтад, өрөнд, сэтгэл уналтанд орсон бүхэн Давид дээр цугларч ирсэн бөгөөд Давид тэдний дээр удирдагч болов. Ийнхүү дөрвөн зуугаад хүн түүнтэй хамт байв” (1Самуел 22:2) гэж хэлэх үед Давид цөлд амьдарч байжээ. Пөөх, Давид арваад жил ийм л хүмүүстэй хамт амьдарчээ. Гонсойсон, бачимдсан, өртэй хүмүүстэй! Тэд ууртай, түгшүүртэй тэгээд мэдээж балмад, хурц авиртай л байсан байгаа. Гэхдээ тэд Давидын хувь чанарыг хэлбэршүүлсэн үү? Үгүй ээ! Яагаад? Яагаад гэвэл Давид байнга Бурханы оршихуйд байдаг болохоор, хаан хүний зан төлвөө хадгалсаар, эцэстээ тэр хүмүүсийг үе үеийнхэнд нэрээ дуурсгасан аугаа удирдагч нар болгон хүмүүжүүлжээ.

Бурханы урилгад хариулсан Давидын дараах үгд би ихэд хайртай:

“Миний царайг эрэн хайцгаа!” гэхэд Зүрх минь Танд
“ЭЗЭН, царайг тань би эрж хайюу” гэсэн (Дуулал 27:8).

Давид Бурханы оршихуйд хамаг цагаа зориулахдаа, дөрвөн зуун ааштай эрд төдийгүй, бүхэл үндэстэнд нөлөөлсөн буюу. Давид ингэж л амьдарсан. Давид хамаг л цэц ухаан, мэдлэг, ойлголтын Эх ундаргатай цагийг өнгөрөөдөг байсандаа л тэр. Гэхдээ Давид Бурханаас “цэц ухааныг” нь авах гэсэндээ бус, Бурханы зүрхийг л хайсандээ тэр буюу. Давид Бурханд хэн хэнээс, юу юунаас ч илүү хайртай байсандаа л Бурханаас салдаггүй байжээ.

Энэ гал халуун хүслийг нь хүү Соломон нь өвлөсөн ч болоосой. Соломон чинь Израилийн Бурханыг хоёр ч удаа харсан бөгөөд урьд хожид төрөөгүй суу ухаантан боловч, Бурханы оршихуйг аминчлан хайрлахыг ойлгох ухаан дутсан юм. Тэрбээр насныхаа бөгсөн дээр “Номлогчийн үгс” гэдэг туйлын өрөвдмөөр ном бичсэн. Соломон цэц ухаан, яндашгүй баялаг, дэлхийн сор, согоо хүүхнүүд, алдар нэр, дөрвөн зүг тэлсэн сүр нөлөөтэй эрхэм байсан ч, энэ бүхэн “утгагүй,

хоосон” хэмээн хашхирах! Соломон аав Давид шигээ зүрхтэй байсан бол, Израилийн түүх өөрөөр эргэх байсан.

Үнэндээ Бурханы оршихуйг мөшгих шиг чухал юм байдаггүйг олон хүн ойлгосон сон бол, Библийн ихээхэн түүх өөрөөр бичигдэх байсан. Гэтэл Бурханы оршихуйг их бага хэмжээгээр амталсан хүмүүс энэ амтыг тамшаалгүй, хэлээрээ түлхсэн нь тун эмгэнэлтэй. Тэд Бурханы оршихуйн хойноос эцэж цуцалгүй хөөцөлдөж байж л, тэндээс урт насалж удаан жаргахын амийг олдог гэдэг үнэнийг үл тоов. Тийм хүмүүсийн нэг нь Давидын холын хамаатан Уззиа хаан байлаа. Тэрбээр залуудаа Бурханыг эрэн хайсаар, аугаа амжилтанд хүрсэн боловчиг, хожим нь хаанаас амжилтаа олж авснаа умартсан. Сэхүүн Уззиа Эзэнийг мөшгихөө больж, адагтаа уяман өвчинд баригдан, ганцаар нас нөгчсөн билээ (2Шастир 26-г үзнэ үү).

ХАМГИЙН ТОМ ЭМГЭНЭЛ

Энэ мэт түүх Хуучин гэрээгээр дүүрэн бий. Гэхдээ хамгийн том эмгэнэл нь Давидын эцэг өвгөдийг буюу Абрахамын үр садыг Египетээс гарах үед тохиолддог. Бурхан тэднийг Өөр дээрээ авчрахын төлөө Египетээс чөлөөлснийг бид өмнө сурсан. Бурхан оршихуйгаа илэрхийлэхээр, тэднийг Өөртөө ойртуулахыг хүссэн боловч, “Бурханы байгаа түнэр харанхуйд Мосег ойртон очих үед ард түмэн хол зогссон” (Гэтлэл 20:21, тодруулгыг нэмэв) гэдэг нь тун харамсалтай. Даанч эмгэнэлтэй. Бурхан Өөрийгөө илчлээд байхад, хүмүүс ухарсан! Ганц Мосе л урагш тэмүүлж, ойртож очих халуун хүсэлтэй байв. Ийнхүү хүмүүсийн ийм авир үйлдлээс болоод Бурхан Өөрийнх нь өмнө ард түмнийг төлөөлөн зогсох тахилчийн үйлчлэлийг үүсгэсэн юм. Хүмүүсийн дунд Бурханы халхавч бүхий оршихуй байхын тулд Майхан сүмийг бий болгов. Тийнхүү Бурханы нарийн чанд зааврын дагуу барьж байгуулсан Майхан сүмийн тухай ингэж өгүүллрүүн:

Тэгтэл уулзалтын майхныг үүл бүрхэн ЭЗЭНий цог
жавхлан асрыг дүүргэлээ. ЭЗЭНий цог жавхлан асрыг
дүүргэж, дээр нь үүл багшран суусан тул Мосе уулзалтын
майханд орж чадахгүй байв (Гэтлэл 40:34-35, тодруулгыг
нэмэв).

БУРХАНЫ ОРШИХУЙН ӨӨР ӨӨР ТӨВШИН

Яг одоо сэдвээ түр орхиод, Бурханы оршихуй өөр өөр төвшинтэй байдаг талаар ярихгүй бол болохгүй. Дээр буй эшлэл дээрх *цог жавхлант оршихуй* гэдэг үийг тэмдэглэнэ үү. Анх Майхан сүм нээгдэх үед пүл хийтэл буусан Бурханы оршихуйн жин нь Бурхантай нүүр нүүрээрээ уулзаж ярилцдаг анд нөхөр Мосе нь ч даашгүй, хүчирхэг байжээ. Нэгэн зэрэг гайхамшиг, аймшгийг хослуулсан Бурханы бишрэм чанарын хүчдэлийг төсөөлж байна уу?

Олон жилийн дараа Аароны холын хамаатан болох шүүгч, тахилч Елиг удирдаж байх цагаар Бурханы оршихуй Майхан сүмд тун ховор байжээ. Үнэндээ Мосегийн орж чадаагүй тэр л газрын дэргэд ичих нүүргүй нүгэл хийж байсан тэр хүмүүс өөрсдөө ч дотогш нэвтэрч чаддаггүй байв. “Балчир хөвгүүн Самуел, Елигийн дор ЭЗЭНд үйлчилж байв. Тэр өдрүүдэд ЭЗЭНий үг ховор, үзэгдлүүд ч цөөн байв” (1Самуел 3:1). Эзэний үг яагаад ховор байв? Яагаад гэвэл Бурханы илчлэл, Үг инү Бурханы оршихуй дотор л явдаг. Оршихуй үгүй бол, илчлэл ч үгүй. Оршихуй өчүүхэн байвал, Бурханы илчлэл ч өчүүхэн, оршихуй их байвал, илчлэл ч том байна! Энэ бүлэг дээр Бурханы дэн (Түүний оршихуй) бүүдийсээр, хэзээ мөдгүй унтрах (огт оршихуйгүй) болох гэж байжээ. Эл явдал Елигийн захиргааны төгсгөл дээр буюу Филистинчүүд Эзэний авдрыг олзлох үед өрнөсөн юм. Ели амьдралынхаа эцсийн өдөр “алдар одов” гэсэн утга бүхий *Икабод* гэдэг нэрийг хэлсэн байдаг.

Нүглээс болж Эзэний оршихуй ховор бөгөөд олдошгүй байсан Елигийн өдрүүд шиг биш ч гэлээ бас Майхан сүм байгуулагдаж байсан үеийн сүр жавхланд хүрэхгүй боловч, Бурханы бодитой бөгөөд арвин илчлэлтэй үеүд олон бий. Тийм үед Бурхан алдраа пүл пал хийтэл буулгалгүйгээр, харин уран нарийн аргаар ойртдог. Тухай нь Иаковын жишээ байна. Тэрбээр Бурхантай барилдаж, нүүрийг нь харсан боловч, алдрыг нь үзээгүй юм. Гэхдээ энэ уулзалтын үр дүнд Иаков хувьсан өөрчлөгдөж, Бурханы илчлэл дотор өссөн (Эхлэл 32:24-30). Иошуа Эзэнийг үзэхдээ, өөртэй нь ярилцаж буй Нэгэн нь тэнгэрийн их цэргийн Удирдагч байна гэдгийг таниа ч үгүй. Гэтэл Мосе Эзэний царайг харъя хэмээн гуйгаад, “Намайг хараад амьд үлдэж чадах хүн байхгүй тул чи Миний нүүрийг харж чадахгүй” (Гэтлэл 33:20) гэдэг хариулт сонссон байдаг. Мосе Бурханыг хамаг цог жавхлангаар нь үзэх гээд чадаагүй байтал, Иошуа тэргүүтэй олон хүн Эзэний нүүрийг харсан атлаа амьд үлджээ. Яагаад? Тэд Эзэний алдрыг бүрэн эхээр нь үзээгүй юм.

ЭЗЭНИЙ ГЭРЭЛТ ЦАРАЙ

Эхлээд - Эзэний алдрын тухай товч ярьцгаая. Зарим хүн Эзэний алдрыг униар, үүл гэх зэрэг үзэгдэл гэж боддог юм шиг байгаа юм. Үүнээс ч “Өө, тэр орой Бурханы алдар цуглаан дээр буусан шүү” гэх зэрэг үгс үүддэг. Гэхдээ энэ нь Бурханы зөвлөгөөг мэдлэггүй үгээр хязгаарлаж, харанхуйлдаг юм (Иов 38:2-ыг үзнэ үү).

Нэгдүгээрт - Бурханы алдар нь үүл биш юм. Та “Тэгвэл яагаад Бичээс дээр Бурханы алдар үзэгдэх тоолонд үүл гардаг юм бэ?” гэж асууж магадгүй. Учир нь: Бурхан Өөрийгөө үүлээр халхалдаг. Бурхан маань дийлдэшгүй алдартай болохоороо, үүлээр нүүрээ халхлахгүй л бол, махан биетэй хамаг амьтад Бурханыг харуутаа газар дээрээ үхэх буюу. Өөрийнх нь царайг үзсэн хүн амьд үлдэхгүй гэдгийг Бурхан Мосед хэлснийг санаарай. Үүнээс дараагийн асуулт ургана: Тэгвэл Исаиа, Езекиел, элч Иохан нар Эзэний алдрыг үзэхээр барахгүй, амьд үлдээд энэ тухай бичсэн биз дээ? Хариулт нь тун энгийн: тэд биеэсээ гараад, сүнс дотроо байжээ. Хүний мөнх бус бие Ариун Бурханы төгс алдарт оршихуйд байж чадахгүй. Тэрбээр харанхуй үгүй, залгигч гал болой (Еврей 12:29, 1Иохан 1:5). Элч Паул Есүсийн тухай ингэж бичсэн:

Ерөөлт бөгөөд цор ганц хэмжээлшгүй Эрхт, хаадын Хаан, эздийн Эзэн цагт нь үүнийг харуулна. Түүнд ганцааранд нь үхэшгүй мөнх буй бөгөөд хүршгүй гэрэл дотор оршдог. Ямар ч хүн Түүнийг хараагүй бөгөөд харж чадахгүй. Түүнд хүндэтгэл ба мөнх ноёрхол нь байг! Амен (1Тимот 6:15-16).

Есүс хүмүүний үзээ ч үгүй, үзэж ч чадахгүй, хүрэшгүй гэрэл дотор орших. Үнэндээ Эзэн гэрлийг өмсдөг гэж магтаалч хэлсэн байдаг (Дуулал 104:2-ыг үзнэ үү). Паул чинь Дамаск явах замдаа Бурханы хүрэшгүй, алдарт оршихуйг цухас үзсэн хүн. Тэгээд энэ тухайгаа Агриппа хаанд ийн өгүүлдэг:

Хаантан, тэгтэл үд дунд зам дээр нарнаас ч хурц гэрэл тэнгэрээс гэрэлтэж, намайг болон надтай хамт явагсдыг хүрээлэн авахыг би харсан (Үйлс 26:13).

Паул Есүсийн царайг үзэлгүй, Есүсээс мандан, Ойрхи Дорнын нарыг бүрхэн сүүдэрлэсэн гэрлийг л үзэж! Паул Бурханы алдрын оршихуйд оржээ. Тухайн үед өглөө эрт юмуу орой үдэш бус, яг үд дунд болж байж. Би арван хоёр жил “нарлаг” Флоридад амьдрахдаа хэзээ ч нарны шил зүүж байгаагүй. Гэтэл хэдэн жилийн өмнө Лизатайгаа хамт Ойрхи Дорнод руу аялахдаа, нарны шил зүүхээс өөр арга байгаагүй! Цөлийн, хуурай уур амьсгалд нар хэт хурц байснаас гадна дээрээс нь экваторын бүстэй ойрхон байршил нь мөн хэд дахин хурцалж байв. Гэтэл Паул Есүсийн гэрэл Ойрхи Дорнын үд дундын нарнаас ч хурц байсан гэх! Үд дундын нар руу эгц харах гэж оролдож үзсэн үү? Хэцүү шүү. Ямар нэг юмаар халхавч хийж харах юмуу нар үүлний цаагуур орохгүй л бол, харах боломжгүй. Гэтэл Эзэний алдар энэ их гялбаанаас ч хурц ажээ.

Энэ нь ч сүүлчийн өдрүүдэд Эзэний алдар илэрхийлэгдэх үед нар харанхуйлна гэсэн хэлсэн Иоел, Исаиа хоёрын үгийг тайлж байна. “... ЭЗЭНий өдөр ирж байгааг харагтун. Тэнгэрийн одод болон түүний ордууд гэрлээ эс өгөх бөгөөд Нар мандахдаа харанхуйлж, сар гэрлээ үл тусгана” (Исаиа 13:9-10).

Үүнийг цааш нь тайлбарлая. Цэлмэг тэнгэрээс юу харагдах уу? Одод! Шөнийн тэнгэрээр дүүрэн од. Гэхдээ өглөө болж, нар мандах үед юу болдог уу? Одод хаачдаг уу? Одод маань нар дахин жаргах хүртэл нэг газар нуугдаж байгаад, харуй бүрий болмогц, байр байр руугаа яаран тогтдог уу? Мэдээж үгүй. Тэгэхээр яадаг байх нь уу? Одод өөрийн гэсэн алдрын төвшинтэй бол, нар бүр ч хүчирхэг алдартай байх нь. Тиймдээ ч нарны гэрэлд одод харанхуйлдаг ажээ. Одод байж л байгаа ч, харагдахгүй. Үүнтэй адил Есүсийг эргэж ирэх үед нар Есүсийн алдрыг барахгүй болохоороо, харанхуйлах ажээ. Байх нь байх боловч, харагдахгүй! Янзтай! Тиймээс л Паул “Түүнийг хүмүүн хараагүй бөгөөд харж чадахгүй” гэж бичсэнийг одоо ойлгов уу?

Эзэний оршихуй бусад бүх гэрлийг давна. Тэр болбоос бүгдийг залгих, төгс гэрэл. Тиймээс л Түүнийг хоёр дахь удаагаа ирэх үед “Түүний жавхланта сүр хүч, аймшгийн өмнө хүмүүс хадны агуй, газрын ангал уруу орно” (Исаиа 2:19, тодруулгыг нэмэв). Иохан ч хэлсэн:

Дэлхийн хаад, суутнууд, цэргийн жанжингууд, баячууд, хүчтэнүүд, боол хийгээд чөлөөт хүн бүр агуй болоод уулсын хаданд нуугдацгааж, уулс ба хадуудад хандан — Бидний дээр унаж, биднийг сэнтийд Залрагчийн нүүрнээс ба Хурганы уур хилэнгээс (нүүрнээс) далдлаач... гэнэ (Илчлэл 6:15-16, тодруулгыг нэмэв).

БУРХАНЫ АЛДАР ГЭЖ ЮУ ВЭ?

Энэ асуултад хариулцгаая. Үүнд хариулахын тулд бүгдээрээ Мосе, Бурхан хоёрын харилцааг дахин харах хэрэгтэй. Мосе Бурханы оршихуйг хүсээд зогсохгүй, алдрыг нь үзэхийг гуйжээ.

Тэгэхэд Мосе —*Алдраа* надад үзүүлээч, гуйж байна гэжээ (Гэтлэл 33:18, тодруулгыг нэмэв).

Алдрыг Еврейгээр *кабод* гэнэ. Стронгийн Библийн тайлбар толь дээр “юмны жин, гэхдээ зөвхөн сайн утгаар зүйрлэсэн ойлголт” хэмээн тодорхойлжээ. Түүнчлэн сүр жавхлан, баялаг, хүндэтгэлийг ч тодорхойлдог. Мосе Бурханаас “Хамаг л сүр жавхлангаараа үзэгдээч” хэмээн гуйсан байна. Үүнд нь Бурхан хэрхэн хариулсныг үзнэ үү:

“Би бүх *сайн сайхнаа* өмнүүр чинь өнгөрүүлж, ЭЗЭНий нэрийг чиний өмнө тунхаглана” (Гэтлэл 33:19, тодруулгыг нэмэв).

Мосе Бурханы хамаг л алдрыг хүсэн гуйтал, Бурхан өөдөөс нь “хамаг л *сайн сайхнаараа*” хариулжээ. Сайн сайхныг Еврейгээр *тоов* гэнэ. Энэ нь “Бүх талаараа сайн” гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, ямар ч харамгүй, цөм сайн.

Дараа нь Бурхан “Эзэний нэрийг өмнө чинь тунхаглана” гэсэн. Газрын хаадыг сэнтийн өрөөнд залрахаас өмнө шадар түшмэд нь хааныхаа нэрийг тунхагладаг. Тэгээд хааныг залран орж ирэх үед бүрээ цангинана. Хэн нь хаан болохыг хэн ч андуурахааргүй болтол нь хааныхаа сүр хүчийг мандуулан зарлана. Хааны сүр хүчинд бүх хүн эмээн бөхийнө. Гэтэл тэр хаан ямар ч бараа бологчгүй, жирийн хувцас хунартай, гудмаар алхалж явбал, яах уу? Үнэндээ, ордны хүндэтгэлийн сүрдэм дэг жаяг байхгүй болохоор, олон хүн түүнийг хэн болохыг нь ч мэдэлгүй, зүгээр л зөрж өнгөрөх байх. Тэр хааны оршихуй сэнтийн өрөөнд байсан шигээ нүдэнд тусмаар, биширмээр байхгүй л болов уу. Үндсэндээ, Бурхан Мосед “бүх сайн сайхнаа өмнүүр чинь өнгөрүүлж, нэрээ тунхаглана” хэмээхдээ, Мосегийн төлөө чухам үүнийг л хийсэн юм.

Шинэ гэрээнд Есүс Христийн царайнаас Эзэний алдар илчлэгдсэн гэдэг (2Коринт 4:6). Эзэний оршихуйд орсон олон хүн Есүсийг үзсэн, Түүний царайг үзсэн тухайгаа гэрчлэн ярьдаг. Энэ нь ч магадлалтай.

Гэхдээ тэр хүмүүс Есүсийн алдрыг бүрэн эхээр нь үзээгүй нь тодорхой.

Зарим хүн “Дагалдагч нар үхлээс амилуулагдсан Есүсийн царайг харсан биз дээ?” гэх байх. Энэ ч бас үнэн хэдий ч, тэд ч мөн Эзэний алдрыг нэвт шувт үзээгүй. Хуучин гэрээнд Эзэний оршихуйг үзсэн боловч, Эзэний алдар илчлэгдэхийг үзээгүй хүмүүс байсныг би өмнө хэлсэн. Эзэн Абрахамд Мамрегийн царс модны дор үзэгдэхдээ, алдраа үзүүлээгүй байдаг (Эхлэл 18:1-2). Иаков Бурхантай барилдсан, Иошуа (Иошуа 5:13-15) тэргүүтэй олон хүн Эзэнийг таниа ч үгүй.

Иошуа Иерихо руу дайрахаасаа өмнө Эзэний царай руу харах үед Эзэн Дайчны төрхөөр үзэгдсэн байдаг. Иошуа Түүнийг хэн болохыг нь мэдэлгүй, “Та манай тал уу, дайсны тал уу?” гэж асуусан. Тэгтэл Эзэн Өөрийгөө Эзэний их цэргийн Удирдагч болохоо илчлээд, зогсож буй газар нь ариун тул шаахайгаа тайлахыг Иошуд тушаав! Иаков Эзэнтэй үүр цайтал шөнөжин барилдахдаа, “Нэрээ хэлээч” (Эхлэл 32:29) гэж хашхирсан байдаг. Бүгдээрээ нөгөө хэнд ч танигдалгүй, гудмаар алхалж яваа, энгийн хувцастай хаан руугаа эргэе. Энэ жишээ нь Иошуа, Иаков хоёрт тохиолдсон явдалтай таардаг боловч, Эзэн Өөрийгөө тэдэнд ихээхэн илчилсэн нь үнэн юм.

Амиллын дараа ч ялгаагүй ийм л явдал болсон. Есүс хамгийн түрүүнд Магдалын Мариатай ярилцсан бөгөөд Мариа Есүсийг цэцэрлэгчтэй эндүүрчээ (Иохан 20:15-16). Дагалдагч нар эрэг дээр Есүстэй хамт өглөөний цайндаа загас идэх үедээ (Иохан 21:9-10), анхандаа Есүсийг Өөрийг нь ч, Есүсийн дуу хоолойг ч таниагүй. Тэгсээр Есүс тэдний танил нэгэн зүйлийг үйлдэх үед нь л таньсан байдаг. Мөн Есүс үхэхээсээ өмнө юу, юу болохыг ярьж өгч байсан хоёр дагалдагчтайгаа амилсныхаа дараа уулзаад, хамт алхаад байхад л “нүд нь халхлагдсан” (Лук 24:16) хоёр дагалдагч нь Есүсийн царайг ч, дуу хоолойг нь ч таниагүй. Дагалдагч нар Есүсийн алдрыг нь нэвт шувт үзээгүй боловч, царайг нь үзэж, дэргэд нь байхдаа, оршихуйгаас нь илчлэл хүлээн авчээ.

Тэгвэл эсрэгээрээ, элч Иохан Патмос арал дээр, Есүсийг Сүнс дотор үзэж, алдар дотор нь харсан нь нөгөө эрэг дээр өглөөний цай уусан явдлаас тэс өөр зиндааны үйл явдал байжээ. Элч Иохан Есүсийг “Тэр баруун мутартаа долоон од барьж, хоёр талдаа иртэй хурц илд амнаас нь цухуйх бөгөөд нүүр нь хурцаар гэрэлтэх нар мэт байв. Би Түүнийг хармагц хөлд нь, үхсэн мэт уналаа” (Илчлэл 1:16-17) гэжээ. Иохан Эзэний алдарт оршихуйн хүчинд цохиулахдаа, үхсэн мэт навс унасан байна.

Эзэний алдар л Бурханыг Бурхан болгодог. Үүнд Бурханы зан чанар, эрх мэдэл, эрх хүч, цэц ухаан - Түүний хэмжээлшгүй жин, хүчдэл нь

нууцалсан, нөөцөлсөн зүйлгүй, бүрэн эхээрээ, цөм багтах! Энэ сүр жавхлантад алдрыг Бурханы зөвхөн хөл, нурууг хальт үзсэн Мосе шиг зэрвэс үзэж болох. Эсвэл Дамаск руу явах замдаа хэлбэр дүрсгүй, дан хүрэшгүй гэрэл, дуу хоолойтой уулзсан Паул шиг үзэж болно.

БУРХАНЫ ОРШИХ ГАЗАР

Бүгдээрээ Абрахамын үр сад руу дахин эргэе. Бурхан Синай уулан дээр анх оршихуйгаа илэрхийлэх үед хүмүүс “Бидний Бурхан ЭЗЭН бидэнд *Өөрийнхөө сүр жавхлан (алдраа)*, аугаа чадлаа үзүүллээ. ...Тэгэхээр бид одоо юунд үхэх ёстой юм бэ? Энэ их гал биднийг залгина. Хэрэв бид ЭЗЭН Бурханыхаа дууг цааш нь сонсвол үхнэ” (Дэд хууль 5:24-25, тодруулгыг нэмэв) хэмээн уйлалдсан. Амиа бодсон аргадаа битүүрсэн ухамсартай тэр хүмүүс Бурханы жавхлантад оршихуйг тэвчиж чадаагүй.

Тэгтэл Майхан сүм байгуулагдаж, Бурхан ч үүний “Ариунаас ариун газар” гэгдэх дотоод хэсэгт орших болжээ. Тэр газар руу тэргүүн тахилч жилдээ ганц нэвтэрнэ. Үүний тулд эхлээд өөрийнхөө болоод ард түмнийхээ нүглийг цагаатгуулах цусан тахил өргөдөг хүрэл тахилын ширээ байршдаг гадаад талбайгаар нэвтэрнэ. Дараа нь тахилын ширээний дэргэдийн угаалтуурт өөрийгөө угаана. Тэгээд хөшгөөр тусгаарласан Ариун газарт нэвтэрнэ. Тэнд байгалийн гэрэл тусахгүй. Зөвхөн бидний Гэрэл - Есүсийг төлөөлөх (Иохан 9:5) алтан суурь бүхий лааны гэрэл л асаатай. Түүнчлэн тэнд бидний Амийн талх - Есүсийг (Иохан 6:48) төлөөлөх үзүүлэнгийн талх байна. Тэнд байх гурав дахь эд зүйл нь хэзээ ч үл тасрах залбирал, хүндэтгэлийг төлөөлөх утлага бүхий тахилын ширээ байна.

Гэхдээ тахилч Бурханы оршихуйн газар руу бас л нэвтрээгүй байна. Өөр нэгэн хөшиг Ариунаас ариун газар, Ариун газар хоёрыг тусгаарлана. Ариунаас ариун газарт өршөөлийн суудлын дээр Бурханы бодитой, ил оршихуй заларна. Есүсийг сүнсээ өргөх үед “Сүмийн хөшиг дээрээсээ доош хүртэл хоёр хэсэг болон цуурсан” (Матай 27:51) гэдэг нь яг энэ хөшиг юм. Доороосоо дээшээ бус, дээрээсээ доошоо гэж байгааг тэмдэглээрэй. Бурхан л энэ хөшигийг эзэмшдэг байсан бөгөөд эдүгээ Тэрбээр нүүж гарах болж! Бурхан өнө эртнээс мөрөөссөөр ирсэн, оршин суух шинэ газартаа буюу дахин сэргээгдсэн хүүхдүүдийнхээ зүрхэнд суурьшихад элэн болжээ. Тэгвэл энэ нүүдэл суудал нь хэзээ өрнөсөн бэ? Тавин гурван хоногийн дараа, Пентекост өдөр Бурхан өнө эртнээс мөрөөссөн сүмдээ нүүж орсон юм.

Бурханд ойрт

Хүчит хуй салхи мэт чимээ тэнгэрээс гэнэт гарч, тэдний сууж байсан байр бүхэлдээ үүнд автжээ. Тэгтэл галынх мэт хуваагдсан хэлүүд бий болон хүн нэгбүр дээр буув. Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв (Үйлс 2:2-4).

Мосег майхан сүмийнхээ ажлыг дуусгасан хойно л Эзэний оршихуй тэнд суурьшсан шиг Есүсийг “Түйцэлдлээ! гээд, тэргүүнээ гудайлган сүнсээ өргөх” (Иохан 19:30) үед л Эзэн мөнхийн Хурганы цусаар бэлэн болсон оршихуйн шинэ газартаа нүүж оржээ.

Иймд ах дүү нар аа, бидэнд Есүсийн цусаар, махбод болох хөшгөөрөө дамжуулан Түүний нээсэн шинэ, амьд замаар ариун газарт нэвтрэн орох итгэл байгаа тул, мөн бидэнд Бурханы гэр дэх аугаа Тахилч байгаа тул хилэнцэт мөс чанараас цэвэрлэгдэхийн тулд зүрхэндээ цацуулж, биеэ ариун усаар угаалган, итгэлийн дүүрэн баталгаатай, үнэн зүрхээр *ойртон очицгооё*. Найдвараа хүлээн зөвшөөрснөө гуйвалгүй бат баримталцгаая. Учир нь Амлагч нь итгэмжит билээ (Еврей 10:19-23, тодруулгыг нэмэв).

“Ариунаас ариун газарт” оршин буй Нэгэн рүү *ойртож очих* зориг бидэнд бий! Бурхан эдүгээ майхан юмуу сүмд бус, бидний биед оршин суугаа! Тийм ээ, Бурхан Есүсийн цусаар ариусгагдсан хүмүүний зүрхэнд нүүж орсон. Бид Бурханыг дуудахдаа, ихэвчлэн хэдэн сая бээрийн холхи газарт орших сэнтийн өрөөг төсөөлдөг. Гэтэл үгүй юм. Бурхан бидний зүрхэнд орших! Бид дотогшоо өнгийхийг хараахан сураагүй, гадагшаа л өнгийсөөр байна! Шинэ гэрээний Бичээс маш энгийнээр “Зүрхэндээ “Хэн тэнгэрт гарах вэ?” гэж бүү хэл” (Энэ нь Христийг доош авчрахын тулд юм)” (Ром 10:6) гэдэг.

Тийм ээ, гурав дахь тэнгэрт Бурханы сэнтий бодитоор оршино. Гэхдээ хүмүүстэйгээ ойр дотно байхыг хүссэн Бурхан маань Хуучин гэрээний үед газар дээр майхан сүмд ирж суурьшсан бол, өнөөдөр амьдралаа Есүст өргөөд, Есүсийн Сүнсээр дүүрэхийг хүсэн гуйсан хүмүүсийн зүрхэнд оршин суух болжээ. Бурхан хамгийн хайртай, дуртай объекттайгаа хамгийн ойр газрыг л Өөрийн болгосон байна. Бид зүрхэнд минь орших Бурханд ойртож очихдоо, сая сая бээрийн алс холхид орших сэнтийн өрөөнд ч давхар нэвтэрдэг. Яаж тэр вэ? Бурханы Сүнс дотор алслал үгүй. Түүний оршихуй дотор байх нь Аавтай, Есүстэй

сэнтийн өрөөнд байхтай л ижил. Учир нь Тэрбээр Аавын ч, Есүсийн ч Сүнс болой (Ром 8:9-ийг үзнэ үү).

Бичээч “Найдвараа хүлээн зөвшөөрснөө гуйвалгүй бат баримталцгаая. Учир нь Амлагч нь итгэмжит билээ” гэсэн байгааг тэмдэглээрэй. Түүнчлэн:

Энэхүү найдвар бидэнд сэтгэлийн зангуу мэт бөгөөд найдвартай хөдөлгөөнгүй агаад хөшигний дотуур (*Оршихуйд*) нэвтрэн ордог (Еврей 6:19, тодруулгыг нэмэв) ч гэдэг.

Хуучин хөшигийг цуулсан нь энэ дэлхий дээрх итгэгч хүн бүрт Бурханы оршихуйд цоо шинэ, амьд арга замаар нэвтрэх зам тавьжээ. Хөшиг эдүгээ бидний махан бие болжээ. Махан биеэ загалмайд хадах юмуу няцаасаар махан биеийнхээ гадна талбайд гарч ирж чадсан хүн (Галат 5:24-ийг үзнэ үү) “Ариунаас ариун” руу нэвтрэх бөгөөд тэнд мөнхөд үргэлжлэх амьд харилцаа бүрэн нээлттэй. Бурханы бодит оршихуйтай туждаа хамт байна. Бид чин зүрхээрээ ойртох аваас, Бурхан оршихуйгаа хэзээд нээлттэй хэмээн амласан! Бурхан тодорхой, тогтоосон цагт л оршихуйгаа нээнэ гэж хэлээгүй! Хүмүүс Бурханд үнэнч аваас, Бурханы оршихуй Майхан сүмд туж байсан шигээ, бидний зүрхний майхан сүмд ч туж оршино.

Иаковын үгийг дахин сонсоно уу “Бурханд ойрт. Тэгвэл Тэр та нарт ойртоно.” “Өмнө маань тавигдсан найдварыг барьж авахаар хоргодох газар уруу зугтаагч бид Бурханы хувьд худал айлдах боломжгүй, өөрчлөгдөшгүй хоёр зүйлээр дамжуулан хүчтэй урам авахын тулд тэгжээ” (Еврей 6:18). Ямар найдвар вэ? Бид Түүн рүү ойртбол, Тэр бидэн рүү ойртоно гэсэн найдвар! Энэ баталгаатай!

Тэгвэл, бид яагаад Бурханы ил оршихуйд эс дурлана вэ? Эй. Даблю. Тозер гуай ийнхүү халаглажээ:

Есүсийн махыг уран байж хөшиг цуулагдсанаас хойш Бурханы зүгээс хориглох ямар ч саадгүй байтал, бид юунд саатна вэ? Яагаад бид бүх насаараа Ариунаас ариуны гадна суурьшиж байгаадаа ханаж цадаад, Бурханыг ширтэхээр цааш үл нэвтэрнэ вэ? Сүйт хархүү “Үзэмж зүс чинь жавхаалаг, өөрийн чинь дуу цовоолог тул Өнгө эгшгээ сонсгоод өөрийгөө нэг үзүүлээч” (Соломоны дуун 2:14) гэсэн. Энэ бол биднийг дуудсан дуу гэдгийг мэдрээд байгаа

Бурханд ойрт

хэрнээ л бид ойртдоггүй. Тийнхүү он жилүүд өнгөрсөөр, бид ч майхан сүмийнхээ гадна талбай дээр өтөлж, хөшинө. Бидэнд юу саад хийнэ вэ? (*The Pursuit of God* номын 41-ээр нүүр)

Тэгэхээр, бидэнд юу саад хийнэ вэ? Яагаад бид өөрийнхөө хүчээр хийх гэж махаа идэн, сохроосоо болоод зорилгодоо эс хүрнэ вэ? Хэзээ ч хөсөрдөхгүй амлалтаар давхар баталгаажсан гайхамшигтай найдвар өгөгдсөөр байтал, юунд сэтгэл үл ханан, цааргална вэ? Итгэгч хүн бүрт нээлттэй, Бурхантай тогтоох нөхөрлөлд маань юу садаа болдгийг цааш цаашдын бүлгээрээ олж мэдэцгээе.

СУДЛАХ АСУУЛТ

1. Бүлгийхээ эхэнд “Тэгвэл яагаад үй олон хүн Бурхантай оюуны харилцаанд гарын үсэг зурна вэ? Яагаад бид Христийн оршихуйгүй Христэд итгэх итгэлийг байгуулахыг зорино вэ? Бурхантай дотносолгүйгээр яаж сэтгэл хангалуун байж сураа вэ? Яагаад бид хүмүүсийн дотор Бурхан руу ойртож, Түүний оршихуй дотор амьдрах гал хүсэл байгуулахгүй Христэд итгэх итгэлийг заадаг болчихсон юм бэ?” гэж асуусан.

Та үүнд хэрхэн хариулах вэ?

2. Сэтгэл судлал дээр сүүлийн таван жил тогтоосон харилцаа нь хүний хувь чанарыг хэлбэршүүлдэг гэдэг. Бичээс ч “Аягүй муу нөхөрлөөн аятай ёсзүйг ялзалмуй” (1Коринт 15:33), “Мэргэнийг дагавал мэргэн. Мулгуутай нөхөрлөвөл хорлол” (Сургаалт үгс 13:20) гэдэг. Энэ хоёр туйлын аль нэг рүү хадуурч явсан тохиолдол танд бий юу? Тэгээд юунд хүрсэн?

Зургадугаар бүлэг

БУРХАНЫ АНД НӨХӨР



Бурхан тэдэнтэй дотносохыг хүссэн ч,
тэд дотносохыг эс сонгов.

Эхний хэдэн бүлгийг бичих зуураа дотроо ер бусаар ангаж суулаа. Иймэрхүү юмсын талаар ярихаар, дотор гал дүрэлзэж, биднийг дэндүү гэмээр хайрласан Бурханы араас улам л хөл алдмаар санагддаг юм. Гэхдээ нэг зүйлийг анхаарууштай. Бурхан амархан олз биш шүү. Тэрбээр ариун бөгөөд аугаа Хаан учраас зохих ёсоор нь хүндэтгэх ёстой. Тиймээс “ариун эмээхүйг” ярилгүйгээр “Бурхан руу ойртох” талаар ярилтгүй.

ЗАМ САЛАХ

Яг энэ уулзвар дээр “эрэлчдэд чимэгтэй мэдээ”, үнэн хоёр зам салдаг. Хүмүүнийг хүсэмжилдэг, хүнийг ерөөхийн мөрөөсөл болсон Бурханы тухай өгүүлдэг, бүх урсгал чиглэлд байж л байдаг тэрхүү чимэгтэй мэдээ нь Бурханы ариун чанарыг орхигдуулдгаараа алдаатай. Хөөрхий, ихэнх нь сайн санааны улмаас л үйлдэнэ. Зарим нь хуульчлалын аюулыг хөндлөнгөөс нь харах юмуу биеэрээ үзсэн байдаг бол, зарим нь хүмүүсийг хайрлаж, санаа тавьсандаа л тэгэх. Гэтэл нөгөөтэйгүүр

бас дагалдагч нараа өсгөх үүднээс зориуд дутуу номлох ч тал байдаг нь эмгэнэлтэй.

Хуульчлалын атгаас мултарсан хойноо бидний хуульгүй, дэлхийн явдлыг өнгөрөөдөг, хэзээд ойлгодог, хайрын Бурханыг номлодог болсон хүмүүс нь сэдэл, тактикаа халдашгүй дархан байлгана. Тэд энэ Үг зөвлөгөөгөө Бурханы оршихуйгаас тээж гарч ирээгүй. Хэрэв үнэхээрийн тэгсэн бол, Бурхан руу ариун хайр, эмээхүйгээр хиллэсэн замаас өөр ямар ч замаар ойртож очихгүйг ойлгох байсан.

Санасан зорилгодоо хүрэх гэсэн тэдний мэдээнд “амархан Эзэн” гарна. Эзэнээс эмээхүйг орхигдуулсан тэр мэдээ нь үндсэндээ хүний өмнүүр “Бурханы оршихуйг” хаадаг.

МЭХИЙН ХҮНДЭТГЭХ

Бурханы оршихуйд орох хүмүүст хэзээ ч хувирашгүй, мөнхийн нэгэн үнэн хэрэгжих. Үүнийг Бичээс түс тас хэлжээ:

Ариун хүмүүсийн чуулалд Бурханаас эмээнэ. Түүнийг тойрох бүхнээс Тэрээр аугаа болоод сүрдмээр (Эргэн тойрныхон нь бүгд мэхийн хүндэтгэх) (Дуулал 89:7).

Эшлэлийн хоёрдугаар хагасыг дахин уншъя. “Эргэн тойрныхон нь бүгд мэхийн хүндэтгэх.” Тэгэхээр, “Өөрийг нь үл хүндэтгэсэн уур амьсгал дунд Бурхан оршихуйгаа илэрхийлдэггүй” нь хөдлөшгүй үнэн ажээ. Бурханыг дээд зэргээр эрхэмлээгүй, үнэлээгүй, хүндэтгээгүй газарт Бурхан айлчлахгүй, оршихгүй. Хичнээн супер дуутай, “хүндэтгэл мөргөлтэй”, номлол хичээлтэй, бичээсийн дагуу залбирдаг байлаа гээд Бурханыг эмээн хүндэтгэхгүй бол, Бурхан Өөрийгөө илчлэхээр ойртож ирэхгүй. Энэ нь Ели бөгөөд түүний хоёр хүүгээс ялгаа юун.

Зуу зуун, мянга мянган итгэгч хуран цугласан танхимд явж орох үед харамсалтай нь Бурханы оршихуйн мөр ч үгүй байх нь олонтаа. Шалтгаан нь: хүмүүс, заримдаа бүр удирдлага нь ариун эмээхүйгээр хомсдох. Магтаал хүндэтгэлийн баг нь туг далбаа намируулсан, уян бүжигчидтэй, уран хөгжимчидтэй, уянгалаг дуучидтай - мундаг байж болно. Цуглаан нь шинэ санаачилгатай, боловсронгуй техник, медиатай ч байж болно. Үйл ажиллагаа нь бүтээлч бөгөөд хүмүүсийг хөгжилтэй найрсаг уур амьсгалаар угтаж, сонирхолтой сэдвээрээ татдаг ч байж болно. Гэхдээ нэг юм дутагдсаар байна. Тэр уур амьсгал

Бурханы анд нөхөр

Бурханы оршихуйгаар хоос оргино. Тэгээд хамгийн эмгэнэлтэй нь уур амьсгал хичнээн хөндий хоосон байгааг дийлэнх нь мэдэх ч үгүй. (Энэ дашрамд, харилцааны шинэлэг арга нь хэзээд сэргэг зүйл бөгөөд Бурханы оршихуйн илрэлд хэзээ ч саад болдоггүйг хэлэх хэрэгтэй. Ийм тэргүүлэгч газруудад Бурханы оршихуй цалгиж байхыг би үзсэн. Бурханы оршихуй нь технологитой, технологигүйгээс болдоггүй, харин зүрхний нөхцлийг тусгадаг юм.)

Ийм нөхцөлд Эзэн дуулгавартай байдал, Эзэнээс эмээхүйг зааж өгөхийг надад үүрэг болгодог бөгөөд гэмшилд дуудах бүрийд хүмүүсийн дийлэнх хувь нь - тэр дундаа удирдагч нар ч хариу үйлдэж байхыг би үзсэн. Тэгээд залбирч ч амжаагүй байтал, Бурханы оршихуй багтай илэрхийлэгдэж, хүмүүс уйлж эхэлдэг. Яагаад ийм зүйл болдог вэ? Яагаад гэвэл Бурхан Өөрийг нь хайрладаг, хүндэтгэдэг, эмээдэг хүмүүст ойртдог. Ийм л учраас, Иаков:

Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Нүгэлт та нар гараа цэвэрлэ. Хоёр санаат та нар зүрхээ ариусга (Иаков 4:8-9) гэжээ.

Анх энэ эшлэлийг харбал, Иаков аврагдаагүй хүмүүст буюу бидний “нүгэлтэн” гэж нэрлэдэг хүмүүст хандсан мэт. Гэвч Иаков яриан дундаа сонсогч нарыгаа арван таван удаа *ахан дүүс* хэмээн дуудсан учраас, тэрбээр үнэндээ дахин төрсөн хүмүүст хандан өгүүлжээ.

Тэгэхээр, нүгэлтэн гэдэг үгийг үзье. Энэ нь *хамартолоос* гэдэг Грек үг ажээ. Үүнийг Вайны толь бичиг дээр “хүн байнаасаа зөрөх” хэмээн үгчлэн тодорхойлдог. Энэ үгээр аврагдаагүй хүнийг тодорхойлох нь зүйтэй боловч, Христэд итгэдэг хүний талаар ярихдаа ч ялгаагүй хэрэглэж болно. Дээрх агуулга дээр байнаасаа зөрж сэтгэснээсээ болоод ахин дахин буруу үйлдэл юмуу зан авир гаргаж байгаа итгэгч хүний талаар өгүүлжээ. Иаков цааш нь “Хоёр санаат та нар зүрхээ ариусга” гэдэг мэдэгдлээрээ итгэгч хүн байнаасаа зөрөөд байгаагийн үндсэн асуудлыг заасан байна.

Эзэнээс эмээхүй нь хүний зүрхнээс эхээ аваад, гадаад үйлдлээр нь илэрдгийг ойлгох ёстой. Бурхан нэгэнтээ Өөрийнхөө хүмүүсийн талаар ийнхүү айлдсан бөгөөд “ойртох” гэдэг үгийг нь цохон тэмдэглэнэ үү:

“Энэ ард түмэн амаараа *ойртон*, Уруулаараа л Намайг хүндлэвч, Зүрх нь Надаас алс хол байдаг. Тэд Намайг эмээн хүндлэхэд хүний тушаалаар суралцжээ... (Исаиа 29:13, тодруулгыг нэмэв).

Бурхан руу ойртох нь юу юунаас илүүтэй хэзээд Бурханаас эмээдэг, Бурханыг хайрлаж явдаг зүрхнээс л эхэлнэ. Энэ нь зөвхөн гадаад үйлдэл бус, зүрхний дотор сэдэл мөн. Тиймээс Эзэнээс эмээхүйг тодорхойлох үүднээс эхлээд зүрхний хандлагын талаар ярих хэрэгтэй.

За эхэлцгээе: Бурханаас эмээхүй нь Түүнийг дээдийн дээрээр үнэлж, хүндэтгэж, өргөмжлөхийн сацуу бишрэх, сүрдэх, эрхэмлэх гэсэн утгатай. Бурханыг, Бурханы оршихуй, зарлиг, хүслийг нь оройлон дээдэлж, хүндэтгэн чичрэх. Энэ бүхэн зөвхөн эхлэл нь гэдгийг мэдээрэй.

БУРХАН РУУ ХҮНДЭТГЭЛГҮЙ ИРЭХ

Зарим зүйлийг ойлгохын тулд заримдаа эсрэг утгыг нь мэдэх тустай байдаг. Бурханы оршихуй руу хүндэтгэлгүй очихын онцсайн жишээг Аароны хоёр хүүгийн амьдралаас үзэж болно.

Майхан сүмийг дуусгахын босгон дээр Эзэн “Надад Израилийн хөвгүүдийн дундаас Аарон ахыгаа мөн түүний хөвгүүд Надаб, Абиху, Елеазар, Итамар нарыг тахилчийн албанд өөртөө авагтун” (Гэтлэл 28:1) хэмээн Мосед зааварлажээ.

Энэ эрчүүд Эзэнд үйлчилж, ард түмнийхээ төлөө ангал дээр зогсохын төлөө тусгаарлагдан, сургагджээ. Тэдэнд Бурханы оршихуй руу нэвтрэх эрх соёрхогдож. Тэдний хүндэтгэл мөргөлийн үүрэг, параметр нь Мосегоор дамжуулан Бурханы тушаасан тусгай зааврын дагуу тогтоогдсон байв. Сургагдаж дуусаад, ариусгагдах үед нь Бурханы оршихуй майхан сүмийг дүүргэж, тэдний үйлчлэл ч эхэлжээ.

Гэвч майхан сүм дотор үзэгдсэн, Эзэний алдрыг нүдээр үзсэн Аароны хоёр хүү энэхүү эрхэм үүргээ тун эрт дуусгажээ. Хожим:

Аароны хөвгүүд Надаб, Абиху нар өөр өөрсдийн бойпрыг авч, дотор нь гал хийгээд дээр нь утлагат тахилыг тавьж өөрсдөд нь ЭЗЭНий тушаагаагүй *ёс бус* (бузартай) галыг Түүний өмнө өргөв (Леви 10:1, тодруулгыг нэмэв).

Надаб, Абиху хоёр Эзэний оршихуйд *бузартай* галыг өргөжээ. Бузартай гэдэг үгийг *Уэбстерийн толь бичиг* дээр “Ариун юмст хүндэтгэлгүй, жигшилтэйгээр хандах” гэдэг. Өөрөөр хэлбэл, Бурханы ариулан нандигнадаг зүйлст байдаг л юм мэт мэдэмхийрэн хандахыг хэлнэ. Тэр хоёр эр Эзэний хүндэтгэл мөргөлд тусгайлан зориулагдсан бойпорыг аваад, Бурханы зааварласан ёсоор бус, өөрсдийнхөө

Бурханы анд нөхөр

хүссэн гал, утлагаар дүүргэжээ. Ийнхүү ариун юмсыг мэдэмхийрэн, дуулгаваргүй авирласан.

Тэд Эзэний оршихуйд нэвтрэхдээ, ариун зүйлсийг мэдэмхийрэн, зөвшөөрөөгүй, хүндэтгэлгүй тахилыг өргөсөн байна. Тэгээд дараах явдал болжээ:

ЭЗЭНээс гал гарч ирэн тэднийг залгиж, тэд ЭЗЭНий өмнө үхэцгээв (Леви 10:2).

Тэр хоёр хүн үл хүндэтгэлийнхээ улмаас газар дээрээ шүүгдэн, үхэлд хүрчээ. Тэд чухам Бурханы оршихуйн өмнө ийн хүндэтгэлгүй авирласан бөгөөд тахилчийн зэрэг зиндаа нь тэднийг Бурханыг хүндэтгэх үүрэгт албаас чөлөөлөөгүй байна. Тэд ариун Бурхан руу мэдэмхий хандлагаар ойртон, нүгэл үйлдэв! Тэд Бурханы оршихуйг байдаг л юм мэт үзсэн! Энэ шүүхийн дараа Мосе юу хэмээснийг үзнэ үү. Ингэхдээ, *Надад ойртон* гэдэг үгийг тэмдэглээрэй:

“*Надад ойртон* ирэгсдээр дамжин Би Өөрийгөө ариун хэмээн үзүүлж, бүх ард олны өмнө Би алдаршуулагдах болно” гэж ЭЗЭНий айлдсан зүйл нь энэ юм гэв. Тэгэхэд Аарон дуугүй байлаа (Леви 10:3, тодруулгыг нэмэв).

Энэ бол мөнхийн бөгөөд ертөнцийн зарлиг болой. Бурхан руу ойртож очиж байгаа хүн Бурханд хөнгөн юмуу мэдэмхий хандахгүйг Бурхан зарлигджээ. Бурханы оршихуйд байгч бүхэн Бурханыг ариулан дээдэлж, хүндэтгэлээ сахих ёстой.

Өөрийнх нь оршихуй дотор үл хүндэтгэл амьдрахгүйг Эзэн тодорхой анхааруулсаар байхад, Надаб, Абиху хоёр мэдэмхийрчээ. Тэгвэл өнөөдөр ч ялгаагүй. Бурхан хэвээрээ! Бид үл хүндэтгэлээр Бурханы оршихуйд нэвтрэнэ гэж найдалтгүй!

Танил талаараа мултарчихна гэж горьдолтгүй. Надаб, Абиху хоёр Мосегийн хамаатнууд, Аароны төрсөн хөвгүүд байсан атлаа цорын ганц шударга Нэгэний шударга чанарыг үл хэрэгсжээ. Үнэндээ Мосе Ааронд болоод Аароны үлдсэн хоёр хүүд “талиийгаачдын араас гашуудаад байвал, өөрсдөө ч үхэж болзошгүйг” анхааруулж хэлсэн байдаг. Энэ хандлага нь Эзэнийг үл хүндэтгэсэн явдлыг өөгшүүлсэн хэрэг болох байсан тул Надаб, Абиху хоёрын цогцсыг бушуухан хуарангаас гаргаад, оршуулжээ.

Хоёр талийгаач Бурханы тусгай зааварт хөнгөн ханджээ. Эзэнээс

эмээдэггүй, хүндэтгэлгүй зүрх сэтгэл нь адагтаа дуулгаваргүй үйлдэлд хүргэжээ. Тэгэхээр тэр нүглийн уг үндэс нь Эзэнээс эмээдэггүй зүрх болох нь харагдаж байна.

БУРХАНААС АЙХ, БУРХАНААС ЭМЭЭХИЙН ЯЛГАА

Синай уулан дээр Бурхан Израилийн хүүхдүүдэд үзэгдэх үед Израиль Бурханы оршихуйд зогсож дийлээгүй. Шалтгаан нь: Израиль Эзэнээс эмээдэггүй байв. Учир нь тэднийг Эзэний оршихуйгаас гарах үед Мосе:

“Бүү ай. Учир нь Бурхан та нарыг зөвхөн шалгахын тулд ирсэн. Мөн Түүнээс эмээхүй нь та нарт байж та нарыг нүгэл бүү үйлдээсэй гэсэндээ ирсэн юм” (Гэтлэл 20:20) гэсэн байдаг.

Мосе: “Бурхан “Өөрөөс нь эмээхүй та нарын өмнө” байгаа эсэхийг харахаар ирсэн тул “Бүү ай” гэжээ. Утгын хувьд зөрчилдсөн мэт үг боловч, үнэндээ үгүй юм. Мосе Бурханаас айх болоод эмээхийн ялгааг тодруулжээ. Маш том ялгаа байх. Нууц ихтэй хүн л Бурханы оршихуйн шижир гэрэл хамаг явдлыг нь ил болгочих бий хэмээн айж, сүрдсэндээ, Бурхан руу ойртож очихыг хүсдэггүй. Паул “Харин бүх зүйл гэрлээр илчлэгдэхдээ харагддаг” (Ефес 5:13) гэсэн.

Бурхан биднийг айх бус, эмээж явахыг хүсдэг. Паул “Бурхан бидэнд айдсын сүнсийг өгөөгүй” (2Тимот 2:7-г үзнэ үү) гэсэн бол, Иохан “Хайр дор айдас үгүй. Харин төгс хайр нь айдсыг хөөн зайлуулна. Учир нь айдаст ял байдаг” (1Иохан 4:18) гэдэг. Тэд Эзэнээс эмээхүйн тухай бус, харин айдсын сүнсний талаар өгүүлжээ. Учир нь Шинэ гэрээний бичээч нар мөн “...өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр гүйцээ” (Филиппой 2:12), “Тиймээс бид үл ганхах хаанчлалыг хүлээн авсан тул талархалаа илэрхийлцгээе. Үүгээр хүндлэл, айдас бүхий тааламжит үйлчлэлийг Бурханд өргөх юм. Яагаад гэвэл бидний Бурхан шатаах гал мөн” (Еврей 12:28-29) гэдэг. Петр “Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтун. Та нар ялгаварлалгүйгээр хүн бүрийг үйлсийнх нь дагуу шүүдэг Нэгэнийг Эцэг гэж дууддаг юм бол, энд байх хугацаандаа эмээн биеэ авч яв” (1Петр 1:16-17) хэмээн бүр ч түс тас хэлжээ. Эдгээр мэдэгдлийг уншсан хүн ариун эмээхүй нь Шинэ гэрээний амин бүтэц болохыг няцаахгүй биз ээ.

Бурханы оршихуй бууж ирэх үед Мосе ард түмэнд “Та бүгд нүгэл үйлдэхгүйн тулд Түүний эмээхүй та нарын өмнө байг” гэжээ. Бурханы

хайр бус, чухамхүү Эзэнээс эмээхүй л биднийг нүглээс сахин хамгаалдаг ажээ. Паул “Авралаа “хайр, эелдэг байдлаар” бус, харин “айдас, чичрэлээр гүйцэлдүүл” гэсэн. Паул өөр нэгэн захидал дээрээ бидний дунд байх Бурханы оршихуйн амлалт бидэнд байгаа учраас, “бид өөрсдийгөө махбодын ба сүнсний бүх л бохироос цэвэрлэе. Ингэхдээ Бурханаас эмээж (Бурханаас эмээхүй дотор)...” (2Коринт 7:1) хэмээн ятгасан байна. “Бурханы хайр дотор” гэж хэлээгүй байгааг нь тэмдэглээрэй.

Залилангийн хэргээр шоронд суусан, нэгэн алдартай үйлчлэгчийг эргэж очсон түүхээ би ёстой мартаггүй. Түүнээс: “Та Есүст хэзээнээс хайргүй болчихсон юм бэ?” гэж асуусан юм.

Тэгтэл тэр над руу харснаа шууд л: “Хайргүй болоогүй!” гэж хариулав.

Би ч гайхсандаа: “Тэгээд залилан, завхайрал чинь?” гэтэл, тэрбээр:

“Жон, Би Бурханд дандаа хайртай байсан. Гэхдээ би Түүнээс эмээдэггүй байсан юм” гэв. Тэгээд миний орой руу орсон нэг үг хэлсэн юм: “Жон, цаана чинь над шиг сая сая Америк итгэгч хүн бий. Тэд Есүсийг Аврагчаа болгон, хайрладаг ч, Есүсийн Эзэний бүрэн эрхт чанараас нь ер эмээдэггүй.”

Тэр үед миний дотор гэрэл ассан юм. Бид жинхэнэ Есүсийг бус, харин хүнийхээ төсөөлөл, ойлголтоор бүтээсэн “Есүсийнхээ дүрийг” хайрлаж болдог ажээ. Учир нь Эзэнээс эмээхүй нь Бурханыг дотно мэдэхийн эхлэл буюу эхэлбэр цэг болохыг Бичээс хэлдэг (Сургаалт үгс 1:7, 2:5-ыг үзнэ үү). Дээрх эрхэм Есүсийн гажуудуулсан дүрийг хайрладаг байсныг нь би ойлгосон юм.

“ТЭД НАДААС ЭМЭЭХИЙН ТӨЛӨӨ...”

“Нүгэл биднийг Бурхантай дотно байхаас салган тусгаарладаг бөгөөд Эзэнээс эмээхүй л биднийг нүглээс сахидгийг” Мосе маш тодорхой хэлсэн. Эзэнгэрээний хүмүүстээ: “Харин хилэнц чинь танарыг Бурханаас хагацуулан Нүглүүд чинь Түүний нүүрийг Та нараас далдалжээ” (Исаиа 59:2) гэсэн. Бидний нүгэл Бурханыг биднээс бус, харин биднийг Бурханаас салган тусгаарладаг гэсэн байгааг тэмдэглээрэй. Бурхан энэ үгээ харийнханд бус, Өөрийнхөө хүмүүст хэлсэн юм шүү. Бид л өөрийгөө Бурхантай дотносохоос салган тусгаарладаг бөгөөд энэ бүхний үндэс нь ариун эмээхүйгээр хомсдох явдал ажээ.

Бурханаас эмээж явдаг хүнд нууж хаах юм байдаггүй. Үүгээрээ тэрбээр Бурханаас айдаг хүнээс ялгаатай. Амьдрал нь Эзэний мэлмийн өмнөх нээлттэй ном гэдгийг тэрбээр мэднэ. Тэрбээр Эзэний хүслийг

Бурханд ойрт

юу юугаас дээгүүр тавина. Түүний хувьд Эзэний Үг инү найз нөхөд, гэр бүл, тэр байтугай сэтгэлийнх нь дур хүслээс ч жинтэй. Бурханыг дагахаас өөр ханаж цаддаг зүйл түүнд үгүй. Тэрбээр өөрийгөө няцааж, загалмайгаа аваад, Есүсийг дагана. Тэрбээр Бурханы төлөө л амьдарна.

Мосе яг л ингэж амьдарсан. Эзэнээс эмээсэн. Тэгвэл Израиль эмээлгүй, тав тух, хүсэл, хэрэгцээгээ Бурханы хүслээс дээгүүр тавьсан. Аман дээрээ Бурханд найдаж байгаа гэдэг ч, амьдрал дээрээ огт найдаагүй. Эргэлзээгүй хэмээн гүрэлзэв ч, байнга эргэлзэнэ. Бурханы Үгийг, хүслийг, зарлигийг өөр бусад юмсаас дээгүүр үнэлээгүй. Бурханаас эмээдэггүй учраас, Бурханыг үнэн голоосоо хэзээ ч хайрлаагүй. Яагаад? Тэд Бурханы жинхэнэ илчлэлийг үзээгүй. Гиймээс л Бурханы оршихуйгаас няцсан. Тэдэнд Бурханы оршихуйн гэрлээс нууж хаах асуудал ч багагүй байсан. Энэ гэрэл хэзээ нэгэн цагт тэднийг асуудлаа шийдвэрлэхээс өөр аргагүй нөхцөлд оруулаад, хэнд үйлчлэх сонголтыг тулгахыг тэд мэдэж байжээ.

Израилийг ухарч байхад, Мосе ойртсон. Бурханы хамаг л хүч, гайхамшгаа гайхуулан байж, хүлээсээс чөлөөлөөд, Өөр дээрээ авч ирсэн хүмүүс нь дахиж ойртох хүсэлгүй байгааг эдүгээ Мосе Эзэнд дуулгах ёстой болжээ. Мосе үүнийг хиймээргүй байсан ч, Бурхан хэдийнээ мэдээд, дараах хариултаараа Мосег цочоосон байдаг:

“Энэ ард түмний чамд хэлсэн үгийг Би сонслоо. Тэдний хэлсэн бүхэн зөв зүйтэй...” (Дэд хууль 5:28).

Мосегийн нүүрэн дээрх цочроог төсөөлөшгүй. Бурхан ард олны хэл яриаг мэдэхээр барахгүй (Бурхан бүхнийг мэддэгийг бид умартдаг нь гайхмаар шүү), бүр Израилийн хүүхдүүд зөв зүйтэй ярьж байна гэх! Тэгээд Мосе өөдөөс нь “Яагаад тэд Тан руу ойртож чадахгүй байгаа билээ?” гэх утгатай үг хэлжээ.

Үнэндээ, хүмүүс яагаад *ойртож* чадахгүйг тайлбарлан буй Бурханы хоолойн гуниг сонсогдож байна:

Тэдний зүрх хэвээр үлдэж, Надаас үргэлж эмээж, Миний бүх тушаалыг сахин тэд бас тэдний хүүхдүүд үүрд сайн сайхан байх болтугай! (Дэд хууль 5:29)

Энэ үгээрээ Бурхан хоёр зүйлийг тодорхой болгожээ. Нэгдүгээрт - ариун эмээхүй байхгүй бол, Бурхан руу ойртох боломжгүй. Хоёрдугаарт - энэ эмээхүй байгаа л бол, Бурханы тушаалыг дуулгавартай дагана.

Бурханы анд нөхөр

Израилийн хүүхдүүд ярихыг мэддэг ч, зүрхэнд нь Эзэнээс эмээхүй байгаагүй. Эзэнээс эмээхүй нь ямагт хүний зүрхнээс эхээ аваад, дуулгавартай үйлдлээр илэрнэ!

Дараа нь Эзэн Хуучин гэрээний хамгийн өр өвтгөм мэдэгдлийг хийсэн. Тэрбээр энэ үгийг Мосегоор хүмүүстээ хэлүүлсэн юм:

Чи очоод, тэдэнд “Майхан уруугаа буцацгаа!” гэж хэл
(Дэд хууль 5:30).

Эвий эвий. Ингэж хэлэхдээ Бурханы зүрх яаж шархирсан бол. Эргээд явж байгаа Мосегийн зүрх ямар хүнд байсан бол. Энэ үгийг бичиж суугаа миний ч зүрх уйлж байна. Бурхан тэр хүмүүсийг Өөр дээрээ авчрах гэж л Египетээс чөлөөлсөн байтал, тэд ойлгоогүй (Гэтлэл 19:4-ийг үзнэ үү). Тэр аугаа их чөлөөлөлтийн тэнгэрлэг зорилго нь ийм л байсан. Гэтэл яг Өөрийгөө илчлэх гэтэл нь Эзэнээс эмээдэггүй тэр хүмүүс Бурханы оршихуйг тэвчилгүй, гэдрэг ухарсан. Тэд майхандаа эргэж очоод, Бурханы оршихуй, дуу хоолойноос зайгаа авчээ. Бурхан тэдэнтэй дотносохыг хүссэн ч, тэд дотносохыг эс сонгов.

ЭЗЭНТЭЙ НӨХӨРЛӨХ

Гэтэл нөгөөтэйгүүр, хүмүүсийг майхандаа буцаасныхаа дараа Бурхан Мосед:

“Харин чи энд Миний дэргэд зогс! ...Би чамд хэлж
огъе” (Дэд хууль 5:31) хэмээн айлджээ.

Пөөх! “Миний дэргэд зогс... Би чамд хэлье”. Юутай ер бусын! Юутай баяр! Юу гээчийн ухаанд багташгүй завшаан бэ! Мосе үлдээд, Бурханы зүрхийг сонсох урилга хүлээн авав! Үүнээс дээр юм ертөнц дээр үгүй! Хайр, цэц ухаан, мэдлэг, хүчээр яндашгүй Нэгэний оршихуйд байх урилга. Тэнгэрс даяараа биширч, хүсэмжилдэг Нэгэний дэргэд зогсох. Мосе ийм л урилга хүлээн авч!

Мосе Эзэнээс эмээхүйг тээсэн учраас, Эзэнтэйгээ дотно нөхөрлөх эрхтэй болжээ. Үүнийг магтаалчийн үгс гэрчилдэг: “Өөрийн замыг Мосед, Үйлсээ Израилийн хөвгүүдэд Тэрээр мэдүүлсэн” (Дуулал 103:7). Мосе Бурханы үйл хэргийг биелэхээс нь ч өмнө мэдэх нь элбэг байв. Учир нь Мосе хүмүүсийн ойртож очоогүй тэр газарт Эзэний дэргэд байсан болохоор, Эзэн зүрхээ Мосед нээдэг байв.

Израиль Бурханыг залбиралд хариулдгаар нь мэддэг байснаас Бурханы сэдэл, хүсэл, төлөвлөгөө зэрэг зүрхнийх нь гүн юмсыг мэддэггүй байсан. Тэд Бурханы үйлдсэнийг л мэдэхээс бус, яагаад үйлдсэнийг нь эс мэднэ. Тэгвэл Мосе Бурханыг нууцаг газартаа өгүүлдэг юмсаар нь мэднэ.

ЭЗЭНий андлал Өөрөөс нь эмээгчидтэй хамт байдаг. Тэр тэдэнд гэрээгээ мэдүүлнэ (Дуулал 25:14). Би энэ эшлэлд хайртай.

Дээрх үгийг утгыг нь алдагдуулалгүйгээр “Эзэний зүрхний нууц нь Түүнээс эмээдэг хүмүүстэй хамт байдаг бөгөөд Эзэн тэдэнд гэрээний замаа харуулна” гэж хэлж болно. Бүх хүнд нууц байдаг (муу нууц биш шүү) бөгөөд бид нууцаа хаа хамаагүй хүмүүст бус, ойр дотны, итгэл даах хүмүүстэй л нээдэг. Энэ нь ч зөв: Тэд зүрхний минь нарийн нандин юмсаар далимдуулан манийгаа хохироохгүй. Тэд бидний эрхэм юмст болгоомжтой хандана. Бидний хуваалцсан юмсыг ашиг хонжооны төлөө цааш нь задлах юмуу давслахгүй. Тэд бидний зүрхийг мэддэг, бидэнд хамгийн сайн сайхныг л хүсч явдаг хүмүүс.

Тэгвэл Бурхан ч ялгаагүй. Тэрбээр нууцаа хар биеийнхээ таашаал, дур хүслийг л бодож явдаг хүмүүст дэлгэлгүй, харин Өөрийнх нь зүрхийг тээдэг, амиа зориулахаас ч буцаагүй анд нөхөдтэйгээ л хуваалцана. Үүнийг ч дараах орчуулга батална: “ЭЗЭНий андлал Өөрөөс нь эмээгчидтэй хамт байдаг. Тэр тэдэнд гэрээгээ мэдүүлнэ” (Дуулал 25:14).

БУРХАНЫ НАЙЗ АБРАХАМ

Хуучин гэрээнд Бурханы анд хэмээх алдрыг хүртсэн Абрахам гэдэг нэгэн хүн бий. Яахаараа Бурханы анд болчихдог билээ? Хариултыг нь Абрахамын давж гарсан, хамгийн том шалгалтаас мэдэж болно. Тэрбээр Бурханы нэгэн амлалтыг хорин таван жил хүлээн байж, хүлээж авсан юм. Тэр нь Абрахамын хүүхэд олох чадваргүй гэргий Сарагаас нь Абрахамд төрүүлж өгсөн хүү нь байв. Хэвлийдээ бойжсоор, хорвоод мэндэлсэн хүүдээ тэд *мишээл* гэсэн утга бүхий Исаак нэрийг хайрлажээ. Бяцхан хүү аав, ээждээ хөлгүй жаргал авч иржээ.

Аав - хүүгийн амин холбоо улам л бөхлөгдөхийг Бурхан ч алдалгүй ажиглан сууна. Тэгээд шалгалтын цаг болж, Бурхан Абрахамд: “Чи

цорын ганц *хайртай* хүү Исаакаа аваад Мориа гэдэг газар уруу яв. Тэнд түүнийг шатаалт тахил болгон Миний чамд зааж өгөх тэр нэг уулан дээр тахин шатаагтун” (Эхлэл 22:2, тодруулгыг нэмэв) хэмээв.

Энэ хүсэлт Абрахамыг яаж цочирдуулсныг төсөөлж байна уу? Тэр чинь хорин таван жил хүлээлгэн байж төрсөн, Бурханы амласан хөвгүүн. Ишмаэлыг хэдийнээ явуулчихсан болохоор, Абрахам юу ч үгүй хоцорно! Яагаад одоо гэж? Амин холбоо нь ийм бат бэх болсон үед шүү. Бурхан яагаад өдий болтол хүлээлгэв? Нярай байхад нь хэлчихгүй дээ? Библийн олон эрдэмтэн Исаакийг тухайн үед гучин гуравтай байсан гэж үздэг.

Тэр шөнийг төсөөлж байна уу? Абрахамын сэтгэлд дайн болж байсан биз. Бурхан яаж түүнээс ийм юм хүсэв ээ? Бүх юм төлөвлөгөөний дагуу өрнөж байсан шүү дээ. Исаак нэг өдөр гэрлэж, үр удам нь Бурханы амласан үндэстэн, хаадыг төрүүлэх байв. Гэтэл Бурхан ид залуугаар нь амийг нь хүсч байдаг? Абрахамын сэтгэл ийм л асуулттай дайтаж байсан. *Бурхан яах гэж анхнаасаа надад Исаакийг өгсөн юм бэ? Авчих байсан юм бол, яах гэж өгсөн юм бэ? Бурхан Исаакийг миний хайрладаг шиг хайрладаг уу? Оронд нь миний амийг авчихаж болохгүй юу?*

Гэвч Абрахамын дотор буцлах энэ олон асуулт, зөвлөгөөг давж байсан нэгэн зүйл нь Эзэнээс эмээхгүй байв. Бурхан хэлсэн учраас, Абрахам дагах л болно. “Тэгээд Абрахам *өглөө эртлэн* босоод илжгээ эмээллэж, хоёр зарц залууг хүү Исаакийнхаа хамт дагуулж, шатаалт тахилын мод хагалж аваад Бурханы өөрт нь айлдсан тэр газар уруу явжээ” (Эхлэл 22:3, тодруулгыг нэмэв). Өглөө эртлэн гэдэг үгийг тогтоож аваарай. “Бурхан сүүлийн хэдэн сар надад “ингэ, тэг” гэсээр байгаа. Гэхдээ би шийдэж чадахгүй л явна” гэж ярьж байгаа хүнийг та харсан л байх. Үнэндээ, тэд Бурханаас эмээхгүй байгаагаа л илчилж байгаа юм.

Бурханаас эмээнэ гэдэг чинь Бурханы үгд чичирнэ гэсэн үг. Ямар ч шалтгаан, ямар ч ашиггүй байсан ч, дуулгавартай дагана гэсэн үг. Бүр ойлгохгүй байсан ч, дуулгавартай дагана. Зовиуртай байсан ч, дагана! Сайн мэдээний зарлагууд - бид Христийн биед ихээхэн хор хохирол учруулдаг. Учир нь бид ашгийг нь харж байж л, дуулгавартай дагадаг хандлага хөгжүүлжээ. Бид “Өргөл өргөх юм бол, Бурхан ингэнэ, тэгнэ”, “Залбирах юм бол, Бурхан ингэнэ, тэгнэ”, “Дуулгавартай дагабал, Бурхан ингэнэ, тэгнэ” гэдэг. Товчхондоо “Авахын тулд Есүс дээр ир” гэдэг. Бурхан ерөөдөг гэдэгт би итгэдэг үү? Яриангүй! Гэхдээ байна шүү, хэзээ ч ерөөгдөх сэдлээр Бурханд үйлчлэх ёсгүй. Бид Бурханд үйлдэх чадал чадвар дээр нь суурилж бус, харин Хэн гэдэг мөн чанар дээр нь суурилж үйлчлэх ёстой.

Абрахам тэр даруй Бурханы үгэнд орон, заасан уул руу нь гурав хоног аялж хүрчээ. Бурхан яагаад арай дөт газрыг сонгоогүй юм бол? Яагаад гурав хоногийн аялал хийлгэв? Би л хувьдаа, Бурхан Абрахамд ахин дахин эргэцүүлээд, эргэж буцах цаг олгожээ гэж итгэдэг. Бурханы дуу хоолойг сонсуугаа хөдлөх нь нэг хэрэг бол, төгсгөл нь тэс ондоо хэрэг юм. Гурав хоногийн дараа аминаасаа ч илүү хайрладаг хүнээ тахилд өргөх ёстой уулаа ширтэж зогстол, Бурхан дув дуугүй байвал, та яах байсан бол?

Харин Абрахам уулын орой дээр гараад, тахилын ширээ босгоод, Исаакийг хүлээд, хутгаа далайсан. Тэгтэл гэнэт Эзэний тэнгэрэлч Абрахамыг дуудан айлдруун:

“Хөвгүүний эсрэг гар бүү далай! Түүнд юу ч бүү хий!
Учир нь чи хүүгээ, цорын ганц хүүгээ Надаас харамлаагүй
тул чамайг Бурханаас эмээдгийг чинь одоо Би мэдлээ”
(Эхлэл 22:12, тодруулгыг нэмэв).

Абрахам Өөрөөс нь эмээж явдгийг Бурхан хэрхэн мэдэв? Абрахам ойлгомжгүй, зовиуртай, өөрт нь ширхэг ч ашиггүй үед ч Бурханы үгэнд оржээ. Абрахам Өөрийнх нь хүслийг юу юунаас өргөмжлөхийг Бурхан үзжээ. Тэр үед л Бурхан: “Энэ хүмүүнд Өөрийгөө илчилж, зүрхээ хуваалцаж болохыг” мэдсэн.

БУРХАНЫ ИЛЧЛЭГДЭЖ БАЙГААГҮЙ ЧАНАР

Үүний дараа Абрахам өөдөө хараад, бутанд эврээрээ ороолдсон нэгэн хуцыг олж хараад: “Иавэ Ирэ!” (Энэ нь “Эзэн хангадаг” гэсэн утгатай нэр) хэмээн дуу алджээ. Чухам энэ үед л Абрахам Бурханыг Иавэ Ирэ гэдгээр нь таньжээ. Абрахамын хүндэтгэл, дуулгавартай зангийн хариуд л Бурхан урьд өмнө хүмүүнд хэзээ ч таниулж байгаагүй чанараа илчилсэн байна.

Та намайг зохиолч Жон Бивэр гэдгээр нь мэдэх байх. Зарим чинь “Номлогч Жон Бивэр” гэдгээр нь мэднэ. Гэтэл Лиза бүсгүй намайг “хань нөхөр” гэдгээр минь мэднэ. Лиза миний гэргийгээс гадна дотны минь найз бөгөөд би өөр хэнд ч хэлэхгүй нууцаа зөвхөн түүнтэй л хуваалцдаг. Хөвгүүд минь миний “аав” гэдэг талыг мэднэ. Бидний дунд аав - хүүгийн амин холбоо бий. Танд ч бас ийм хүмүүс байгаа. Тэгвэл Бурханы хувьд ч ялгаагүй юм.

Бурхан хүмүүсийн үл мэдэх юмсыг Абрахамтай хуваалцдаг байсан. Тэр бүү хэл төлөвлөгөөгөөгөө хуваалцаж, зөвлөлдөж, саналаар нь ч

шийднэ. Жишээ нь Содом, Гоморрагийн түүх байна. Бурхан: “Би хийх гэж буй юмаа Абрахамаас нууна гэж үү?” (Эхлэл 18:17) гэсэн. Эзэн энэ тохиолдлыг хэлэлцэхээр Абрахам дээр хүрч очоод, түүний оролцоог үнэлж, анхааралдаа авчээ. Ийнхүү Содомд арван зөвт хүн байхад л, тэр хотыг өршөөхөөр шийдсэн боловч, арван хүн байсангүй!

БУРХАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ГАДАРЛАА Ч ҮГҮЙ

Тэгвэл Абрахамын садан Лот тэс өөр хүн байсан нь сонирхолтой. Библи түүнийг “зөвт” хүн гэсэн (2Петр 2:7-г үзнэ үү). Лот Эзэнээс эмээдэггүй, махан биеийн явдалд дуртай хүн байв. Амьдралынх нь түүх ч өөр байдаг. Тэрбээр гараанаас Абрахамтай цугтаа гарсан. Гэхдээ махан бие сүнсийг дарангуйлах бүрийд эцэстээ зөрчил үүсдэг. Дэлхийн үр өгөөжөөс илүүтэй Бурханы юмст дуртай Абрахам Лотод сонголт олгожээ. Тэгээд үлдсэнийг нь өөрөө авахаар тохирсон нь эцэстээ сүү балаар халгиж цалгисан, хамгийн үр жимстэй газар болж таарахыг нь хоёр эрийн хэн нь ч мэдсэнгүй.

Тэгээд “Лот хараагаа өргөн, Зоар хүртэлх Иорданы талыг бүх газартаа элбэг устай, ЭЗЭНий цэцэрлэг шиг мөн Египетийн нутаг шиг байхыг харав (Эхлэл 13:10) (Лот Иорданы хөндийн үржил шимтэй тал газрыг удаан ширтэв. ЭнЭлТи Библи). Тухайн үедээ энэ нь хамгийн л хүсэл татмаар, үр жимстэй газар байжээ. Яагаад удаан гэгч нь ширтэв? Лот Содом, Гоморрагийн бузар булайг сайн мэднэ. Тэгээд ширтэж зогсохдоо, тэр хүмүүсийн нөлөөнд авталгүйгээр хэрхэн элбэг дэлбэгийг нь эдлэх аргаа л сэтгэж байсан байх. Тэгээд Содом хотын дотор нь суурьшилгүй, гадна хөндийд майхнаа барихаар шийдсэн. Ийм маягаар ёрын муугаас нь зайгаа барингаа, газрынх нь сайн сайхныг ялгаагүй эдлэх байв. “... Лот талын хотуудын дунд сууж, майхнаа нүүлгэн Содомын ойролцоо босгожээ” (Эхлэл 13:12). Гэхдээ хүн нүглээс хол байх хичнээн шилдэг төлөвлөгөө боловсрууллаа ч, Бурханаас эмээдэггүй бол, эцэстээ уруу татагдах л болно. Лотын хувьд ч тийм л байсан. Тэрбээр анх хотын гадна хөндийд майхнаа босгож байсан бол, зургаан бүлгийн дараа Содомын хаалган дотор сууцтай болсон тухай гарна (Эхлэл 19:2-ыг үзнэ үү).

Содом цэцэглэн хөгжиж, хөлжиж байв. Тэд хэдхэн цагийн дараа газрын хөрснөөс арчигдахаа мэдээгүй. Үүнд нь ч гайхалтгүй. Зүгээр, энэ тухай Лот мэдээгүй нь л сөрдхиймээр. Бурхан түүнд анхааруулахаар нигүүлслийн зарлага - тэнгэрэлч нараа илгээсэн. Лот Содомын нүгэлтнүүдтэй адил юу ч мэдээгүй явснаараа, үйл явдал эцэслэн шийдвэрлэгдэхээс өмнө Бурханы амин зөвлөгөөг дуулдаг байсан, Бурханаас эмээдэг Абрахамаас ялгардаг.

ЖИНХЭНЭ ЕСҮС?

Моше, Абрахам хоёрын амьдралыг Эзэнээс эмээхүйн гэрлээр нэвтрүүлэн шалгангаа, энэ ойлголтоо цааш нь задалж үзье. Эзэнээс эмээхүй нь Бурханы хайрладгийг хайрлаж, үзэн яддагийг үзэн ядахад хүргэдэг. Бурханд чухал нь бидэнд чухал болж, Бурханд чухал бус нь бидэнд чухал бус болох. Бид Бурханы нэн чухал юмс, хүслийг өвлөх ёстой. Бурханы хүсэл, тэмүүлэлд нэг ч эргэлзээгүй дуулгавартай байх нь Эзэнээс эмээхүйн илрэл мөн.

Бичээсээс үзбэл, бид Эзэнээс эмээхүйг тээх үед Бурхан бидэн рүү ойртдог байна. Бурхан бидэнтэй ойр дотно байгаа нөхцөлд Бурханыг хайрлах хайр маань өснө. Бид илчлэгдсэн, амьд Бурханыг хайрлах ёстой болохоос, Бурханы тухай ойлголтыг хайрлах ёсгүй юм. Эзэнээс эмээх гүн гүнзгий, чин сэтгэл үгүй бол, бид Бурханыг жинхэнээсээ дотно мэдэхгүй, хоосон хайр зарлаад л явна. Бид Бурханы тухай мэдэхээс бус, Бурханыг Өөрийг нь мэдэхгүй. Үүнийхээ үр дүнд Аавынхаа баруун гарт суугаа жинхэнэ Есүсийг бус, харин төсөөлөлдөө ургуулан бүтээсэн “Есүсийнхээ дүрд” дурлана.

Холливүүдийн алдартай жүжигчин, тамирчныг бишрэн шүтдэг фэнтэй л адил. Тэд хайртай супер одынхоо видео ярилцлага, сонины нийтлэл зэрэг медиагийн урлан бүтээдэг дүрд л дурлах. Тэр супер оддын нэрс нь Америк айл болгоны хойморт залардаг. Бишрэн шүтдэг одынхоо талаар чухам анд нөхрийнхөө талаар мэт ярих хүмүүсийг би харсан. Одынхоо хувийн амьдралд ч гэр бүлийнхээ гишүүнд мэт санаа зовнино. Гэхдээ биечлэн уулзбал, нөгөө од нь танигдсан дүрээсээ тэс ондоо хүн болохыг нь харах байх. Алдартан - бишрэн шүтэгчийн харилцаа чинь нэг хэрэг. Харин яг нүүр тулан уулзбал, тэд бие биеэ сайн мэдэхгүй учраас, нийлэх ч юмгүй, ярих ч юмгүй байх болов уу.

Энэ динамикийг би чуулган дотор ч хардаг. Олон хүн Эзэнтэй үй зайгүй юм шиг л ярьдаг ч, мэдэмхийрээд байгаа Эзэнээ тийм ч сайн мэддэггүй нь ярианаас нь илхэн. Тэд Есүсийн үгийг нь мэдэхээс дуу хоолойг нь мэдэхгүй, үйлсийг нь мэдэхээс арга замыг нь мэдэхгүй, өмнө хэлснийг нь мэдэхээс, одоо юу хэлж байгааг нь мэдэхгүй.

Үүний нэг тод жишээ өнгөрсөн жил тохиолдож билээ. Манайх гэр бүлээрээ Хавайд амарч байлаа. Цагийн зөрүүтэй учраас, би эрт босоод, эрэг дээгүүр алхлан залбирч явтал, нэг залуу хүрч ирээд, яриа дэлгэх нь тэр. Тэрбээр арлын сайханд хөл алдсандаа, тэсгэлгүй: “Эндхийн охидынх нь хөөрхөнийг яана. Ёстой найрсаг, хөгжилтэй...” гэж ирээд л дуу алдлаа. Тэгээд саяхан очсон үдэшлэг гэх зэрэг махан биеийн явдлаасаа ярих зуураа эсэн бусын бохир үг хэллэг урсгаж байв.

Тэгж тэгж надаас юу хийдгийг минь асуусан юм. Бурханд үйлчилдэг хүн гэдгийг сонсоод, улам хөөрч, Эзэний талаар ярьж гарав. Чуулганыхаа гадаад хэргийн хэлтэст ажилладаг тухайгаа бас пасторынхаа тухай яриад л. Есүст итгэсэн түүхээ хуваалцаж бас өөрт байсан танилцуулгаа ч өгч байна. Дараа нь буудалд унтаж байгаа гэргий, хүүхдүүдийнхээ тухай ярьлаа. (Тэр үед надад арлын хүүхнүүдэд дуу алдаж байсан нь шууд орж ирэв) Тэр хүн өөрийгөө Эзэнийг мэддэг гэж итгэж байгаа ч, амьдрал нь ондоог өгүүлэхийг үзээд сэтгэл өвдөж билээ. Есүс тиймээс л итгэгч хүмүүсийг үг, үйлчлэлээр нь бус, үр жимсээр нь буюу амьдралынх нь хэв маягаар танина гэдэг (Матай 7:20-23-ыг үзнэ үү).

Ийм жишээ олныг хэлж болно. Та бас үүнээс ч гайхалтай жишээ мэдэх л байх. Тэгэхээр, “Есүст итгэдэг гээд байгаа” энэ хүмүүс нь нөгөө супер одын фэнтэй л адил юм. Үнэхээрийн сэтгэл өвдмөөр. Авралыг хүсэх атлаа дэлхийг хайрлан, таашаал, цагийн хуваарь, санаа зорилгоо Бурханы хүслээс дээгүүр тавих гэж дээ.

Нөгөөтэйгүүр бас жинхэнээсээ аврагдсан атлаа Лоттой адил махан биеийн үйлд дуртай, дэлхийн явдалтай хүмүүс байна. Тэд Бурханд үйлчлэхийг хүсдэг ч, дур хүсэлдээ боолчлогддог. Тэд аминч амьдралаа хаяж чаддаггүй ч, Бурханы цэвэршүүлэх ажлыг эсэргүүцэж чадна. Тэд Бурханы хүсэл, хаанчлалын өсөлт хөгжилд халуун сэтгэлээр ханддаггүй. Аврагдсан атлаа Бурхантай дотно байдаггүй. Тэд махан биеийнхээ хөшгөөр заагласан гадна талбайдаа амьдардаг учир, шинэ, амьд арга зам руу ойртож чаддаггүй. Тэд Бурханы дэргэд байгаа атлаа хөндий байдаг.

Гадна талбайд амьдрагсад нь Бурхан яах гэж тэднийг дэлхийн дарлалаас чөлөөлснийг ухаардаггүй. Тэд Бурханыг дотно таньж мэдэх дээд дуудлагыг эс ойлгох. Тэд Бурханы хайр, ерөөл, хамгаалалт, хангамж, баялгийн мэдээнд (эдгээр нь үнэн юм) дуртай атлаа зүрхийг хөндсөн асуудлаас зугтдаг. Тэд өөрсдийг нь хангаж цатгахгүй юмсыг сонгохдоо, зүрхэнд нь ундрах Амийн усны булгийг урсгачихдаг.

Бурхан бидэнтэй дотно харилцахыг хүсдэг. Бурхан хэнд ч элэг бариулаад байхгүй, аугаа ариун Бурхан болохыг мэдээрэй. Бурхан биднийг Өөр дээрээ авчрах гэж асар их үнэ төлсөн байхад, бид яаж энэ дэлхийтэй нөхөрлөсөөр байх юм бэ? Иаков Бурхан руу ойртох ятгалгынхаа өмнө “... ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү?” (Иаков 4:4) хэмээн анхааруулсан байдаг. Тэгээд дэлхийн дур хүсэлтэй хөөцөлдөөд байвал, Бурханы дайсан болж хувирахыг хэлсэн! Иаков итгэгч хүмүүст хандаж өгүүлснийг санаарай. Паул ч мөн: “Учир нь бүх хүнд аврал авчрагч Бурханы нигүүлсэл

үзэгдэж, сүсэг бишрэлгүйг болон ертөнцийн шуналыг үгүйсгэхийг мөн эдүгээ үед биеэ цэнэдэг ба сүсэг бишрэлтэй амьдрахыг бидэнд сургадаг. Ингэхдээ бид аугаа Бурхан ба Аврагч Есүс Христийнхээ ерөөлт найдвар хийгээд цог жавхланта илэрхийллийг хүлээдэг (Тит 2:11-13) хэмээн андуурахын аргагүй, тодорхой хэлжээ. Тиймээс л авралаа айдас, чичрэлээр гүйцэлдүүлээрэй гэсэн юм.

ЕСҮСИЙН НӨХӨД

Есүст итгэсэн хүмүүс Есүсийн найз болдог гэж заахыг бид зөндөө сонсдог. Гэхдээ Бурхан далласан газарт ил гарч, далайсан газарт далд ордог, дорд нэгэн биш болохыг эдүгээ та ойлгосон байх аа. Нэгэн удаа Бурхан залбиралд “Надад үнэнч байгаа шигээ Намайг өөртөө үнэнч байхыг хүсч буй эсэхийг Миний хүмүүсээс асуу?” хэмээн хашхирсан байдаг. Есүс “дахин төрөгсдийн дугуйлангаа” ганц ч атугай хүнээр нэмэгдүүлэх гэж Аврагч болж ирээгүй. Есүс хайртай хүмүүстэйгээ харилцаа тогтоохыг л хүсдэг. Үүнийг ч үг нь баталдаг:

Та нар тушаасныг минь үйлдвээс Миний нөхөд мөн
(Иохан 15:14).

Есүстэй тогтоох харилцаанд тогтоож өгсөн параметр гэж бий. Есүс “Та нар Намайг Христ гэж итгэх л юм бол, автоматаар Миний нөхөд мөн” гэж хэлээгүй. Харин “Та нар тушаалыг минь үйлдбээс, Миний нөхөд мөн” гэж хэлсэн. Тэгвэл “Бурханы тушаасан бүхнийг хийх” хүч нь Эзэнээс эмээхүй дотор оршдгийг энэ бүлгээрээ ярьсан билээ.

Есүс дээрх үгээ Иудаг урвахаар гарч явсны дараа айлдсан юм. Эшлэлээ цааш нь хөврүүлж үзэх юм бол, Есүс арван нэгтээ: “Цаашид Би та нарыг боолууд гэж дахиж дуудахгүй” (Иохан 15:15) гэсэн байдаг. “Цаашид” гэдэг нь үнэндээ өмнө Есүс тэднийг зарц гэж үздэг байсан бол, эдүгээ цоо шинэ төвшин бүрэлдсэнийг илтгэх. Энэ мэдэгдлийнхээ дараа Есүс:

Учир нь эзнийхээ юу хийж байгааг боол эс мэдэх юм.
Харин Би та нарыг анд нөхөд гэж дуудав. Учир нь Би
Эцэгээсээ сонссон бүхнээ та нарт мэдүүлсэн билээ (Иохан
15:15) гэжээ.

Анд нөхөд нь Эзэний үйл хэргийг мэддэг гэсэн байгааг тэмдэглээрэй. Тэд Эзэний замыг мэднэ! Тэд яагаад харилцааныхаа эхлэлээс бус, одоо анд нөхөр хэмээн дуудуулах болов? Хариулт нь: тэд Эзэнтэйгээ хамт бэрхшээл, хүнд үеийг ч туулж, гайхамшиг, сайн сайхан дунд ч хамтдаа баярлан, үнэнч бөгөөд дуулгавартай чанараа батлан харуулжээ. Тэд дуулгавартай үйл хэргээрээ үнэнч чанараа батлан харуулжээ.

“Та нар тушаасныг минь үйлдвээс Миний нөхөд мөн” гэдэг мэдэгдэл нь Есүсийн нэрийг дуудсан хүн болгонд хамаатай. Нөхөрлөл нь Өөрийнх нь үгэнд ордог хүмүүст л хадгалагдсаныг Есүс тов тодорхой айлдсан байгааг тэмдэглээрэй. Энэ нь ч Дуулал номын үгийг тусгадаг: “Өөрөөс нь эмээдэг хүмүүст л нөхөрлөл хадгалагдсан”.

Бурхан яагаад нөхөрлөлөө гамнана вэ? Биднийг мэдэмхийрэхээс хамгаалахын тулд гэж би итгэдэг. Бурхан Аароны хөвгүүдэд болоод Ааронд “Над руу ойртон ирэгсдээр Өөрийгөө ариун хэмээн мэхийн хүндэтгүүлэх...” хэмээн уриалсан байдгийг санаарай.

Шинэ гэрээн дээр ч нэгэн эхнэр, нөхөр хоёр ариун Бурханы оршихуйд нөгөө л эрүүл бус, мэдэмхий зангаараа нэвтрэх үед яг ийм үйл явдал болсон байдаг. Тэд Бурханы оршихуй дотор үхсэн (Үйлс 5:1-11-ийг үзнэ үү). Үл хүндэтгэл нь тоглоом биш болохыг итгэгч нар ойлгох үед чуулган дээр “үлэмжийн их айдас” буусан. “Эргэн тойрныхон нь Бурханыг мэхийн хүндэтгэх ёстойг” дахиад л харуулж байна.

Өнгөрсөн жил би нэгэн ер бусын нууцыг тайлсан юм. Би залбирахдаа үгийг хойш тавиад, зүгээр л Аавынхаа цог жавхлан, сүр хүчийг бишрэн алмайрахад л анхаардаг. Намайг Өөрийн болгохын төлөө Есүсийн дайтаж, ялсан ер бусын, алдарт тулааны тухай бодно. Мөн миний дотор амьдрахаар шийдсэн, Есүсийн биширмээр Сүнсний тухай эргэцүүлнэ. Үнэхээр сэтгэл ухаанд багтамгүй!

Ийнхүү, намайг ангайж ч амжаагүй байхад, Эзэний оршихуйд пөн хийтэл бууж ирээд, надтай уулзана. Бурханы оршихуйд ямар амархан орж байгаагаа гайхаад, Ариун Сүнснээс лавлалаа. Гэтэл Ариун Сүнс: “Хүү минь, Есүс дагалдагч нартаа юу гэж залбирахыг зааж өглөө?” хэмээн зүрхэнд минь өгүүлэв. Би ч Эзэний залбирлыг эшлэв: “Тэнгэрт буй бидний Аав минь ээ, Таны нэр ариунаар дуурсагдах болтугай!” Тэгээд зог тусаад, “Тийм шүү дээ!, тийм шүү дээ!” хэмээн баясан дуу алдлаа. Тийм ээ, бүр анхнаасаа л Ариун хэмээн мэхийн хүндэтгэх ёстой аж: “Таны нэр ариунаар дуурсагдах болтугай!” Оршихуйн босгоор хөл тавихдаа л ариун мэхийн хүндэтгэлээр дава ёстой юмсанж. Ийм учиртай байтал, би Есүсийн үгийн нарийн ухааныг мэдэхгүйгээр өчнөөн олон жил энэ залбирлыг хэлсэн байдаг!

АМЬДРАЛЫН ЭРДЭНЭСИЙН САНГ НЭЭХ ТҮЛХҮҮР

Эзэнээс эмээхүй нь Бурхантай дотносохын түлхүүр бөгөөд амьдралын суурь болой. Исаиа:

ЭЗЭН өндөрт орших учир өргөмжлөгдөнө. Тэр Сионыг шударга ёс, үнэн зөвөөр бялхаана. Тэр чиний цаг хугацааны баг суурь бөгөөд Мэргэн ухаан, мэдлэг ба авралын баялаг мөн. ЭЗЭНээс эмээхүй нь түүний эрдэнийн сан билээ (Исаиа 33:5-6) гэдэг.

Ариун эмээхүй нь аврал, цэц ухаан, мэдлэгийн эрдэнэсийн санг нээдэг. Яагаад? Яагаад гэвэл, энэ нь Бурхантай дотносохын суурь бөгөөд Бурхантай дотно газар дээр Түүний эрдэнэсийн сан нээгддэг. Амьдралын суурийг Бурханы хайраас гадна Бурханаас эмээхүй сүндэрлүүлдэг билээ. Бид Бурханаас эмээхээс нааш Түүнийг жинхэнээсээ хайрлаж, дотносож чадахгүй.

СУДЛАХ АСУУЛТ

1. Бурханаас эмээх, Бурханаас айхын ялгааг өөрийнхөө үгээр тайлбарлана уу.
2. Энэ бүлэг дээр “Бурханы анд нөхөр” Абрахамыг түүний “зөвт” садан - Лоттой харьцуулсан. Лот Содом, Гоморра гэдэг бузар хотуудын дур хүсэл сорсон газрыг сонжиж зогсохдоо, хэрхэн нөлөөнд нь авталгүйгээр, үр өгөөжийг нь эдлэх аргаа тунгаасан байх. Та бас яг ийм шалтаг бодож олж байсан уу? Эзэнээс эмээх жинхэнэ эмээхүй нь энэ мэт хуурамч гаргалгаанаас хэрхэн сэргийлэх үү?
3. Зохиолч Хавайн эрэг дээр нэг залуутай тааралдсан тухайгаа өгүүлсэн. Танд тийм жишээ тулгарч байсан уу? Байсан бол, хэрхэн шийдвэрлэсэн бэ?
Тэгвэл та өөрөө тэр хүнтэй адилхан зан аяг гаргаж, яриа, үйлдэл чинь зүрхнээс чинь урвасан тохиолдол бий юу? Иймэрхүү жишээнээсээ та юу сурсан эсвэл сурсаар байгаа вэ?
4. Зохиолч Дуулал 25:14-ээр (ЭЗЭНий андлал Өөрөөс нь эмээгчидтэй хамт байдаг) эшлэлээс үүдэн, Бурхан биднийг мэдэмхийрлийн аюулаас хамгаалах гэсэндээ л нөхөрлөлөө гамнадаг гэсэн.
“Мэдэмхийрлийн аюулд” юу, юу орох вэ?

Долдугаар бүлэг

ЖИНХЭНЭ ДОТНОСЛЫН САДАА



Мэхлэгдэгсэд нь хэзээ ч дотносоогүй
Бурханыхаа талаарх мэдлэгтээ тухалдаг.

Эзэнээс эмээхүй нь Бурхантай дотносохын суурь болой. Үүнийг ч Сургаалт үгс номын эхэнд хэлдэг. “ЭЗЭНээс эмээхүй нь мэдлэгийн эхэн (суурь) юм” (Сургаалт үгс 1:7). Ямар мэдлэгийн? Үүнийг бичээч хэдэн эшлэлийн дараа хэлжээ:

Хүү минь, үгсийг минь хүлээн авч,
Тушаалуудыг минь дотроо нандигнаваас,
Мэргэн ухаанд чих тавьж,
Ухаан бодролд зүрхээ зүглүүлвээс,
Ухаарлыг чи чангаар дуудаж,
Ухаарал ойлголтын төлөө дуугаа өндөрсгөвөөс,
Цалин цагаан мөнгө мэт үүнийг эрж,
Нууц эрдэнэ мэт түүнийг хайваас
ЭЗЭНээс эмээхүйг чи ойлгоно
Бурханы мэдлэгийг олж авна
(Сургаалт үгс 2:1-5, тодруулгыг нэмэв).

Мэдлэг гэдэг үгийг *Библийн хэлний толь бичиг* дээр “харилцаатай байх онц магадлалтай хүмүүнийхээ талаар мэдэх мэдлэг” гэж тодорхойлсон байдаг бол, *Вайны тайлбар толь* дээр *мэдлэгийг* “Түүний (Бурханы) талаар бодитой, дотно мэдлэгтэй байх” гэж тайлбарладаг. Тэгээд цааш нь “Бурханыг “мэдэхүй” нь эерэг утгаараа Бурханаас эмээхүйтэй зэрэгцэнэ” гэжээ.

Эзэнээс эмээхүй нь Бурханы тушаалыг нандигнах явдал болохыг дээрх Бичээсээс харж болно. Бурханы тушаалыг нандигнах нь Бурханы үгд чихээ бөхийлгөж, ямар ч нөхцөл байдал дунд дагахад бэлэн байх явдал юм. Тэгвэл ариун эмээхүй байхгүй хүмүүсийг эсрэгээрээ хөндийрөл хүлээх бөгөөд Бурханы хүслийг мэддэг атлаа дагадаггүй хүмүүс нь “өөрийгөө мэхлэдгийг” (Иаков 1:22) Иаков хэлдэг. Мэхлэгдсэн хүмүүс өөрсдийгөө зөв гэж боддог ч, үнэндээ буруу байдаг нь аймшигтай. Мэхлэгдэгсэд нь хэзээ ч дотносоогүй Бурханыхаа талаарх мэдлэгтээ тухалдаг.

ЭЗЭНИЙ ГАЖУУДУУЛСАН ДҮР ТӨРХ

Эзэнээс эмээхүй байхгүй бол, Бурханыг жинхэнээсээ мэдэхгүй. Сэтгэл, төсөөлөл дотор минь буруу дүр төрх цутгагдан, хэлбэршиж, боловсорно. Хэдийгээр Бурхантай харилцаатай хэмээн хэл амаараа хүндэтгэв ч, зүрх маань хөндий, амьдрал маань ч Бурханы хүсэлтэй хөрвөхгүй. Үүнийг ч Израилийн үр сад тодорхой харуулдаг.

Мосе тэднийг Синайд Бурхантай уулзуулах гэж авчирсан байтал “Бурханы байгаа түнэр харанхуйд Мосег ойртон очих үед ард түмэн хол зогсож байв” (Гэтлэл 20:21). Тэд энэхүү жавхланта хүлээлт дунд Бурхан руу ойртож очоогүй нь юутай харамсалтай. Юу болох байсныг хэн мэдлээ? Тэд Бурханы Үгийг яг Өөрийнх нь хоолойгоор сонсох завшаантай байв! Гэтэл тэдэнд Эзэнээс эмээх зүрх байгаагүй болохоор, тушаалыг нь биелүүлж чадаагүйг (Дэд хууль 5:29) бид өмнө ярьсан.

Гонсойсон Бурхан Өөрийнхөө болоод хүмүүсийн дунд зуучийг томилжээ. Тэгээд Мосед: “Бууж очоод, *Ааронтай хамт* гарч ир” (Гэтлэл 19:24, тодруулгыг нэмэв) хэмээв. Бурхан Мосе, Аарон хоёрыг зууч болгон Өөртөө дууджээ. Тэд Бурханаас сонссон үгээ хүмүүст дамжуулж, хүмүүсийн үгийг Бурханд дамжуулах ажээ. Гэхдээ энэ нь Бурханы анхдагч эх төлөвлөгөөний хаа ч хүрэхгүй байв.

Гэтлэл номыг цааш нь уншбал, Мосе уулан дээр эргэж очсон бол, Аарон хуарандаа байхыг нь харна. Аарон уул руу явсан боловч, дундуураа буцаад хүмүүс рүүгээ явсан болтой. Яагаад? Яагаад гэвэл Ааронд Бурханы оршихуйд байснаас хүмүүсийн оршихуйд байх нь

таатай байжээ. Түүнд Эзэнээс эмээхүй дутсан. Аарон Бурханаас илүү хүнээс айдаг байсан тул хүмүүст үйлчилсээр, эцэстээ хүмүүст хүссэнийг нь өгснийг бүгдээрээ тун удахгүй үзнэ.

Харин Мосе уулан дээр бараг дөч хоног байтал, ийм явдал болжээ:

Мосег уулнаас бууж ирэлгүй саатсаныг ард түмэн хараад Аарон дээр цугларч, түүнд —Бос. Бидний өмнө явах бурхдыг бидэнд бүтээж өг. Учир нь биднийг Египет нутгаас гаргасан хүн болох энэ Мосед юу тохиолдсоныг бид мэдэхгүй байна гэж хэлэв. Аарон тэдэнд —Эхнэр, хөвгүүд, охидынхоо чихэнд байгаа алтан ээмгүүдийг мулталж, надад авчир гэв (Гэтлэл 32:1-2).

Аарон удирдах бэлэг авъяастай хүн байсан бөгөөд энэ нь хэдэн төрлийн давуу чанар дагуулж байсны нэг нь хүмүүсийг соронздон татах увидас байв. Бэлэг авъяастай удирдагч хүн Бурхантай байсан ч, байгаагүй ч, бусдыг соронздон татдаг. Иймээс л Бурханы хүслийг буруугаар таниулдаг, Бурханы оршихуйгүй газарт ч хэдэн мянган хүнтэй чуулган байгуулж болдог байна. Эзэнээс эмээдэггүй удирдагч хүн Бурханаас өгөгдсөн бэлэг авъяасаа Эзэний хүслийг бус, хүмүүсийн хүслийг биелүүлэхийн төлөө ашигладаг.

Хүмүүс Ааронаас “Бос. Бидний өмнө явах бурхдыг бидэнд бүтээж өг. ... энэ Мосед юу тохиолдсоныг бид мэдэхгүй байна” хэмээн шахан шаарджээ. Хүмүүс “Бурхан яасныг бид мэдэхгүй байна” гэж хэлээгүй байгааг анзаараарай. Тэд Бурханыг бус, зүгээр л Мосег үл хэрэгсжээ.

БУРХАН ШҮТЭЭН ҮҮ, БУРХАН УУ?

Миний бие үүний эх бичвэрийг нь судлахдаа, орчуулагч нар жинхэнэ эх утгаас нь далийчихсан юм болов уу хэмээн гайхахад хүрсэн юм. Тэд *gods* (Монголоор *бурхад*) гэдэг Англи үгийг хэрэглэжээ. Гэтэл Еврей эх дээрээ *бурхад* гэж орчуулсан үг нь *элохим* гэдэг үг байдаг. Энэ үг нь Хуучин гэрээнд 2,606 удаа гардаг бөгөөд үүнээс ойролцоогоор 2,350 удаа дээр нь (Энэ нь 90-ээс дээш хувь болно) бидний үйлчилдэг, аугаа хүчирхэг Бурханыг нэрлэсэн байх юм. Тус үг нь Эхлэл номын нэгдүгээр бүлэг дээр л гэхэд 32 удаа гарахдаа, тухай бүр Эзэнийг хэлжээ. Жишээ нь Библийн эхний эшлэл дээр “Эхэнд Бурхан (*элохим*) тэнгэр ба газрыг бүтээжээ” (Эхлэл 1:1) гэдэг. Энд *элохимыг* “*Бурхан*” хэмээн орчуулжээ.

Нөгөөтэйгүүр, Хуучин гэрээн дээр энэ үгээр 250 удаа худал бурхдыг нэрлэсэн байдаг. Тиймээс бид зөв уншихын тулд ямагт бүрэн агуулгаар нь авч үзэх хэрэгтэй.

Аарон хүмүүстэй: “Эхнэр, хөвгүүд, охидынхоо чихэнд байгаа алтан ээмгүүдийг мулталж, надад авчир” (Гэтлэл 32:2) гэжээ.

Аарон алтыг хайлуулаад, багажаараа тугал цутгатал, ард түмэн: “Израиль аа, та нарыг Египетийн нутгаас гаргаж авчирсан бурхан чинь энэ байна гэгцгээв!” (Гэтлэл 32:4)

Энд *бурхан* гэхэд хэрэглэсэн үг нь нөгөө л *элохим* байна. Хүмүүс “Израиль аа, та нарыг Египетийн нутгаас гаргаж авчирсан *элохим* чинь энэ байна гэгцгээв!” Юу болж байгааг одоо харж байна уу? Тэр хүмүүс яг юу хэлснийг баттай мэдэхийн тулд үргэлжлүүлэн уншъя:

Аарон үүнийг үзээд, тугалын өмнө тахилын ширээ босгож
—Маргааш ЭЗЭНд зориулсан баяр наадам болно гэж
зарлан тунхаглав (Гэтлэл 32:5, тодруулгыг нэмэв).

Энэ эшлэл дээрх ЭЗЭН гэдэг Еврей үг нь *Иеховах* буюу *Иахвэх* гэдэг үг юм. *Иахвэх* нь Хуучин гэрээний хамгийн эрхэм үг болно. Энэ нь цорын ганц жинхэнэ Бурханы бүрэн эрхт, дархан нэр болой. Хуучин гэрээнд энэ нэрээр худал бурхдыг нэг ч удаа дүрслэх юмуу нэрлээгүй. Еврей гүүш нар энэхүү ариун дархан нэрийг оройлон дээдэлж, хамаагүй дуудах аваас алдас болом, ариун дархан дөрвөн үсэг хэмээн үзсэндээ, гүйцэт бичилгүй, зөвхөн гийгүүлэгчээр нь ИХВХ хэмээн товчлон буулгадаг байжээ. Энэ нь Израилийн амьдралд бузраас сахигдсан, дурьдашгүй ариун нэр байв.

Тэгэхээр, Аарон ба Израилийн үр сад цутгасан тугалаа “Биднийг Египетийн нутгаас гаргаж авчирсан цорын ганц жинхэнэ Бурхан Иахвэхийг үзтүгэй!” гэж хэлээгүй байна. Мөн “Биднийг Египетийн нутгаас гаргаж авчирсан Бурхан Баалыг үзтүгэй!” ч гэж хэлээгүй. Эсвэл өөр нэгэн чөлөөлөгч - худал бурхныг ч дуудаагүй байна. Тэд тугалаа Эзэний нэрээр нэрлэжээ.

НАЙР ЦЭНГЭЭНД ХҮРГЭСЭН ХҮНДЭТГЭЛ МӨРГӨЛ

Израильчууд Бурханыг улайм цайм няцаалгүй, харин Бурханы алдрыг цутгамал тугалын зэрэг рүү дордуулжээ. Тэд Бурханы тухай мэдлэгтээ мэхлэгджээ. Тэд Египетээс гаргаж авчирсан авран чөлөөлөгч Иахвэх

Бурханыг хүлээн зөвшөөрсөөр байсан. Мөн Түүний эдгээгч хүчийг ч няцаалгүй, ердөө Бурханы хувь дүрийг л сольчихож! Цааш нь:

Тиймээс дараа өдөр нь тэд эртлэн босож, шатаалт тахилууд өргөж, эвийн тахилуудыг авчрав. Ард түмэн идэж уухаар сууж, тоглож наргихаар босоцгоов (Гэтлэл 32:6).

Тэд тахил авчирсан байгааг нь тэмдэглээрэй. Яах гэж? Хүчин зүтгэх гэж байгаа нөгөө Иахвэхээ хүндэтгэх гэж! Тахил, хүндэтгэлийн дараа тэд махан биеийн дур хүслээ тоглуулан, мансуурцгаажээ. ЭнАйВи Библи дээр “босоод баяр цэнгэлд умбасан” гэдэг.

Өнөөдөр ч ийм явдал болдог уу? Бурханы авралын нигүүлслээр чөлөөлөгдсөн атлаа ариун эмээхүй байхгүй хүмүүс төсөөлөлдөө ургуулан бүтээсэн Есүсээ дуудаж байж болох уу? Гэхдээ үүнийхээ хажуугаар цуглаандаа явсаар, чөлөөлөлт, эрх чөлөөний тухай дуулсаар, номлол сонссоор, өргөл өргөсөөр, шинээр төрсөн амьдралаасаа атгасаар, Есүсийг Эзэнээ хэмээн мэдэгдсээр байх атлаа ашиг олох гэж худлаа ярьчихаад, үүнийгээ Бурханы ерөөл хэмээн гэрчилнэ. Магад пасторынхаа талаар юмуу бусдын талаар хов жив ярьчихаад, үүнийгээ “Энэ чинь үнэн, бүгдээрээ мэднэ” хэмээн зөвтгөх юмуу аль эсвэл садар самуун зэрэг гаж явдал үйлдчихээд, Есүс тэднийг аварсан ч гэлээ, махан бие дотор амьдарч байгаа хүн учраас, хэрэгцээ гэж нэг юм бий хэмээн шалтаглана. Энэ жагсаалт дуусахгүй байх.

Тэд Есүсийг мэдэх үү? Асуубал, шууд л “Тийм” гэнэ! Тэд мэхлэгдсэн үү? Тэд Өндөрт буй Эрхэм дээд Бурханы баруун гарт залран суугаа Нэгэнийг мэдэгдэж байна уу эсвэл хүссэн бүхнийг нь өгдөг, төсөөллийнхөө Есүсийг мэдэгдэж байна уу? Гэхдээ үүнээс илүү чухал нь “Бид өөрсдөө ийм байдалтай байна уу?”

Эзэнээс эмээхийг мэддэггүй хүмүүс Бурханы нэрийг дуудсаар байж болох ч, махан биеийнхээ дур хүсэлд уруу татагддаг бөгөөд харин махан бие нь Бурханы хүсэлд захирагддаггүй учраас, Бурхантай дайсагнадаг юм (Ром 8:5-7). Тэд Бурханы нэрийг дуудсаар, Түүнийг мэднэ хэмээн мэдэгдсээр, Бурхан тэдний зан үйлдлийг болгооно гэж итгэдэг атлаа Бурханы хүслийг дагадаггүй. Тэдний дуулгаваргүй явдал нь бүх дуулгаваргүй явдлын үндэс болох Эзэнээс эмээдэггүй зүрхнээс нь ургадаг бөгөөд “Есүсийг мэднэ” гэдэг мэхлэлээр хувцасласан буруу холбоо юм.

НУУЦ ҮГҮЙ

Үүнийг Библийн хаанаас ч харж болно. Энэ явдал Адам, Ева хоёрын нүглээс хойш нэг их удалгүй гарч ирсэн бөгөөд эхний хүн нь Адамын төрсөн хүү - Каин байв. Каины аав, ээж хоёр мэдлэггүй байдлаасаа болоод цэцэрлэгт нүгэл үйлдчихээд, дараа нь газрын үр жимс болох инжрийн навчаар биеэ халхалсан байдаг. Гэтэл Бурхан тэдэнд амьтны тахил хүсч байгаагаа илэрхийлсэн. Бурхан тэднийг амьтны арьсаар хувцасласан бөгөөд би үүнийг нь хурганы арьс байсан болов уу гэж итгэдэг.

Гэтэл Каин мэдлэггүй байгаагүй. Тэрбээр Бурхан газрын үр жимсийг бус, харин амьтны тахилыг таалдгийг аав, ээжийнхээ амьдралаас харсан. Гэх атал: “Хожим нь Каин газраас авсан үр жимснээсээ ЭЗЭНД өргөл болгон барьжээ” Эхлэл 4:3, тодруулгыг нэмэв) гэдэг. Каин худал бурхдад өргөл өргөсөн гэж хэлээгүй, тэрбээр чухам Эзэнд үйлчлэх гэсэн нь тодорхой байна. Каин Бурханд тахил өргөх гэж хичээнгүй ажилласан ч, энэ нь илтийн дуулгаваргүй явдал байв.

Дуулгаваргүй явдлын үндэс нь юу вэ? Мэдээж Эзэнээс эмээдэггүй сэтгэлээс өөр юу байх билээ. Энэ нь ч Эзэн түүнээс алагдсан дүү нь хаана байгааг асуух үед: “Би мэдэхгүй. Би дүүгийнхээ харгалзагч юм уу?” (Эхлэл 4:9) хэмээн уурсан хариулснаас нь илт харагддаг. Харж байна уу, яг л Израиль, тугал хоёрын түүх дээр гардаг шиг Эзэнээс эмээх сэтгэл дутсан Каин Бурханы дүр төрхийг дордуулан, Бурханд үйлчлэх зүй зохистой арга замыг өөрчилжээ. Мэхлэгдсэн Каин эдүгээ хүнээс нуухтай адил Бурханаас юм нууж болно хэмээн эндүүрч. Каины нүдэнд Бурханы дүр төрх хүний зэрэг рүү урууджээ. Сүүлчийн өдрүүдэд энэ л үлгэр загвар газар авахыг Паул аминчлан анхааруулсан байдаг: “Тэд Бурханыг мэдсэн атлаа... Бурханы алдрыг мууддаг хүн, шувууд, дөрвөн хөлт амьтад хийгээд мөлхөгчидтэй адил дүрээр сольжээ (Ром 1:21-23). Бурханаас эмээх сэтгэлгүй тэр хүмүүс Каинтай л адил заль мэхд автагдаад, Бурхан тэдний сөрөг арга замыг анзаарахгүй гэж итгэдэг.

Каин Бурханаас юм нуух арга байдаггүйг умартсан болох нь хэлсэн үгээс нь харагдана. Бурхан хүн биш бөгөөд бүгдийг хардаг бас мэддэг. Бид Эзэнээс эмээх сэтгэлээ гээхдээ, сүнсний юмсыг жирийн мэдэрхүйн хэмжээ рүү бууруулдаг. Учир нь хамгийн эрээ цээргүй нүгэлтэн ч Бурхан тэрслэлийг нь харж л байгаа гэдгийг мэддэг. Бурханыг мэддэг хүмүүс Бурханаас эмээх сэтгэлээ алдахдаа, өөрсдийгөө “Эзэн үзэхгүй!” (Езекиел 9:9-ийг үзнэ үү) гэх юмуу за үзсэн байлаа ч, ойлгоно гэж тайвшруулдаг. Энэ дунд удирдагч нар ч орно. Бурхан “Хүний хүү чи,

Израилийн гэрийн ахмадууд харанхуйд, хүн бүр сийлмэл хөргийнхөө өрөөнд юу үйлдэж буйг харав уу? Учир нь тэд “ЭЗЭН биднийг хардаггүй. ЭЗЭН энэ нутгийг орхив” хэмээдэг” (Езекиел 8:12) гэжээ.

Есүс Бурханаас эмээж явахыг анхааруулсныг бид умартаа юу? Учир нь Есүс “... илчлэгдэхгүй байхаар далдлагдсан, мэдэгдэхгүй байхаар нууцлагдсан юм гэж огт үгүй” (Лук 12:2) гэсэн. Гэтэл бид Бурханаас эмээхээ болихоороо, Бурханыг өөрийнхөө хэмжээнд бууруулаад, Түүнээс юм нууж болно гэх ухааны юм сэтгэдэг. Тэд Бурханы хаа сайгүй оршдог, бүхнийг мэддэг чанарыг үг дуугүй хүлээн зөвшөөрдөг атлаа сэтгэл дотроо Бурханы аймшигтай бөгөөд гайхамшигтай чанарыг мэдрэхээ больчихсон явдаг байна. Учир нь, хэрэв мэдэрдэг байсан бол, юм хумаа нууж хаах талаар сэтгэх ч үгүй байв. Тэд бурханлаг хүмүүсээс амжилттай нууж хааж чаддаг юмаа гэхэд, “ЭЗЭНий мэлмий хаа сайгүй. Ёрын муу хийгээд сайныг ч бас харах” (Сургаалт үгс 15:3) гэдгийг умартах.

ДУУЛГАВАРГҮЙ АТЛАА ДУУЛГАВАРТАЙ ХЭМЭЭН ИТГЭХ

Мэхлэл үүгээр дуусахгүй ээ. Мэхлэлийн дараагийн алхам нь дуулгаваргүй байгаа атлаа өөрийгөө дуулгавартай байна гэж итгэх явдал. Үүнийг Давидын удам Уззиа хаан яруу тодоор харуулдаг. Түүнийг арван зургаатай байхад нь аав Амазиа нь нас нөгчиж, Уззиа аавыгаа залгамжлан Иудагийн хаанаар өргөмжлөгджээ. Арван зургаахан насандаа хаан болсон хүн - эрүүл ухаантай л бол, Бурханыг л дуудан хайх бөгөөд Уззиа ч тэгжээ. Тэгээд үр дүнд нь ч ер бусаар хөгжин цэцэглэв гэнэ. Олон ч жил эд баялаг, амжилтыг эдлэв. “Ингээд түүний нэр алдар алс хол түгж, тэрээр хүчирхэг болтлоо асар ихээр тэтгүүлж байлаа” (2Шастир 26:15).

Уззиа хүчирхэгжмэгцээ, зүрх нь бардан сагажээ. Бардал, Эзэнээс эмээхүй хоёр нь эсрэг тэсрэгийн туйл юм. Зүрхэнд ариун эмээгүй хомсдох үед бардамнал боловсордог. Дараа нь юу болсныг анхааралтай уншина уу:

Гэвч хүчирхэг болмогц түүний зүрх сэтгэл ихэд бардам болсноос болж тэрээр завхарч, өөрийн Бурхан ЭЗЭНий эсрэг харш юм хийв. Тэрээр утлагын тахилын ширээн дээр утлага уугиулахаар ЭЗЭНий сүмд орсон юм. Түүний араас тахилч Азариа болон түүнтэй хамт зоригт эрс болох

ЭЗЭНий наян тахилч орсон билээ. Тэд Уззиа хааныг эсэргүүцэж, түүнд —Уззиа, ЭЗЭНд утлага уугиулах нь чиний үүрэг биш, харин утлага өргөхөөр ариусгагдсан Аароны хөвгүүд болох тахилч нарын үүрэг юм. Ариун газраас гарагтун, учир нь чи харш юм үйлдсэн бөгөөд ЭЗЭН Бурханаас хүндлэл хүртэхгүй болно гэв. Харин Уззиа утлага өргөхөөр утлагын бойпорыг гартаа барин, уурлаж хилэгнэжээ. Түүнийг тахилч нарт уурлан хилэгнэж байх үед духан дээр нь уяман өвчин гарчээ. Энэ нь тахилч нарын өмнө ЭЗЭНий өргөөнд, утлага уугиулдаг тахилын ширээний хажууд болсон билээ (2Шастир 26:16-19).

Тэгэхээр, Уззиагийн зүрх бардамналаар сагах үед тэр хүний сүнсний амьдрал өссөн үү, буурсан уу? Ингэж асуухаар сонсогч нар голдуу буурсан гэж хариулдаг юм. Гэхдээ үгүй юм аа. Учир нь Уззиа *хүндэтгэл мөргөл* үйлдэхээр сүм рүү явж оржээ. Үнэндээ Уззиагийн үйлдэл бүр л сүнслэг (шашинлаг) болжээ. Ер нь хэт сүнслэг зан авир, бардам зан хоёр бие биенээ нөхөн, хөтлөлцөж явдгийг харж болно. Бардам зан хүнийг шашинлаг байгаагаа хүлээн зөвшөөрөхөөс нь хорьдог бол, шашин нь бардам зангаа сүнсний хэв маягаар халхавчилж явдаг. Тэгээд аль, аль нь Эзэнээс эмээхүй, жинхэнэ даруу зангаар дутах!

Уззиа үнэнтэй нүүр тулах үедээ хилэгнэсэн. Каин ч мөн үнэнтэй нүүр тулах үедээ хилэгнэсэн. Бичээс “Каин ихэд уурлан, уруу царйлав” (Эхлэл 4:5) гэдэг. Каин Бурханд уурласан! Дуулгаваргүй амьдарч байгаа хүнийг үнэнтэй нүүрэлдүүлэх бүрийд, ариун эмээхүй байхгүй тэр хүмүүс уурладаг. Яагаад? Яагаад гэвэл тэд биеэ зөв гэж үзнэ! Тэд мэхлэгджээ. Харин мэхлэгдэх нь буруу атлаа өөрийгөө зөв хэмээн итгэх явдал юм.

Уззиа өөрийгөө зөв гэж итгэсэндээ л, тахилч нарт хилэгнэсэн бус уу? Тэрбээр Бурханыг дээдлэхээр сүмд орсон боловч, Аароны хөвгүүдтэй адил Эзэний дүр төрхийг бууруулан, зааврыг нь үл хэрэгсжээ. Уззиа уул санаа нь Бурхантай дотносох гэсэн боловч, дуулгаваргүй зангаараа буруу хөглөгдөөд, дотносох нь бүү хэл, харин ч бүр холдож одсон байна.

Өнөөдөр Бурхантай дотно харилцаатай хэмээн мэдэгддэг атлаа, хүсэл зорилготой нь хөг ч, хөл ч нийлүүлдэггүй үй олон чуулган байдгийг энэ явдал тайлбарлах шиг. Тиймээс та энэ зарчмыг ойлгож авахгүй бол, Бурханы нэрийг барьж ирээд л Бичээстэй огт нийцэхгүй юмсыг ярьж буй хүнтэй таарахаараа, нүд чинь орой дээрээ гарна байх шүү. Тийм хүмүүс залбирлын цаг дээрээ залбирахын оронд Бурханы хүндэтгэж яваарай хэмээн заасан удирдагч нарыг шүүмжилдэг. Тэгээд өдөөс нь Бичээсийн

үгийг сануулах юм бол, уурлаж гарна. Таныг сүнслэг бус хүн, шал буруу ярьж байна гэж дайрах боловч, үнэндээ тэд өөрсдөө л Бурханы замд хөндөлсөж яваа улс юм.

Миний бие удирдагч хүн болохоороо заримдаа хүмүүсийн Бурханаас хүлээж авсан гэх “илчлэлийг” нь сонсохдоо, дотор тавгүйтээд явчих үе олонтаа тохионо оо. Тэд тэр “үнэнээ” Бурханаас хүлээж авсан гэдэгтээ бат үнэмшилтэй байдаг. Гэхдээ Бичээсээр дамжуулан засч залруулж өгөх гэхээр эшлэл бүрийг маань үл хэрэгсэнэ. Ганц намайг тэгэхгүй л дээ. Өөрт нь туслах гэсэн хүн бүрт тэгж хандана. Тэд хэлсэн үгээ зөвтгөх үүднээс өөр Бичээсийг агуулгаас нь ховх татаж ирээд л хэрэглэдэг бөгөөд ямар ч зөвлөгөөг хүлээж авдаггүй. Тэгээд надаас зугтана. Мөн өөрт нь туслах гэсэн хүн бүрийг “сүнслэг бус” хэмээн үзэж, зайгаа авна. Цаг хугацаа өнгөрсөөр, тэд Бурханы хүслийг зөрчиж явсан нь үйлсийнх нь үр жимсээр батлагдах юмуу нөхцөл байдал тэдний санаснаас тэс өөрөөр эргэж таардаг. Тэд Есүсийн дуу хоолойг бус, төсөөллийнхөө дуу хоолойг сонсчихсон юм биш байгаа? Дотнослыг хайсан тэр хүмүүс мэхлэгдчихсэн юм биш байгаа?

ЗҮРХЭНДЭЭ НУУЦ ШҮТЭЭНТЭЙ АТЛАА БУРХАН ДЭЭР ОЧИХ

Энэ аймшигтай мэхлэлээс аврагдах арга зам бий. Гэхдээ тэр гарцыг мөн л Эзэнээс эмээхүй дотроос л олно. Эзэнээс эмээдэг хүн Бурхан дээр очихдоо заавар, засварын үгийг нь сонсоход бэлэн, нээлттэй зүрхээр ханддаг. Тэрбээр өөрийнхөө ухаан, аминч хүсэлд түшиглэлгүй, харин Бурханы хүслийг улайран хайна.

Эзэний хүсэлтэй нэг ч эгнэшгүй, хувийнхаа хүслийг Эзэн дээр барьж оччихоод, энэ Таны хүсэл мөн хэмээн тулган шаардаад байх шиг аюултай бөгөөд мунхаг зүйл үгүй. Учир нь ингээд байвал, бид дараагийн, бүр ч аймшигтай мэхлэлд унана. Энэ төвшний мэхлэл дээр Бурхан үндсэндээ бидний хүсээд байгаа зүйлийг зүгээр л баталчихдаг ажээ:

Хүний хүү, энэ хүмүүс зүрхэндээ шүтээнүүдээ залснаар хилэнцийнхээ бүдрэх чулууг нүүрнийхээ яг өмнө тавьсан атал Би ер нь тэднээр асуугдах ёстой гэж үү? (Езекиел 14:2-3)

Зүрхэндээ нууц шүтээнээ залчихсан атлаа Өөрөөс нь чиглүүлэг, зөвлөгөө, цэц ухаан гуйж ирж байгаа хүмүүсээ үзээд, Эзэн гашууддаг.

Тэр хүмүүс бодит байдлаа ухаарч байгаа эсэх нь бүрхэг боловч, үнэнийг үзэх нүдгүй болсон нь тодорхой байна. Шүтээн нь тэднийг хууль ёсгүй байдал руу унагадаг. *Хууль ёсгүй* байдлыг Еврейгээр *ауон* гэх бөгөөд онцгойлон Бурхан руу чиглэсэн санаатай бөгөөд санаандгүй зөрчлийг хэлдэг байна.

Бурхан тэднийг гэрийнхээ хашаанд юмуу хана туурга дотроо, орныхоо дэргэд шүтээнээ залдаг гэж хэлээгүй байгааг тэмдэглээрэй. Шүтээн шүтэх нь дан ганц харийн бурхдын нэрийг дуудах явдал биш юм шүү. Шүтээн шүтэх нь Бурханы дүрийг доройтуулан, бидний улайран хүсч байгаа зүйлийг өгдөг нэгний зэрэг зиндаа руу бууруулах явдал болохыг өмнө ярьсан билээ. Шүтэн шүтэхийн үндэс нь шунал болохыг үзэж болно. Үүнийг ч Шинэ гэрээ баталдаг:

Тиймд та нар газар дээрх эрхтнүүдийг үхүүл. Энэ нь садар самуун, бузар булай, тачаал, муу хүсэл, *шунахайрал болох шүтээн шүтэх явдал* юм. Эдгээрээс болж Бурханы хилэн [дуулгаваргүй хөвгүүд дээр] ирэх болно (Колоссай 3:5-6, тодруулгыг нэмэв).

Шуналт хүн шүтээнд мөргөдгийг Ефес 5:5 дээр ч Паул хэлжээ. Шүтээн шүтэх нь шунал юм бол, одоо *шунал* гэдэг үгийг тодорхойлъё. *Уэбстер* дээр “Сайн гэж үзсэн зүйлээ өөрийн болгох, эрхшээх гэсэн хүчирхэг хүсэл” гэж тодорхойлжээ. Би нэг удаа залбирч байхдаа, энэ үгийн утгыг Эзэнээс асуутал, Эзэн: “Шунал нь ашгийн төлөөх хүсэл” хэмээн хариулж билээ.

Дан ганц мөнгөний шуналаар хязгаарлагдахгүй л дээ. Үүнд хөрөнгө, байр суурь, тав тух, нэр алдар, таашаал, эрх хүч, бэлгийн хүсэл тачаал гэх мэт олон юмс багтана. Бид сэтгэл ханаагүй үедээ шуналтдаг. Бид Бурханы хайрладаг амар тайван, амгалангаар гачигдаад ирэхээрээ, зөрчил өрнүүлдэг. Амьдралд маань хандсан Бурханы төлөвлөгөө, үйл явцсыг санаатай бөгөөд санаандгүйгээр эсэргүүцдэг. Иймээс бидэнд “Байгаа юмандаа сэтгэл хангалуун байж, амьдрал чинь мөнгийг хайрлахаас чөлөөтэй байг. Учир нь Тэр Өөрөө “Би чамайг хэзээ ч орхихгүй мөн чамайг хаяхгүй” гэж айлдсан” (Еврей 13:5) гэдэг. Бид “Өөрт минь Та амийн замыг таниулна Өөрийн тань оршихуйд л баяр хөөр дүүрэн Таны баруун мутарт Баяр жаргал үүрд байдаг” (Дуулал 16:11) гэдэг баталгаа дотор амьдарбал, Бурханы оршихуй, төлөвлөгөөнөөс гадуур элдэв дур таашаал эрэлхийлэхээ болино.

Шунал нь амар амгалан бус байдалд амьдардаг бөгөөд унтаршгүй хүслээр тэжээгдэж байдаг. Энэ нөхцөл нь Египетээс гарч ирсэн

Израилийн хүүхдүүдийг төгс дүрслэх. Бурхан хүслээ илэрхийлчихээд байхад л Израильчууд сайн гэж итгэсэн зүйлээсээ тавилгүй, зууралдсаар байжээ. Израильчууд өөрсдийг нь Амлагдсан газарт бэлтгэхийн төлөө Бурханы боловсруулсан үйл явцад дургүйлхэж, орчин нөхцөл, ус, хүнс гэх мэтийн талаар увруулан цувруулан гомдоллосон. Бурханаас ариунаар эмээдэггүй зүрх нь ч шунал боловсрох таатай хөрс болжээ. Бурхан Өөрийгөө илчлэх үед ч Израильчууд Бурханыг гэхээсээ илүү дур таашаал, олз ашгийг мөрөөсч явдаг, жинхэнэ зүрхээ нуухын тулд Бурханаас дайжиж зугтсан.

Эзэн, Мосе хоёрыг эзгүй хойгуур Израиль Бурханы дүрийг шунаг хүслийг нь хангаж өгдөг дүрээр сольжээ. Энэ бүх үйл явдал нь дандаа алттай холбогдож байгаа нь ч сонирхолтой. Бурханы хүсэлд бүрэн зориулагдах санаагүй, бурханлаг бус сэтгэлээс нь тэдний үнэ мөнгөний шунал ч ханхлах. Израиль мэхлэлийн өтгөн мананд төөрчээ.

(Дашрамд хэлэхэд, шунал нь бусад бүх төрлийн шүтлэгийн үндэс мөн. Хүн төрөлхтөн Бурханыг дээдлэн хүндэтгэх угийн хүсэлтэй бүтээгджээ. Гэвч олонх нь жинхэнэ Бүтээгчдээ захирагдалгүй, худал бурхдыг бүтээдэг байна. Тэгвэл худал бурхны үндэс дээр нь хэн байдаг вэ? Хариулт нь: бүтээсэн эзэн нь буюу хүн өөрөө. Ийнхүү эдүгээ тэрбээр өөрийнх нь хүслийг гүйцэлдүүлэн, хангаж өгдөг худал бурхнаа шүтнэ. Үндэс нь мөнөөх л шунал ажээ.)

Үндсэндээ, төрөл хэлбэрээсээ үл хамааран, эх ундарга нь шүтээн шүтэх явдал юм. Шүтээн нь Бурханы эзлэх ёстой, бүрэн эрхт байр суурийг эзэлдэг. Шүтээн шүтлэг нь таны аз жаргал, тав тух, амар тайван, хангамж тэргүүтний үндэс болдог. Бурхан “Та нар бөхийн мөргөх гэж шүтээн ба сийлмэл хөрөг бүү хий...” (Леви 26:1) хэмээсэн. Шүтээнийг хүн өөрөө л бүтээдэг. Амьдралдаа Бурханаас дээгүүр залж байгаа бүхэн чинь шүтээн болно. Өөрөөр хэлбэл, Эзэнээс илүү хайрладаг, дурладаг, найддаг, хүсдэг, анхаардаг зүйл чинь. Шүтээн нь таны хамаг хүчээ авдаг бас хамаг хүчээ өгдөг тэр зүйл юм. Итгэгч хүн сэтгэл дундуур байдлаа таягдаж хаяхын оронд харин ч өөгшүүлээд, сэтгэлээ хангах юмсыг Бурханы хүслийн гаднаас хайгаад эхлэхээрээ л шүтээн рүү урвадаг. Үүний хамаг үндэс нь нөгөө л шунал юм.

ШУНАСНЫХАА ДАГУУ ХАРИУЛТАА АВАХ

Бүгдээрээ Езекиелд айлдсан Бурханы Үгийг эргэн сөхье. Хүмүүс нь зүрхэндээ шүтээн залчихаад, Өөрөөс нь тусламж хүсэхээр ирсэнд

Бурхан гашууджээ. Тэд Бурханаас хүслийг нь асуухаар бус, өөрсдийнхөө хүслийг биелүүлж өгөхийг гуйхаар иржээ. Яг л аав, ээж хоёр минь надаас илүү мэргэн бөгөөд миний л төлөө хэлдэг учраас, аав, ээжийнхээ мэргэн үгийг сонсьё гэж бодолгүй, өөрийнхөө хүсэл санааг аав, ээждээ тулган шаарддаг өсвөр насны хүүхдүүдээс өөрцгүй.

Бурхан Езекиелд нэгэн зэрэг түгшээмээр ч, сэхээрүүлмээр ч үг айлджээ. Бурхан Езекиелд “Над руу ирж байгаа шунаг зүрхтэй хүмүүст “Израилийн гэрийн ямар ч хүнд ЭЗЭН Би шүтээнүүдийнх нь тоо томшгүй байдлаар хариулахыг хэл” (Езекиел 14:4) хэмээн түс тас хариулжээ.

БУРХАНЫ ХҮНИЙ ТӨӨРӨГДӨЛ

Үүнийг Балаамын амьдрал дүрслэн харуулдаг. Балаам худал бурхдын бус, харин бидний үйлчилдэг Эзэн - Иехувагийн аугаа эш үзүүлэгч байв. Түүний эш үзүүлэх хүчирхэг үйлчлэл нь хаадын сонорт ч хүрсэн бөгөөд тэдний нэг нь Моаб, Мидианы хаан Балак байжээ.

Дөнгөж сая дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн Египетийг газартай тэгшилчихээд, эдүгээ Моабын хөндийд буудаллаад байгаа Израилиас Моаб, Мидианы хүмүүс аюужээ. Египетийг дор нь сүйрүүлчихсэн улс чинь тэднийг юухан байх уу гэж бодсон болтой. Энэ айдас нь асар хурдтай давалгаалсаар, ордонд хүрэв гэнэ.

Балак хаан ч төлөвлөгөөгөө боловсруулжээ. Тэрбээр нөгөө аугаа эш үзүүлэгч Балаамын ерөөсөн бүхэн нь ерөөгдөж, хараасан бүхэн нь хараагддаг болохыг олж мэдсэн байна. Тэгээд төлөөлөгч нараа илгээгээд, Балаамд татгалзахын аргагүй санал хүргүүлэн, төлөөний хүмүүсийнх нь хамт хүрэлцэн ирээд, дэргэд нь зогсоод, Моабын өндөрлөг газраас Израилийг харааж өгөөч хэмээн хүсэн гуйсан байна.

Энэ хүсэлт нь ч Балаамын сэтгэлийг хөвсөлжүүлжээ: “Тэр тэдэнд —Шөнийг эндээ өнгөрүүлэгтүн. ЭЗЭНий надад айлдах үгээр би та нарт хариу хэлье гэлээ. Моабын түшмэд Балаамтай хамт үлдэв” (Тооллого 22:8). Өнөөдөр ч Есүст итгэдэг олон хүн Балаамтай тун төстэй үг хэлдэг: “Энэ талаар залбиръя. Эзэн юу гэх нь үү, сонсьё”.

Эзэн Балаам дээр ирээд: “Чамтай хамт байгаа энэ хүмүүс юун хүмүүс вэ?” хэмээн нүүрэлджээ. Өөрөөр хэлбэл: “Чи юунд энэ талаар залбирах гэнэ вэ? Надтай ямар ч гэрээгүй энэ хүмүүс чамаас Миний гэрээний хүмүүсийг хараахыг гуйж байна! Тэгээд чи Надаас юугаа асуух гээд байгаа юм?” гэжээ.

Тэгэхээр, эндээс бид - бүгдээрээ нэгэн сургамж авах ёстой: “Бидний хувьд залбирах ч хэрэггүй юмс гэж бий! Гуйхаасаа ч өмнө Бурханы хүслийг мэдэж байх ёстой юмс. Жишээ нь, өсвөр насны хөвгүүд маань аавыгаа зөвшөөрөхгүйг мэдсээр байж, ямар нэг юм гуйж шалаад байхад би дургүй. Мэдсээр байж, яагаад асууна вэ? Тэгээд мэдээд байсан хариултыг нь өгсөн хойноо би дотроо бувтнадаг. Тэд ч дуртайдаа бус, харин аавынх нь үг хил хязгаарыг нь тогтоож өгдөг хууль учраас л асуудаг.

За, Балаам руугаа эргэж орёе. Түүнд ер бусын их шан харамж, Моаб, Мидианы хүмүүсийн дунд асар хүндтэй байр суурь амлаа байх. Энэ их олзны сургаар Балаамын эрүүл ухааны нүд сохорсон уу?

Нигүүлсэнгүй Бурхан маань: “*За яахав, Балаам аа, чи Миний санааг ойлгоогүй - үнэндээ ойлгохыг хүсээгүй учраас, Би хүслээ маш ойлгомжтой болгоё*” хэмээн бодсон болтой. Тиймээс Бурхан “Тэдэнтэй хамт бүү явагтун. Тэр ард түмэн ерөөгдсөн учир чи тэднийг харааж болохгүй” (Тооллого 22:12) хэмээв. Одоо ойлгомжтой болсон уу? Надад заримдаа Бурханы маш товч, тодорхой хэлсэн үгийг бид л будлиантуулж, булингартуулдаг юм шиг санагддаг юм.

Балаам маргааш өглөө нь Бурханы үгэнд ороод, Балакийн албатад: “Намайг та нартай явахыг ЭЗЭН *татгалзсан* тул нутаг уруугаа буцаж явцгаа” (13, тодруулгыг нэмэв) гэж хэлжээ. Балаам Бурханы үгэнд орсон хэдий ч, дурамжхан байгааг нь *татгалзсан* гэдэг үгээс нь харж болохоор байна. Жишээлбэл: нэгэн өсвөр насны охиныг тун царайлаг боловч, үл бүтэх явдлаараа зартай залуу бүжгэнд урьжээ. Охин алдартай залуугаас урилга хүлээж авсандаа хөөрөөд, баяр баяслаа дарж ядан, ааваасаа зөвшөөрөл асууж гэнэ. Охиндоо санаа тавьдаг, хайрладаг тэр аав охин үрийнхээ хүсэлтэд зөөлнөөр татгалзжээ. Голдоо ортол гомдсон охин нөгөө залуудаа: “Аав, ээж хоёр зөвшөөрөхгүй байгаа болохоор л би явж чадахгүй нь” гэж хэлжээ. Үнэндээ охин “Аав, ээж л зөвшөөрөхгүй байна. Би бол зөвшөөрнө” гэж хэлсэн байна. Охиныг улайрсан шунал хүсэлдээ хүрэхэд нь аав, ээжийн хоёрынх нь үг л саад хийгээд байгаа ажээ. Тэр охин аав, ээжийнхээ зүрхийг ойлгохгүй бол, хэзээ нэгэн өдөр ямар нэгэн аргаар залуутайгаа уулзсаар, тун таагүй үр дүнд хүрэх боломжтой.

Балаам мөнгөнд хайртай эш үзүүлэгч байжээ. Дотроо байнга буцалж явдаг гэх үү. Тэр гоё тансаг амьдрал, олны дунд нэр нөлөө олохыг мөрөөсч явдаг байж. Балаам Эзэний үгийг дагасан боловч, битүүхэндээ дурамжхан байв. Хүслээс нь чангаагаад байгаа Бурханы Үг Балаамд сэтгэлийн жаргал бус, хорио цээр шиг л санагдсан биз ээ.

АМИН ХҮСЭЛДЭЭ ТАТАГДАХ

Моаб, Мидианы ахлахууд Балак хаан дээр эргэж очоод “Балаам бидэнтэй хамт ирэхээс татгалзав” хэмээн тайлагнажээ. Гэхдээ хаан няцсангүй. Харин ч бүр хоёр дахин өндөр байр суурь, их хүндэтгэл, мөнгө амлаад, хүмүүсээ буцаагаад илгээв.

Балак яагаад тэгсэн бэ? Чөтгөрийн хүчин л оролцсон байх. Яагаад ингэж хэлнэ вэ гэж үү? Библи “Харин *тачаалдаа автаж, татагдахдаа* хүн бүр уруу татагддаг” (Иаков 1:14, тодруулгыг нэмэв) гэдэг. Эндээс хоёр үгийг тэмдэглэнэ үү. Нэгдүгээрт - *тачаал*. Бурханы хүсэлтэй зөрчилдсөн аливаа хүчирхэг хүсэл нь шунал буюу шүтээн шүтлэг мөн. Хоёрдугаарт - *уруу татагдах*. Энэ чинь харин дайсны хийдэг ажил - дайсан уруу татдаг. Гэхдээ нэг зүйлийг мэдээрэй: Хүн дургүй юмдаа уруу татагддаггүй. Жишээ нь, чуулганд явдаг хүмүүст хар тамхи санал болгобол, ихэнх нь шууд л татгалзана. Яагаад? Яагаад гэвэл, тэдэнд хар тамхи хэрэглэх хүсэл байхгүй. Хүн дургүй юмандаа уруу татагдахгүй. Тийм боловч, загалмайн хөлд авчирч тавиагүй хүсэлдээ уруу татагдах боломжтой! Бид шунадаг - өөрөөр хэлбэл, *дурладаг* зүйлдээ л уруу татагддаг.

Эш үзүүлэгч Балаам мөнгө, нэр алдарт ухаанаа алддаг байсныг дайсан мэддэг болохоороо, Балак гэдэг бурханлаг бус хаанаар дамжуулан хоёр дахин их баялгийг санал болгожээ. Төлөөнийх нь хүмүүст ч Балак хаанд байгаа бүхнийг гаргаж тавиад, “Хэлсэн бүхнийг тань биелүүлье” хэмээн амлах бүрэн эрхийг олгожээ. Пөөх, ямар том санал вэ! Танай хөрш танд шагнал амлах нь нэг хэрэг. Учир нь тэрбээр их бага хэмжээний мөнгөтэй байлаа ч, улсын хааны хаа ч хүрэхгүй. Гэтэл улсын хаан - хүн байгаа бүхнээ барин тавин, санал тавих нь тэс өөр хэрэг юм. Нэн ялангуяа, түүнд таны сул талыг нөхөх давуу тал байгаа нөхцөлд. Гэтэл Балаам юу гэж хариулсныг үзнэ үү:

Балак надад алт мөнгөөр дүүрэн гэрээ өгсөн ч би өөрийн Бурхан ЭЗЭНий тушаалыг зөрчин их, бага ямар ч зүйлийг *хийж чадахгүй* (Тооллого 22:18, тодруулгыг нэмэв).

Ихэнх хүн Балаамын дуулгавартай байдлыг сайшаах байх. Гэхдээ мөн л Балаамын үгийн сонголтыг үзнэ үү: *хийж чадахгүй*. Балаам мөн л Эзэний үгд тушигджээ. Балаам чуулганы хаалгаар нэвтэрдэг дийлэнх хүмүүсийн мэддэг зүйлийг буюу *Эзэний Үгийг санаатайгаар зөрчсөн хүн ерөөгдөж чадахгүйг* мэддэг байжээ. Түүнчлэн Балаам чуулганд явдаг

хүмүүсийн магадгүй тал хувийнх нь мэддэг зүйлийг буюу *санаатайгаар дуулгаваргүй авирладаг хүнийг шүүх хүлээж байгааг* ч мэддэг байжээ. Тийм боловч, үүнийг мэдлээ гээд ихэнх хүн асуудлаас аврагддаггүй. Учир нь Бурханы хүсэлд бүрэн ханахгүй байгаа хүн “Бурханы хүслийн хүрэн” дотроо санасандаа хүрчих арга замыг хайсаар л байдаг. Үүнийг тайлбарлахын тулд Балаамын дараагийн мэдэгдлийг үзье:

Харин та нар өнөө шөнө эндээ үлдэгтүн. ЭЗЭН надад өөр юу айлдахыг нь би мэдье гэлээ (Тооллого 22:19).

“Эзэн надад өөр юу айлдахыг нь... мэдье”. Сонсож байна уу? Илүү их мөнгө Бурханы бодлыг өөрчилнө хэмээн санаа юм болов уу? Эзэн эхний удаа “Тэдэнтэй бүү хамт яв” гэж хэлсэн нь илүү дээр саналыг хүлээсэндээ тэр байжээ гэж бодоо юм болов уу?

Яахаараа энэ талаар дахиад залбирах хэрэгтэй гэж? Балаам хүссэндээ хүрчих арга чарга хайсаар байгааг нь харж байна уу? Дур хүсэл нь Балаамын хамаг эрүүл ухааныг бүрэн дарангуйлжээ. Яг л нөгөө алдартай хөвгүүнтэйгээ болзох зөвшөөрөл аван автлаа аавыгаа шаналган шаналгасаар байгаа өсвөр насны охинтой л адил. Бурханы хүсэл Балаамын шунаг зүрхтэй цавчилдаж байсан болохоор, Балаам Бурханы хүслийг дагамааргүй, гөжүүдэлж байв. Өөрөөр хэлбэл, шүтээн шүтдэг зүрхтэй хүн гэх үү. “Гөжүүдлэх нь ёс бус агаад шүтээнд мөргөхтэй адил” (1Самуел 15:23). Тэгээд Бурхан Балаамд юу гэж хариулсныг үзнэ үү:

Шөнө нь Бурхан, Балаам уруу ирж, түүнд —Хэрэв энэ хүмүүс чамайг дуудахаар ирсэн аваас босож тэдэнтэй хамт явагтун. Харин зөвхөн чамд Миний хэлснийг л чи хийх ёстой гэв (Тооллого 22:20).

Балаамынд хоногдосон эрчүүд өглөө нь Балаамыг дагуулж явах найдлага өвөрлөн, дуудах ёстой байжээ. Тэгэхээр, Бурхан үндсэндээ “Хүмүүс чамайг дуудахаар нь хамт яв. Гэхдээ чи гагцхүү Миний хэлсэн үгийг л хэлэх болно” гэжээ. Пөөх, бид буруу бодсон болтой. Энд “Шөнө нь Диавол Балаам дээр ирээд: “Босоод тэдэнтэй хамт яв” гэж хэлээгүй мөн “Шөнө нь мэхлэгч сүнс Балаам дээр ирээд...” гэж ч хэлээгүй байгааг тэмдэглээрэй. Би өмнө тоглоом шоглоом болгож хэлсэн л дээ. Гэхдээ энэ үйл явдлыг үзэх юм бол, Бурхан үнэхээр мөнгөний хэмжээг нь өсгөтөл хүлээлгэж байгаад, өсгөмөгц нь: “Яв” гэж хэлсэн мэт харагдаж байна.

ХҮССЭНЭЭ АВАХ

Ийнхүү Балаам явах зөвшөөрлөө Эзэнээр батлуулж чадав. Тэгээд шөнө Эзэний өгсөн зааврыг биелүүлэхээр өглөө нь босов. Тэгтэл ийм явдал болжээ:

Балаам өглөө босоод, илжгээ эмээллэж унаад, Моабын түшмэдтэй хамт явав. *Гэвч түүний явснаас нь болж Бурхан уурласан бөгөөд ЭЗЭНий тэнгэрэлч түүнд садаа болохоор зам дээр зогслоо. Балаам илжгээ унаж явсан бөгөөд хоёр зарц нь хамт байлаа (Тооллого 22:21-22, тодруулгыг нэмэв).*

Байзаарай! Өнгөрсөн шөнө Өөрийнх нь хэлснийг л хийсний төлөө одоо Бурхан Балаамд уурлав гэнэ! Бурхан шизотой Бурхан биш учраас, үүнийг юу гэж тайлбарлах вэ? Хариултыг нь Езекиелд хэлсэн Бурханы үгээс олж болно. Хүмүүс нь Эзэн дээр шунаг зүрх өвөрлөн ирэх үед “ЭЗЭН Би шүтээнүүдийнх нь тоо томшгүй байдлаар хариулна” хэмээснийг санаж байна уу?

Үүнийг чуулганы олон хүн мэддэг ч үгүй, ойлгодог ч үгүй. Бурхан хүслээ илэрхийлчихээд байхад л бид ямар нэг зүйлийг улайран хүссээр, үргэлжлүүлэн шунасаар байвал, Бурхан дургүй бөгөөд хожим биднийг үүнээсээ болж шүүгдэхийг мэдэж байсан ч, хүсээд байгаа зүйлийг маань бидэнд өгнө!

Гайхаж байна уу? Гэхдээ хааныг хүссэн Израилийг үз л дээ. Самуел хүмүүсийн хүслийг барьсаар Эзэн дээр очих үед Бурхан ард түмнийхээ дээр хааныг залах хүсэлгүй байгаагаа мэдэгдсэн. Бурхан Самуелаар дамжуулан “хаан чинь та нарын шилдэг хөвгүүд, охид, газар, усан үзмийн талбай, төгөлийг аваад, дээрээс нь татвар татаас авахыг” анхааруулан хэлжээ.

Самуел Эзэний үгийг хүмүүст хүргэтэл, “...хүмүүс *Самуелын* үгэнд орохоос татгалзсан” гэдэг. Библи тэднийг Эзэний үгэнд татгалзсан гэж хэлээгүй байгааг тэмдэглээрэй. Нөгөө л Мосегийн түүхтэй адил, санасандаа хүрэхийн тулд тэд *Эзэнийг төлөөлүүлэн өөрсдийнхөө бүтээсэн дүрээ* сахиад, зарлагын үгийг үл хэрэгсжээ. Харин Бурхан Самуелыг хувьчлан тайтгаруулав: “Тэд чамайг няцаагаагүй, Намайг няцааж байгаа юм” (1Самуел 8-ыг үзнэ үү).

Эцэст нь Бурхан хүмүүст хүссэн хааныг нь өгдөг. Бүр Өөрөө сонгож

ирээд л өгсөн буюу эхнийх нь Саул байв. Тэгээд мэдээж хэлсэн ёсоор, хаад нь ард түмнийхээ шилдэг хөвгүүд, охид, газрыг авч, дээрээс нь татвараар дарамталсан. Тэр хаад л адагтаа ард түмнээ Вавилоны дарлалд оруулсан юм. Бурхан хүмүүст улайрч хүссэн зүйлийг нь өгсөн байна!

Цөлд байсан Израилийг аваад үз. Тэд хүний хүртэж яваагүй, манна хэмээх тэнгэрийн хоолыг идсэн. Елиа энэ хоолноос хоёр зүсэм идээд л дөчин өдөр, шөнө гүйсэн байдаг! Хүч чадлын хүнс гэх үү!

Гэвч Израиль маннагаас залхаад, махны төлөө уйлалджээ. Тэд Эзэнээс мах гуйсан бөгөөд Бурхан хүсэлтийг нь биелүүлснийг үзнэ үү (Дуулал 106:15). Эзэн мөн л хүмүүсийн шунаг хүслийг нь биелүүлж өгчээ. Үнэндээ гайхамшгаа гайхуулан байж, хангаж өгсөн.

Тэнгэрт дорнын салхийг үлээлгэж,
Хүч чадлаараа өмнөдийн салхийг ч
Тэрээр тууж авчирсан.
Тэдэн дээр махыг тоос шороо мэт,
Шувуудыг далайн элс мэт Тэр буулгасан.
Хуарангийнх нь дунд,
Суудаг газрынх нь эргэн тойронд унагаасан
(Дуулал 78:26-28).

Хүмүүсийн тавьсан хүсэлтийн хариуг Бурхан ер бусаар (“хүчээрээ”) биелүүлдэг, гурван сая хүнийг хооллох хангалттай олон бөднө шувууг цөлд тууж авчирсан! Бөднө шувуу цөлд амьдардаггүй учраас, ёстой л гайхамшиг гэхээс өөр юу гэх вэ! Үүгээр зогсохгүй, тэр хүмүүст буу ч, нохой ч байгаагүй. Тиймээс л гайхамшиг мөн! Гэвч үүний дараа юу болсныг үзнэ үү:

Тэр тэдэнд *шунан хүссэнийг* нь өгсөн тул
Ийнхүү тэд идэж, сайн цадацгаасан.
Харин шунал хүсэл нь эс хангагдсан.
Хоол нь тэдний аманд байх зуур л
Бурханы уур хилэн тэдний дээр ирж,
Тэднээс хамгийн тарганыг нь алсан бөгөөд
Израилийн шилдэг эрчүүдийг цохиж унагасан
(Дуулал 78:29-31, тодруулгыг нэмэв).

Бурхан хүмүүсийн хүслийг ер бусаар хангасан атлаа идэж дуусахаас нь өмнө шүүхээ буулгажээ. Бурхан тэдэнд зүрхнийх нь улайрсан хүслийн дагуу л хариулжээ.

Нэгэн жишээ: Залуу, бүсгүй хоёр болздог байжээ. Гэтэл аав, ээж хоёр нь: “Миний хүү, та хоёрын харилцаа нэг л биш байна. Миний хүү эртхэн больсон нь дээр” гэж зөвлөжээ. Залуусын пастор нь ч бас: “Би ч бас аав, ээжийн чинь үгийг давтмаар байна. Залбирахаар нэг л түгшүүртэй байна. Наад охиноосоо эртхэн больсон нь дээр” гэжээ. Эцэстээ залуу: “Би зөндөө залбирлаа. Бурхан намайг түүнтэйгээ гэрлэ гэсэн” гэв. Тэгээд гэрлэхийгээ, хожим нь яагаад ийм зовлонтой байгаагаа гайхна.

Нэгэн жишээ: Нэг залуу тушаал дэвших талаараа гэргийдээ хэлжээ. Гэргий нь: “Дэмий байх аа. Надад тайван биш байна. Чи тэр ажилд орчихбол, жилийн хоёр зуун өдөрт нь дэлхийгээр аялдаг болно. Чуулгандаа сардаа ганц л явбал явна, пасторын дамжуулах Бурханы Үгийг ч сонсохгүй, дээрээс нь хүндэтгэл, магтаал, үйлчлэл ч байхгүй...” хэмээнэ. Пастор нь ч бас яг адилхан үг хэлсэн боловч, нөхөр нь шийдсэн чигээрээ тушаал дэвших хүртлээ залбирна. Тэгээд жилийн дараа яаж яваад гэр бүлээсээ хол, зочид буудлын өрөөнд нэг хачин хүүхэнтэй хоноглохдоо тулснаа гайхна.

Ийм жишээ төгсөхгүй байх. Бид нэг зүйлийг ойлгох хэрэгтэй: Хүн өөрт нь зориулсан Бурханы хүсэлтэй нийцэхгүй юмд шунаад байвал, хүмүүний зүрхэнд заларсан шүтээнийх нь дагуу хариулдаг Бурхан маань хүссэн юмыг нь хүнд зүгээр л өгчихдөг. Бурхан эцсийн эцэст бидний зүрхийг эргүүлж олзлох гэсэндээ л ингэдэг ажээ.

Тиймээс тэдэнтэй ярьж, тэдэнд “Эзэн БУРХАН айлдахдаа “Шүтээнүүдээ зүрхэндээ оруулж, хилэнцийнхээ бүдрэх чулууг нүүрнийхээ яг өмнө тавиад эш үзүүлэгч дээр очдог, Израилийн гэрийн ямар ч хүнд ЭЗЭН Би шүтээнүүдийнх нь тоо томшгүй байдлаар хариулна. Ингэснээр бүх шүтээнээрээ дамжин Намайг хаясан Израилийн гэрийн зүрхнүүдийг Би эргүүлэн барих юм” хэмээв” гэж хэл (Езекиел 14:4-5).

ЭнАйВи Библи: “Би Израиль хүмүүсийн зүрхийг эргүүлэн олзлохын тулд үүнийг үйлдэнэ” гэдэг. Эзэн ямар ч хамаагүй аргаар биднийг зүрхэндээ ойртуулахыг хүсэмжлэх. Бурхан бидний мөрөөсөл болон араас маань нэхэдгийг санаарай. Бурхан бидний дундаас нэгийг маань ч алдахыг хүсдэггүй хэдий ч, хэнд ч дорд үзэгдэхээргүй Бурхан болой. Өөрт нь зүрх юугаа бүрэн өргөсөн хүмүүст л Бурхан Өөрийнхөө зүрхийг зориулдаг. Иймээс л хүн - бидний зүрхийг зүйл бүрийн шуналын буюу шүтээний урхинаас эргүүлж татахыг эрэлхийлдэг ажээ.

Тэнэмэл хүү ааваасаа өөрийнхөө өвлөх ёстой хувийг гуйж авахаар автайгаа уулзахдаа, харь хүний юмуу зарцын хувиар бус, харин тэр гэр бүлийн гишүүн - хүүгийнхээ хувиар уулзсан байдаг. Залуу хүү тухайн үедээ аавынхаа зүрхийг өвлөөгүй, цэвэр аминч сэдлээр хөдөлжээ. Хүү нь хамаг байдгаа үрэн таран хийхийг нь аав нь мэдэж байсан атлаа хүсэлтийг нь зөвшөөрсөн. Хамгийн сайхан нь хүү адагтаа ухаан ороод, аавдаа эргэж очсон байдаг. Тэрбээр ирэхдээ, өмнө нь мэддэггүй явсан аавынхаа зүрхийг ойлгодог болсон байжээ.

Ариун эмээхүйгээр гачигдаж, төөрсөн хүүхэд бүрээ эргүүлж олзлох нь Бурханы амин хүсэл. Харамсалтай нь, зарим нь Балаамтай адил Эзэнийхээ зүрхийг хэзээ ч ойлгодоггүй, хэзээ ч эвлэрдэггүй. Балаамын түүхийг цааш нь үзбэл, тэрбээр шуналаасаа болоод адагтаа цавчуулж цаазлуулсан байдаг.

Өнөөдөр Шинэ гэрээн дор ариун эмээхүйг үл хэрэгсдэг хүмүүсийг Израилийн хүүхдүүдтэй, Каинтай, Балаамтай жишсэн байдгийг санаарай. Бидэнд ийн анхааруулжээ:

Хэдий та нар энэ бүхнийг мэддэг ч гэсэн би одоо та нарт дахин сануулахыг хүсэж байна. Юу гэвэл, Египетийн нутгаас ард түмнийг Эзэн нэгтээ чөлөөлөөд, дараагийн удаад итгээгүйг нь устгасан юм (Иуда 5).

Иуда дараа нь Шинэ гэрээний дор, Бурханы нигүүлслийг тунхаглаж амьдардаг атлаа шунал, тачаал, дуулгаваргүй амьдрал руугаа эргэж гулсдаг хүмүүсийг дүрслэн өгүүлжээ.

Тэд золгүй еэ! Учир нь тэд Каины замаар явж, шан харамжийн төлөө Балаамын төөрөгдөлд өөрсдийгөө тушаасан бөгөөд Корегийн тэрслэлд мөхжээ. Эд бол та нарын хайрын зоогон дахь сэв бөгөөд эмээлгүйгээр та нартай найрлахдаа өөрсдийгөө л тэжээдэг (Иуда 11-12).

Бидний хайрын зоог дээр буюу орчин цагийнхаар - цуглааны үйлчлэл дээр сэв цав байдаг хэмээснийг анхааралдаа авна уу. Есүс өөрийгөө дэлхийн тачаалаас өө сэвгүй сахисан (Өөрийнхөө дотны хайртай) сүйт бүсгүйн төлөө эргэж ирэхийг хэзээ ч бүү март. Гэтэл Есүст итгэдэг нэртэй хүмүүс “огт эмээлгүйгээр та нартай найрлахдаа, өөрсдийгөө л тэжээдгийг” Иуда хэлсэн байна. Тэд ерөөлийг, тэр бүү хэл Бурхантай дотносохыг эрмэлздэг ч, Бурханаас огт эмээхгүй. Мэхлэлд автсан

тэр хүмүүс ариун айдас, хайраар Бурханы зүрх рүү эргэхгүй аваас, мэхлэлдээ улам л гүн живнэ.

АНХААРУУЛ БАС ЗАА

Еврей номын зохиолч “Бид сүйрэл уруу ухрагсад бус харин итгэж, амийг хадгалагсад билээ” (Еврей 10:39) гэсэн. Та Бурхантай дотно явахыг хүсэхээсээ гадна үг, санаагаараа төдийгүй, үйлс, үнэн дотор Түүнд таалагдаж амьдрахыг чин сэтгэлээсээ хүссэндээ л, зүрхээ шинжлэн шалгахын төлөө энэ номыг уншиж байгаа гэдэгт чинь итгэж байна. Тиймээс л бидэнд ингэж сургажээ:

Иймээс хайртууд минь, та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг байхад ч биш, харин эдүгээ байхгүй байхад минь бүр илүүгээр өөрсдийн авралыг *айдас ба чичрэлээр* гүйцээ. Учир нь Өөрийн сайн тааллын төлөө та нарын хүсэх, ажиллахын аль алинд нь та нарын дотор үйлдэгч нь Бурхан Өөрөө юм (Филиппой 2:12-13, тодруулгыг нэмэв).

Ариунаар айж эмээж явдаг хүмүүс чинь Бурханы оршихуйг мэдэрсэн үедээ ч, мэдрээгүй үедээ ч дуулгавартай амьдардаг. Бурхан хаяад явчихсан мэт санагдах үед ч тууштай чигээрээ л байх! (Бурхан хэзээ ч хаяхгүй гэж амласан билээ.) Эзэн ариунаар айж эмээж явдаг хүмүүс рүү ойртож, Бурханы хүслийг төдийгүй, сайн тааллыг нь ч гүйцэлдүүлэх хүчийг хайрладаг. Бурхан бидэнд авралаа хайр, баяр хөөрөөр бус, харин айдас, чичрэлээр гүйцэлдүүлэхийг үүрэг болгосон. Эзэнээс эмээж явах нь аминд өлзийтэйгээс гадна болзолгүй дуулгавартай зан, үйлдлийг зүрхэнд маань төрүүлдэг.

Энэ бүлэг маань нилээд цочирдмоор байсан байж болох. Гэхдээ Паул “... хүн бүрийг Христэд төгс болгохын тулд бүх мэргэн ухаан дотор хүн бүрд сануулж, хүн бүрд заан Түүнийг тунхагла...” (Колоссай 1:28) гэдэг. Ямар ч анхааруулга анхандаа мууг ёрлосон, таагүй үг мэт үзэгддэг боловч, эцэстээ анхаарсан хүний амийг авардаг, ашигтай үр жимс төрүүлдэг үг байдаг. Би өөдрөг, сайхан үгд дуртай. Гэхдээ Шүүх өдөр үй түмэн хүн үйлчлэгч нар руу хараад: “Яагаад надад анхааруулаагүй юм бэ?” гэж бархиралдахыг бас мэддэг. Сонсголонтой, ээлтэй Үг дамжуулдаг байсан номлогч нар Шүүх өдөр цусан толбо тогтсон гараа үзээд, бэмбэгнэх болно.

Энэ үгийг нэгэн цуглаан дээр заасны минь дараа нэг пастор надтай дайралцахаар уулзаж билээ. Тэгээд: “Та яаж өрөөлийн цусыг бидний гарт нялж зүрхэлнэ вэ? Тэр чинь Хуучин гэрээний явдал... нигүүлсэл биш!” гэв. Тэгэхээр нь би Библиэ дэлгээд, Паулын үгийг хуруугаараа дарж үзүүлэв.

Тиймээс би бүх хүний цусны буруугүй гэдгээ та нарт энэ өдөр гэрчлэх байна. Учир нь би Бурханы бүхий л төлөвлөгөөг та нарт мэдүүлэхээс зайлсхийсэн нь үгүй билээ. Бурхан Өөрийн цусаар Өөртөө өмчилж авсан Бурханы чуулганыг хариулуулахаар Ариун Сүнс та нарыг харгалзагч болгосон бөгөөд та нар өөртөө болон бүх сүрэгт анхаарал тавь (Үйлс 20:26-28).

Энэ үгийг уншиж буй тэр эрхмийн царай нүдэн дээр минь хувхайран цайрч байсныг би хэзээ ч мартаггүй. Тэрбээр арван жил үйлчлэхдээ, дээрх үгийг хэдэн арвантаа уншсан атал тэр өдөр л анх ойлгожээ. Тэрбээр толгой сэгсрэн уучлалт гуйгаад, бид хоёр “өөдрөг юмуу эсвэл бүр сөрөг талыг дөвийлгөсөн, нэг талыг баримталсан номлолоор бөмбөгдөх урхинд унахгүй явах нь хичнээн чухал болох” талаар хэсэгхэн ярилцаж билээ. Бид “анхааруулж” бас “зааварлахын” аль, алийг нь тэнцвэртэй хийх ёстой.

Өнөөдөр бид үй олон хүн - тэр дундаа сонгогдсон хүмүүс ч бөөн бөөнөөрөө мэхлэлд автана хэмээн Есүсийн анхааруулсан, тэр цагт амьдарч байна. Хаана зогсож байгаадаа анхаарбал, унахгүй. Амархан мэхлэгддэг, сэрэмжгүй зүрхээр сэлгүүцээд явалгүй, ариун эмээхүй бүхий зүрхээр Бурхандаа ойрт. Хайрын Аав маань бидний л төлөө байдаг. Мөн бурханлаг ёсоор амьдрахад шаардлагатай бүхнээр хангаж өгдөг. Бурхан Өөрийнх нь хүсэлд дуулгавартай амьдрах нигүүлслийг Эзэн Есүс Христээр дамжуулан бидэнд олгосон. Бид ариун эмээхүйгээр л дамжиж байж л Бурхантай жинхэнээсээ дотносно!

СУДЛАХ АСУУЛТ

1. Зохиолч “Эзэнээс эмээхүй байхгүй бол, Бурханыг жинхэнээсээ мэдэхгүй. Сэтгэл, төсөөлөл дотор минь буруу дүр төрх цутгагдан, хэлбэршиж, боловсорно” гэсэн. Өнөөдрийг хүртэлх итгэлээ эргэж харбал, Бурханы талаар гаж буруу төсөөлөл тээж явсан үе танд байна уу? Байгаа бол, ямар талаараа буруу байв?
2. “Бурхан хүслээ илэрхийлчихээд байхад л бид ямар нэг зүйлийг улайран хүссээр, үргэлжлүүлэн шунасаар байвал, Бурхан дургүй бөгөөд хожим биднийг үүнээсээ болж шүүгдэхийг мэдэж байсан ч, хүсээд байгаа зүйлийг маань бидэнд өгч л орхидгийг” зохиолч олонтаа хэлсэн. Залбирлынхаа амьдралыг шударгаар шүүбэл, Бурханаас шалаад байгаа зүйл чинь шунаг хүсэл байж болох уу? Улайран хүссэн зүйлээ хүлээж авсан хойноо харууссан явдал танд байдаг уу?
3. Бүлгийн төгсгөлд танаас энэ номыг унших болсон шалтгааныг асуусан. Энэ хүртэл сурсан зүйл чинь танд ямар өөрчлөлт авчрав? Бурханы дүр төрхийн талаарх ойлголт чинь хэрхэн өөрчлөгдөж байна? Мөн үйлсээр ч, үнэнээр ч Бурханд таалагдах гэдэг нь ямар утгатай вэ?

ЖИНХЭНЭ ХҮНДЭТГЭЛ



“Өөрийнхөө хүслийг биелүүлэхийн төлөө
Миний үгийг хэрэглэдэг нэгэн нь шашны сүнс юм.”

Эзэнээс эмээдэггүй хүн мэхлэлд унадаг бол, ариунаар эмээдэг хүмүүсийг дотносол хүлээх. Бурханы хүсэлд үг дуугүй захирагддаг дуулгавартай байдал нь гаднаа дуулгавартай үйлдлээр илрэхээс гадна дотроо Бурханы хүслийг биелүүлэх чин зүрхний хүсэлтэй байдаг. Үүнийг ч Бурхантай хамт алхсан хүмүүсийн амьдралаас ахин дахин харж болно.

Енох Бурханд таалагдсан. Үүнийг эртний чуулганы эцэг - Клементийн бичвэрээс дэлгэрүүлэн ойлгож болно. Нэгдүгээр зуунд аж төрж байсан, Паул, Петр хоёрын хамтран зүтгэгч, Ромын Клемент нь “Жишээлэхэд, *дуулгавар дотор зөвт* хэмээн үзэгдсэн Енох нь өргөгдөөд, үхлийг хэзээ ч үзээгүй” хэмээн бичсэн байдаг. Енохын чухам дуулгавартай чанар нь л Бурханы тааллыг татах содон тэмдэг нь байжээ.

Бичээс дээр Бурхантай хамт алхаж, дотно нөхөрлөсөн дараагийн хүн нь Ноа билээ. Дэ Нью Ливинг Транслэйшн Библи Ноагийн амьдралыг ийнхүү тайлагнажээ:

Энэ болбоос Ноагийн болоод түүний гэр бүлийн түүх. Ноа зөвт хүн - тухайн цагт газар дээр аж төрж байсан цорын

Бурханд ойрт

ганц ял зэмгүй хүн байв. Тэрбээр цаг үргэлж Бурханы хүслийг даган, Бурхантай ойр дотно харилцааг эдэлдэг байжээ (Эхлэл 6:9, тодруулгыг нэмэв).

Енохын нэгэн адил Ноа цаг үргэлж Бурханы хүслийг дагадаг байсан нь амьдралынх нь содон тэмдэг байжээ. Өөрөөр хэлбэл, тэрбээр Бурханы хүсэлд дуулгавартай байсан. Энэ хоёр хүн амин хувийнхаа эрх ашгийг түрүүнд тавих дэг дарааллаар Бурханы хүслийг дагадаг байсан Балаамын яг нөгөө туйл байв. Эрээ цээргүй дуулгаваргүй авирлах нь ерөөлд хүргэхгүй бөгөөд эцэстээ ялтайг Балаам мэднэ. Балаам Бурханы бүх хүслийг гал халуунаар дагахын оронд ашиг өвөрлөж дагаснаараа, Бурханы үгийг завхруулдаг байв. Эзэний хүсэл бус, хууль л Балаамын туйлын хүсэл байжээ.

Тэгвэл Давид тийм байсангүй. Бичээс:

Тэгээд Бурхан түүнийг зайлуулан, тэдэнд Давидыг хаан болгож өгсөн. Түүний тухай Тэрээр гэрчилж, “Бүх хүслийг минь биелүүлэх зүрх сэтгэлийн минь дагуух хүн, Иессийн хүү Давидыг Би олсон” гэсэн байдаг (Үйлс 13:22).

Эзэнээс эмээхүй нь дан ганц дагах явдал бус, харин Бурханы бүх хүслийг биелүүлэх явдал ажээ. Яг л хувийнхаа хүслийг биелүүлэх гэж буй мэт зүтгэх. Бурханы зүрхний хүслийг өөрийн болгох. Энэ чинь л жинхэнэ дуулгавартай байдал мөн.

ШАШНЫ СҮНС

Нэг удаа Эзэнийг хүндэтгэж байх үеэр Түүний зүрхэнд маань шивэгнэсэн үгийг би хэзээ ч мартахгүй: “Жон, чи шашны сүнс гэж юу болохыг мэдэх үү?”

Бурхан юм асуух үедээ мэдлэг мэдээлэл нэмэх гэсэндээ бус, биднийг мэдэхгүй учраас эсвэл бидний мэддэг аар саар юмсыг өргөтгөн тэлэхийн төлөө асуудаг болохыг эдүгээ би мэддэг болсон. Миний бие шашинлаг хүний талаар бичиж, ярьж явсан хэдий ч, Бурханд “Эзэн минь, би яалаа гэж мэдэх билээ. Шашны сүнс гэж юу юм бэ?” гэж хариулсан юм.

Тэгтэл Эзэн зүрхэнд минь “Өөрийнхөө хүслийг биелүүлэхийн төлөө Миний үгийг хэрэглэдэг нэгэн нь шашны сүнс юм” хэмээн айлдаж билээ. Бурханы тэр үг олон ч өдөр зүрхэнд минь лугшин цуурайтсаар, олон ч асуултад хариу өгч билээ.

Балаам яг л ийм байж. Тэр дуулгавартай байхыг эрэлхийлсэн хэдий ч, Бурханы амин хүслийг биелүүлэхийн оронд амин хувийнхаа ашиг хонжоог л урьтал болгодог байв. Ийм учраас Эзэн түүнд “...надаас *гажсан* учир... (Миний өмнө чиний зам *гажуу* байна)” (Тооллого 22:32, тодруулгыг нэмэв) хэмээн айлдсан байдаг. *Уэбстерийн* толь бичиг дээр *гажуу* гэдгийг “мурий сарий” гэж тодорхойлдог. Тийнхүү үүнийг Бурханы Үгийн санаа зорилгыг мурийлгах юмуу гуйвуулаад, өөрийнхөө эрх ашгийн төлөө хэрэглэх хэмээн тодорхойлж болно.

ЖИНХЭНЭ МӨРГӨЛ ХҮНДЭТГЭЛ

Бичээс дээр Эзэнтэй ойр дотно явсан Абрахам, Мосе, Иошуа, Давид, Естер, Даниел тэргүүтэй хүмүүсийн бүгдийнх нь амьдралаас нэгэн нийтлэг ангилагчийг олж үзнэ. Тэдний Бурхантай тогтоосон дотно харилцааных нь цөмд Бурханы хүсэлд захирагдах чин зүрхний дуулгавартай байдал оршиж байжээ. Хуучин гэрээнээ Бурхан Өөрийнхөө гэрээний хүн нэг бүрт хандан:

“Учир нь Би та нарын эцэг өвгөдийг Египет нутгаас гарган авчирсан тэр үеэс өнөөг хүртэл “*Дуу хоолойг минь сонс (дага)*” гэж цөхрөлтгүй анхааруулсаар, хатуу сануулсан” (Иеремиа 11:7, тодруулгыг нэмэв) хэмээн хашхирдаг байжээ.

Хүмүүс нь Өөрийг нь дагалгүй, өөр өөрийнхөө зүрхний зааврыг дагаж байгаад Эзэн халаглан гашуудаж байна. Тэд Бурханы зүрхийг хүлээж авалгүй, зөвхөн айлдсан үгийг нь дагах төдийхнөөр л хязгаарлагдсан. Үүнээсээ болоод амин хувийнхаа хүслийг төсөөлсөн хэмжээ хязгаарынхаа төвшинд л хангах арга замыг хайхад хүрсэн бөгөөд үүнийг нь Бурхан яав ч таашаахгүй учраас, Түүнтэй дотно харилцаатай амьдарч чадаагүй юм. Дотносолд бүрэн төгс дуулгавартай зан амин чухал. Шинэ гэрээн дээр Есүс:

“Харин үнэн мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр Эцэгт минь мөргөх цаг ирж байгаа бөгөөд одоо ирчихээд байна. Эцэг Өөрт нь ийнхүү мөргөгчдийг *эрж байна*. Бурхан бол сүнс, Түүнд мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр мөргөх ёстой” (Иохан 4:23-24, тодруулгыг нэмэв) хэмээн айлдсан.

Энэ хэдхэн мэдэгдэл дотор маш их зүйл агуулагдаж байна. Нэгдүгээрт - Эцэг Өөрт нь ийнхүү мөргөгчдийг *эрж (эрэн хайж) байна*. Бурхан биднийг мөрөөсч, бидэнтэй нөхөрлөхийн хүслэн болдог талаар бид ярьсан даа. Тэгвэл үүнийг Есүс ч мэдэгдсэн байна.

Хоёрдугаарт - Бурхан Өөрийг нь сүнс ба үнэн дотор хүндэтгэж мөргөх хүмүүсийг хайдаг аж. Хүндэтгэл мөргөлийн талаар ярья л даа. Нэг удаа намайг Библиэ уншиж байтал, Ариун Сүнс зүрхний минь гүнд: “Хүндэтгэл чинь дуу дуулахын нэр биш!” хэмээн хашхирсныг би хэзээ ч мартаггүй. Би шууд л зог тусч билээ.

Олон хүн хүндэтгэл мөргөлийг удаан хэмнэлтэй дуу гэж боддог. Жишээ нь бидний хийж заншсан евангелийн цуглаан нэг иймэрхүү дарааллаар өрнөдөг: хүмүүс цуглаандаа ирээд, эхлээд магтана, араас нь хүндэтгэнэ тэгээд зарлал явна, өргөлийн цаг, номнолын цаг, хамгийн сүүлд нь шийдвэрт дуудна. Уламжлалт чуулганууд гарын авлага хэвлэж тараадаг бол, евангелийнхан цээжээрээ хийдэг зүйлсээ Сүнсээр удирдуулах буюу эрх чөлөөт явдал хэмээн сайрхдаг. Хүндэтгэл мөргөлийн тал дээр - магтаал, хүндэтгэлийн ялгааг мэдэхгүй байгаа цөөхөн хэддээ: магтаал нь хурдан дуу, хүндэтгэл нь удаан дуу гэх ухааны ойлголт өгнө. Инээдтэй биш гэж үү? Яагаад гэвэл бид чинь сүлд дууллаас дөнгөж чөлөөлөгдөөд л эргээд том дэлгэцийн проекторт олзлуулчих гэж. Тиймээс *хүндэтгэл мөргөл* гэхээр, ихэнх итгэгч хүний толгойд хамгийн түрүүнд CD, хөгжмийн клип юмуу цуглаан дээр дуулдаг удаан дуу л орж ирдэг байх.

Эзэнийг ярих үед би Библиэ хойш тавиад: “Эзэн минь, хүндэтгэл мөргөл гэж юу болохыг би мэдэхгүй. Юу болохыг нь хэлж өгөөч” гэж билээ.

Гэтэл Эзэн надад: “Энэ чинь амьдрал!” хэмээн түс тас айлдав.

Тэгээд шууд жишээн дээр ингэж өгүүлсэн юм: “Хүү минь, бодоод үз. Өглөө сэрэхэд чинь Лиза чамаас хүүхдүүдээ сургуульд нь бэлтгэхдээ тусламж гуйсан ч, чи завгүй гээд татгалзана. Жаахан байж байгаад түүнд бас л тусламж хэрэгтэй болсон ч, чи нөгөө л хариултаа хэлнэ. Өдөр болж, Лиза хоол хийхдээ мөн л чамаас тусламж гуйтал, чи нөгөө л хариултаа хэлнэ. Үдээс хойш нь хүүхдүүдээ сургуулиас нь аваад ирэхийг гуйсан ч, нөгөө л хариултаа сонсоно. Орой нь хоол хийхдээ бас гэрээ цэвэрлэхдээ тусламж хүссэн ч, нөгөө л “завгүй” гэдэг үгийг сонсоно.

Шөнө болов. Лизаг хүүхдүүдээ унтуулж дуусмагц, одоо чиний Лизагаас юм гуйх - ялангуяа секс хүсэх ээлж ирнэ. Тэгээд л: “Хайрт минь, энээ тэрээ...” гээд л хэл амаа зажлаад л хүрч очно.”

Тэгээд Бурхан надаас: “Лиза чиний хайрын үг, сексийн дур хүсэлд юу гэж хариулах бол?” хэмээн асуув.

Би ч: “Ирсэн замаараа сурсан дуугаа дуулаад буц!” гэх янзын л үг хэлэх байх даа” гэлээ.

Тэгтэл Бурхан: “Тийм ээ, чиний зөв. Гэхдээ яагаад тэр вэ?” гэв.

Би ч: “Яагаад гэвэл хайр чинь өглөөнөөс л эхлээд, шөнө сексийн нэгдлээр оргилдоо хүрдэг эд шүү дээ” гэж хариулсан юм.

Бурханы Үгийг тунгаан бодож байхдаа, миний гэргийдээ илчилдэг хайр маань үйлс, үнэн дотор бус, дан үгээр байсныг ухаарав. Гэргийдээ ингэж ханддаг эр нөхөр нь өөрийгөө мэхлэгч ажээ.

Тэгтэл Эзэн надад: “Хүү минь, би хүүхдүүдийнхээ анхаарлыг долоо хоногийн турш хайдаг ч, тэд Намайг тоодоггүй. Би хүүхдүүдээрээ дамжуулж хөршид нь үйлчлэхийг хүсдэг ч, хүүхдүүд маань намайг сонсдоггүй эсвэл хэт завгүй байх юмуу төлөвлөсөн дуртай юмаа эдлэхийн төлөө Миний удирдамжийг хойш тавьдаг. Бид хүүхдүүдээ өргөл өргө эсвэл цуглаандаа юмуу нийгэмдээ, гэр бүлийнхээ гишүүнд үйлчил гэхэд тэд огт сонсдоггүй. Тэгээд цуглаан дээр ирээд, Надаас ямар нэг юм - *ерөөл* хүсэхээрээ, Надад хайр зарласан үгтэй, уянгын дуу дуулдаг бөгөөд үүнийгээ *хүндэтгэл мөргөл* гэж нэрлэдэг. Гэтэл энэ чинь хүндэтгэл мөргөл бус, ердөө л удаан дуу!” хэмээсэн юм.

Би ч ангайв. Миний хүндэтгэл мөргөлийн талаарх ойлголт бут үсэрснийг ч ойлгов. Хожим би урьд өмнө хэзээ ч анзаарч яваагүй, гайхмаар нэгэн зүйлийг олж мэдсэн юм. Уншигч танаас нэгэн зүйлийг асуухыг болгооно уу: Библид *магтаал хүндэтгэл* гэдэг ойлголт хэзээ хамгийн анх гардаг вэ? Энэ тун чухал асуулт шүү. Учир нь би ном бичихдээ, уншигчид ямар нэгэн шинэ ойлголтыг анх танилцуулахдаа, хамгийн түрүүнд гурван зүйлийг хийх ёстой байдгийг олж мэдсэн юм. Нэгдүгээрт - тухайн үгийн тодорхойлолтыг нь өгөх юмуу тайлбар бүхий дүрслэл - жишээ өгөх эсвэл утгыг нь илэрхийлэх үгийг хэрэглэх. *Хүндэтгэл мөргөл* гэдэг үг нь анх Эхлэл 22 дээр гарна:

Тэгээд Абрахам зарц залуустаа —Та хоёр, илжигтэйгээ энд хүлээж бай. Хүү бид хоёр тийшээ очиж *мөргөчихөөд* та нар уруу эргэж ирнэ гэв (Эхлэл 22:5, тодруулгыг нэмэв).

Абрахам Исаактай хамт уртын дуу дуулахаар яваагүй. Абрахам Бурханы хүсэлтээр хамгийн үнэтэй зүйлээ алж өргөхөөр явж байсан! Тиймээс хүндэтгэл мөргөл нь *дуулгавартай амьдрал* ажээ. Тиймээс л Бурхан Өөрт нь зориулж дуу дуулж байгаа хүмүүстээ хандан:

Дуунуудынхаа чимээг Надаас зайлуул. Ятгын эгшгийг

чинь ч эс сонсоно, Би. Харин шүүлт ус мэт, Зөвт байдал мөнх урсах урсгал мэт хуйлран бууг (Амос 5:23-24) хэмээн голоосоо хашхирчээ.

Миний бие маш сайхан, оргилсон дуу хөгжимтэй атлаа Эзэний оршихуйн ул мөр ч үгүй маш олон цуглаанд сууж явсан. Тийм нөхцөлд би нэн түрүүнд өөрийнхөө зүрхийг шинжээд, Ариун Сүнснээс: “Би Таныг гомдоосон уу эсвэл нүгэл үйлдсэн үү?” гэж асуудаг. Тэгээд дийлэнхдээ л зүрхнийхээ гүнд “үгүй” гэсэн хариултыг сонсдог учраас, тэр саад нь хүмүүсийн зүгээс эхтэйг ойлгоно. Тиймээс Эзэнээс эмээхүй, дуулгавартай байдлыг зоригтой номлодог. Үүний дараа уур амьсгал өөрчлөгдөн, бараг л заавал Бурханы оршихуй шууд илэрдэг. Яагаад тэр вэ? Жинхэнэ хүндэтгэл мөргөл нь дуулгавартай амьдрал учраас, тэр дуулгавартай амьдралаас хүндэтгэл мөргөлийн дуу урсан гардаг бөгөөд энэ нь дээрх Бичээс шиг Бурханыг бухимдуулахгүй, харин ч Бурханы зүрхэнд тааламжтай байдаг. Эхнэрээ өдөржин үл тоогоод, орой нь бэлгийн харилцаанд орох гэж татаж чангаадаг шиг харилцаа л Эзэнийг бухимдуулдаг юм.

ҮНЭН ДОТОР ХҮНДЭТГЭН МӨРГӨХ

Аав Өөрийг нь сүнс ба үнэн дотор хүндэтгэж мөргөх хүмүүсийг эрэн хайж байгааг Есүс хэлсэн. Сүнс дотор хүндэтгэж мөргөх талаар бүгдээрээ дараа дараагийн бүлгээрээ маш дэлгэрэнгүй ярьцгаана. Харин одоо Бурханыг үнэн дотор хүндэтгэх талаар ярилцъя. *Үнэнийг Грекээр алетиа* гэдэг. *Вайны* толь бичиг дээр: “юмны ул сууринд орших бодит байдал, хэрэг явдлын үзэгдэх, жинхэнэ мөн чанар” гэдэг.

Энэ тодорхойлолт нь Есүсийн хэлэх гэсэн санааг хүчжүүлдэг учир, би энэ тодорхойлолтод дуртай. Тэрбээр жинхэнэ хүндэтгэл мөргөл нь хүмүүний оршихуйн суурийн төвшинд буюу зүрхэнд оршдгийг харуулж байна. Ойлгомжтой болгох үүднээс эхлээд харилцааны гурван төвшинг тодорхойлж ярих хэрэгтэй байх.

Нэгдүгээрт - хамгийн доод төвшний харилцаа буюу аман харилцаа. Есүс үүнийг хоёр хүүгээ усан үзмийн талбай дээр ажиллахыг хүссэн аавын жишээгээр заасан (Матай 21:28-31-ийг үзнэ үү). Нэг хүү нь “За, аав аа” гэсэн боловч, явдаггүй. Нөгөө хүү нь “Чадахгүй ээ” гэсэн боловч, дараа нь ажилласан байдаг. Тэгээд Есүс “За” гэсэн нь бус, эхлээд “Үгүй” гэж хэлсэн хүү нь л аавынхаа хүслийг биелүүлснийг тайлбарлажээ. Үүнчлэн, үйлдэл нь үгэн харилцаанаас арай ахиу төвшний харилцаа аж.

Иаков ч бас “Хэрэв ах дүү чинь, эсвэл эгч дүү чинь нүцгэн, өдөр тутмын хоолоор дутагдаж байхад нь, та нарын нэг нь тэдэнд “Амар тайван яв. Дулаацах болтугай, цадах болтугай” гэж хэлчихээд биед нь хэрэгцээтэй байгаа зүйлсийг нь тэдэнд өгөхгүй бол ямар ашигтай юм бэ?” (Иаков 2:15-16) гэж хэлэхдээ, аман харилцаа нь хамгийн доод төвшин болохыг харуулжээ. Элч Иохан ч үүнийг баталсан: “Дэлхийн эд хөрөнгөтэй нь ах дүүгийнхээ гачигдлыг хараад түүнд туслах сэтгэл үл гаргавал, түүний дотор Бурханы хайр хэрхэн байх билээ?” (1Иохан 3:17)

Энэ мэтчилэн энэ харилцааг үй олон нөхцлөөс харж болох агаад үүний нэг нь гэргийдээ хайр зарладаг атлаа хэзээ ч дэргэд нь байдаггүй нөхөр эсвэл нөхрөө хүндэтгэдэг гэх атлаа кредит картаа хэтрүүлж хэрэглэхээ болихыг зөвлөсөн нөхрөө сонсдоггүй эхнэр болно. Ийм жагсаалт дуусдаггүйг та ч мэдэж байгаа. Жон цааш нь захидалдаа:

“Бяцхан хүүхдүүд ээ, бид үг хэлээр бус, харин үйл ажил, үнэнээр хайрлацгаая” (1Иохан 3:18) гэжээ.

Дэ Амплифайд Библи дээр “Бяцхан хүүхдүүд ээ, (дан) амаараа бус, харин үйлс ба үнэн дотор хайрлацгаая” гэдэг. Мэдээж бид үгээрээ зайлшгүй хайрлах ёстой боловч, хайрын үгийг чинь батлах үйлс, үнэн байхгүй бол, хоёр нүүртнээс ялгаа юун. Иохан “үйлс ба үнэн” гэсэн байгааг тэмдэглээрэй. Энэ нь харилцааны дараагийн хоёр төвшинг дүрсэлж байна.

Дараагийн төвшин нь үйлс буюу үйл хэрэг боловч, энэ нь мөн л харилцааны хамгийн өндөр төвшин биш бөгөөд үйл хэрэг нь үнэнтэй сөргөлдөж болох учраас, амархан төөрөгдүүлэх боломжтой. Жишээ нь Паул “Хэрэв би бүх өмч хөрөнгөө тараан өгч, биеэ шатаахаар тушаасан ч надад хайр үгүй бол энэ нь надад ямар ч ашиггүй” (1Коринт 13:3) гэсэн. Паулын энэ эшлэл дээр дүрсэлсэн үйл хэрэг нь хайрын дээд төвшин мэт харагдаж байгаа ч, Бурханы хайрыг өвөрлөөгүй зүрх ч сүрдэм, сүрхий үйлсийг бүтээж чаддагийг Паул хэлжээ.

Тэгэхээр, энэ нь биднийг харилцааны хамгийн өндөр төвшин болох зүрх рүү хөтөлж байна. Зүрх чинь хүний суурийн төвшин. Энэ төвшнийг Иохан, Есүс хоёрын хэн хэн нь үнэн хэмээсэн. Зүрхний бодол, санаа хоёр нь бидний хүндэтгэл мөргөлийн үнэн сэдлийг илчилдэг боловч, үүнийг нь Бурханы Үгээс гадуур ялгаж мэдэх боломжгүй. Зүрхнээс л амь урсдаг учраас, биднийг зүрхээ хичээнгүйлэн сахихыг заасан. Зүрхээ хайхрахгүй бол, дорхноо мэхлэгдэнэ. Бурханы Үг, Ариун Сүнсний зөвлөгөөний гадна орхигдсон зүрх л юу юунаас илүү мэхлэгдсэн зүрх юм.

Бурхан хүмүүстээ: “*Уриалгахнаар (дуртайяа бөгөөд дуулгавартайяа)* та нар дагах аваас Уул газрын сайныг иднэ” (Исаиа 1:19, тодруулгыг нэмэв) гэж хэлсэн. Бурхан зөвхөн дуулгавартай дагах талаар бус, харин *дуртайяа* бөгөөд дуулгавартайяа дагах талаар өгүүлжээ. Хүсэл нь зүрхний хандлагыг хамаардаг. Би хүүгээсээ юм гуйх үед хүү минь шууд дагасан нь гаднаасаа их л дуулгавартай үйлдэл мэт харагдаж болох ч, тэрбээр дотроо дурамжхан үйлдсэн байж болох. Хэрэг дээрээ, үнэн дотор дагасан бус, ердөө дагасан л дүр эсгэж. Иохан бидэнд Бурханыг ч, хүмүүсийг ч үйл хэргээр ч, үнэнээр ч хайрлахыг хэлсэн нь зүрхний төвшний хэрэг явдлыг хамаарчээ: “Үүгээр бид үнэнийх болохоо мэдэж, Түүний өмнө зүрхээ тайтгаруулах болно” (1Иохан 3:19).

Бурхан надтай энэ асуудлаар нүүр тулсныг би хэзээ ч мартахгүй. Тухайн үед би ямар нэг гомдол гаргахгүй хэмээн машид хичээж байлаа. Гомдол нь Бурханд: “Надад Таны хийж байгаа юм таалагдахгүй байна. Би л Таны оронд байсан бол, өөрөөр хийх байсан” гэж хэлдэг учраас, Бурханы зан чанарыг доромжилсон явдал билээ. Энэ нь ариун айдасгүй явдал бөгөөд Бурхан ч үүнийг үзэн яддаг. Үнэндээ гомдлоос л болж Израилийн хүүхдүүд Амлалтын газартаа хөл тавих завшаанаа алдсан. Тиймээс би нэг хэсэг хэл амаараа огт гомдол унагахгүй байж чадсан бөгөөд үүндээ ч пээдгэр байлаа. Гэтэл нэг өглөө “Би чиний зүрхний гомдлыг сонсож байна!” гэх Ариун Сүнсний хатуу үгэнд цочин сэрэв. Би ч бардам зандаа мэдлүүлснаа ухаарах үедээ манаргал цохиулснаасаа болоод цочроонд орчихсон амьтан шиг л сууж байлаа. Би Бурханыг үнэн дотор хүндэтгээгүй байжээ. Тийнхүү Бурханы засвар зааврын үгийн гэрлийн ачаар л зүрхний минь алдаа илчлэгдэв. Би газар дээрээ гэмшсэн бөгөөд тэр цагаас хойш дахиж ингэж бангадуулаагүй минь зол. Бурханы нигүүлсэлд л талархах минь!

Одоо яг энэ ойлголтоороо *Вайны* толь бичиг дээрх үнэний тодорхойлолтоо дахин харна уу. Тэнд “үнэн нь юмны ул сууринд орших бодит байдлыг тодруулдаг” гэсэн. Хүн үнэнээс маш амархан далийж чадна. Жишээ нь: Хүн Эзэнд хандан залбирч, дуулж чаддаг ч, нөгөөтэйгүүр нэг ч үгээ үнэн зүрхнээсээ хэлэхгүй байж бас чадна. Бид дуулж байхдаа өлсөж байгаагаа, хүүхдүүдийнхээ өглөөний муудалцааныг, цуглааны дараа төлөвлөсөн зугаатай юмсаа гэх мэт элдвийг бодож чаддаг. Бид: “Эзэн минь, баярлалаа!” гэж хэлж байгаа ч, нөгөөтэйгүүр сүүлийн хэд хоног тасралтгүй одоогийнхоо нөхцөл байдалд гоморхож байж болох. Бид жинхэнээсээ талархаад байна уу эсвэл зүрхнийхээ цөмд “чадах байж хийсэнгүй” хэмээн Эзэнийг буруутгасаар байна уу? Гэх мэтчилэн ийм жишээ дуусахгүй.

Үнэн дотор Бурханд хүндэтгэж мөргөнө гэдэг нь Түүний үгэнд ороод зогсохгүй, хүслийг нь баяртайгаар гүйцэтгэх явдал мөн. Энэ нь ярих ёстой зөв зүйлээ ярих бус, харин зүрхэндээ байгаа зүйлээ л ярих явдал. Энэ нь Бурханы өмнө хоёр нүүрлэж, “манжлахгүй” байх явдал. Би Давидын хэлсэн дараах үгд хайртай:

“Хэзээд Түүнд итгэ, хүмүүс ээ *Түүний өмнө зүрхээ уудал.*
Бурхан бидний хоргодох газар юм. Села” (Дуулал 62:8,
тодруулгыг нэмэв).

Бурхантай шувын шударга байвал, Бурхан бидэн рүү ойртдог болохыг би мэдэж авсан. Бурхантай холбогдож чадахгүй байгаа үед ажил үйлс маань ч бүтэлтэй болохгүй, залбирч ч чадахгүй - үндсэндээ энэ бүхэн үнэхээрийн зовлон болдог. Бурхан Өөр дээр нь хувилсан зүрхээр бус, харин чин зүрхээр ойртох хүнийг харж хайж байдаг. Заримдаа цуглаан дээр “Есүс ээ, баярлалаа... Халлелүяа... Бурхан алдаршиг” гэх мэтээр үглэж байгаа хүмүүсийг харахдаа, энэ хүмүүс зүгээр л Христэч хэллэг урсгаад байна уу, зүрхнийхээ ул суурийн төвшнөөс өгүүлээд байна уу хэмээн гайхахад хүрдэг. Гэргийгээ аргалахын тулд “Хонгор минь, би чамд хайртай” гэж зүрхээрээ бус, цээжээрээ хэлдэг нөхөртэй л ижил гэх үү. Энэ нь “Хайртай” гэдэг үгийг зүрхээрээ холбогдож байгаад, зүрхнийхээ угаас хэлэх явдлаас өөр юм.

Хүний оршихуйн цөмөөс гардаг дуулгавартай байдлаас буюу жинхэнэ хүндэтгэл мөргөлийн амьдралаас хүндэтгэл мөргөлийн дуун ундрах болно. Христийн бие дотор магтаал, хүндэтгэлийн дууг оргилуулан бадраах бэлэг авъяастай эрчүүд, эмэгтэйчүүд байна аа байна. Тэд чинь орчин цагийн магтаалч нар юм. Тэдний зарим нь жинхэнэ хүндэтгэл мөргөлөөр амьдардаг бол, зарим нь дэлхийн явдалтай атлаа зүгээр л мэдрэмжтэй хүмүүс байдаг. Тэр завхарсан чанартай хүмүүс бэлэг авъяасынхаа хүчээр гоё сайхан дуу зохиож чаддаг ч, Эзэний ариун оршихуйгаар дутаж явдаг бол, цэвэр хүмүүс нь Бурханы жавхлант оршихуйг тээж, Бурханд болоод Бурханы хүмүүст зүрхнээсээ үйлчилдэг.

ЕСҮСИЙН ӨӨРИЙГӨӨ ХАРУУЛАХ АМЛААЛТ

Бурханыг чин зүрхээрээ хүндэтгэх нь Бурханд үнэнээр хүндэтгэн мөргөх явдал болой. Байж болох хамгийн үнэн мэдрэмжээрээ Бурханаас эмээж бас хүндэтгэх. Магтаалч:

“Баярт дууг мэддэг ард түмэн Юутай ерөөлтэй вэ! Аяа ЭЗЭН, Таны царайны гэрэлд тэд алхнам” (Дуулал 89:15) гэжээ.

Бурхан Өөрийнх нь хүндэтгэл мөргөлийн амьдралд уриалан дуудах дуудлагыг нь олж сонсох хүмүүсийг эрэн хайж байдаг. Бурханы дуудлагад анхаарсан хүмүүс л Бурханы оршихуй дотор явна. Бурхан тэдэнд Өөрийгөө илчлэхэд, тэд Бурханыг дотно таньж мэднэ. Есүс айлдруун:

Жаахан байзнаад ертөнц Намайг дахиж харахгүй. Харин та нар Намайг харна. Учир нь Би амьд байдаг агаад та нар амьдрах болно. ...Миний тушаалуудыг хүлээн авч сахигч нь Намайг хайрлагч мөн. Намайг хайрлагч нь Эцэгт минь хайрлагдана. Би ч түүнийг хайрлаж, *Өөрийгөө түүнд илчилнэ* гэж хэллээ (Иохан 14:19-21, тодруулгыг нэмэв).

Бурханы тушаалыг хадгалж, сахидаг хүмүүс нь Бурханд үнэн дотор хүндэтгэж мөргөдөг хүмүүс бөгөөд тэдэнд Өөрийгөө илчлэхээ (үзүүлэх, харуулахаа) Есүс амлажээ. *Үзүүлэх* гэдэг нь үл үзэгдэхээс үзэгдэх талбар руу, үл мэдэгдэхээс мэдэгдэх талбар руу гаргах гэсэн утгатай болохыг санаарай. Нью Американ Стандарт Библи дээр “Би түүнийг хайрлаж, түүнд Өөрийгөө тайлна” гэдэг. Дэ Амплифайд Библи дээр:

Хэсэгхэн хугацааны дараа дэлхий Намайг дахиж үзэхгүй ч, та нар Намайг үзнэ... Миний тушаалыг тээдэг бөгөөд сахидаг хүн нь (үнэхээр) Намайг хайрладаг; (үнэхээр) Надад хайртай нь Аавд минь хайрлагдах бөгөөд Би (ч) түүнийг хайрлаад, Өөрийгөө түүнд харуулна (илчилнэ, үзүүлнэ). (*Би түүнд Өөрийгөө тодорхой харуулахыг зөвшөөрөх бөгөөд Өөрийгөө түүнд бодитой болгоно*) гэдэг (Иохан 14:19, тодруулгыг нэмэв).

Бурханыг жинхэнээсээ хүндэтгэдэг хүмүүс л Бурханыг *жинхэнээсээ* мэддэг. Бурхан ч Өөрийгөө тэдэнд хайртай анд нөхөддөө мэт илчилнэ. Энэ үг элч нарыг гайхшруулсан тул нэг нь аргагүй дуугарахад хүрчээ:

Иудас (Искарриотын биш) Түүнд —Эзэн, Та бидэнд Өөрийгөө илчлэх атлаа яагаад ертөнцөд илчлэхгүй юм бэ? гэхэд Есүс —Хэн нэг нь Намайг хайрлавал, *үгийг минь тэр сахих* бөгөөд Эцэг минь ч түүнийг

хайрлана. Бид түүн уруу очиж түүнтэй амьдарна. Намайг эс хайрлагч нь үгийг минь сахидаггүй. Та нарын сонсож байгаа үг Минийх биш, харин Намайг илгээсэн Эцэгийнх билээ (Иохан 14:22-24, тодруулгыг нэмэв).

Тэгэхээр, ул үндэс нь мөн л дуулгавартай байдал байгааг харж байгаа биз. Бурхан миний зүрхэнд “Хүндэтгэл мөргөл нь Бурханы зүрхний хүсэлд дуулгавартай байх явдал” хэмээн айлдсаныг санаарай. Бурхан Өөрт нь үнэн голоосоо хайртай хүн дээр зочлох гэж бус, харин дотор нь амьдрахаар ойртож ирдэг бөгөөд Өөрийгөө илчилдэг.

Бурханы Сүнсний бэлэг авьяастай хүн олон байдаг ч, Үгийг нь хамаг зүрхээрээ сахидаг нь цөөхөн. Үгийг сахидаггүй нь дорхноо мэхлэгддэг. Учир нь тэд номлох, дуулах, залбирах зэрэг үйлчлэлийнхээ бэлэг авьяасын хэр хэмжээн дотроо л Эзэний оршихуйг мэдэрдэг. Яг л эш үзүүлэх өндөр бэлэг нь ажиллах үед л Эзэний оршихуйг тодорхой хэмжээнд үздэг боловч, зүрхээрээ Бурханаас хол хөндий байсан Балаамтай адил.

Ийм хүмүүс үйлчлэлийнх нь дээр буй Эзэний оршихуйг “миний амьдрал дээр Эзэний таалал оршиж байна” хэмээн андуурдаг бөгөөд Эзэний оршихуйг Бурхантай тогтоох дотносолтой эндүүрдэг. Гэтэл энэ бүхэн нь үнэндээ, нэгэн сайн эзэн ажилчин хөлсөлж авсантай л ижил юм. Ажилчин өдөр бүр эзнийхээ дэргэд байгаагаа эзэнтэйгээ дотносчихлоо гэж эндүүрчээ. Энэ үнэмшил худлаа болохыг та мэдэж байгаа. Есүс Өөрийг нь танина гэдэг хүмүүстэй дараах явдал тохиохыг хэлсэн:

Нэгэнтээ өрхийн тэргүүлэгч босож үүдээ түгжвэл, та нар гадна нь зогсоод, үүдийг нь тогшин “Эзэн, бидэнд онгойлгож өгөөч” гэхэд чинь Тэр та нарт хариуд нь “Та нар хаанаас ирснийг Би (дотно) мэдэхгүй” гэнэ. Тэгэхэд нь та нар “Бид Таны өмнө (оршихуйд) идэж, ууж байсан. Та манай гудамжинд сургаал зааж байсан шүү дээ” гэх болно. Тэр “Би та нарт хэлье. Та нар хаанаас ирснийг Би мэдэхгүй. Ёс бусыг үйлдэгч та нар бүгд Надаас зайл” гэнэ (Лук 13:25-27, тодруулгыг нэмэв).

Дээрх түүхийг Матай 7:21-23 дээрх түүхтэй хослуулж уншбал, дээрх үгийг Есүсийн нэрээр гайхамшиг үйлддэг байсан хүмүүс хэлж байгааг харна. Тэд бэлэг авьяасыг нь дагалддаг байсан Эзэний оршихуйг Бурханы тааллын оршихуй, Бурханы дотносол хэмээн андуу ташаа үнэмшжээ. Эзэнийг мэднэ гэдэгтээ баталгаатай байсан тэр хүмүүс

аймшигтай цочирдсон хэдий ч, няцаагджээ. Тэгэхээр, Бурханы амьдран суудаг оршихуй, үйлчлэлийг дагалддаг оршихуй хоёр нь ялгаатай.

Дээрх эшлэл дээр Есүс Иудагт (Искарриотын биш), Өөрийг нь үнэн дотор хүндэтгэдэг хүмүүсийн дотор л Бурхан амьдран суудгийг хэлжээ. Энэ хэсэг дээр Есүс амьдран суух газрынхаа тухай өгүүлсэн гэдэг утгаараа машинд онцгойрох учиртай. Би Есүсийн хэрэглэсэн: *гэр, сууц, онцгой орших газар* гэдэг үгэд дуртай. Эдгээр үгд л Хуучин болоод Шинэ гэрээний ариун хүмүүсийн содон ялгаа оршдог. Хуучин гэрээний ариун хүмүүст Бурханы амьдран суух газар байх завшаан олдоогүй. Хуучин гэрээнд Бурхан майхан сүмийн “Ариунаас ариунаас” газарт л оршдог байв. Гэхдээ эндээс параллель шугам харагдаж байна. Елигийн өдрүүдэд Елигийн болоод хүмүүсийн хар биеэ хичээсэн замаас болоод Бурханы оршихуй майхан сүмд ховор, бараг л оршихгүй шахам байжээ. Гэтэл Бурханы хүмүүс Бурханаа хичээнгүйлэн дуулгавартай дагаж байхад Бурханы оршихуй хүчирхэг байдаг байсан.

Тэгвэл өнөөдөр ч ялгаагүй юм. Бурханыг сүнс болоод үнэн дотор хүндэтгэн мөргөдөг - гал халуун сэтгэлээр дуулгавартайяа дагадаг итгэгч хүмүүс нь Бурханы ил оршихуйг үздэг хүмүүс юм. Ийм хүмүүст л Бурхан Өөрийгөө илчилнэ. Биднийг юутай сүр жавхлант нөхөрлөл хүлээнэ бэ. Ийм эрдэнэс хүлээж байхад, итгэгч хүн яахан дуулгаваргүй зан, дэлхийн явдалтай сээтэгнэж чадах билээ?

Бурхан биднийг гэрээ, сууцаа, орших онцгой газраа болгохыг хүсдэг бөгөөд ингэснээрээ жинхэнэ Өөрийгөө үзүүлэх юмуу илчилдэг. Энэ сүр жавхлант амлалт нь гагцхүү ирээдүйд бус, эдүгээ цагт ч зориулагдсан! Алдарт Хаан маань та, бид хоёрт “Өөрийгөө хувьчлан “илэрхийлэхийг” буюу мэдүүлэхийг хүсдэг гэдэг Библийн үгд би үнэн голоосоо хайртай. Бурхан үүнийгээ хэрхэн хийдгийг дараа дараагийн бүлгээрээ баяртайяа судалцгаая. Гэхдээ эхлээд удаах бүлгээрээ амьдран суухыг хүсдэг хүмүүсээсээ Эзэний хардаг, өөр нэгэн амин чухал чанарыг үзнэ.

СУДЛАХ АСУУЛТ

1. Енох, Ноа, Абрахам, Мосе, Естер, Даниел тэргүүтэй Бичээсийн хүмүүсийн Бурхантай тогтоосон дотно харилцааных нь цөмд хувийнхаа хүсэлд бус, Бурханы хүсэлд захирагдах чин зүрхний дуулгавартай байдал оршиж байсан. Та өнөөдөр ийм дуулгавартай байдлыг хэрэгжүүлбэл, амьдралд чинь юу өрнөх бол?
2. “Магтаал хурдан дуу, хүндэтгэл удаан дуу” гэдэг шог мэдэгдэл танд танил санагдаж байна уу? Эцэст нь Бурхан хүндэтгэл мөргөлийг “Энэ чинь амьдрал” хэмээн зохиолчид зааж өгсөн гэдэг. Энэ мэдэгдэл таны амьдралд ямар өөрчлөлт хэрэгтэйг хэлж байна?
3. Лук 13:25-27, Матай 7:21-23 дээр хэлсэн Есүсийн үгийг эргэцүүлэхдээ, Бурханы амьдран суудаг оршихуй, үйлчлэлийг дагалддаг Бурханы оршихуйн ялгааг юу гэж дүрсэлмээр байна?

Есдүгээр бүлэг

БУРХАНЫ ОРШДОГ ХҮН



Эзэнээс эмээхүй, даруу зан хоёр нь
Хаанчлалын хүчирхэг хоёр ихэр болой.

Энэ бүлгээрээ бидэнтэй нөхөрлөхийн хүслэн болдог Бурхантай дотносоход маань шаардагдах, өөр нэгэн амин бүтцийг сурцгаана. Энэ номын уриа Бичээс биднийг “Бурханд ойрт. Тэгвэл тэр та нарт ойртохыг” уриалсаар байна. Гэвч энэ гайхамшигтай урилгын өмнө бөгөөд хойно юу өгүүлсэн байдгийг үзэцгээе:

...“Бурхан бардмыг эсэргүүцэж харин *дарууд* нигүүлсэл өгдөг”. ...Бурханд ойртогтун. Эзэний өмнө өөрсдийгөө *даруу болго*. Тэгвэл Тэр та нарыг өргөмжлөх болно (Иаков 4:6-10, тодруулгыг нэмэв).

Хоёр удаагийн дарууслын ятгалгын дунд Бурханы зүрхний хашхираа хавчуулагдсан байгаа нь цаанаа учиртай бөгөөд Бурхан:

Ариун хэмээх нэртэй, мөнх амьдрагч, Өндөрт өргөмжлөгдсөн Нэгэн ийн айлдав. “Сүнсэндээ *дарууг нь* сэргээхийн тулд, Зүрхнээсээ гэмшсэнийг нь сэргээхийн

тулд Сүнсэндээ *даруутай нь*, гэмшсэн нэгэнтэй нь Би *өндөрт*, ариун газарт оршдог (Исаиа 57:15, тодруулгыг нэмэв) хэмээн айлдруун.

Бид Бурханы мэлмийн өмнө даруу байвал, Бурхан биднийг өргөхийг Иаков хэлжээ. Хааш нь өргөх гэж? Бурхан үүнийг эш үзүүлэгч Исаиагаараа дамжуулан айлдсан: *өндөр, ариун газар руу!* Бурхан зочлоод явах бус, амьдран суух хүмүүсийг хайдаг. Иаков бидэнд зочлоод гарах бус, харин Бурханы оршихуйд мөнхөд амьдран суух урилга өгсөн бөгөөд энэ нь гагцхүү даруу хүмүүст л боломжтойг Исаиа өгүүлжээ.

ДАРУУ БАЙДЛЫГ ҮЛ ХЭРЭГСДЭГ БИД

Христийн бие доторх олон хүн даруу байдлыг ч, даруу байдлын хүчийг ч ойлголгүйгээр үл барам; харин ч сул дорой, улцгар, үлбэгэр, тэр бүү хэл шашинлаг гэж ойлгодог. Үнэндээ жинхэнэ даруу хүнийг хэнхэг бардам хүн гэж үзэх нь ч бий! Филистинчүүдтэй тулалдаж байсан ах нараа аавынхаа даалгавраар эргэхээр очсон Давидыг л аваад үз. Давид тэнд очихдоо, ах нарыг нь багтаасан Израилийн цэргүүд тэр чигээрээ байлдааны тун жигтэй байрлалд байхыг нь анзаарсан: Тэд үлэмж биетэй Голиатаас айсандаа, хадны араар бэмбэгнэж суув. Бүр энэ байдал нь бүтэн дөч хоног үргэлжилж байгааг ч олж мэдсэн. Тиймээс Давид эр бор дуугаар цэргүүдээсээ: “Амьд Бурханы цэргийг шившиглэн ичээгч энэ хозлуулаагүй филист хүн хэн юм бэ?” (1Самуел 17:26) гэж асуужээ.

Энэ байдал нь Елиаб ахынх нь зэвүүг хүргэсэн бөгөөд тэрбээр дүүгээ “*Муу өөртөө эрдсэн, аманцар жулдрай*” гэж бодоо байх. Тийнхүү Елиаб Давид руу: “Би чиний *их зан*, муу санааг мэднэ” (1Самуел 17:28, тодруулгыг нэмэв) гэж ирээд л дайрчээ. ЭнАйВи Библи дээр “Би чамайг ямар сагсууг мэднэ” гэдэг.

Байзаарай, хэн нь бардам байлаа? Нэг бүлгийн өмнө эш үзүүлэгч Самуел Израилийн дараачийн хааныг тослохоор Иессегийн гэрт ирэх үед Елиаб тэнцээгүй юм. Иессе ч, Самуел ч тэр гэрийн хөвгүүд дундаас магадгүй хамгийн нуруулаг, хүчирхэг, цэцэрхэг нь болох Елиабыг л мөн байх хэмээн бодтол, Бурхан “Би түүнийг тоохгүй” гэдгээ (1Самуел 16:7-г үзнэ үү) баттай айлджээ. Елиаб өөрийнхөө дотор байсан бардам занг Давидад тохсон боловч, харин Бурхан Давидыг “Миний зүрхийг хөөдөг хүн” хэмээн цоллоод (Үйлс 13:22), Давидын даруу зангаар сайрхсан бөгөөд Давид хэзээ ч сул дорой, улцанхай юмуу үлбэгэр байсангүй.

Давид ахынхаа доромж үгийг сэгсэрч хаячихаад, үлэмж биетэнд

удахгүй толгойноосоо салахыг нь мэдүүлэн, бат итгэлээр мөргөлджээ. Тэгээд дайсны хуаран руу дайрч ороод, Голиатыг алаад, толгойг нь тасалсан.

Бид даруу байдлыг ямар их эндүүрдгийг цааш нь улам задлан тайлбарлахыг болгооно уу. Библийн эхний таван ном буюу *Пентатүкийн* нэг болох Тооллого ном дээр ингэж бичжээ:

“Моcе гэгч хүн газрын хөрсөн дээрх хэнээс ч илүүгээр маш даруу нэгэн байлаа” (Тооллого 12:3).

Ёстой янзтай мэдэгдэл! Яг үнэндээ хүмүүс бүгдээрээ л битүүхэндээ өөрийгөө ингэж хэлэхийг хүсдэг ч, хэзээ ч зүрх хүрэхгүй! Яагаад? Үнэхээрийн хэнхэг бардам хүн л өөрийгөө ингэж хэлэх байх. Тэгтэл Тооллого номыг хэн бичлээ? Моcе бичсэн! Ёстой янзтай!

Өөрийгөө зүгээр ч нэг даруугаар тогтохгүй, газар дээрх хамгийн даруу хүн хэмээн зарласан хүнийг бид хэзээ ч дарууд тооцохгүй! Жишээлбэл, Христэд үйлчилдэг хүн конференцийн өмнө гарч ирээд: “Сонсоцгоо, би та нарт ямар даруу хүн болохоо яруу тодоор ярьж өгье!” гэвэл, юу болох бол оо. Түүнийг элэглэн шоолоод, буруу номтон гэх байх. Гэтэл Есүс юу айлдсаныг үзнэ үү:

Зүдэж зүтгэгсэд хийгээд хүнд ачаа үүрсэн бүгд ээ, Над дээр ир. Би та нарыг амраая. Буулгыг минь өөрсөд дээрээ ав. *Надаас сур*. Би дөлгөөн, зүрхэндээ *даруу*. Та нар сэтгэлдээ амралтыг олох болно (Матай 11:28-29, тодруулгыг нэмэв).

Тэгэхээр, үндсэндээ бид даруу занг өөрийнхөө тухай дуугардаггүй, юунд ч ашиггүй өт хорхой мэт амьдрах явдал гэж бодсондоо, даруу байдлын жинхэнэ утгыг нь алдагдуулаад, үнэнээс хол далийжээ.

ДАРУУ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Даруу байдал нь гурван талтай. Нэгдүгээрт - Бурханд дуулгавартай байх, хоёрдугаарт - Бурханаас бүрэн хамаарах, гуравдугаарт - өөрийгөө үзэх үзэл.

Нэгдүгээрт - бидний дуулгавартай байдал. Иаков даруу байдлын талаар бичингүүтээ, араас нь “Бурханд захирагдагтун” (4:7) гэжээ.

Энэ нь дуулгавартай байдал, даруу зан хоёрыг холбож байна. Эзэн Өөрийнхөө хүмүүст амлалт, төлөвлөгөөгөө өгдөг. “Учир нь та нарт зориулж байгаа төлөвлөгөөнүүдийг Би мэдэх бөгөөд тэдгээр нь та нарт ирээдүй ба найдварыг өгөх гай гамшгийн бус, сайн сайхны төлөөх төлөвлөгөөнүүд юм” хэмээн ЭЗЭН тунхаглаж байна” (Иеремиа 29:11). Эдгээр амлалт нь Бурханы хүсэл мөн бөгөөд тийш хүрэх замыг заасан эш үзүүллийн дүр зургийг бидний дотор дүрслэн урладаг. Энэ их хүслээ зүрхэнд маань суулгасан Бурхантай (Дуулал 37:4) адил бид ч эдгээрийн биеллийг үнэн голоосоо хүсэмжлэх. Бурхан биднийг хааш нь дагуулж явааг зүрхэндээ зэрвэс харсан бид, төрөлх ойлголтоороо тийшээ хүрэх учир зүйтэй арга замыг боловсруулна. Гэтэл Бурхан биднийг хамгийн учир зүйтэй гэмээр харагдах тэр арга замын яг эсрэг зүг дагуулах нь олонтаа. Энэ үед л жинхэнэ даруу зан чанар нь Бурханы цэц ухаан, чиглүүлгийг өөрийнхөөсөө ухаанаас дээр тавиад, ойлгохгүй байсан ч, дагахыг сонгодог. Сургаалт үгс 3:5 дээр “Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ Бүү түшиглэ, өөрийнхөө ойлголтод” гэдэг.

Абрахам Исаакийн талаарх амлалтын биеллийг олон жил хүлээсний эцэст хүлээж авчээ. Тэгээд олны эцэг болгоно гэсэн Бурханы амлалт биелэх голдрилдоо орсныг зах зухаас нь үзэж эхлэв. Тэгтэл Бурхан ганц шөнийн дотор энэ бүхнийг эргүүлж хаяад, Абрахамыг гурав хоногийн газар очоод, Исаакийг ал хэмээв! Ёстой хэлэх ч үгүй алга! Ийм үед яаж дуулгавартай дагах юм бэ? Энэ зовлонтой тушаал нөгөө том амлалттай яаж ч холбогдохгүй байв! Гэвч Абрахам даруу тулдаа ямар ч ойлгомжгүй байсан ч, Бурханы үгэнд орох сонголт хийжээ.

Бурхан хүмүүнд харуулсан зүйлээсээ шал эсрэг заавар өгөх юмуу нөхцөл байдалд оруулав ч, хүн дуулгавартай дагах үед Бурханы амлалт хүн - бидний ухаан хүрэхгүй арга замаар биелсэн, дээрхтэй адил жишээ Библи дээр олон.

БУРХАНААС БҮРЭН ХАМААРАХ

Хоёрдугаарт - даруу байдлыг Бурханаас бүрэн төгс, үг дуугүй хамаарах хэмээн тодорхойлж болно. Давидыг бардам сагсуу гэсэн ч, тэрбээр өөрийнх нь чадвар Бурханаас ирснийг мэддэг байсан. Давид: “Арслан, баавгайн савраас намайг аварсан ЭЗЭН тэр филист хүний гараас ч намайг аварна” (1Самуел 17:37) гэдэг. Ах нар нь өөрийнхөө чадварт найдаж байсандаа л өөрсдийгөө Давидын дэргэд насаар ч, хүчээр ч илүү гэж сэтгэсэн бол, Давидын хүч нь итгэл, дуулгавартай зан чанарт нь оршдог байжээ.

Бид үүнийг Калев, Иошуа хоёроос харна. Тэр хоёр амлагдсан газрыг танадахаар явсан арван хоёр ахлахын нэг байв. Тэд дөч хоногийн дараа эргэж ирээд, Мосед болоод ард түмэнд тайлангаа тавьжээ. Ийнхүү арван ахлах нь: “Таны биднийг илгээсэн нутагт бид очлоо. Тэр нь үнэхээр сүү, зөгийн бал урссан нутаг мөн бөгөөд түүний үр жимс энэ байна. Гэхдээ тэр нутагт амьдарч буй ард түмэн нь хүчирхэг, хотууд нь бэхлэгдсэн агаад маш том юм. Бид тэнд Анакийн үр удмыг үзэв” (Тооллого 13:27-28) хэмээв.

Тэдний үгийг дуулсан зон олон орилолдон босч ирсэн боловч, Калев: “Бид гарцаагүй дийлж чадах учир өгсөж очоод түүнийг эзэлж авцгаая” (30-аар эшлэл) хэмээн баталгаатай үг айлдан, үймээнийг намжаав.

Гэвч бусад ахлахууд нь шууд л: “Тэд биднээс хэтэрхий хүчирхэг тул бид тэр ард түмний өөдөөс өгсөж очиж чадахгүй” (31-ээр эшлэл) хэмээн эсэргүүцсэн.

Бичээс “Харин даяар хотол түмэн —Тэднийг чулуугаар шид гэгцгээж байлаа” (Тооллого 14:10) гэдэг.

Калев, Иошуа хоёрыг бусад арван ахлах, ард олон бүгдээрээ өөртөө эрдсэн, том толгойтууд гэж үзжээ. Тэр газрыг эзэлж чадахгүй гэсэн ахлахууд нь их л амьдралтай юм ярьж байв. Тэд нөхцөл байдлыг хэмжээд, боол явсан хүмүүс тийм хүчирхэг, бат цаазтай улс үндэстнүүдийг эзлэнэ гэж түүхэнд байхгүйг мэджээ. Тэгээд ч тэд эмэгтэйчүүд, нялхсыг бодсондоо л тэгж хэлсэн (Тооллого 14:3). Тэд хүн арддаа - тэр дундаа өтгөс, бүл чадал дорой хүмүүст санаа тавьдаг, даруухан хүмүүс шиг л үзэгдэх. Гэтэл Калев, Иошуа хоёр хажууд нь сул дорой хүмүүсийг юмын чинээ боддоггүй, бардам сагсуу этгээдүүд шиг л харагдаж байна.

Гэхдээ тэр хоёр эрийн бат итгэл нь хаанаас гарсныг үзнэ үү: “Зөвхөн ЭЗЭНий эсрэг л бүү тэрсэл. Тэр нутгийн ард олноос бүү ай. Тэд бидний хоол болно. Хамгаалалт нь тэднээс зайлуулагдсан бөгөөд ЭЗЭН бидэнтэй хамт байна. Тэднээс бүү айгтун!” (Тооллого 14:9). Иошуа, Калев хоёр өөрийнхөө хүчинд найдсан бус, Эзэнээс л бүрэн төгс хамаарч байжээ. Бурхан хүмүүсээ тэр газар руу дайрч ороод, булаан эзлэхийг хүсч байгааг Иошуа, Калев хоёр мэдэж байсан. Тэр хоёр том толгойтой, бусад нь амьдралын ухаантай мэт харагдаж байгаа боловч, бардам, даруу хоёрыг гагцхүү Бурхан л ялган тунгаадаг болой.

Даруу байдал буюу Бурханы нигүүлслээс бүрэн хамаарахыг Паулын амьдрал яруу тодоор харуулдаг. Паул өөрийнхөө тухай:

“Бид чухамхүү аливааг өөрсдөөсөө мэт зүтгэж чадахгүй ч, бидний чадвар Бурханаас” (2Коринт 3:5) гэсэн.

Мөн:

“Тэр надад “Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөсдөлд [Миний] хүч бүрэн төгс болдог” гэж айлдсан. Иймд Христийн хүч надад орших тул би ихэд баяртайгаар мөхөсдөлөөрөө илүү сайрхана. Иймд Христийн төлөө мөхөсдөл, доромжлол, гачигдал, хавчлага, шахалтдаа би баяртай байна. Учир нь би хэзээ мөхөсдөнө, тэр үедээ хүчтэй” (2Коринт 12:9-10) гэсэн.

Паулын амьдрал дараах замаар л боловсорчээ: Тэрбээр нас явах тусам, өөрийнхөө хүч, авъяас, чадвараас улам бага, Бурханы нигүүлслээс улам их хамаарах болсон. Тэгээд өөрийгөө Христийн мэдэл рүү хоослох тусам, Христийг алдаршуулах шийдвэртээ улам л болд зоригтой, хүчтэй болжээ.

ӨӨРИЙГӨӨ ХЭРХЭН ҮЗЭХ

Энэ нь биднийг даруу чанарын гуравдугаар тал руу буюу өөрийгөө хэрхэн үзэх үзэл рүү хөтөлж байна. Паул аврагдсан хойноо Есүстэй учрахаасаа өмнө хураасан хамаг ололт амжилтаа хаяж, өөрийгөө даруусгасан. Христийг мэддэг болохоосоо өмнө бүтээн босгосон амьдралаа хог новшт тооцох нь ихэнх хүнд хэцүү биш ээ.

Харин аврагдсанаасаа хойш Христийн дотор байгуулсан ололт амжилт яах бол? Энэ чинь ихэнх хүний хувьд тэс өөр түүх болоод явчихна. Тэгвэл энэ тухайд Паул: “Ах дүү нар аа, би өөрөө барьж авсан гэж боддоггүй, харин хийдэг ганц юм маань ардахаа мартаж (*Паулыг аврагдсанаас хойш Бурхан түүгээр дамжуулж хийсэн юмс*), урдах өөдөө тэмүүлдэг...” (Филиппой 3:13, тодруулгыг нэмэв) хэмээв.

Паул Есүст итгэсэн цагаасаа олон жилийн дараа элчээр томилогдсон (Үйлс 13:1-4-ийг үзнэ үү). Бурхан Паулд бөөн бөөн сүнсний илчлэл, цэц ухаан хайрласан нь дахиад л ололт амжилтанд хүрэх чадал олгожээ. Паул Ази, Зүүн Европ даяар чуулган тариалсан. Коринтод эхлүүлсэн залуу цуглаандаа МЭ 56 онд бичсэн Паулын захидлаас нь тэр эрхэм хүний даруу чанар зэрвэс үзэгдэх. Тэрбээр арван жилийн дараа цаазлуулах, Есүсийн төлөөх үйлчлэлийн халуун тогоонд чанагдсан, ахмад үйлчлэгч болоод байжээ. Гэхдээ түүний юу хэлснийг сонсоно уу:

Бурханы оршдог хүн

“Учир нь би элч нараас хамгийн өчүүхэн нь бөгөөд Бурханы чуулганыг хавчиж байсан тул элч гэж нэрлэгдэх зохисгүй хүн юм” (1Коринт 15:9).

Паулын үгээс даруу зан үнэртэж байна уу? Би нэгэн зүйлийг цохон тэмдэглэмээр байна - энэ хуурамч даруу чанар биш шүү. Хулхи даруу чанар нь гаднаасаа их ухаалаг, зөв үгтэй атлаа, зүрхээрээ ч, оюунаараа ч гэдгэр байдаг бөгөөд хуурамч, зальжин үнэр ханхлуулдаг. Тэгвэл Ариун Сүнсний хөгөөр бичигдсэн Бичээс нь худлаа ярьдаггүй! Паул үнэхээр өөрийгөө тэгж үзээгүй байсан бол, Бурхан худлаа юм бичихийг нь эс зөвшөөрнө! Тиймээс Паул өөрийгөө хамгийн өчүүхэн элч хэмээхдээ, “попроогүй”, үнэхээрийн даруу чанараасаа өгүүлжээ.

Тэгвэл Паулын дараагийн мэдэгдлийг үзнэ үү: “...би тэд бүгдээс илүү зүдэж зүтгэсэн” (1Коринт 15:10). Бүгд гэж хэн бэ? Бүх элч нар! Байзаарай. Паул одоо сайрхаад унав уу? Яг л амныхаа нөгөө булангаар ярив уу гэлтэй. Өөрийгөө хамгийн өчүүхэн элч гээд байсан хүн ямар нүүрээрээ “...би бүгдээс нь илүү зүтгэсэн” гэдэг билээ? Паул эхний үгээ санаандгүй унагачихжээ гэмээр, их л бардам сонсогдож байгаа хэдий ч, үнэндээ үгүй юм. Паул яагаад ингэж хэлэх болсныг одоо тайлъя:

“Гэхдээ би биш, харин надтай хамт байдаг Бурханы нигүүлсэл билээ” (1Коринт 15:10).

Паул хийсэн бүхнээ “Бурханы нигүүлслээр...” хэмээн, хамаг гавьяаг нь Бурханд хамаатуулжээ. Паул өөрийгөө бүх ололт амжилтаасаа салгасан бөгөөд ололт амжилт болгон нь түүгээр дамжих Бурханы чадвараас эхтэйг бүрэн мэдэж байжээ.

Өөрийгөө “хамгийн өчүүхэн элч” гэсэн Паулын үгийг залгихад хэцүү. Паул амьд ахуйдаа ч, хожмын түүхэнд нь ч ёстой л цагийг эзэлсэн аугаа элчийн нэг болсон. Тэгвэл долоон жилийн дараа буюу МЭ 63 онд буюу нас барахаасаа дөрвөн жилийн өмнө Паул Ефесчүүдэд юу хэлснийг үзэх үү? Коринтод бичсэн захидлаас хойшхи долоон жилдээ Паул урьд урьдынхаасаа ч илүү үр бүтээлтэй амьдарчээ. Гэтэл өөрийгөө ийнхүү дүрслэх:

Бүх ариун хүний хамгийн өчүүхэн нь болох надад энэхүү нигүүлсэл өгөгдсөний учир нь Христийн яндашгүй баялгийг харийнханд тунхаглаж... (Ефес 3:8, тодруулгыг нэмэв).

Долоон жилийн өмнө Паул өөрийгөө “элч нарын хамгийн өчүүхэн нь” гэж дуудаж байсан бол, эдүгээ “ариун хүмүүсийн хамгийн өчүүхэн нь” гэх! Юу вэ?! Өөрөөрөө сайрхах зүрхтэй хүн байдаг бол - Паулаас өөр хүн үгүй байтал, Паул өөрийгөө жинхэнээсээ ингэж л үзсэн! Бичээсийг худлаа юмуу зөв зүйтэй шашны үг хэлээр бичих боломжгүй байдгийг санаарай.

Паулын амьдралын хөврөл үүгээр ч дуусалгүй, цааш өрнөснийг нь цаазлуулахынхаа өмнө Тимотод бичсэн захидлаас нь үзэж болно:

“Христ Есүс нүгэлтнүүдийг аврахаар ертөнцөд ирсэн гэдэг нь итгэмжит бөгөөд бүрэн зөвшөөрөхөд зохистой үг мөн. Тэдний эхнийх нь би байна” (1Тимот 1:15).

Эдүгээ Паул өөрийгөө элч нарын ч, ариун хүмүүсийн ч хамгийн дордоор барахгүй, тэргүүн зэргийн нүгэлтэн гэж үзжээ. Паул “би тэргүүн *байсан*” гэж хэлээгүй, харин “тэргүүн нь *мөн*” гэж хэлснийг тэмдэглэнэ үү. Христийн дотор цоо шинэ бүтээл байх, хуучин юмс өнгөрч, бүгд шинэ болсон (2Коринт 5:17-г үзнэ үү) гэдэг илчлэлийг Паул л хүлээж авсныг санаарай. Тийм атлаа Паул Аврагчдаа хичнээн их өртэйгээ хэзээ ч мартаагүй байна.

Үйлчлэх тусам, Паулын даруу чанар нь өсч, даруу чанар нь өсөх тусам, өөрийгөө бууруулан харах болжээ. Магадгүй, иймээс ч өтлөх тусам, Бурханаас хүртэх нигүүлсэл нь ч нэмэгдээ юм болов уу? Учир нь Бурхан “нигүүлслээ дарууд өгдгийг” Иаков хэлсэн (Иаков 4:6-г үзнэ үү). Түүнчлэн, магадгүй иймээс Бурхан Өөрийгөө Паулд Петрийг ч гайхширтал, тийм дотно илчлээ юм болов уу? Бурхан даруу хүмүүс дээр зочилдоггүй, харин оршдгоо Исаиагаар айлдсан. Бид Бурхантай оршихдоо, Түүнтэй дотно болдог.

ХҮЧИРХЭГ ИХЭЭ

Ийнхүү бүгдээрээ Хаанчлалын хүчирхэг хоёр ихэр дээр ирлээ: Тэдгээр нь *Эзэнээс эмээхүй*, *Даруу байдал* хоёр юм. Эзэнээс эмээхүй нь Түүнийг дотно таньж мэдэхийн эхлэл болохыг бид өнгөрсөн хэдэн бүлгээрээ тодорхой сурсан. Тэгвэл даруу байдлын хувьд ч ижилхэн юм. Магтаалч:

“Тэрээр *даруу* хүнийг шударгаар удирдаж, Тэдэнд замаа сургадаг” (Дуулал 25:9, тодруулгыг нэмэв) гэсэн.

Бурханы оршдог хүн

Бурхан даруу хүнд замаа илчилдэг гэсэн атлаа хэдхэн эшлэлийн хойно ингэж хэлжээ:

“*ЭЗЭНээс эмээдэг хүн хэн юм бэ? Түүнд тэрээр сонгох ёстой замыг нь зааварчилна*” (Дуулал 25:12, тодруулгыг нэмэв).

Үндсэндээ, Эзэнээс эмээдэг хүмүүс нь жинхэнээсээ даруу хүмүүс бөгөөд жинхэнээсээ даруу хүмүүс нь Эзэнээс эмээдэг ажээ. Мосе Бурханы замыг мэддэг байсан бол, Израиль Бурханыг залбиралд хариулдгаар нь буюу хэргээр нь л мэддэг байсныг санаарай. Мосе Эзэнээс эмээдэг ч хүн, даруу ч хүн байсан. Уялдааг нь харж байна уу? Израиль Эзэнээс эмээгээ ч үгүй (Дэд хууль 5:29), даруу ч байгаагүй (Үүнийг Иошуа, Калев хоёрын жишээнээс үзсэн).

Магтаалч Эзэнээс эмээхүй, даруу чанар хоёрыг бараг л салшгүй, бат холбожээ. Үүнийг ч Бичээсээс ахин дахин харж болно. Жишээлбэл:

“*ЭЗЭНээс эмээхүй нь мэргэн ухааны сургамж Алдрын өмнө даруу дорд байдал*” (Сургаалт үгс 15:33, тодруулгыг нэмэв).

Гэхдээ байна шүү - харанхуйн хаанчлал ч өөрийн гэсэн ихэртэй. Тэдгээр нь Эзэнээс эмээхүй, Даруу байдал хоёрын яг эсрэг чанар буюу *Тэрслэл, Бардамнал* хоёр юм. Эдгээрийг Сургаалт үгс дээр харьцуулжээ:

ЭЗЭНээс эмээхүй ба даруу дорд байдалд эд баялаг, алдар хүнд, амь нь шагнал болно. *Адайрын (гөжүүд бөгөөд дураараа)* замд сундуу хийгээд занга. Анхаарал болгоомжтон тэдгээрээс ангид (Сургаалт үгс 22:4-5, тодруулгыг нэмэв).

Эзэнээс эмээхүй, даруу чанар хоёр нь хослохоос гадна бардамнал, тэрслэлтэй жишигдсэн байгааг харж байна уу? Есүс Өөрийгөө хүмүүн, тэнгэрлэг элч - хэнээс ч илүү даруусгасан болохоороо, хэн хэнээс дээгүүр өргөмжлөгдсөн юм (Филиппой 2:8-9-ийг үзнэ үү). Түүнчлэн Есүс юу юунаас илүүтэй ЭЗЭНээс эмээхүйг хайрладаг учраас, Бурханы Сүнс ч Есүстэй хамт бөгөөд Есүсийн дээр энгүй ихээр орших” (Исаиа 11:2-3, Иохан 3:34).

Тэгвэл эсрэгээрээ, эдүгээ Сатан нэрээрээ алдаршсан, тослогдсон

херуб агсан - Люцифер бардам зангаараа өөрийгөө хэн хэнээс дээгүүр өргөмжилж, тэрсэлсэн болохоороо, “Газрын гавд тултлаа” хамгаас доош орсон юм (Езекиел 28:14-17, Исаиа 14:12-15-ыг үзнэ үү).

Бурхан хамгийн өндөрт оршдог бол, чөтгөрийн хүчин хамгийн доор газарт байдгийг Бичээс ахин дахин хэлдэг. Бардам зан, тэрслэл нь хамгийн дордтой нь, даруу зан, Эзэнээс эмээхүй нь хамгийн дээдтэй нь холбоотой байдгийг Бичээсийн хаанаас ч, хэзээ ч харж болно. Өргөгдөхүй нь Бурхантай дотно орших!

БУРХАНААР НЭХҮҮЛДЭГ ХҮМҮҮС

Бурхан бардам, тэрслүүг эсэргүүцдэг (Иаков 4:6) бол, Өөрөөс нь эмээдэг, жинхэнэ даруу хүнд татагддаг. Бурханд яг л хуулийн ном ёсоор үйлчилдэг хэсэг хүмүүс Хуучин гэрээнд байжээ. Тэд Ариун газар дээр Бурханд зориулан хурга, бухын тахил өргөж, утлага уугиулж, буудайн өргөл өргөнө. Гэтэл Бурхан тахилыг нь хүн алахтай адил, өргөлийг нь гахайн цустай адил, залбирал, магтаалыг төлөөлсөн утлагыг нь шүтээн баясгахтай адил харагдаж байна хэмээв! Тэгээд учрыг нь хэлжээ:

“Би дуудсан боловч хэн ч хариулсангүй, Би дуугарсан боловч хэн ч чих тавьсангүй, Харин тэд Миний өмнө мууг үйлдэж, Хүсээгүйг минь сонгосон учраас Би мөн эрх хүслийг нь сонгож, Айдсыг нь тэдний дээр авчирна” (Исаиа 66:4).

Бурхан яагаад эс таалав? Яагаад гэвэл тахил нь дуулгавартай байдалтай хослоогүй байна! (1Самуел 15:22-ыг үзнэ үү). Өөрөөр хэлбэл, Эзэнээс эмээхүй байхгүй хүндэтгэл мөргөлүүд.

Эзэн тэр “мөргөлчдийг” мэл гайхаж, цэл хөхөртөл нь тас цохисон. Тэдний цочирлыг төсөөлж байна уу? Тэд Бурханд үйлчилж явна, Бурханд таалагдаж байна л гэж бодтол, Бурхан тэдний хүндэтгэл мөргөлд огижээ. Гэвч Эзэн сугалчихаад, оронд нь шинээр суулгадаггүй, нураачихаад оронд нь шинээр байгуулдаггүй Бурхан биш болохоороо, Өөрийг нь татдаг юмсыг хүмүүстээ хэлж өгөөд, урам оруулжээ:

“Энэ бүх юмсыг Миний мутар бүтээсэн бөгөөд Энэ бүхэн байдаг болжээ” гэж ЭЗЭН тунхаглав. “Харин даруу, гэмшсэн сэтгэлтэй, Үгэнд минь чичирдэг нэгнийг л Би анхаарна” (Исаиа 66:2).

Анхаарна (үнэлнэ) гэхийг Еврейгээр *набат* гэнэ. *Стронгийн* толь бичиг дээр “зориуд харах, таашаал, таалал, анхаарлаа хандуулах” хэмээн тодорхойлжээ. Тэгэхээр, Бурхан үндсэндээ, “Ийм хүнд л би таашаал, таалалтай хандаж, нарийн анхаарна” гэсэн байна. Товчхондоо, “Би ийм хүний л араас явна, ийм хүний л араас нэхнэ” гэжээ. Орчин цагийн зохиолч, багш Томми Тенни миний бодлоор манай үеийн хамгийн шилдэг нэртэй нэгэн номыг бичсэн хүн. Тэр номыг нь “*The God Chasers*” (*Бурханы араас нэхэгчид*) гэдэг. Бурханд хайртай хүмүүсийн зүрхийг төгс дүрсэлсэн нэр байх. Гэхдээ Бурханы араас нэхэх нь нэг хэрэг бол, Бурханыг араасаа нэхүүлнэ гэдэг тэс өөр хэрэг! Гэтэл Бурхан энд чухам энэ тухай л хэлжээ.

Давидыг аваад үз. Израилийн тэргүүн эш үзүүлэгч Самуел Саулын хилэнгээс айдаг учраас, тун дурамжхан байсан хэдий ч, Бурхан түүнийг Иессегийн гэрт очихыг үүрэгджээ. Бурхан Иессегийн нэгэн хөвүүнийг нь хүссэндээ, Самуелыг илгээсэн байна. Эш үзүүлэгч Иессегийн долоон хөвгүүнийг бүгдийг нь шинжсэн боловч, Бурхан: “Үгүй ээ, Самуел аа, энэ хөвгүүдийн хэн нь ч биш. Би хээр хонь хургатай хөөцөлдөж яваа, улаа бутарсан жаалхүүг хайж байна!” хэмээн айлддаг. (Зохиолчийн дүрслэл)

Давидын ах нар ялгаагүй л Израиль эрчүүд мөн атал Бурхан яагаад чухам Давидын араас л нэхэл сурал болно вэ? Хариултыг нь дээрх эшлэлээс харж болно. Бурхан даруу, сүнс дотроо гэмшдэг, Бурханы Үгд чичирдэг хүнийг л таалдаг. Сүнс дотроо гэмшдэг хүмүүс тэр даруй гэмшиж, тэнгэрийн мэдэлд бүрэн төгс захирагддаг хүмүүс юм. Өөр нэгэн орчуулга дээр “Би даруу бөгөөд гэмшдэг, Надаас эмээдэг, дуулгавартай дагадаг хүмүүсийг таалдаг” (ТийИВи Библи) гэдэг. Гэмшдэг сүнс нь Эзэнээс эмээхүй, жинхэнэ дарууслын өөр нэгэн хэлбэр юм. Тэгэхээр үндсэндээ, Бурхан Өөрөөс нь эмээдэг бөгөөд даруу, Хаанчлалын хүчирхэг хоёр ихрийн чанар дотор явдаг хүмүүсийн араас нэхэдгээ л хэлж байна! Тиймээс л бидэнд:

“Тохуурхагчдыг Тэр тохуурхдаг атлаа Дарууд нигүүлсэл үзүүлдэг” (Сургаалт үгс 3:34) гэдэг.

Мөн:

“Танаас эмээгчдэд зориулан
Таны хуримтлуулсан,
Таны дотор хоргодогчдод
Таны соёрхсон сайн сайхан

Бурханд ойрт

Хүний хөвгүүдийн өмнө хичнээн агуу вэ!
Та тэднийг оршихуйнхаа нууц газарт
Хүний хуйвалдаанаас нуун
Та тэднийг хэл амны хараалаас
Майхандаа нууцалж хамгаалдаг” (Дуулал 31:19-20) гэдэг.

Тиймээс л Шинэ гэрээ бидэнд “...даруу хандах байдлаар хувцасла” (1Петр 5:5), “...эмээн биеэ авч яв” (1Петр 1:17) гэж заадаг. Бурхан, Ариун Сүнс хоёр Петрийн үгээр дамжуулан биднийг Өөртэй нь дур булаам харилцаанд нэвтрэхийг ятгаж буй нь үр хүүхэд - бидэндээ хандсан Бурханы чин хүслэн болой.

Сонголт нь биднийх. Бурхан бидэнд Өөртэй нь хамт алхах зам тавьж өгөөд, дээрээс нь түүгээр явах нигүүлслээ ч өгсөн. Бидний Бурхан ямар сайн Аав бэ! Тэгэхээр эдүгээ ордондоо хувьчлан уулзах Бурханы дуудлагыг анхаарах, сонсох эсэх нь бидний л шийд. Харин Бурхан үүнийгээ хэрхэн хийдгийг дараагийн хэдэн бүлгээрээ үзье!

СУДЛАХ АСУУЛТ

1. Даруу байдлыг ерөнхийдөө сул дорой, улцгар, үлбэгэр байдалтай эндүүрэх тал байдаг ч, жинхэнэ даруу хүмүүсийг ихэвчлэн хэнхэг бардам гэж үздэг талаар ярьсан. Ингээд бодохоор, та ч бас даруу хүмүүсийг хэнхэг бардам, сагсуу гэж бодож явсан тохиолдол байгаа юу? Байгаа бол, энэ алдаатай дүгнэлтээсээ ямар сургамж авсан бэ?
2. Даруу байдлын гурван талыг буюу Бурханд дуулгавартай байх, Бурханаас бүрэн хамаарах, өөрийгөө үзэх талаар мөн тухай бүрийнх нь Библийн жишээг эргэцүүлнэ үү. Таны хувьд, аль нь хамгийн хэцүү тал вэ?
3. Исаиа 66-аар бүлэг дээр Бурханд хуулийн үсгийн дагуу зүй ёсны тахил өргөж, зүй ёсны утлага уугиулж, зүй ёсны өргөл өргөх маягаар хүндэтгэн мөргөдөг хүмүүс гардаг. Гэвч дуулгаваргүй байсан тул Эзэн хүндэтгэл мөргөлийг нь таалаагүй. Тэгвэл бидний хувьд ч, бэлэгтэй, авьяастай удирдагч нарын чиглүүлгээр явж байгаа хэдий ч, хүндэтгэл мөргөл маань Бурханд таалагдахгүй байх боломжтой юу? Тайлбарлаж ярина уу?

Аравдугаар бүлэг

АРИУН СҮНСТЭЙ ДОТНОСОХ



Чуулган дотор Ариун Сүнснийг л арай үл тоогоод байх шиг.

Ийнхүү бид миний хамгийн ихээр ярихыг хүссэн хэсэг дээр буюу Эзэн бидэн рүү хэрхэн ойртдог тухай яриан дээр ирлээ. Гэхдээ эхлээд - бид Бурханыг хүсэхээсээ илүү Бурхан биднийг хүсэмжилдгийг дахин хэлэхийг болгооно уу. Мосе: “Чи өөр ямар ч бурханд мөргөж болохгүй. Учир нь Хардагч нэртэй ЭЗЭН нь хартай Бурхан билээ” (Гэтлэл 34:14) гэснийг санаарай.

Миний бие саяхан гүн залбирч байхдаа, өөрөө ч ухаарч амжихын сөхөөгүй: “Эзэн минь, би газар дээр Тантай дотно нөхөрлөхгүй юм бол, Тэнгэрт Тантай хамт байхаар явсан нь дээр!” гэж хашхирсан юм. Зүрхнээс үг олгойдохтой хамт өвдөг маань чичирч байлаа. Би үгээ хэлье гэж хэлснээ мэдэж байсан ч, оюун ухаан маань тэр даруй: “Чи чинь сая юу гуйчих нь энэ вэ?” гэж донгодов. Учир зүйн ухаан маань ингэж гуйж болох эсэхийг лавлаж байлаа.

Бурханд ойрт

Хэдэн цагийн дараа Аризона мужийн Финикс рүү нисч явахдаа, цүнхнээсээ Библиэ аваад, дэлгэгтэл, шууд дараах эшлэл дээр харц тусав:

ЭЗЭН, Тан уруу би хашхирнам,
Хад минь, намайг сонсохоос
Бүү татгалзаач!
Хэрэв Та дуугүй байвал
Нүхэнд ойчих хүмүүсийн адил болно, би (Дуулал 28:1).

Золтой л суудлаасаа дэвхэрчихсэнгүй. Нүд маань очиж очиж яг ийм утгатай эшлэл дээр тусах гэж байдаг аа? Яг л хэдэн цагийн өмнө гайхширч байсан асуулттай маань холбоотой байв. Зүрх маань дэлдэх үед би энэ Бурханы хариу - үг байна гэдгийг ухаарсан юм.

Бурхан бидэнтэй ярихгүй бол, бид там руу уруудаж яваа нүгэлтнүүдээс ялгаагүй болохыг Давид хэлжээ. Би биедээ байнга Нью Ливинг Транслэйшн Библи авч явдаг учраас, үүнийгээ нээгээд, өглөө хэлсэн залбиралтайгаа тохируулав. Тэнд “Учир нь Та дуугүй байвал, би бууж өгөөд, үхэж болзошгүй” гэжээ. Би яг л ингэж хашхирсан шүү дээ. Өмнө энэ эшлэлийг хэд дахин уншихдаа, ийм гэгээрлээр уншиж явсангүй.

Би Бурханы хүслийг сөрж бус, харин Ариун Сүнсээр залбирснаа тэр дороо ойлгов. Энэ үг Бурхан бидэнтэй чимээгүй байхыг хүсдэггүй, харин харилцахыг үнэн голоосоо хүсдгийг дахин бататгав. Би Давидын хэлсэн дараах Бичээст үнэхээр хайртай:

“Миний царайг эрэн хайцгаа!” гэхэд
Зүрх минь Танд “ЭЗЭН, царайг тань би эрж хайюу” гэв
(Дуулал 27:8).

Бурханы зүрхний санаашралыг сонсож байна уу? Бурхан бидний хүн нэг бүрт: “Наашаа ойрт, Би чамтай харилцмаар байна, зүрхээ хуваалцаж, чиний мэдэхгүй аугаа, хүчирхэг юмсыг харуулмаар байна!” хэмээн урьсаар л.

“Бурханд ойртох” нь итгэгч хүн бүрийн амьдралын дүрслэл байх ёстой бөгөөд ойртох аваас, “Бурхан бидэнд ойртох” баталгаа өгчээ. Бид аль хэр дотносохыг Бурхан бус, бид тодорхойлох ажээ. Бурхан сэнтийн өрөөнийхөө хаалгыг хэдийнээ нээсэн бөгөөд биднийг дуудсаар, хүлээсээр байна. Хэрхэн хариу үйлдэх нь бидний шийд бөгөөд биднийг ойртох тусам, Бурхан Өөрийгөө болоод хүслээ улам улам илчилнэ. Тийм боловч дараах аугаа урилгыг хэлэхээсээ өмнө Иаковын үгийг үзнэ үү:

“Эсвэл Бичвэр дэмий хоосноор “Бидний дотор Түүний нутаглуулсан сүнс нь атаархан хүсдэг (улайран хүсдэг)” хэмээсэн гэж та нар бодож байна уу?” (Иаков 4:5)

Бурхан биднийг санаашран санагалздаг ч, нөгөөтэйгүүр улайран хүсдэг байх нь. Бурхан биднийг дэлхийн шунаг хүсэлтэй хуваалцахгүйг өнгөрсөн хэдэн бүлгээрээ үзсэн. Тиймээс л Иаков “...ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгэхлээр хорвоотой ходий хэн боловч өөрийгөө Бурханы дайсан болгож байгаа юм” (Иаков 4:4) гэжээ. Энэ нь яг л итгэмжгүй нөхөртөө: “Чи надтай байхдаа нууц амрагтай байна гэж байхгүй! Тиймээс сонго. Надаас татгалзаад, түүнийг сонгох юм бол, би явлаа” гэж хэлж байгаа гэргий хүнтэй л адил. Эзэн ч ялгаагүй, биднийг дэлхийтэй хуваалцахгүй. Эзэн л бидний зүрхний тэмүүлэл байх ёстой бөгөөд эс бөгөөс Тэр бидэнд Өөрийгөө нээхгүй.

БИДНИЙ ДОТОР ОРШИХ СҮНС УЛАЙРАН ХҮСДЭГ

Бурхан биднийг яаж үгүйлж хүсдгийг хангалттай ярьсан болохоор, одоо бүгдээрээ *Сүнс* гэдэг үг дээр төвлөрч ярилцъя. Бичээс “Бидний дотор Түүний нутаглуулсан сүнс нь атаархан хүсдэг (улайран хүсдэг)” гэж бичсэн нь тун чухал. “Бидний дотор байдаг Есүс атаархан хүсдэг (улайран хүсдэг)” гэж хэлээгүй. Есүс газар дээр бус, харин Өндөрт залрах Эрхэм дээдсийн баруун гарт залран суугаад бараг хоёр мянгаад жил болж байна. Есүсийг явсан өдөр тэнгэрэлч нар дагалдагч нарт: “Талилын эрчүүд ээ, та нар юунд тэнгэр ширтэн зогсоно вэ? Та нараас өргөгдөн тэнгэрт аваачигдсан энэ Есүс тэнгэр өөд явсныг нь та нар харсан лугаа адил мөн тийн буцаж ирнэ” (Галил 1:11) гэсэн. Есүс дагалдагч нарынхаа нүдэн дээр биеэрээ үүлэн дээр өргөгдсөн бөгөөд Түүнийг яг үүнчлэн буцаж ирэхийг амлажээ.

Тэгэхээр намайг ташаа ойлгуузай. Гайхамшигт Аврагч Есүс маань биднийг улайран хүсдэг хэдий ч, Есүсийг явсны дараа бидний дунд Ариун Сүнс л үлдсэн бөгөөд энэ эшлэл дээр Бурхан чухам Ариун Сүнсийг л тодорхойлон хэлжээ. Тийм боловч, Есүсийн нэрийг дууддаг хүмүүс Ариун Сүнсэнд л хамгийн анзаараггүй ханддаг гэмээр. Үнэндээ, Чуулган дотор Ариун Сүнсийг арай үл тоогоод байх шиг. Бодоод үз: Хориод минут машин дотор хамт яваа хүнтэйгээ ганц ч үг дуугарахгүй явбал ямар байх уу? Гэтэл бид Ариун Сүнсэнд яг л ингэж ханддаг. Бид тухайн өдрийнхөө талаар эргэцүүлэх юмуу Хритэч дуу хөгжим,

радио сонссон шигээ давхиж явахдаа, Ариун Сүнс байгаад байгааг анзаардаг ч үгүй. Бид гэртээ, ажил дээрээ болоод бусад газарт цаг заваа зарцуулахдаа, Ариун Сүнсний нөхөрлөлийг мэддэг ч үгүй атлаа Ариун Сүнсний талаар ярихаараа, амьдралд маань ч, зүрхэнд маань ч байдгийг дуун дээр нь хүлээн зөвшөөрдөг.

АРИУН СҮНСНИЙ ТАЛААРХ ТӨСӨӨЛӨЛ

Ариун Сүнсний оршихуй, нөхөрлөлийг бодитоор хэрэгжүүлдэггүйн нэгэн шалтгаан нь бид Ариун Сүнсний талаарх төсөөлөлдөө ороогддог учраас тэр. Ариун Сүнсийг бичдэг, номлодог арга замаасаа болоод бид Ариун Сүнсийг нэг л нууцлаг этгээд мэт болгодог. Үнэндээ Ариун Сүнсийг “юм” мэтээр ярьж байхыг сонсох бүрийдээ, би нэг доллар аваад байсан бол, өдийд баяжчихгүй юу. Харамсалтай нь, олон хүн Ариун Сүнсийг бидний хамгийн дотны найз байхыг хүсдэг “Ариунаас ариун нэгэн” гэж үзэхийн оронд “ариун юм” мэт ханддаг. Гэтэл Ариун Сүнс оюун ухаантай (Ром 8:27) мөн хүсэлтэй (1Коринт 12:11), биднийг гэх хайраар нь илэрдэг сэтгэл хөдлөлтэй (Ром 15:30) болохыг Бичээсийг тунгаан боддог хэнбугай нь ч мэдэх л байсан. Ариун Сүнс ярьдаг (Еврей 3:7), үнэндээ маш тодорхой ярьдаг (1Тимот 4:1). Ариун Сүнс заадаг (1Коринт 2:13) мөн хүн шиг л гашуудахыг (Ефес 4:30) доромжлуулахыг (Еврей 10:29) бас худлаа хэлэхийг үздэг.

Ариун Сүнс гэхээр хамгийн түрүүнд бидэнд тагтааны л дүр зураг орж ирдэг байх. Гэхдээ яагаад тагтаагаар дүрсэлнэ вэ? Ариун Сүнс хэзээ ч тагтаагаар үзэгдэж байгаагүй! Сайн мэдээний дөрвөн номд дөрвүүлэнд нь Иохан Баптист Ариун Сүнсийг Есүс дээр “тагтаа мэт” буухыг нь үзсэн гэдэг (Матай 3:16, Марк 1:10, Лук 3:22, Иохан 1:32). Гэхдээ ингэлээ гээд Ариун Сүнс тагтаа болчихгүй. Жишээ нь: Салхи шиг хурдан хүүхэн”, “Бух шиг бяртай залуу” гэж ярьдаг. Тэглээ гээд тэр хүүхэн салхи болчихгүй, тэр залуу дөрвөн туурайт болчихгүй. Хүн хэвээрээ л байна.

“Жон, гэхдээ элч Иохан Ариун Сүнсийг Бурханы сэнтийн өмнө дүрэлзэн буй галт бамбараар харсан шүү дээ” гэх хүн гарах байх. Энэ үнэн. Учир нь “Сэнтийнээс аянгын гялбаа, нижигнээн, тэнгэрийн дуун гарав. Бурханы долоон сүнс болох долоон бамбар сэнтийн өмнө асаж байв” (Илчлэл 4:5) гэдэг. Гэхдээ тэр л Иохан: “Тэгээд би сэнтий ба дөрвөн амьтны хооронд, ахлагчдын дунд зогсож буй нядлуулсан мэт Хургыг харав. ...Тэд шинэ дуу дуулж —Хуйлмал номыг авч, Лацнуудыг нь нээх зохистой нь Та мөн. Учир нь Та нядлуулсан бөгөөд Өөрийн цусаар бүх овог, хэл, ард

түмэн болон үндэстнүүдээс Бурханд ариун хүмүүсийг арилжин авч өгсөн билээ” (Илчлэл 5:6-9-ийг үзнэ үү) хэмээн бичжээ. Иохан энд Есүсийн тухай өгүүлсэн нь хэнд ч тодорхой боловч, бид Есүсийг хэзээ ч амьтан гэж боддоггүй! Бид Есүсийг Өөрийнхөө дүр төрхөөр биднийг бүтээсэн, Хувь нэгэн гэж боддог. Бид амьтны дүрээр бүтээгдээгүй!

Ариун Сүнс Хувь нэгэн бөгөөд бид Түүний л дүр төрхөөр бүтээгдсэн. Тийм ээ, Түүний дүр төрхөөр! Эхлэл дээр “Бурхан —Бид дүр төрхийнхөө дагуу бидэнтэй адилхан хүнийг буй болгоё” (Эхлэл 1:26) гэдэг. Энд “Би Өөрийнхөө дүр төрхөөр хүн бүтээе” гэж хэлээгүй байна. Үгүй ээ, Аав, Хүү, Ариун Сүнс гурав нийлж байгаад хүнийг бүтээсэн. Бид бүтээл дэхь Аав, Хүү хоёрын үүргийг мэддэг ч, Бичээс “Бурханы Сүнс намайг бүтээсэн” (Иов 33:4), “Таныг Сүнсээ илгээхэд тэд бүтээгддэг” (Дуулал 104:30) хэмээн маш тодорхой хэлдэг. Тиймээс Бурханы “Өөрсдийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээх” үйлсэд Ариун Сүнс оролцсон нь тодорхой байна. Бид Аав, Хүү, Ариун Сүнсний дүр төрхөөр бүтээгдсэн. Ариун Сүнс Хувь нэгэн бөгөөд нууцлаг салхи юмуу нисдэг шувуухай бус, харин Бурханы Гурвалын гуравдугаар бие болой.

Бид Ариун Сүнсний дүр төрхөөр бүтээгдээгүй байсан бол, Мариа хэрхэн Ариун Сүнсээр бие давхар болох билээ? Гэтэл Бичээс “Түүний эх Мариа Иосефтой сүй тавиад, дэр нийлэхээсээ өмнө Ариун Сүнсээр хэвлийдээ хүүхэд олсон” (Матай 1:18) гэдэг. Хожим Эзэний тэнгэрэлч Иосефт “...түүнд олдоод байгаа нь Ариун Сүнснийх юм” (Матай 1:20) гэсэн. Ариун Сүнс “эд”, “юм” байсан бол, Мариа дотор яаж хүн бүрэлдэх билээ? Мариа Ариун Сүнсээр бие давхар болсон. Ижил дүр төрхтэй, хоёр биет нийлж байж л хэвийн үр төл бүтээнэ.

Одоо та Ариун Сүнснийг Хувь нэгэн гэдгийг - үнэндээ хамгийн биширмээр нэгэн болохыг ойлгож эхлээ байх аа. Иймээс л Паул ахан дүүсдээ:

“Эзэн Есүс Христийн нигүүлсэл, Бурханы хайр, Ариун Сүнсний нөхөрлөл (нэгдэл) та бүгдтэй хамт байх болтугай” (2Коринт 13:14, тодруулгыг нэмэв).

“Ариун Сүнсний *нөхөрлөл (нэгдэл)* та бүгдтэй хамт байх болтугай” хэмээсэн байгааг нь тэмдэглээрэй. Бурханыг дотно таньж мэдэх нь миний хүслэн учир, би *нөхөрлөл (нэгдэл)* гэдэг үгийг олон жил судлахдаа, олдож болох бүх толь бичгийг эргүүлээд тийнхүү дараах үндсэн тодорхойлолтыг гаргаж ирсэн юм:

- Нөхөрлөл
- Хоорондоо хуваалцах буюу нийтийн харилцаа
- Түншлэл буюу хамтын оролцоо
- Хоёр талын дотно холбоо
- Дотносол

Нөхөрлөл (нэгдэл) гэдгийг өөр олон үгээр тодорхойлж болох ч, тэдгээр нь мөн л дээрх тодорхойлолтын аль нэгтэй нь төстэй учраас, дээрх хэдийг шилсэн болно. Одоо үг тухай бүрийг тусгайлан авч үзье.

НӨХӨРЛӨЛ

Нөхөрлөл гэдэг эхний үгийг Уэбстерийн толь бичиг дээр *ханьсал* буюу *хань* гэж тодорхойлжээ. Түүнчлэн *андлан нөхөрлөх байдал, чанар* гэдэг. Хань нөхөд чинь хоорондоо харилцахгүй байна гэж хэзээ ч үгүй бөгөөд одоо хийж байгаа, ирээдүйд хийх зүйлийнхээ талаар хэн хэндээ мэдүүлдэг. Анд нөхдийн хооронд үргэлжийн тууштай харилцаа тогтоно. Ариун Сүнс - Түүний зарц нарын харилцааг Үйлс ном дээр ахин дахин үлгэр жишээ болгон өгүүлдэг. Тухайлбал, Паулын ганц мэдэгдлийг жишээ болгоё:

Үзтүгэй, эдүгээ би Иерусалим уруу Сүнсээр хүлүүлэн явж байхдаа ч надад тэнд юу тохиолдохыг мэдэхгүй. Зөвхөн хүлээс болон зовлон намайг *хот бүрд* хүлээж байгаа гэдгийг Ариун Сүнс надад гэрчилдэг (Үйлс 20:22-23, тодруулгыг нэмэв).

Ариун Сүнс, Паул хоёрын харилцааг Паулын өөрийнх нь үгээс л харж болохоор байна. Тэр хоёр амьдрал, аялал, үйлчлэлийн анд нөхөд байжээ.

Ер нь Шинэ гэрээний Эзэний зарц бүр ингэж л амьдарсан байдаг. Тэд хаашаа ч явсан Ариун Сүнсийг л харж, Ариун Сүнс ч тэдэнтэй хамт явж, харилцдаг байв. Ариун Сүнс тэдний хань байжээ. Өөр нэгэн дагалдагч - Филип хотыг хамарсан цуглаанаа дуусгаад, цөл рүү аялахдаа, ганцаардах юмуу яахаа мэдэхгүй мухардаагүй. Учир нь Ариун Сүнс түүнд: “Тэр тэргийг гүйцэн оч” (Үйлс 8:29) гэсэн байдаг.

Петр ч бэрх үзэгдлийг тайлах хэмээн мэрийхдээ, Бичээсийн талаарх өөрийнхөө ойлголтод найдах шаардлагагүй байв. Учир нь Ариун Сүнсний дуу: “Бурханы цэвэршүүлснийг чи байдаг юмд тооцох ёс байхгүй” хэмээн

айлдсан. Тэгээд цааш нь “Сүнс түүнд -Үзэгтүн, гурван эр чамайг хайж байна. Бос, доош буугаад эргэлзэлгүй гэдэн дээр оч. Учир нь Би тэднийг илгээв гэжээ” (Үйлс 10:19-20, тодруулгыг нэмэв) гэдэг.

Лук “Азид үг тунхаглахыг *Ариун Сүнс хориглосон* тул тэд Фруг болон Галатын нутгаар дайран өнгөрч, Мусиад ирээд Битун явахаар завдан байтал Есүсийн *Сүнс зөвшөөрсөнгүй* (Үйлс 16:6-7, тодруулгыг нэмэв) хэмээн бичсэнээс үзбэл, Паулын багийнхантай бүгдтэй нь хамт байсан Ариун Сүнсний ханилгааг үзэж болно.

Би ийм жишээ олныг хэлнэ. Гэхдээ, хамгийн гол нь Шинэ гэрээний зарц нар Бурханы байнгын ханилгаагаар Сүнс тэдэнтэй хамт буйг сайн мэддэг байснаас гадна Ариун Сүнстэй харилцан холбогдох нь ерөөсөө ч айж гайхмаар этгээд явдал байгаагүй ажээ. Бид долоо хоногийн 24 цаг хамт амьдардаг хүнийхээ оролцоог амьдралдаа хүсэн хүлээдэг шиг, дагалдагч нар ч Ариун Сүнсний оролцоог амьдралдаа хүсэн хүлээдэг байжээ.

Хүмүүс намайг ингэтэл их аялахдаа, өрөөндөө ганцаараа уйддаг эсэхийг байнга асуудаг. Тэгэхээр нь би: “Ерөөсөө ч уйддаггүй” гэж л хариулдаг. Үнэндээ би Ариун Сүнстэй нөхөрлөөд сөхөөгүй байдаг болохоороо, энэ дэлхийн хамгийн л гэгдэх үзэсгэлэнтэй хотод очихдоо ч, хоттой танилцах сонирхол төрдөггүй юм. Гэтэл урьд нь Ариун Сүнсний нөхөрлөлийг ойлгодог ч үгүй, мэддэг ч үгүй байхдаа, уйдаг шиг муухай юм байхгүй, дандаа л хүмүүстэй байх дуртай байлаа. Харин одоо бол, Ариун Сүнсийг амархан сонсож, амархан ярилцахын тулд ганцаараа байхыг л чухалчлах болсон.

Тантай нөхөрлөх нь Ариун Сүнсний хүслэн! Одоо хэсэг нүдээ аниад, Ариун Сүнсийг өөрийнхөө хань нөхөр, анд нөхөр гээд бод доо. Учир нь Бурханы Үг “Ариун Сүнсний *нөхөрлөл (нэгдэл)* чамтай хамт байг” гэсэн. Эсвэл “Ариун Сүнсний *андлал* чамтай хамт байг”, “Ариун Сүнсний *ханилгаа* чамтай хамт байг” гэж болно. Эдгээр үгс таны зүрхэнд тэлж, Эзэн, та хоёрыг дотносуулах үүдийг нээх болтугай.

ХООРОНДОО ХУВААЛЦАХ

Хоорондоо хуваалцах буюу *нийтийн харилцаа* гэдэг хоёрдугаар тодорхойлолт нь бодол, мэдрэмжийн солилцоо юм. Дотно найзуудтайгаа зүрхнийхээ угаас ярилцаж, уушги зүрхээ уудлах шиг баялаг зүйл хүнд байхгүй. Тэр үед хүн танихгүй этгээд сонсбол, буруугаар ойлгох юмуу доог шоог хийж мэдэх, нарийн нандин юмсаа хуваалцдаг болохоор, тун эгзэгтэй нөхцөлд ордог. Гэхдээ дотно нөхөд гэдэг өөр. Дотно

нөхөд бидний зүрхийг мэддэг учраас, нарийн нандин юмсыг маань буруугаар эргүүлэх явдал гаргахгүй. Паул “Би худал яриагүй, Христ дор үнэнийг хэлж байна. Миний мөс чанар *Ариун Сүнсээр* надад гэрчилж байгаачлан...” (Ром 9:1-2) хэмээн бичихдээ, Ариун Сүнтэй яг л ийм харилцаатай байдгаа илэрхийлжээ. Ариун Сүнс Паулын зүрхийг мэддэг, Паул ч Ариун Сүнсний зүрхийг мэднэ. Тэдний дотносол нь хоорондоо хамгийн гүн бодол, мэдрэмжээ хуваалцах явдлаас л хөгжин боловсорчээ.

Тиймээс л Эзэнээс эмээхүй нь амин чухал байдгийг дахин хэлье. Бид үнэт сувдийг найдваргүй этгээдэд өгөхгүй шиг, Эзэн ч нандигнахыг мэддэггүй хүмүүстэй гүний бодлоо хуваалцахгүй. Бид амьдралынхаа нарийн нандинг өөдгүй хүмүүстэй хуваалцахгүйтэй л адил.

Хуучин гэрээ “Бурханы гүн гүнзгийг чи олж чадах уу...” (Иов 11:7) хэмээн хашхирсан байдаг. Тэгвэл Шинэ гэрээтэй цуг Ариун Сүнтэй дотносох үүд нээгдсэн тул Паул: “Тэвч Бурхан үүнийг *Сүнсээр* бидэнд илчилсэн юм. Учир нь Сүнс бүх зүйлийг, тэр байтугай Бурханы *гүн* юмсыг ч гэсэн нягталдаг ажгуу” (1Коринт 2:10, тодруулгыг нэмэв) хэмээн баясалтайгаар хэлжээ. Бурханы Сүнсээр гэсэн байгааг тэмдэглээрэй. Ариун Сүнс - бидэнтэй Бурханы дотно, гүн юмсыг хувцаалцдаг, Бурханы Гурвалын нэг мөн! Энэ үг таныг баясахгүй байна гэж үү? Ёстой гоё!

Тэгэхээр, нүдээ аниад Ариун Сүнс тантай ч ингэж дотносохыг хүсдэг гээд бод доо. Ариун Сүнс танд Бурханы гүний гүн бодол, мэдрэмжийг харуулаад, эргээд таныхыг ч сонсохыг хүсдэг. Учир нь Бурханы Үг “Ариун Сүнсний *бодол, мэдрэмжийн хуваалцал* чамтай хамт байг” гэдэг.

ТҮНШЛЭЛ

Түншлэл буюу хамтын оролцоо хэмээх гуравдугаар тодорхойлолт нь эртний чуулганы удирдагч нарын гэрчлэлээр яруу тод жишээлэгджээ. Тэд захидалдаа ингэж бичсэн байн:

Учир нь Ариун Сүнс болон бидэнд эдгээр зайлшгүй зүйлсээс өөр илүү ачааг та нарт үл тохох нь зүйтэй хэмээн санагдаж байна. (Учир нь үүнийг Ариун Сүнс ч, бид ч сайн хэмээн үзэв) (Үйлс 15:28).

Тэд Ариун Сүнсний бодлыг ч, өөрсдийнхөө бодлыг ч тодорхой харуулжээ. Энэ нь хамтын шийдвэр бөгөөд тэд Хаанчлалын үйл хэргийн түншүүд байв. Үүнийг Бурхан Содомын төлөвлөгөөг хэлэлцэхээр

Абрахам дээр ирсэн Хуучин гэрээний түүх тусгадаг. Бурхан Абрахамд үзэл бодлоо нэмэрлэхийг зөвшөөрсөн бөгөөд Абрахамын зөвлөгөөг сонсоод, эцсийн шийдээ гаргасан юм.

Ийм явдал Мосед ч хэд хэд тохиолдсон. Эзэн хилэгнэсэндээ Израилийн хүүхдүүдийг устгах шахсан бөгөөд Мосегийн зөвлөгөө байгаагүй бол, утсгаж л орхих байв. Мосе Бурханд амлалтыг нь бас нэр төрийг нь сануулсан бөгөөд нэг удаа Мосегийн оролцооны улмаас “ЭЗЭН ард түмэн дээр буулгана гэж айлдсан хөнөөлт санаагаа өөрчилжээ” (Гэтлэл 32:14) гэдэг. Мосе, Абрахам хоёрын хэн, хэн нь Бурханы түншүүд байсан ч, Шинэ гэрээний хангамж дор бидэнд заяагдсан байнгын нөхөрлөл тэдэнд ч заяагаагүй билээ. Ингэж бодохоор үнэхээрийн эрүү мултармаар болох.

Ефесийн удирдагч нарт хандсан Паулын үгээс бидний тэргүүн түнш болох Ариун Сүнсний үүргийг гэрчилнэ:

“Бурхан *Өөрийн цусаар* Өөртөө өмчилж авсан Бурханы чуулганыг хариулуулахаар *Ариун Сүнс* та нарыг харгалзагч болгосон бөгөөд та нар өөртөө болон бүх сүрэгт анхаарал тавь” (Үйлс 20:28, тодруулгыг нэмэв).

Энэ эшлэл дээр Бурханы Гурвалыг тус тусад нь нэр дурьдсан боловч, тэд төгс нэгдэлтэй байх нь тодорхой харагдаж байна. Эхлээд *цусаараа* худалдаж авсан хэмээн Хүүгийн үүргийг хэлээд, дараа нь *Бурханы чуулган* хэмээн Аавыг дурьдаад, эцэст нь тэднийг харгалзагч болгосон Ариун Сүнсний талаар өгүүллрүүн. Гурван тусдаа бие атлаа нэг Бурхан. Ойлгоход жаахан бэрх. Гэхдээ үүнийг байгалийн нэгэн жишээгээр амархан дүрсэлж болом. Ус нь хатуу, шингэн, уур гэсэн гурван хэлбэртэй байж чаддаг ч, нэг л молекулын бүтэцтэй байдаг. Үүнтэй адил Бурханы Гурвал ч гурван бие атлаа төгс нэг Бурхан болой.

Бурханы Гурвал дундаас Ариун Сүнс л удирдагч нарыг байр сууринд нь тавьсан нь бас л сонирхолтой. Яг ийм явдал Антиох хэмээх өөр нэгэн чуулганы удирдагч нар Эзэнийг эрэлхийлэх үед бас тохиолддог. “Тэднийг Эзэнд үйлчилж, мацаг барьж байх үед Ариун Сүнс —Миний дуудсан үйлчлэлд Барнаб, Саул нарыг надад тусгаарлагтун гэв. Тэгээд тэд мацаг барин залбирч, тэдэн дээр гар тавиад, явуулжээ. Ийнхүү *Ариун Сүнсээр илгээгдсэн тэд* Селюкт ирж, тэндээсээ Кипр уруу усан онгоцоор явав” (Үйлс 13:2-4, тодруулгыг нэмэв). Мөн л Бурханы Гурвал дундаас Ариун Сүнс л Есүсийг алдаршуулахын төлөө тэр эрчүүдтэй гар нийлж ажиллажээ.

Дээрх жишээнээс тодорхой түншлэл харагдаж байгаа бөгөөд удирдагч буюу тэргүүн түнш нь Ариун Сүнс байжээ. Би нэг зүйлийг дахин хэлмээр байна: Ариун Сүнс бидэнтэй хамтран зүтгэж, түншлэхийг туйлаас хүсэх! Паул ч үүнийг: “Учир нь бид Бурханы хамтран зүтгэгчид бөгөөд та нар Бурханы тариан талбай, Бурханы барилга мөн” (1Коринт 3:9) хэмээн Коринтод бичсэн захидалдаа тодорхой хэлсэн. Хамтрагч гэдэг нь *анд нөхөр* юмуу *холбоотон* гэсэн утгатай. Үүнийг Кинг Жэймс Вержн Библи бүр тодорхой хэлсэн: “Бид Бурхантай хамт хөдөлмөрлөгчид билээ.” Тэгэхээр, өөр хоорондоо харилцдаггүй, хамтарч ажилладаггүй анд нөхөд байдаг эсэхийг би дахин асууя?

Таны тэргүүн түнш байх Ариун Сүнсний хүслийг дахин нэг эргэцүүлнэ үү. “Ариун Сүнсний *түншлэл* чамтай хамт байг” эсвэл “Ариун Сүнс та бүхний бүх зүйлд *хамтран оролцох* болтугай”.

ХОЁР ТАЛЫН ДОТНО ХОЛБОО

Дараагийн тодорхойлолт нь *хоёр талын дотно холбоо* юм. Үүнийг Бурханы эрчүүд, эмэгтэйчүүдээс харсан, олон жилийн туршлага маань хамгийн сайн дүрслэх байх. Дэлхийн хамгийн том чуулганы нэг болох Солонгосын чуулганы пастор Ёнги Чотой анх хэрхэн уулзсанаа би хэзээ ч мартаггүй. Доктор Чо манай чуулганд анх зочилсон юм. Тэр үед би туслах пастораар үйлчилдэг байсан бөгөөд Доктор Чог зөөвөрлөх үүрэгтэй байв. Миний бие энэ ажлыг олон ч жил хийж, манай чуулганд зочилсон зуу зуун үйлчлэгчийг тосч авсан туршлагатай байлаа. Гэвч энэ удаагийнх нэг л өөр байв. Учир нь Доктор Чог машинд суухад, Эзэний оршихуй хамт орж ирж билээ. Тэр дороо өөрийн мэдэлгүй аньсага чийгтээд л, хацраар нулимс бөмбөрөөд л явчихав. Би тэр эрхэм хүнийг үйлчлэхээс нь өмнө түвэг болохыг хүсээгүй тул чимээгүй уйлж явсан ч, сүүдээрээ биеэ барьж дийлэлгүй: “Доктор Чо, манай машинд Бурхан байна” хэмээн шивнэгнэх төдий хэлтэл, Доктор Чо мишээснээ, толгой дохиж билээ.

Гэтэл тэр эрхэм Ариун Сүнстэй нөхөрлөх хичнээн дуртай тухайгаа байнга бичиж, номносон байдгийг бүр хожим ухаарсан юм. Тэгээд тэр үйлчлэлийг хийх хугацаанд миний зөөж явсан олон хүн Ариун Сүнстэй тогтоох дотно харилцааг цохон тэмдэглэж, түүнийхээ дагуу амьдардаг байсныг ч санах. Би зуугаас олон үйлчлэгчийг зөөвөрлөж явсан ч, тоотой хэдхэнтэй нь уулзахад л Ариун Сүнсний оршихуй мэдрэгдэж байсан сан. Тийм хүний нэг нь Эзэн рүүгээ яван явтлаа олон жил зуучлан залбирах үйлчлэл хийсэн хагагтай Жийнне Уилкерсон байлаа.

Тэр хатагтайг чуулганы машинд суухаас авахуулаад, зорьсон газарт нь хүргэж өгтлөө би эрүүгээ мултартал биширч билээ. Жолоон дээрээ төвлөрөхөд ч хэцүү байв. Би Бурханыг мэддэг төдийгүй, маш дотно мэддэг хатагтайтай хамт яваагаа ухаарсан сан. Уулзах бүрий, тэрбээр Ариун Сүнсний тухай маш их ярих бөгөөд Ариун Сүнсний оршихуй ч маш бодитой бөгөөд хүчтэй байна.

Миний бие саяхан Америкийн Баруун хойд мужийн дөрвөн мянган хүнтэй чуулганд заасан юм. Бүтэн сайны өглөө нь Ариун Сүнсний тухай номлочихоод, оройны цуглаан дээр дөчин таван минут номлох төлөвлөгөөтэй байв. Гэтэл цуглаан дууссанаас хоёр цагийн дараа л надад микрофон барих боломж олдсон юм. Учир нь Ариун Сүнс өөр төлөвлөгөөтэй байжээ. Ариун Сүнс үй олон хүнд үгээр илэрхийлэшгүй гайхамшигтай үйлчлэв! Эцэст нь намайг тайзан дээр урихаасаа өмнө тэр цуглааны булиа том пастор (тэрбээр хэвтээгээс 200 кг шахдаг байв) асгартал уйлсаар хүрч ирээд: “Жон, би энэ чуулганд найман жил үйлчлэхдээ, Бурханы оршихуйг ийм хүчтэй үзээгүй!” гэж билээ.

Би ч өөдөөс нь: “Энэ чинь учиртай. Өглөө бид Ариун Сүнсний тухай ярьсан шүү дээ. Харин Түүний тухай ярих бүрийд Тэрбээр Өөрийгөө үзүүлдэг” гэж хариулсан юм.

Хоёр талын дотно холбоог гэрлэлтийн амьдралаас харж болох. Зарим эрэгтэй номлогчид гэргийнхээ тухай маш их ярьдаг. Хол байгаа гэргийгээ байнга номлол, яриандаа дурьдаж, багтаана. Тэд амьдрал дээр төдийгүй, олон нийтийн нүдэн дээр ч үргэлж хамт явна. Тиймээс тэр номлогчийг бодохоор гэргий нь ч заавал санагдана. (Эсрэгээрээ, номлогч гэргий нь эр нөхрөө байнга дурьдаж ярьдаг тохиолдол дээр ч ялгаагүй юм.) Би ч Лизагийн тухай үргэлж ярих юмуу бичдэг учраас, намайг ганцаараа явж байвал, хүмүүс байнга Лизаг асуудаг. Гэтэл нөгөөтэйгүүр, гэр бүлтэй атлаа гэргийнхээ тухай нэг их ярьдаггүй, хамт ч нэг их явдаггүй үйлчлэгч нар ч бий. Тэр хүмүүсийг бодох үед гэргий нь огт санагдахгүй.

Тэгвэл Ариун Сүнсний тухайд ч ялгаагүй юм. Бурханы Сүнстэй хоёр талын дотно холбоотой Бурханы хүүхдүүд байна аа. Тийм хүмүүсийн тухай ярихаар, шууд Ариун Сүнс бодогдоно. Учир нь тэр эрчүүд, эмэгтэйчүүд ямагт Ариун Сүнсний залуу түншүүд шиг хамтран үйлчилж, ямагт Ариун Сүнсийг хүлээн зөвшөөрдөг тул Ариун Сүнс ч тэдний үйлчлэлээр үзэгддэг. Ариун Сүнс Есүсийг алдаршуулдаг учраас, үр дүнд нь Есүс улам л хүндлэгдэнэ.

Ариун Сүнс тантай хоёрын талын дотно холбоотой байхыг хүснэ. Ариун Сүнсийг хүндэтгэх үед Ариун Сүнс Өөрийгөө илэрхийлдэг бол,

хүндэтгэхгүй аваас, олон жил ханилсан гэргийтэйгээ ямар ч дотносол байхгүй үйлчлэгчийн амьдралтай л адил болно. Тэд хоорондоо хол хөндийгөөс гадна олны нүдэнд ч хөндий хүйтэн харагдах. Тиймээс үүнийг эргэцүүлнэ үү: “Ариун Сүнсний *дотно холбоо* чамтай хамт байг”.

ДОТНОСОЛ

Жагсаалт дээрх сүүлчийн тодорхойлолт нь *дотносол* юм. Энэ үг нь бидний өмнө ярилцсан дөрвөн ангиллыг бүгдийг нь базаж байгаа гэдэг утгаараа нөхөрлөлийг (нэгдлийг) хамгийн сайн дүрсэлнэ. Үнэндээ *нөхөрлөлийг* (нэгдлийг) Уэбстерийн толь бичиг дээр *дотно нөхөрлөл буюу харилцан ойлголцол, харилцаа* хэмээн тодорхойлдог. Дотносол нь бат бэх нөхөрлөлийн дэвсгэр бөгөөд гагцхүү харилцаан дээр л үндэслэж хөгжинө. Шинэ гэрээний нэгэн хувилбар дээр: “Ариун Сүнсний *дотно нөхөрлөл* та бүгдтэй хамт байг” гэдэг (*Мессеж Библи*).

Дахиад л бүх зүйл нөхөрлөл дээр бууж байгаа бөгөөд нөхөрлөл нь нэгдлийн эцсийн зорилго ажээ. Бурханы Сүнс таны найз байхыг хүсдэг. Таны нөхөрлөлийг улайран хүсдэг. Мэддэг зүйлээ танд заахыг хүсдэг бөгөөд Түүний мэдлэг ч хязгааргүй! Тэр Бурхан бөгөөд Түүнээс нуугдмал, нууцлаг юм үгүй. Түүнд байхгүй мэдлэг байхгүй. Исаиа дээр:

Хэн ЭЗЭНий Сүнсийг удирдаж эсвэл Зөвлөх нь болж
Түүнийг сургасан бэ? Тэр хэнтэй зөвлөлдөв? Хэн Түүнд
ухаарлыг өгч, Шударга ёсны замыг Түүнд зааж, Мэдлэгийг
сургаж, ухаарлын замыг мэдүүлсэн бэ? (Исаиа 40:13-14,
тодруулгыг нэмэв) гэдэг.

Хариулт нь: Хэн ч биш. Учир нь тэр Бурхан!

Би дахин хэлье: Тэр Бурхан! Түүний цэц ухаан, мэдлэг, ойлголт хязгааргүй бөгөөд Тэр бидэнд мэддэг бүхнээ зааж өгөхийг хүсдэг. Бодоод үз дээ: Хүн үнэ цэнэтэй юм мэдэж авахаараа, дотны, хайртай хүмүүстэйгээ хуваалцахын хүслэн болдог. Тэгвэл Ариун Сүнс ч ялгаагүй. Тэр мэддэг зүйлээ Тантай хуваалцахыг хүсэх! Танд ямар боломж байгааг харж байна уу? Та өөрийнхөө дотор амьдардаг Бурханы Гурвалын Нэгэний араас явдаггүй учраас, ихийг алдаж байгаа юм биш биз? Та Ариун Сүнснээс гадуур Есүстэй харилцаа тогтоох гэж үзээд байгаа юм биш биз?

Чуулганы олон хүн Ариун Сүнстэй дотно харилцаа тогтоолгүйгээр, Есүстэй дотносох гэж үздэг. Энэ талаар саяхан бодож байгаад, Есүсийн газар дээрх үйлчлэлийн үед Иүдейчүүд Есүсээс гадуур Бурхантай дотно харилцаа тогтоохыг хүсч байсныг ойлгосон юм. Тэд “Бидэнд Бурхан хэмээх нэг л Эцэг байгаа” (Иохан 8:41), “... бид Мосегийн дагалдагчид. Мосед, Бурханы айлдсаныг бид мэднэ” (Иохан 9:28-29) гэх зэрэг мэдэгдэл их хийдэг байсан. Тэд Бурхантай тогтоогоогүй харилцаандаа бат итгэлтэй байв. Тэд Мосегоор өгөгдсөн Бурханы Үгийг (Бичээсийг) мэддэг учраас, ийнхүү бат итгэлтэй байжээ. Гэвч, тийм гэж үү? Өөрсдийнх нь дунд махан биеэр ирээд, зогсож буй нөгөө Үгийг тэд хүлээж авахаас татгалзсан юм.

Өнөөдөр ч Есүст итгэдэг олон хүн Ариун Сүнснээс гадуур Есүстэй харилцаа тогтоохыг хүсдэг. Гэтэл бидний дунд зогсож байгаа нэгэн болох Ариун Сүнснээс гадуур хэн ч Есүсийг мэдэж чадахгүй бөгөөд Иүдейчүүд Есүсийг үл тоож байсан бол, бидний хувьд махан бие, цусгүй Ариун Сүнсийг үл тоох нь бүр ч амархан байдаг нь байдлыг улам л ээдрээтэй болгодог.

Есүс “Та нар Намайг мэдсэн бол Эцэгийг минь ч мөн мэдэх болно” (Иохан 14:7) гэсэн. Есүс ердөө л “Аав энд байхгүй, тэнгэрт байгаа. Гэхдээ та нар Намайг мэдэх аваас, Аав бид хоёр нэг учир, Аавыг минь ч мэднэ” гэж л хэлжээ. Тэгвэл Ариун Сүнсний тухайд ч ялгаагүй юм. Есүс одоо энд байхгүй, тэнгэрт байгаа ч, та нар Ариун Сүнсийг мэдэх аваас, Есүс, Ариун Сүнс хоёр нэг учраас, Есүсийг ч мэднэ! Тиймээс л Ариун Сүнсийг мөн “Христийн Сүнс” гэдэг (1Петр 1:11, Ром 8:9).

НАДТАЙ АДИЛХАН ӨӨР НЭГЭН

Есүс дагалдагч нараасаа явахаасаа өмнө ингэж айлджээ:

Та нар Намайг хайрладаг бол тушаалуудыг минь сахь. (Тэгээд) Би Эцэгээс гуйхад Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. Тэр бол үнэний Сүнс бөгөөд Түүнийг харахгүй мэдэхгүйгээсээ болж ергөнц Түүнийг хүлээн авч чадахгүй. Тэр та нартай хамт байх бөгөөд та нарын дотор байх тул та нар Түүнийг мэднэ. Би та нарыг өнчрүүлж орхихгүй. Би та нар уруу ирнэ (Иохан 14:15-18).

Энэ хэдхэн мэдэгдэл дотор өчнөөн зүйл агуулагдаж байна. Нэгдүгээрт - Есүс дуулгавартай байдлын тухай “Миний тушаалыг сахь” гээд, араас нь “Тэгээд Би Ааваасаа гуйхад, Тэр та нарт өөр Туслагчийг өгнө” гэжээ. Есүс Ариун Сүнсийг хүлээж авахыг Түүний Үгд дуулгавартай байхтай буюу үүнчлэн Эзэнээс эмээхүйтэй шууд холбож байна. Үүнийг Петр ч “Эдгээрийн гэрч нь бид төдийгүй, Түүнд дуулгавартай байгсдад Бурханы өгсөн Ариун Сүнс юм” (Үйлс 5:32, тодруулгыг нэмэв) хэмээн багатгасан. (Мөн л дагалдагч бөгөөд хоёрдугаарт - Ариун Сүнс гэсэн хоёр өөр гэрчийг дурьдсан, нөхөрлөл яригдаж байгааг тэмдэглээрэй.) Бурхан Өөрийг нь *дуулгавартай дагадаг* хүнд Ариун Сүнсээ өгдгийг Петр хэлжээ. Тэгэхээр, дотнослын суурь нь Эзэнээс эмээхүй л байна. Тэгээд яагаад бид үүнийг үл номлоно вэ?

Иохан 14-ийг эргэж харбал, Бурханаас эмээдэгт Бурхан “*өөр Туслахыг*” өгөхийг Есүс хэлжээ. Шинэ гэрээн дээр Англиар *өөр* хэмээн буулгасан үгийн цаана хоёр төрлийн Грек үг байдаг. Тэр хоёрыг судласнаар, Ариун Сүнсийг улам ихээр мэдэх боломжтой. Эхний Грек үг нь *аллос* буюу “ижил төрлийн өөр нэгэн” гэсэн утгатай бол, нөгөөх нь *хетерос* буюу “өөр төрлийн өөр нэгэн” гэсэн утгатай. Энэ хоёрын ялгааг дараах жишээгээр тайлбарлаж болох байх: Та надаас жимс гуйсанд, би танд тоор жимс өгөв. Та идэж дуусгаад, дахиад жимс гуйсан тул, бид танд алим жимс өгөв. Би танд ялгаагүй л жимс өгсөн боловч, өөр төрлийн өөр нэгэн жимс өгчээ. Харин би танд ахиад тоор өгсөн бол, өмнө өгсөнтэйгээ адил - ижил төрлийн өөр нэгийг өгөх байж. Энэ жишээ танд *хетерос*, *аллос* хоёрын ялгааг ойлгуулсан байх аа гэж найдъя.

Тэгвэл Есүс *аллос* буюу *ижил төрлийн* өөр нэгэн гэдэг үгийг хэрэглэжээ. Есүс “Ариун Сүнс яг Надтай адилхан” л гэжээ. Үнэндээ Туслахыг Грекээр *параклетос* гэдэг. Энэ нь *пара* буюу “дэргэд”, *калеүү* буюу “дуудах” гэсэн хоёр өөр үгийг нийлүүлсэн үг ажээ. Үүнчлэн *параклетос* нь *хэн нэгэнд туслахаар дэргэд нь дуудагдсан нэгэн* гэх утгатай болж байна. Энэ үг нь анх хуулийн тусламж, өмгөөллийн зөвлөгөө, өмгөөллийг тэмдэглэхээр шүүхийн танхимд хэрэглэгдэж эхлээд, дараа нь амьдрал дээр хүний хэргийг батлан даах, зуучлах, өмгөөлөх зэрэг ерөнхий хэрэглээнд оржээ. Энэ үгийг захидал дээр Есүст хамаатуулж ганцхан удаа хэрэглэсэн байдаг нь басхүү сонирхол татмаар (1Иохан 2:1). Тиймээс Есүс бидний Өмгөөлөгч, Зуучлагч байхаар амьдарсаар байгаа шиг, Ариун Сүнс ч ялгаагүй бидний Өмгөөлөгч ажээ. Тэрбээр бидэнд туслахаар дэргэд минь дуудагджээ.

Есүс дагалдагч нартаа: “Би та нартай хамт байсан шиг, Ариун Сүнс та нартай тийнхүү хамт байна” гэдгийг л хэлжээ. Хүмүүс юм л бол:

“Өө, Есүс байсан бол, Түүнээс зөндөө юм асуух сан” гэж ярьдаг. Гэхдээ, тийм гэж үү? Тэд үүгээрээ Ариун Сүнснээс ямар хол хөндий болохоо л илэрхийлж байгаа юм. Бурханы Сүнстэй нөхөрлөдөг хүн юу гэж л Ариун Сүнсний оронд Есүс байсан бол, дээр байх байсан юм гэж бодох вэ дээ? Үнэндээ Есүс дараах зог тусмаар үгийг хэлсэн байдаг:

Гэхдээ Би та нарт үнэнийг хэлж байна (Иохан 16:7).

Есүсийн мэдэгдлийг гүйцээж ярихаасаа өмнө Есүсийг энэ мэдэгдлээ хийхээс өмнө нь болж өнгөрсөн үйл явдал намайг үргэлж гайхшруулдгийг хэлмээр байна. Есүс дагалдагч нартайгаа гурван жил хагас хамт явсан. Есүс тэдэнд нэг ч худал, зальжин санаа хэлээгүй. Энэ хугацаанд Есүсийн хэлсэн бүхэн биелэх байв. Тийм боловч, Есүс одоо дэндүү гайхмаар үг хэлэх шаардлагатай болсон тул: “Залуус аа, Миний хэлэх гэж байгаа зүйл худал бус, үнэн шүү!” хэмээн урьдаас анхааруулах ёстой болжээ. Тэгэхээр, мөнөөх зог тусмаар мэдэгдлийг дахин харцгаая:

Гэхдээ Би та нарт үнэнийг хэлж байна. Миний явах нь та нарт дээр. Би явахгүй бол Туслагч та нар дээр ирэхгүй.
Харин Би явбал Түүнийг та нар дээр илгээнэ (Иохан 16:7).

Пөөх. Есүсийн энэ үгийг хэсэг эргэцүүлж үзнэ үү. Тэрбээр явах нь дагалдагч нарт л ашигтай гэнэ. Одоо л Есүс яагаад энэ үгийнхээ өмнө “Залуус аа, Би та нарт үнэнийг хэлж байна” гэж хэлэх ёстой байсныг ойлгов уу? Есүс дагалдагч нартай хамт байхдаа, хэн хүнд хэлээгүй, хаанчлалын хамгийн л гүн гүнзгий юмсыг зааж өгсөн. Есүс өвдсөнийг эдгээсэн, үхсэнийг амилуулсан, тамлагч сүнснийг зайлуулсан, өр төлбөр, татварыг нь төлсөн бөгөөд энэ бүхэн нь дөнгөж эхлэл байв. Тийм боловч, Есүс явах нь дагалдагч нарт л ашигтай гэх! Яагаад вэ? Хариулт нь: Есүс явбал, Туслагчийг илгээх ажээ.

Бодоод үз дээ: Есүс газар дээр үлдсэн бол, бид Түүнтэй нөхөрлөж, юм асуухыг хүсэхдээ, онгоцоор Тел Авив руу нисээд, Галилын хөдөөд очоод, Есүсийг олж уулзах шаардлагатай болно. Энэ хэцүү биш. Угаасаа Түүнийг мянга мянган хүн бүчээд л байж байгаа. Гэхдээ та Түүн дээр хүрч очихын тулд таны өмнө байгаа мянга мянган хүнийг явж дуустал нь хүлээх шаардлагатай болно. Гэтэл хажуугаар нь бас манай хэл ам нь гүйцэгдэхгүй Петр бүх ярианд хэн хүнээс илүү хошуу нэмэрлэж, цаг сунгана. Дээрээс нь бас л дутахгүй дуу шуутай, алдарт аянган хөвгүүд Иаков, Иохан хоёроос гадна бодож санасан юмсаа асуух завшааныг

отох бусад дагалдагч нар бүрэн бүрэлдэхүүнээрээ байлцана. Хажуугаар нь Есүс маань шөнө 6-8 цаг унтах ёстойгоос гадна идэх, уух гээд л хувь хүнийхээ хэрэгцээнд анхаарах шаардлагатай.

Тэгвэл бидний дотор амьдардаг Ариун Сүнсний хамгийн сайхан нь Тэрбээр огт унтдаггүй. Та Түүнтэй өдөр, шөнийн алинд ч, хэдэн цагт ч ярьж болох бөгөөд бусдыгаа дуусахыг хүлээх шаардлагагүй. Тэр танд цаг үргэлж бүтэн анхаарна. Үнэндээ, Ариун Сүнтэй нэгэн зэрэг арван мянган хүн ч дотночлон ярьж чадна! Ариун Сүнс өлссөн хүнтэй хувьчлан харилцах чадвартай. Ингээд ч дуусахгүй, бүр ч сонирхолтой болж ирнэ. Учир нь Есүс:

Та нарт хэлэх зүйл Надад олон бий ч та нар одоо түүнийг дааж эс чадна. Харин үнэний Сүнс ирэхдээ та нарыг бүхий л үнэн өөд удирдана. Тэр Өөрөөсөө биш харин алив сонсох юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ. Тэр Минийхийг авч та нарт мэдүүлэх учир Намайг алдаршуулна. Эцэгт буй бүхэн Минийх. Тиймээс “Тэр Минийхийг авч та нарт мэдүүлнэ” гэж Би хэлсэн билээ (Иохан 16:12-15) хэмээн айлджээ.

Ариун Сүнс бидэнтэй ярихад, үндсэндээ Ааваас бидэнд хандсан Үг болох Есүс л ярьж байгаа ажээ. Тийм ээ, хэдийгээр Бурханы Гурвал нь тус тусын оюун ухаан, хүсэл, сэтгэл мэдрэмжтэй гурван тусдаа бие боловч, туйлын нэгдмэл ганц Бурхан юм. Тэд хэзээ ч зөрөлдөхгүй, зорилго, төлөвлөгөө, хүслийн гүйцэтгэл дээрээ хэзээд нэг цул байна. Бичээсийн тунхагийг санана уу: “Сонс, Израиль аа! ЭЗЭН бол бидний Бурхан бөгөөд ганц ЭЗЭН” (Дэд хууль 6:4).

ХАРИЛЦААНЫ ГУРВАН ТӨВШИН

Дээрх Бичээс дээр Есүсийн зүгээс дагалдагч нартаа илчлэх зүйл асар их байвч, дагалдагч нар нь дааж дийлэхгүй гэжээ. Дагалдагч нар Бурханы дотно юмсыг хүнийхээ мэдрэмжээр шингээж авах чадваргүй байжээ.

Есүс үхлээс амилуулагдсан хойноо, Томасыг эзгүй хойгуур арван дагалдагчдаа үзэгдсэн түүхийг санана уу. Есүс амьд байна хэмээн гэрчлэх бусдыгаа сонсоод, Томас: “Түүний гар дахь хадаасны сорвийг үзэж, хадаасны оромд нь хуруугаа хийн, Түүний хажуу уруу нь гараа хийж үзэхээс нааш би итгэхгүй” (Иохан 20:25) гэдэг.

Хожим Есүс дагалдагч нартаа дахин үзэгдэхдээ, шууд Томаст хандан Өөрийнх нь гарт хуруугаа, хавирганд нь гараа оруулж үзээд, итгэ гэдэг. Томас ч: “Эзэн минь, Бурхан минь!” гээд л дуу алдаад явчихсан. Тэр үед Есүсийн Томаст хэлсэн үгийг би олон жил ойлгодоггүй явсан юм.

“Чи Намайг харсан учраас итгэв үү? Хараагүй атлаа итгэсэн нь ерөөлтэй ээ!” (Иохан 20:29)

Есүс Томасыг “Эзэн минь, Бурхан минь” хэмээн дуу алдтал гэмшээд байхад ч, хайр найргүй хандаж, хатуурхжээ гэж боддог байлаа, би. Миний буруу ойлголт, хагас хугас мэдлэг л ийм буруу дүгнэлтэнд хүргэсэн байв. Гэтэл хожим Ариун Сүнс надад Есүсийн үгийг соён гэгээрүүлж өгсөн юм. Есүс Томаст хатуурхаагүй, ердөө бодит байдлыг л мэдүүлжээ. Товчхондоо, Есүсийг биеийнхээ мэдэрхүйгээр таньж мэддэг хүмүүс нь хэзээ ч Есүсийг сүнсээрээ мэдээд, үүнийхээ ачаар хожим илүү ихээр ерөөгдөх хүмүүсийн хэмжээнд хүрэхгүйг л хэлсэн байна.

Элч Паулыг л аваад үз. Паул Есүстэй Петр тэргүүтэй дагалдагч нар шиг хамт явж үзээгүй бөгөөд Ариун Сүнсний илчлэлээр л танилцсан. Паул ингэж бичжээ:

Ах дүү нар аа, миний тунхагласан сайнмэдээ нь хүнийх биш гэдгийг би та нарт мэдэгдэж байна. Би үүнийг хүнээс аваагүй, хүнээр ч заалгаагүй. Харин Есүс Христийн илчлэлээр хүлээж авсан билээ. Учир нь иудеизм доторх миний урьдын амьдралын хэв маяг болон хэрхэн Бурханы чуулганыг хэт хавчиж, устгахыг оролдож байсныг минь та нар дуулсан. Би өвөг дээдсийнхээ ёс заншилд дэндүү зүтгэгч байж, нутаг нэгт нас чацуутан олныхоо дунд иудеизмд илүүтэй товойж байсан юм. Харин эхийн хэвлийд байхаас минь сонгон тусгаарлаж, нигүүлслээрээ дуудсан Тэрээр намайг таалж, Хүүгээ миний дотор илчилснээр Түүнийг би харийнхны дунд тунхагладаг юм. Тэр даруй би мах цустай хэнтэй ч зөвлөсөнгүй, Иерусалим уруу, надаас өмнө элч байсан тэр хүмүүс уруу ч явсангүй, харин Арабт очоод, Дамаскт дахин нэг эргэж ирсэн (Галат 1:11-17).

Цаг хугацааны явцад Паул, Эзэн хоёрын харилцаа анхдагч элч нарын хэнийх нь ч хүрээгүй төвшинд гүнзгийрчээ. Энэ тухай Петр ч хэлсэн:

Хайрт ах Паул маань өгөгдсөн мэргэн ухааныхаа дагуу та нарт бичсэнчлэн бидний Эзэний тэвчээрийг аврал хэмээн тооц. Тэрчлэн түүний бүх захидалд эдгээрийн талаар бичсэн юм. *Захидлуудад нь ойлгоход хэцүү зарим зүйл байдаг* бөгөөд юу ч мэдэхгүй, туйлбаргүйчүүд Бичвэрийн бусад зүйлсийг гуйвуулдаг шигээ тэдгээрийг ч мушгин гуйвуулж өөрсдийгөө сүйрүүлдэг (2Петр 3:15-16, тодруулгыг нэмэв).

Пөөх! Эзэнтэй хэзээ ч хамт явж үзээгүй Паул Есүсийн мөн чанар, арга замыг Эзэнтэй гурван жил хагас хамт явсан Петрийн хувьд ч ухаан хүрэмгүй, өндөр төвшинд илчилжээ. Яагаад? Яагаад гэвэл, магадгүй Петр үзсэн, сонссон зүйлийнхээ дурсамж руу байнга эргэж буцдаг байсан нь цаашид Есүстэй харилцаагаа гүнзгийлэхэд нь саад учруулдаг байсан байх. Тиймээс л Есүс: “Зээ, та нарт хэлэх зүйл олон байвч, одоохондоо та нар даахгүй. Үнэний Сүнс ирэхдээ, та нарыг бүх үнэн рүү хөтөлнө” хэмээжээ.

Үүнийг нэг сулхан жишээ нь: (Мэдээж энэ нь бүрэн илэрхийлэл биш боловч, гэрэлтүүлэг болно хэмээн найдаж байна.) биеэрээ уулзаж үзээгүй хүндээ цахимаар дурлах явдал гэх үү. Ийм явдал маш их тохиолддог бөгөөд нэг нэгнээ биечлэн мэддэг хүмүүсээс ч хүчтэй хайрлаж, дурлах талтай.

Үнэндээ, энэ төрлийн харилцаа нь айл гэрийн амьдралыг сүйтгэхчидэг гэхээр, аюултай хүчтэй байгаа биз? Нэгэн оройн цуглааны дараа би шаналгаа зовлон нь нүүрэн дээр нь бичээтэй байгаа нэг залуу дээр очиж уулзсан юм. Тэрбээр гар дээрээ хоёр нялх хүүхэд тэвэрчээ. Би ч: “Та зүгээр үү?” хэмээн санаа тавьлаа.

Залуу: “Зүгээр биш ээ, сая гэргий маань цахимаар танилцсан залуутайгаа зугтчихлаа” гэв.

Гэргий нь хэзээ ч биечлэн уулзаж үзээгүй залуугийнхаа төлөө түүнийг төдийгүй, дундаасаа гаргасан зургаан хүүхдээ ч хаяад явжээ. Тэр хоёр цахимаар учраад, аймшигтай хүчтэй дурласан учраас, хүүхэн нь төрсөн үрсээ хаяхдаа тулжээ.

Үүнийг эерэг талаас нь авч ярьбал, зарим тохиолдолд холын зайнаас дурлалцаж, харилцсан хүмүүс нь байнга биеэрээ хамт байдаг хүмүүсээс илүү гүн гүнзгий төвшинд дотносох талтай байдгийг би анзаарсан. Цаана нь мөн л шалтгаан оршино: тэд бие махбодын төвшний харилцааг даваад, сэтгэлээрээ ойртжээ. Биеэрээ үерхдэг хүмүүсийн биет тал нь дарангуйлдаг учраас, гадаад үзэсгэлэнд нь дарагдаад, жинхэнэ дотоод хүнийг нь харах нүдгүй болдог талтай.

Харилцаа нь аман, үйлсийн, зүрхний гэсэн гурван төвшинтэй байдаг шиг, бие биеэ мэдэлцэх харилцаа ч мөн гурван төвшинтэй ажээ. Хамгийн доод төвшин нь: бодит буюу биет төвшин. Олон гэрлэлт яг энэ төвшин дээр сүндэрлэдэг бөгөөд биеийн тачаал нь алдагдахаараа, хоёр хүн хөндийрдөг нь тун харамсалтай. Нөхөр нь спорт, хобби, үйлчлэл зэрэгт ухаанаа өгч, эхнэр нь дэлгүүр хэсэх, найз нөхөд, үйлчлэл гэх зэрэгт автагдана. Дэндүү гунигтай.

Удаах төвшин нь: сэтгэл буюу хүний хувь чанар юм. Давид, Ионатан хоёр яг энэ төвшинд баг бэх холбогдсон байдаг. Тухай нь: “Давид Саултай ярилцаж дуусахад Ионатаны зүрх түүнийхтэй нэгдэн Давидыг Ионатан амьшигээ хайрлалаа” (1Самуел 18:1) гэдэг. Давид Ионатаны араас гашуудахдаа: “Ах Ионатан минь, таны төлөө би зовон шаналж байна. Та намайг бүхнээс илүү хайрладаг байлаа. Таны хайр надад бүсгүйн хайраас илүү гайхамшигтай байв” (2Самуел 1:26) хэмээн халагласан байдаг. Давид хэзээ ч Ионатаныг гажуу нүдээр харж яваагүй, тэдний хооронд хэзээ ч биеийн дурлалцал байгаагүйг “Ионатаны хайр надад бүсгүй хүний хайраас ч дээр” гэдэг үг нь гэрчилнэ. Тэдний бие биенээ мэдэх мэдлэг нь илүү өндөрт төвшинд буюу сэтгэлийн төвшинд байжээ. Сэтгэлийн харилцаа нь биеийн харилцаанаас өндөр төвшинд байдгийг ойлгохуй нь хүмүүс яагаад утсаар, захидлаар, цахимаар уулзсан хүнийхээ төлөө гэр бүлээ хаяад явдгийг тайлбарлана.

Тийм боловч, хүнийг мэдэх хамгийн өндөр төвшин нь сүнсний төвшин болно. Тиймээс л Паул:

“Хүний бодлыг дотор нь буй сүнснээс өөр ямар хүн мэдэх вэ? Түүнчлэн Бурханыхыг Бурханы Сүнснээс өөр хэн ч эс мэднэ. Бурхан бидэнд бэлэглэсэн юмсыг мэдэхийн тулд бид ертөнцийн сүнсийг бус, харин Бурханы Сүнсийг хүлээн авсан” (1Коринт 2:11-12) гэжээ.

Паул Есүсийг ийм л төвшинд мэддэг болжээ. Петр ч Есүсийг энэ төвшинд мэддэг болсон ч, түүний хувьд Есүстэй биеэр хамт байсан үеийнхээ янз бүрийн төвшний дурсамж руугаа байнга эргэж буцдаг нэг зовлонтой байсан байх. Иймээс л Паул энэ тухай маш тодорхой мэдэгджээ:

Иймд үүнээс хойш бид хэнийг ч махбодын дагуу үзэхгүй. Хэдийгээр бид Христийг махбодын дагуу мэддэг байсан ч эдүгээ бид Түүнийг тийм байдлаар бус гэдгийг мэднэ (2Коринт 5:16).

Бурханд ойрт

Бурханыг дотно таньж мэдэх гэж байгаа хүнд Бурханы хайрласан хамгийн том ерөөл нь Өөрийгөө бидэнд махан биеэр бус, харин Ариун Сүнсээр илчлэх завшаан гэдгийг мэдүүштэй.

Янзтай! Та над шиг баярлахгүй байна уу? Бид ямар гайхамшигтай Бурханд үйлчилдэг вэ! Бурхан бидэнд Өөрийгөө хамгийн л гүн гүнзгий арга замаар илчлэхийг улайран хүсдэг. Бурхан Өөрөө ийм дотнослыг хүсдэг. Таны зүрхэнд ч яг адилхан цангаа төрөхгүй байна уу?

СУДЛАХ АСУУЛТ

1. Та ч бас зохиолчтой адил “... Тэнгэрт Тантай хамт байхаар явсан нь дээр!” хэмээн залбирч үзсэн үү? Үзсэн бол, ямар нөхцөл байдалд тэр вэ?
2. Чуулганы олон хүн Ариун Сүнсгүйгээр хэн ч Есүсийг мэдэж чадахгүйг мэддэг хэрнээ л Ариун Сүнснээс гадуур Есүстэй дотносох гэж үздэг. Яагаад? Та бас ингэж оролдож явсан уу?
3. Ариун Сүнсний түншийн үүргийг эргэцүүлэн бодохул, Ариун Сүнсний оршихуй таныг зүрхээ Бурханд уудлахад хэрхэн зоригжуулж байна? Бурханаас юмаа нууж хаах үнэхээр боломжтой гэж үү?

Арван нэгдүгээр бүлэг

ААВЫН АМЛАЛТ



Итгэдэггүй юмаараа ерөөгдөнө гэж үгүй.

Миний бие 1979 онд Пердю Их сургуулийн нэгэн хуурай ахаараа дамжин Есүст итгэж байлаа. Өөрийнхөө замаас татгалзаад, Есүсийг Эзэнээ болгохдоо, би Бурханы Хаанчлалд дахин төрснөө мэдэж билээ. Бичээс “Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ” (Ром 10:9-10) гэдэг.

Би ямар ч эргэлзээгүй аврагдсан байв. Үүнийг зүрх маань ч гэрчилж, Бичээс ч батлав. Тийм боловч, шинэ амьдралд маань нэг л юм дутагдаад, би ч юу болох талаар хэдэн сар толгойгоо гашилгав. Би Бурханы хүүхэд байтал, Эзэн нэг л хол санагдана. Бичээс уншихаар, манан дунд байгаа мэт юу ч ойлгогдохгүй бөгөөд хичнээн мэрийж уншсан ч, нэг их юм ойлгодоггүй байлаа. Түүнчлэн намайг сөрсөн нөхцөл байдлыг ч ялж дийлэхгүй, оюутан найз нөхдийн зүгээс ирэх дарамтын чанга давалгааг ч сөрж үл дийлнэ.

Цаг хугацааны явцад би, миний дэргэд Эзэнтэй хавьгүй ойр дотно амьдардаг хүмүүстэй уулзаж учирч эхлэв. Тэд Бурхантай нэг л дотно, сайхан ярилцана. Тэгээд би гайхшрав. Тэд надаас илүү юу хийдэг

болоод, ийм байна вэ? Яахаараа Бурхан надад өгөөгүй ойр дотно харилцаагаа тэдэнд өгнө вэ? Тэд Эзэний арга замыг надад байхгүй хүч, ухаарлаар хардаг гэлтэй. Тэгээд Библиэ судлах үеэрээ Эзэнтэй хамаагүй өөр төвшинд харилцаж болдгийг ойлгосон бөгөөд үүнийг нь би хараахан үзээгүй байлаа.

ААВЫН АМЛАЛТ

Тэгээд Бичээсээс юу олсныг үзнэ үү. Есүсийг тэнгэр өөд өргөгдөхөөс өмнө ийм явдал болжээ:

Тэгээд элч нарыг цуглуулан, Иерусалимыг үл орхиж, Эцэгийн амласныг хүлээхийг тушаан “Надаас та нар үүнийг сонссон билээ. Иохан усаар баптисм хүртээдэг байсан бол харин та нар ойрын өдрүүдэд Ариун Сүнсээр баптисм хүртэх болно” гэжээ (Үйлс 1:4-6, тодруулгыг нэмэв).

Есүс итгэдэг хүмүүстээ “Аавын амлалтыг” буюу Түүний айлдсанаар Ариун Сүнсний Баптисмыг хүлээж автлаа ийшээ тийшээ явж, номлож, чуулган эхлүүлж, дуудлагаа биелүүлэхийг нь хоригложээ. Энэ эшлэл дээр Есүсийн хэрэглэсэн *баптисм хүртэх* гэдэг үг нь Грек хэлний “дүрэх, шумбуулах, умбуулах” гэсэн утга бүхий *баптизо* гэдэг үг юм. Дагалдагч нар хэдийгээр Есүсийн амилалд итгэж, Эзэнээ болгож, тэнгэрт харъяалалтай, Есүсийн итгэмжтэй дагалдагч нар болсон ч, Ариун Сүнсний айсуу булхлыг арай үзээгүй байгааг Есүс дагалдагч нартаа айлджээ.

Гэхдээ Ариун Сүнсний дүүрэл нь санал, сонголт юмуу зөвлөгөө бус, харин тушаал байгаа нь хамгийн сонирхол татмаар! Бидний тусын тулд, хамгаалалт, Хаанчлалын төлөө өгөгдсөн тушаал. Тиймээс бид өөрийнхөө төлөө бас Хаанчлалын тусын тулд Есүсийн тушаалд хөнгөн хуумгай хандашгүй.

Дагалдагч нарын хувьд үл мэдэх, нэгэн зүйлийг хүлээж авахыг тушаасан Аавын Амлалт нь Есүсийг өргөгдсөнөөс аравхан хоногийн дараа л биелсэн юм. Хамгийн сонирхолтой нь, Есүс үхлээс амилуулагдсанаасаа хойш таван зуун хүнд үзэгдсэн байдаг ч (1Коринт 15:6), Түүнийг явснаас арван өдрийн дараа зуун хорь нь л Дээд өрөөнд байж байсан. Таван зуугийн дийлэнх нь анх Амлалтыг хамт хүлээлцсэн боловч, цаг хугацааны явцад тэсвэр алдрах, эргэлзэх, үл итгэх зэрэг үй түмэн шалтгаанаар уварч цуварсаар, мөнөөх хэдэн хүн л үлдсэн гэдэгт би эргэлздэггүй. Дөрвөн зуугаад нь Есүсийн тушаасныг биелүүлээгүй нь тун горьгүй.

Харин үлдсэн хэд нь ямар ч амин хувийн сэдэл өвөрлөлгүй, яг нэг аккорд дээр тохирчээ. Тэд Есүсийн тушаасан үгд хөнгөн ч хандаагүй, шалтаглан нүүр ч буруулаагүй. Эзэн нь үлдэхийг тушаасан болохоор, тэр хүмүүс хэдий чинээ тэвчих ёстой - төдий хүртэл тэвчихэд бэлэн байсан гэдэгт би баг итгэдэг. Ийнхүү Есүсийн тушаалыг нухацтай авч үзсэн хүмүүс л үлдсэний дараа:

Пентэкостын өдөр болоход тэд цөмөөрөө нэг газар цугласан байлаа. Хүчит хуй салхи мэт чимээ тэнгэрээс гэнэт гарч, тэдний сууж байсан байр бүхэлдээ үүнд автжээ. Тэгтэл галынх мэт хуваагдсан хэлүүд бий болон хүн нэгбүр дээр буув. Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв (Үйлс 2:1-4).

Тэр өдрийг “Пентекост” гэдэг бөгөөд энэ нь Шинэ гэрээний үед үүссэн нэр томъёо бус, харин Израилийн томоохон баяр наадмын нэр байв. Тэр хүмүүс Есүсийн зөгнөсөн ёсоор Ариун Сүнсээр *дүүрсэн* буюу *баптисм* хийлгэсэн байгааг тэмдэглээрэй. Энэ нь *өөр хэлүүдээр* ярихтай хамссан, мөнөөх Аавын Амлалт байв.

Өнөөдөр хүмүүс зүгээр л мэдлэггүйгээсээ болоод хэлүүд гэдэг ойлголтыг ээдрээтэй юмуу нууцлаг зүйл шиг л үздэг. Гэтэл Бичээс (би ч бас) *хэлүүдийн* талаар ярихдаа, ердөө л таны ойлголтоос харь хэлний талаар л өгүүлж байна. Энэ ойлголт Библиэс гадуур, жирийн амьдрал дээр ч хэрэглэгддэг. Жишээ нь, бид Англиар ярьдаг гадаад хүнээс *эх хэлийг* нь лавлаж асуудаг. Энэ нь ч ердөө л тэрбээр хүн болохдоо ямар хэлээр хэлд орсныг нь л мэдэх гэсэн санаатай.

Хүчит салхины исгэрээ нь Ариун Сүнс өнө эртнээс хүслэн болсоор ирсэн сүмийнхээ босгоор анх удаа нэвтрэн буйн шинж нь байжээ. Гэхдээ Бичээс Ариун Сүнсийг салхи гэж хэлээгүй, салхи нь ердөө л Ариун Сүнсий айлчлалын илрэл байсныг дахин хэлье.

ЭСРЭГ АРГА ЗАМ

Яг одоо би нэгэн сонирхолтой ажиглалт хийснээ хэлмээр байна: Сатан ба түүний хамтрагчид ямагт Бурханы арга замыг тонгоруулж хуулах юмуу гуйвуулах маягаар ажилладаг. Ариун Сүнс анхлан айлчлах бүрийдээ, анзааралгүй өнгөрөхийн аргагүй арга замаар орж ирдэг. Ариун Сүнс

Бурханд ойрт

хүмүүсийг дүүргэхэд, хүмүүс Ариун Сүнсний илрэлийг үздэг ч, сонсдог ч. Үүнийг Үйлс ном дээрх олон түүхээс харж болно. Тийм боловч, Ариун Сүнс явахдаа, чимээгүй яваад өгдөг. Филистинчүүд ирээд байгааг Делила Самсонд мэдүүлэхэд, Самсон босоо харайсан бөгөөд дараах явдал өрнөжээ:

Би өмнөх шигээ гарч яван, биеэсээ тэднийг таягдан сэгсэрье хэмээв. Харин ЭЗЭН түүнийг орхисныг тэр мэдсэнгүй (Шүүгчид 16:20, тодруулгыг нэмэв).

Бурханы Сүнс сүр дуулиангүй явчихдаг учраас, Самсон Эзэний явсныг мэдээгүй байжээ. Тэгвэл, эсрэгээрээ - чөтгөрүүд чив чимээгүй орж ирдэг атлаа гарч явахдаа тодорхой хэмжээгээр өөрийгөө илэрхийлдэг байна (Үүнийг Сайн мэдээний хаанаас ч үзэж болно).

АМЛАЛТ НЬ БҮГДЭД ЗОРИУЛАГДСАН

Бүгдээрээ Пентекостын үйл явдал руугаа эргэж оръё. Баяр наадмыг тохиолдуулан Иерусалимд даян дэлхийн Еврейчүүд зочлоод байжээ. Тийнхүү хот даяараа салхины исгэрээг дуулаад, үй олноороо дагалдагч нарыг шавжээ. Эгэл бор дагалдагч нар өөр өөрсдийнх нь хэлээр Бурханы гайхамшигт үйлсийг өгүүлэхийг сонссон гийчдийн нүд, ам нь орой дээрээ гарсан байна. Тэгээд: “Энэ чинь одоо юу вэ?” хэмээн шаагилджээ.

Энэ аятай завшааныг тохиолдуулан, Петр босч зогсоод, тэнд байгаа хүмүүст Есүсийг номнов. Тэгээд үгээ ийн өндөрлөжээ:

Энэ Есүсийг Бурхан амилуулсан, бид бүгд үүний гэрч нар мөн. Тиймээс Тэр Бурханы баруун гарт өргөмжлөгдөж, Эцэгээс амласан Ариун Сүнсийг аваад, та нарын үзэж, сонсож байгааг цутгасан юм (Үйлс 2:32-33, тодруулгыг нэмэв).

Ариун Сүнсний тухай амлалт нь үзэж бас сонсох боломжтой зүйл гэсэн байгааг тэмдэглээрэй. Өөртөө: “үзэх, сонсох” гэж хэлнэ үү. Энэ хоёр үгийг тогтоож авах нь удаах эшлэлд хэрэгтэй.

Энэ үг хурсан олны зүрхэнд хүрсэн болохоор, тэд ч яах ийх ёстойг асуужээ. Петр:

“Тэмшигтүн, хүн бүр Есүс Христийн нэрээр баптисм хүртэгчээ. Ингэснээр та нарын нүгэл уучлагдаж бас та нар Ариун Сүнсний бэлгийг авах болно. Учир нь уг *амлалт* та нар болон та нарын хүүхдүүдийнх төдийгүй бас *алсад байх бүгдийнх* бөгөөд манай Бурхан Эзэнээр дуудагдсан *болгоных* билээ” (Үйлс 2:38-39, тодруулгыг нэмэв) хэмээн хариулжээ.

Тэр хүмүүсийн үзсэн бөгөөд сонссон Амлалт нь *алсад байх бүгдийнх, Бурхан Эзэнээр дуудагдсан болгоных* гэсэн байгааг сайтар тогтоож аваарай. Дээд өрөөнд байсан дагалдагч нарын хүлээж авсан тэр зүйл нь Эзэнийг дууддаг хүн бүрт буюу тэр дундаа та, бид хоёрт амлагдаж!

Яг одоо би, Шинэ гэрээн дээр Ариун Сүнсийг хүлээж авсан тохиолдол бүрийг цухас танилцуулмаар байна. Пентекостоос гадна дөрвөн тохиолдол бий. Тэгэхээр, хоёр зүйлийг тогтоож аваарай. Нэгдүгээрт - Ариун Сүнсний баптисм нь нэгээс бусад тохиолдол дээр Есүст итгэх явдлаас тусдаа өрнөсөн байдаг. Хоёрдугаарт - тохиолдол болгон дээр хүмүүс Ариун Сүнсээр дүүрэхүйн гадаад шинж тэмдэг нь хөндлөнгийн хүмүүст *харагдсан* бөгөөд *сонсогдсон* байдаг.

САМАРИ

Филип Самарийн хотод очоод Есүсийг тунхаглажээ. Түүний яриаг ч үй олон хүн цуглаж сонссон. Тэгээд “...бузар сүнстэй олноос тэдгээр нь чанга дуугаар хашхиран зайлсан... . Саа өвчтэй болон эрэмдэг олон эдгэрсэн” (Үйлс 8:7) зэрэг ер бусын гайхамшиг өрнөжээ. Ер бусын хүчирхэг тэр аяны улмаас хот ч бусын баяр хөөрт автав.

Харин Бурханы хаанчлал болон Есүс Христийн нэрийн тухай сайнмэдээг тунхагласан Филипт итгэсэн эрэгтэй нь ч, эмэгтэй нь ч баптисм хүртэж байлаа. Симон ч бас итгэсэн бөгөөд баптисм хүртээд Филипийг дагах болж, гайхамшиг болон тэмдгүүд үйлдэгдэхийг хараад, гайхаж хоцордог байв (Үйлс 8:12-13).

Хүмүүс Есүс Христийн Сайн мэдээнд итгээд, усан баптисм хийлгэжээ. Тиймээс Бичээсийн дагуу, тэр хүмүүс эдүгээ Бурханы хаанчлалд дахин төрсөн байв. Гэтэл дараа нь ийм үйл явдал болжээ:

Бурханы үгийг Самари хүлээн авсныг Иерусалим дахь элч нар сонсоод Петр, Иохан нарыг тэдэн уруу илгээв. Тэд ирж, тэдэнд Ариун Сүнснийг авахуулахын төлөө залбирчээ. Учир нь тэдний хэнд ч Ариун Сүнс хараахан буугаагүй байсан бөгөөд тэд Эзэн Есүсийн нэрээр зөвхөн баптисм хүртсэн байжээ (Үйлс 8:14-16).

Бурханы хаанчлалд хэдийнээ дахин төрснийг нь “Эзэн Есүсийн нэр дотор баптисм хүртсэн” гэдэг мэдэгдэл давхар баталгаажуулж байна. Тэд харанхуйн хаанчлалаас чөлөөлөгдөөд, эдүгээ Бурханы гэр бүлд орсон нь ямар ч эргэлзээгүй. Тийнхүү, тэр хүмүүс эдүгээ дахин төрсөн итгэгчид мөн боловч, Ариун Сүнсний баптисмыг хараахан хүлээж аваагүй байжээ.

“Ариун Сүнсээр бус бол хэн ч “Есүс бол Эзэн” гэж хэлж чадахгүй гэдгийг би та нарт мэдэгдье” (1Коринт 12:3) хэмээн Бичээс дээр товын тодорхой хэлсээр байтал, тэр хүмүүс яаж аврагдсан байх билээ хэмээн гайхаж байна уу? Тийм ээ, Ариун Сүнсний нөлөөгүйгээр Есүсийг Эзэн хэмээн дуудаж чадахгүй нь үнэн. Гэхдээ Ариун Сүнсээр дүүрэх нь үүнээс өөр явдал юм. Бид Есүст итгэх үедээ ариусгагдаж, лацдуулж, дотроо Ариун Сүнснийг суурьшуулдаг боловч (1Петр 1:2; Ефес 1:13; Ром 8:9-11-ийг үзнэ үү), Есүсийн нэрээр Ааваас гуйх хүртлээ Ариун Сүнсний оршихуйгаар дүүрдэггүй. Бичээс:

“Та нар ёрын муу атлаа хүүхдүүддээ сайн бэлэг өгөхөө мэддэг бол тэр тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь гуйгсдад Ариун Сүнснийг өгөх нь лавтай бус уу?” (Лук 11:13) гэдэг.

Тэгэхээр, амлалт нь гагцхүү Бурханы хүүхдүүдэд л зориулагдсан болохыг “Тэнгэрлэг Эцэг тань” гэдэг үгээс харж болно. Түүнчлэн хожим Есүс үнэний Сүнснийг “дэлхий хүлээж авч чадахгүй” (Иохан 14:17) гэсэн байдаг. Энэ нь Хаанчлал руу шинээр төрөхөөс тусдаа үйл явдал болох нь Есүсийн үгээс харагдаж байна.

За бүгдээрээ Самарийн хүмүүс дээрээ эргэж очъё:

Тэгээд тэр хоёр тэдэн дээр гараа тавихад тэд Ариун Сүнснийг хүлээн авч байлаа. Элч нарын гар тавилтаар Ариун Сүнс өгөгдөж буйг *ажигласан* Симон тэр хоёрт мөнгө өгч — Энэ эрх мэдэлээ бас надад өгөөч. Тэгвэл би

гараа тавьсан хүн бүрийг Ариун Сүнстэй болгоно шүү дээ гэв (Үйлс 8:17-19, тодруулгыг нэмэв).

Дээрх итгэгч хүмүүс аврагдсан хойноо Ариун Сүнсийг хүлээж авсан байна. Энд хүмүүс хэлээр ярьсан тухай тусгайлан хэлээгүй байгаа ч, Симон яахаараа мөнгө санал болгодог билээ? Хүмүүс Ариун Сүнсийг хүлээн авахыг нь Симон харсан тухай Бичээс хэлжээ. Тэгэхээр, энэ нь хараажийн үйл явдал байсан бөгөөд хэлээр ярихаас өөр гадаад илрэл байгаагүй нь тодорхой юм. Учир нь Шинэ гэрээн дээр Сүнсээр дүүрэх тоолонд хэлээр ярих үзэгдэл хэзээд дагалдаж явдаг.

Бичээс дээрх Самарийн түүхээс бид, нэгдүгээрт - Бурханы Сүнсээр дүүрэх нь Есүст итгэхээс тусдаа үйл явдал гэдгийг, хоёрдугаарт - Сүнсээр дүүрэхүйн гадаад илрэл нь хөндлөнгийн хүмүүст *харагдсан* гэдгийг тус тус мэдэж авлаа.

ЕФЕС

Элч Паул ба түүний багийнхан Ефест ирээд, хэдэн дагалдагчтай уулзжээ. Тэгээд хамгийн түрүүнд:

“Та нар итгэхдээ Ариун Сүнсийг хүлээн авсан уу?” (Үйлс 19:2) хэмээн асуужээ.

Бид ч мөн дөнгөж итгэсэн хүнээс хамгийн түрүүнд ингэж л асуух ёстой аж. Бид чинь хүмүүсийг нэг цагийн ч өмнө болтугай Эзэнтэй дотносож, Есүсийг гэрчлэх хүчтэй байлгахыг хүсэхгүй гэж үү? (Үйлс 1:8-ийг үзнэ үү)

Тэр дагалдагч нар Ариун Сүнсний талаар сонсоогүй, гагцхүү Иохан Баптистаар л усан дотор баптисм хийлгэсэн байжээ. Тиймээс Паул ба түүний багийнхан тэдэнд Есүс Христээр дамжиж ирдэг авралын тухай ярьж өгчээ. Тэгээд дараа нь:

Үүнийг сонсоод тэд Эзэн Есүсийн нэрээр баптисм хүргэцгээв. (Үйлс 19:5)

Ийнхүү Бичээсийн ёсоор, эдүгээ тэд Есүсийг Эзэн хэмээн тунхагласан болохоороо, хаанчлал руу дахин төрсөн бөгөөд усан баптисм хийлгэсэн хүмүүс байв. Цаашаа явъя:

Ийнхүү Паул тэдэн дээр гараа тавихад Ариун Сүнс тэдэн дээр ирж, тэд хэлээр ярьж, эш үзүүлжээ (Үйлс 19:6).

Сүнс дүүргэх үед тэр хүмүүс мөн л хэлээр ярьж, эш үзүүлцгээсэн бөгөөд хөндлөнгийн хүмүүс Аавын Амлалтын илрэлийг нь үзэж бас сонсжээ.

Эш үзүүлэх гэдэг нь “тэнгэрийн амьсгалаар өгүүлэх” гэсэн утгатай. Пентекост өдөр Петр мянга мянган хүнийг Хаанчлал руу оруулсан гайхамшигтай номлол хэлэхдээ, эш үзүүлжээ. Тэрбээр Бурханы Үгийг ямар ч урьдчилсан бэлтгэлгүй, шууд ярихдаа, энэ л амьсгалаар үйлджээ. Ефесийн эрчүүд Ариун Сүнсээр дүүрэхээсээ өмнө Бурханы арга замын талаар багахан ойлголттой л явсан бол, дүүрсэн хойноо Бурханы Үгийн онгодоор номлох болсон байна.

Бурханы Сүнсээр дүүрсэн хүн бүр ингэдэг. Бидний дотор *Багш* амилж, Бурханы юмс нилэнхүйдээ тунгалаг болж ирдэг. Миний хувьд, Сүнсний баптисмыг хүлээж авахаас өмнө Бурханы Үг, арга зам тун бүрхэг байдаг байлаа. Тэгвэл хүлээж авсны дараа Библи надад хувьчлан нээгдсэн юм. Есүст итгэсэн ч, Ариун Сүнсээр дүүрэлгүй удсан хүмүүс Ариун Сүнсээр дүүрснийхээ дараа “Олон асуултдаа хариулт авсан”, “Библи илүү тодорхой болсон” гэж хэлэхийг нь олонтаа үзсэн билээ.

Түүнчлэн дахин төрсөн атлаа Ариун Сүнсээр дүүрээгүй, Библийн хичээнгүй оюутнууд ч Сүнсээр дүүрэн хүмүүсийн Библийн мэдлэгийн талаар ижил үг хэлдэг. Тэд магадгүй гурав дахин их суралцдаг атлаа Сүнсээр дүүрэн итгэгчдийн ойлголтыг үзээд, гайхширдаг. Харин би тэдэнд зүгээр л: “Тун энгийн. Ариун Сүнсээр дүүрээгүй хүмүүс Ариун Сүнсний бүрэн гэгээрлийг тээдэггүй” л гэж хэлдэг. Гэхдээ Бурханы Сүнсээр дүүрэхүй нь Есүсийн нэрийг дууддаг болгонд зориулагдсан амлалт учраас, тэр хүмүүс ч үүнийг эдэлж чадна! Бурхан бидэнд ямар сайн гээч!

Тиймээс Самаричуудтай адил Ефесчүүд ч Есүст итгэснийхээ дараа Бурханы Сүнсээр дүүрсэн бөгөөд гадаад илрэл нь мөн л хөндлөнгийн улсад *харагджээ*.

ЭЛЧ ПАУЛ

Үйлс 9 дээр Паул нэрээрээ алдаршсан Саул итгэгчдийг хавчихаар Дамаск руу явж байв. Тийнхүү дөхөж явтал, тэнгэрээс хурц гэрэл гялбаад, Эзэний дуу хоолой сонсогджээ:

Саул аа, Саул аа, чи юунд Намайг хавчина вэ? гэж түүнд хэлэх дууг сонсоод —Эзэн, Та хэн бэ? гэжээ. Тэгтэл Тэр — Чиний хавчаад буй Есүс Би байгаа юм. Бос, хотод оч. Юу хийх ёстойг чинь чамд хэлэх болно гэв.

Саул яг энэ үед дахин төрсөн гэдэгт би итгэдэг. Энэ маань давхар шалтгаантай. Нэгдүгээрт - Эзэн “Би Есүс байна” гэхэд, Саул Түүнийг “Эзэн” хэмээн мэдэгдсэн. Хоёрдугаарт - Саул гурван хоног мацаг барьж, залбирсны дараа Ананиа ирээд, дараах үгийг тодорхой хэлдэг:

“Саул дуу минь, ирэх замд чинь чамд үзэгдсэн Эзэн Есүс чамайг хараатай болгож, *Ариун Сүнсээр дүүргэхийн* тулд намайг илгээв” (Үйлс 9:17, тодруулгыг нэмэв).

Дуу гэдэг үгийг тэмдэглэнэ үү. Саул Есүс Христэд итгэдэг, Есүсийг Эзэнээ хэмээн мэдэгддэг, гурав хоног залбирдаг итгэгч хүн болоод байжээ. Тэгээд дахин төрснийх нь дараа Ананиа Саулыг Ариун Сүнсээр дүүрэхийн төлөө залбирсан байна.

Саул Ариун Сүнсээр дүүрэхдээ, хэлээр ярьсан тухай яриагүй. Гэхдээ Коринт дээр “Би та бүгдээс илүүгээр хэл ярихуйгаар ярьдаг тул Бурханд талархдаг” (1Коринт 14:18) хэмээн Паул өөрийнхөө тухай маш тодорхой мэдэгдсэн. Паул хэлээр хэзээнээс ярьдаг болов? Ананиагаар гар тавиулж, залбируулахдаа (Үйлс 9:17).

КОРНЕЛ БА ТҮҮНИЙ ГЭР БҮЛ

Корнел нэртэй Ромын цэргийн дарга байжээ. Тэрбээр гэр бүл, найз нөхөдтэйгээ дахин төрсөн анхны гадаад хүмүүс байв. Корнел байнга мацаг барьж, залбирдаг байсан бөгөөд нэг өдөр түүнд тэнгэрэлч үзэгдээд, Петрийг авчруулахаар хүмүүс илгээх заавар өгчээ.

Петр ч хэдэн өдрийн дараа ирж, Корнел ч түүний үгийг сонсохоор хайртай дотны хүмүүсээ бүгдийг нь цуглуулаад байв. Петр Есүсийг номносон бөгөөд үгээ дуусгахаас нь өмнө дараах явдал болжээ:

Петр эдгээр үгсийг хэлж байх зуур үүнийг нь сонсож байсан бүхэн дээр Ариун Сүнс буув. Харийнхан дээр бас Ариун Сүнсний бэлэг асгарахыг хозлуулсан итгэгчид болох, Петртэй хамт ирсэн бүх хүн хараад гайхацгаажээ.

Учир нь тэд хэл ярихуйгаар ярьж, Бурханыг дээдлэн байгаа нь сонсдов (Үйлс 10:44-46).

Иүдейчүүд шашин шүтлэгийн тал дээр байтугай, олон нийтийн ихэнх асуудал дээр ч харийнхныг авч хэлэлцдэггүй байв. Гадаад хүмүүс нь амлалтын гэрээнд багтаагүй, Бурхан ч үгүй, найдвар ч үгүй хүмүүс байжээ (Ефес 2:12-ийг үзнэ үү). Тиймээс Корнелийн болсон үйл явдал Петр тэргүүтэй Иүдейчүүдийн эрүүг мултлав. Гадаад хүмүүс Ариун Сүнсний авралыг хүлээн авсанд тэд мэл гайхаж, цэл хөхөрчээ.

Энэ нь Библи дээр хүмүүс нэгэн зэрэг аврагдаад бас Ариун Сүнсийг хүлээж авсан цорын ганц тохиолдол билээ. Иүдейчүүд Корнел ба түүний хайртай дотно хүмүүсийг аврагдана гэдэгт огтоос итгэхгүй учраас, тэднийг Есүст итгэхийн ч төлөө, Ариун Сүнсийг хүлээж авахын ч төлөө залбирахгүйг нь мэдсэндээ Бурхан зориуд ингэж үйлдсэн гэдэгт би л хувьдаа итгэдэг бөгөөд та ч бас эргэцүүлээд үзээрэй. Бод л доо. Хүнийг дахин төрснийг гаднаас нь шууд мэдчих боломжгүй. Тиймээс тэр хүмүүс Петрийн номлосон үгийг хүлээж аваад, Есүст итгэсэн байлаа ч, Иүдейчүүд тэднийг аврагдсан гэдэгт итгэх байсан нь юу л бол.

Гэтэл Бурхан тэр гадаад хүмүүсийг Ариун Сүнсээрээ дүүргэхэд, тэд яг Иүдейчүүд Ариун Сүнсээр дүүрэхдээ хэлээр ярьсантай адил хэлээр ярих үед Бурхан авралаа гадаад хүмүүс дээр цутгажээ гэдгийг хэн ч няцаах аргагүй болжээ.

Тэгэхээр, хүн Ариун Сүнсээр дүүрсний баталгаа нь гаднаа хэлээр ярих илрэл байдгийг энэ түүх ямар ч эргэлзээгүй харуулж байна. Өөр нэгэн орчуулга дээр “Ариун Сүнсний бэлэг Харь хүмүүс дээр ч цутгагдав. Ийнхүү тэд хэлээр ярьж, Бурханыг магтсан тул энэ тал дээр ямар ч эргэлзээ байхгүй ёсгүй” гэдэг (Үйлс 10:45-46 ЭнЭлТи Библи). Тэд үүнийг хэрхэн мэдэв? “Учир нь тэд сонссон...”. Тэд Аавын Амлалтыг үзсэн бас сонссон!

ХЭЛ БАЙХГҮЙ БОЛНО

Та: “Тийм ээ, энэ бүхэн чинь анхны дагалдагч нарын хувьд үнэн боловч, Библи дээр төгс нь ирэхээр хэл байхгүй болно гэдэггүй билүү?” гэж асууж магадгүй. Тийм ээ, тэгдэг. Гэхдээ төгс нь ирчихсэн юм уу? Зарим чинь: “Төгс гэдэг чинь Библи. Одоо Библи тэй болсон болохоор, хэл хэрэггүй” гэх байх. Тэгвэл энэ орчуулга зөв эсэхийг Библиэс харья л даа. Паул:

“Хайр хэзээ ч дуусдаггүй. Харин эш үзүүллэг үгүй болж, хэл ярихуй зогсож, мэдлэг алга болно. Учир нь бид хэсэгхэнийг мэддэг, хэсэгхэнийг эш үзүүлдэг. Харин төгс нь ирэх үед хэсэгхэн нь ч үгүй болно” (1Коринт 13:8-10, тодруулгыг нэмэв) гэжээ.

Нэгдүгээрт - төгс нь ирэхээр, хэлээс гадна гадна мэдлэг (тодруулбал, илчлэгдсэн мэдлэг) ялгаагүй сарних ажээ. Тийм зүйл хараахан болоогүй байна. Тиймээс хэзээ тэр “төгс нь ирэхийг” мэдэхийн тулд цааш нь уншицгаая:

Тэгэхээр бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч, *дараа нь (тэр үед)* нүүр нүүрээ харна. Би одоо хэсэгхэнийг мэддэг ч, би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ *дараа нь (тэр үед)* би бүрэн мэдэх болно (1Коринт 13:12, тодруулгыг нэмэв).

Паул хоёр ч удаа “тэр үед” гэснийг тэмдэглээрэй. Энэ нь нөгөө “төгс нь ирэх” цаг юм. Тэр цагийг хоёр хүчин зүйл тодорхойлдог. Нэгдүгээрт - бид Эзэнийг *нүүр нүүрээрээ* харна. Та яг одоо Эзэнийг нүүр нүүрээрээ харж байна уу? Түүний амилуулагдсан биеийг, гал дүрэлзсэн нүдийг, ноос шиг үсийг нь, нар шиг гэрэлтэх нүүрийг нь харж байна уу? Хоёр дахь тодорхойлогч нь: “би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ... бүрэн мэдэх болно”. Тэр таныг мэддэг шиг, та Түүнийг мэдэх үү? Эдгээр асуултад мэдээж “Үгүй!” л гэж хариулна. Паул биднийг алдрын биеэрээ Эзэнтэй хамт байх цагийн тухай өгүүлжээ. Тэр цагт л төгс нь ирнэ.

Тэгэхээр, төгс нь хараахан ирээгүй байгаа болохоор, хэл ч байсаар байна. Хэл нь газар дээр биднийг Бурхантай улам бүр дотносуулахын төлөө оршдгийн нэгэн гол шалтгааныг дараа дараагийн бүлгээрээ харуулна.

ХЭЛЭЭР БҮГД ЯРЬДАГ УУ?

Зарим чинь: “Би хэлэнд итгэдэг. Гэхдээ Бичээс “Бүгд хэлээр ярьдаг уу?” хэмээн асуугаад, үүндээ “үгүй” гэж хариулсан байдаг тул, итгэгч хүн болгон хэлийг хүлээж авах боломжтой гэж үү?” хэмээн асуух байх. Гэхдээ энэ ч бас Паулын асуултыг муухай гуйвуулсан явдал юм. Олон хүнийг Бурханы Амлалтаас салгасан энэ асуултыг шийдвэрлэхийн тулд нэн түрүүнд Шинэ гэрээ дөрвөн өөр ангиллын хэлний талаар

өгүүлдгийг тогтоох хэрэгтэй. Хоёр нь нийтийн үйлчлэлийн төлөө, хоёр нь Бурхантай хувьчлан харилцахын төлөө өгөгдсөн хэл. *Хүүхдүүд нь бүгдээрээ хэлээр ярьдаг байх нь Бурханы хүсэл үү?* гэдэг асуултад зүй ёсоор хариулахын тулд бид эдгээрийг нэг бүрчлэн товч үзэх хэрэгтэй.

ҮЛ ИТГЭГЧ НАРТ ӨГӨГДСӨН ТЭМДЭГ - ХЭЛ

Эхний хэлний төрөл нь *нийтийн* үйлчлэлд зориулагджээ. *Нийтийн* гэдэг нь өөр хүн юмуу хүмүүст үйлчлэх тухай ярьж байна. Паул тэдний тухайд:

“Тиймээс хэл ярихуй нь итгэгчдийн төлөө бус, үл итгэгчдийн төлөөх тэмдэг болдог аж” (1Коринт 14:22) гэж бичжээ.

Ариун Сүнс бидний оюун ухааныг давж гараад, өмнө хэзээ ч сурч яваагүй, ярьж мэдэхгүй энэ дэлхийн харь хэлээр ярих чадварыг бидэнд өгөх үед ийм төрлийн хэл тохиолдоно. Энэ нь биднийг хүссэн үед бус, харин Бурханы Сүнсийг хүсэх үед л тохиолддог бөгөөд бид ярихдаа, ихэвчлэн үүнийгээ мэддэг ч үгүй юмсанж. Хэлээр ярьж байгаага мэдээд байгаа хэрнээ энэ дэлхийн нэгэн хэлээр яриад байгаага мэддэггүй.

Жишээ хэлье. Би саяхан Колорадогийн нэгэн том цуглаан дээр номлосон юм. Манай нэгэн ажилтан арын эгнээнд сууж байв. Тэрбээр байнга зуучлан залбирдаг хүн бөгөөд намайг номлох үеэр Эзэн түүгээр миний төлөө залбируулахыг хүсээд байх шиг санагдсан юмсанж. Тэгээд цуглааны турш өөрийгөө үл мэдэх хэлээр (энэ хэлний талаар би удахгүй ярина) залбирч байна гэж бодоод л дотроо чимээгүй залбираад байж л дээ. Цуглааны дараа түүний өмнө сууж байсан нэг эрхэм манай ажилтан бүсгүй рүү эргэж хараад: “Та Францаар төгс цэвэрхэн ярих юм аа” гэж хэлжээ.

Бүсгүй ч Франц хэл мэдэхгүй гэдгээ учирлаж.

Тэгтэл нөгөө эрхэм: “Би Франц хэлний багш хүн. Та номлогчийг номлох хугацаанд түүний төлөө төгс Францаар залбирсан. Тэр бүү хэл залбирал дундаа Бичээсийг ч эш татсан. Тэгээд эш татсан даруйд чинь номлогч биднийг Библиэ нээгээд, таны залбирсан яг тэр эшлэлийг гаргахыг хэлж байсан!” хэмээн гайхшран өгүүлжээ.

Манай ажилтан яаж хөөрснийг хэлэх илүүц биз. Энэ бүхэн нь тэр эрхмийн хувьд намайг чухам Бурханы Үгийг зааж буйн тэмдэг болжээ.

Пентекост өдөр дагалдагч нар яг энэ төрлийн хэлээр ярьцгаасан юм.

Бичээс:

“Тэр цагт тэнгэрийн доорх үндэстэн бүрээс сүсэгт иудейчүүд Иерусалимд амьдарч байж. Энэхүү чимээнээр үй олон цугларч, өөрсдийнх нь төрөлх хэлээр тэдний ярихыг сонсоод ихэд гайхжээ. Гайхаж алмайрсан тэд — Энэ ярьж байгаа чинь бүгд галилчууд биш үү? Гэтэл бид төрөлх хэлээр маань хүн бүр ярихыг сонсох нь юу вэ? Партчууд, медчүүд, еламчууд мөн Месопотами, Иудей, Каппадок, Понт, Ази, Фруг, Памфул, Египет ба Курений хавийн Ливийн хэсэгт суугчид болон Ромоос ирэгсэд болох иудейчүүд бас шинэ итгэлтнүүд, крэтчүүд, арабууд бид нар Бурханы аугаа үйлсийн тухай тэдний яриаг өөр өөрийн хэл дээр сонсоцгоолоо гэв” (Үйлс 2:5-11).

Мөн л энэ хэл үл итгэгч нарт зориулагдсан тэмдэг болжээ. Дээрх Франц хэлний багшид тэмдэг болсон шигээ, энэ Бичээс дээр гарч буй, дэлхий даяараас цугласан, боловсролтой хүмүүст ч тэмдэг болжээ. Энэ тэмдэг тэдний анхаарлыг олзолж, тэд Бурханы Үгд зүрхээ нээсэн байна.

Итгэгч хүмүүс хэзээ ч сурч яваагүй, гадаад хэлээрээ гадаад хүмүүст Бурханы Үгийг яриад, энэ нь тэдний хувьд Бурханы хайрын Үгийн баталгаа - тэмдэг болсон түүхийг би зөндөө сонсож явлаа. Тэгэх болгонд энэ гайхамшигтай тэмдгээс ер бусын үйлчлэл өрнөдөг ажээ.

ТАЙЛБАРТАЙ ХЭЛ

Хэлүүдийн хоёрдугаар ангилал нь мөн л нийтийн үйлчлэлийн төлөө өгөгдсөн аж. Гэхдээ энэ нь газар дээр оршдоггүй аялгатай, тэнгэрийн хэл юм. Гурав, дөрөвдүгээр ангиллын хувьд ч ялгаагүй тэнгэрийн хэлүүд болно.

Тэгэхээр, та тэнгэрт нэгээс олон хэл юмуу аялга байдаг эсэх талаар бодлогоширч байгаа байх. Бодоод үз л дээ: Есүс “Ялагчид Би нууцалсан маннагаас өгнө. Би түүнд цагаан чулуу болон түүн дээр бичигдсэн, хүлээн авагчаас нь өөр хэн ч мэдэхгүй шинэ нэр өгнө” (Илчлэл 2:17) гэж Илчлэл ном дээр гардаг. Түүнчлэн Есүсийг “Түүний мэлмий нь галын дөл шиг, тэргүүн дээр нь олон титэм байна. Тэр өөрөөс нь өөр хэн ч эс мэдэх, бичигдсэн нэгэн нэртэй байлаа” (Үйлс 19:12) гэдэг. Тэгэхээр, тэнгэрт олон янзын хэл байдаг болоод л, нэрийг нь хэн ч мэдэхгүй байгаа ажээ.

Эдгээр нь хэл нь 1Коринт 12-аар бүлэг дээр жагсаасан, Ариун Сүнсний 9 бэлэг дунд багтана:

“...олон янзын хэл ярихуйг, нэгэнд нь хэлүүдийг тайлбарлах чадварыг өгсөн байна” (1Коринт 12:10).

Эдгээр хэлийг орчуулах бус, харин тайлбарлах ёстойг тэмдэглээрэй. Яагаад? Яагаад гэх нь ээ, тэдгээр нь жирийн дэлхийд ойлгогдохгүй, тэнгэрийн хэл юм.

Би Сингапурт болсон нэгэн цуглааныг санаж байна. Намайг Сингапур улсын хамгийн том нэгэн чуулганд номлуулахаар урьсан бөгөөд тэр цуглаан хэд хэдэн удаагийн зочлолын маань анхных байлаа. Намайг тайзан дээр урьж гаргахаас өмнө маш сайхан магтаал явсан бөгөөд тэнд цугласан үй олон хүн хэсэгхэн зуур нам гүм болов. Тэгтэл нэг хүн тэнгэрийн хэлээр ярьж эхэлсэн юм. Микрофонгүй атлаа маш чанга, тод ярив. Тэрбээр тэрхүү нүсэр танхимын тагт хавиас ярьсан ч, дуу хоолойн дахь яруу тод байдал, эрх мэдэл нь хүн бүрт хүрсэн юм. Яг л тэнгэрээс өсгөх мэт.

Түүнийг өгүүлж байхад, миний дотоод хүн баярлан дэвхцэж, гадаад хүн маань эмээсэндээ, хүндэт харуул мэт мэхийж байлаа. Гар, хөлийн маань үсний ширхэг бүр анхаарах мэт, ариун уур амьсгал дор зүрх минь түргэсэх шиг. Нөгөө хүнийг ярьж дууссаны дараа тайлбар нь явсан бөгөөд хэл, тайлбар хоёроор өгөгдсөн Эзэний Үг яг тэр орой миний номлох үг байсанд, би ч гайхав. Ийнхүү миний бие тэр орой чухам Бурханы Үгийг номлосныг Бурхан надад төдийгүй, тэнд байсан бүх хүнд баталж билээ.

Энэ хэл нь тайлбарлагдахаараа, эш үзүүлэлтэй төстэй юм. Иймээс л Паул: “Чуулган босгон байгуулагдахын тулд ярьснаа тайлбарлахгүй л бол хэл ярихуйгаар ярьдаг нэгнээс эш үзүүлдэг нь илүү агуу” (1Коринт 14:5) гэжээ. Энэ хэл нь нийтийн үйлчлэлийн төлөө чуулганд өгөгддөг болохыг энэ эшлэл дахин харуулж байгаа бөгөөд Паул “Бүгд хэлээр ярьдаг уу?” гэж асуухдаа, энэ л хэлний тухай хэлжээ. Одоо уг эшлэлийг агуулгаар нь уншъя:

“Бурхан чуулганд нэгдүгээрт элч нар, хоёрдугаарт эш үзүүлэгчид, гуравдугаарт багш нар, дараа нь гайхамшиг үйлдэхүй, дараа нь эдгээх бэлгүүд, туслахуй, удирдахуй ба олон төрлийн хэл ярихуйг тавьжээ. Бүгд элч нар уу? Бүгд эш үзүүлэгчид үү? Бүгд багш нар уу? Бүгд гайхамшигийг

үйлдэгчид үү? Бүгд эдгээх бэлгүүдтэй юү? Бүгд хэл ярихуйгаар ярьдаг уу? Бүгд үүнийг нь тайлбарладаг гэж үү?” (1Коринт 12:28-30)

Паул Бурханы чуулганд тогтоож өгсөн, төрөл бүрийн үйлчлэлийн бэлгийн талаар өгүүлж байгааг анзаарч байна уу? Мэдээж хүмүүс *бүгдээрээ* элч юмуу эш үзүүлэгч, багш, пастор юмуу гайхамшгийн болоод эдгээх, хэлээр ярих юмуу тэнгэрийн хэлээр ярих бэлэгтэй *байдаггүй*. Яагаад тэр вэ? Хариултыг нь дараах эшлэлээс харж болно:

“Тиймээс хэл ярихуй нь (*тэмдэг - хэл*) итгэгчдийн төлөө бус, үл итгэгчдийн төлөөх тэмдэг болдог аж. ... хэрэв чуулган бүрэн бүтнээрээ хамтдаа цуглаад, бүгд хэл ярихуйгаар (*тайлбартай хэл*) яривал хараахан сураагүй хүн эсвэл үл итгэгчид орж ирээд та нарыг солиорч байна гэж хэлэхгүй гэж үү?” (1Коринт 14:22-23, тодруулгыг нэмэв)

Асуултандаа хариулахаасаа өмнө энэ хоёр эшлэл нь нийтийн төлөөх хоёр хэлний ялгааг тодорхой харуулж байгааг хэлэхийг болгооно уу. Паул эхлээд үл итгэгч хүмүүст зориулагдсан тэмдэг - хэлний талаар өгүүлжээ. Энэ нь хэзээ ч сураагүй, гадаад хэлээрээ ярих явдал юм. Эзэний гайхамшиг бүхий оролцооноос өөр ямар ч аргаар бид тэр хэлээр ярих боломжгүйг үл итгэгч хүмүүс тодорхой хардаг.

Дараа нь Паул чуулган нэгдэн нийлээд, нэгэн зэрэг хэлээр ярих тухай хэлжээ. Энэ нь яахын аргагүй тэнгэрийн хэлүүд болж таарч байна. Яаж ийм багтай хэлээд байна гэхээр - Пентекост өдөр дагалдагч нар бүгдээрээ дэлхий дээрх газар газрын хэлээр Бурханы гайхамшигт үйлсийг өгүүлсэн. Үл итгэгч хүмүүс яриаг нь ойлгож байсан тул дагалдагч нарын хэлийг тайлбарлах шаардлага байгаагүй. Эс бөгөөс хэн ч ойлгохгүй байх байв. Хүмүүс ойлгохгүй байх юмуу эсвэл үл итгэгч хүмүүс галзуу солиотой гэж бодож болзошгүй байдаг болохоор, бүх хүн хэлээр ярих хэрэгцээ байдаггүйг харж байна уу?

Тиймээс олон хүний буруугаар ойлгодог “Бүгд хэлээр ярьдаг уу?” гэдэг асуултын хариу нь маш энгийн байх нь. Бурханы чуулган дотор тогтоож өгсөн үйлчлэлийн бэлгийг бүгдийг нь бүх хүн ажиллуулах хэрэгцээ байхгүй учраас, Бурхан шилээ сонгоо хийдэг байна. Гэхдээ Бурхан *дутуудуулдаг* Нэгэн биш бөгөөд итгэгч хүний хувийн итгэлийн амьдралд зориулсан юмс дээрээ шилээ сонгоо хийдэггүй. Тэгэхээр одоо

үлдсэн хоёр ангиллаа буюу Бурхантай тогтоосон хувийн харилцаанд маань хамаатай хэлний бэлгийг авч үзэцгээе.

ХУВИЙН ЗАЛБИРЛЫН ТӨЛӨӨ ӨГӨГДСӨН ХЭЛ

Хэлний дараагийн хоёр ангилал нь хувийн залбирлын төлөө өгөгдсөн бөгөөд Христэд итгэдэг хүн бүрт өгсөн Аавын хангамж юм. Эдгээрийг дараах эшлэлд танилцуулжээ:

“Учир нь би хэл ярихуйгаар залбирвал миний сүнс залбирдаг бөгөөд харин ухаанд минь үр жимс үгүй юм. Тэгвэл яах вэ? Би сүнсээр залбирах болно, бас ухаанаар залбирах болно. Би сүнсээр дуулах болно, бас ухаанаар дуулах болно” (1Коринт 14:14-15).

Паул эдгээр хэлийг чуулганы үйлчлэлийн төлөө өгөгдсөн бус, харин залбиралд зориулагдсан болохыг онцгойлж хэлсэн байгааг тэмдэглээрэй. Энэ л бүлэг дээр мөн “Хэл ярихуйгаар ярьдаг нь хүмүүст бус, харин Бурханд ярьдаг. Тэрээр нууцуудыг сүнсээр ярьдаг ч сонсон ухаарагч нь үгүй ажээ” (1Коринт 14:2) гэсэн. Бид нийтийн үйлчлэлийн төлөө хэлээр ярихдаа, үл итгэгч хүмүүст өгүүлэх (тэмдэг - хэл) юмуу чуулганд хандаж өгүүлдэг (тайлбартай хэл) бол, хэлээр залбирахдаа хүнд бус, Бурханд ханддаг байна. Ялгааг нь харж байна уу?

Дээрх эшлэл дээр Паул хоёр арга замаар залбирах тухай хэлсэн ба үүний нэг нь ухаанаар залбирах арга ажээ. Тухай нь би өөр дээрээ авч ярьбал, Англи хэлээр залбирна гэсэн үг. Тэгвэл нөгөө арга нь хэлээр залбирах буюу миний сүнс Ариун Сүнсээр хөтлүүлэн залбирах арга ажээ. Магтаал дуун дээр ч ялгаагүй. “Би сүнсээр ч дуулна бас ойлголтоороо ч дуулна.”

Иуда хэлээр хувьчлан залбирах тухай ингэж хэлжээ:

Хайртууд минь, харин та нар хамгийн ариун итгэл дээрээ өөрсдийгөө сүндэрлүүлж, Ариун Сүнсээр залбиран... (Иуда 20-21).

Бид хэлээр залбирахдаа, өөрийгөө босгон байгуулдаг бол, чуулганд хандан хэлээр ярьж, тайлбарлахдаа, чуулганыг боловсруулах буюу босгон байгуулдаг ажээ (1Коринт 14:5). Бурхан аль алийг нь хүсдэг бөгөөд аль аль нь ялгаагүй чухал.

Энэ ангиллын хэлний талаар би дараагийн бүлгээрээ гүнзгийрүүлж ярих бөгөөд Эзэнтэй дотно явахад, энэ хэл амин чухал байдгийг та сурч авна. Энэ ангиллын хэлийг би “Дотнослын хэл” гэдэг.

ЗУУЧЛАН ЗАЛБИРЛЫН ХЭЛ

Хэлний дөрвөн ангиллын сүүлчийнх нь зуучлан залбиралд зориулагдсан бөгөөд бид зуучлан залбирахдаа, бусдынхаа төлөө гуйн, ангал дээр зогсдог.

Үүнчлэн мөн Сүнс бидний сул дорой байдалд тусалдаг. Учир нь яаж залбирах ёстойгоо бид мэддэггүй юм. Харин Сүнс Өөрөө үгээр илэрхийлшгүйгээр ёлон бидний төлөө зуучлан гуйдаг. Сүнсний бодол санаа юу болохыг зүрхнүүдийг Нягтлагч нь мэддэг. Учир нь Бурханы хүслийн дагуу ариун хүмүүсийн төлөө Сүнс зуучлан гуйдаг юм (Ром 8:26-27).

Заримдаа бид үнэхээр юу залбирахаа мэддэггүй. Энэ тухай Нью Ливинг Транслэйшн Библи: “Учир нь бид юуны төлөө залбирбал зохихыг ч, хэрхэн залбирбал зохихыг ч мэдэхгүй” хэмээн маш тодорхой хэлдэг.

Хайртай хүмүүст маань ч, хар элгийн хүмүүст ч юу тохиолдож байгааг би мэдэхгүй ч, Бурханы Сүнс мэднэ. Ижий минь Флоридад, би Колорагод амьдардаг. Магадгүй ижийд минь тэнгэрийн тусламж хэрэгтэй байтал, энэ тухай өөрөө ч мэдэхгүй байх юмуу эсвэл надтай холбоо барьж чадахгүй байвал, яах уу? Түүнд залбирал хэрэгтэй байгааг бас юу гэж залбирбал зохихыг би хэрхэн мэдэх билээ?

Намайг Их сургуулийн оюутан байхад, энэ Бичээс миний амьдралд амилсан юм. Би итгээд хоёрхон жил болоод байсан ч, бусдад Есүсийн тухай ярихын хорхойтон болоод байсан болохоор, оюутны хотхондоо хуурай ахан дүүс, эгч дүүсийн холбооны оюутнуудыг хамруулсан Библи судлалын цагийг эхлүүлээд байлаа. Манай Библи судлал жараад оюутантай. Нэг орой Ариун Сүнсний тухай заав. Тэгээд зүгээр л Бичээсийг уншаад, тэдэнд Бурханы хүслийг харуулав. Тэгтэл манай бүлэгт “анх итгэхдээ л автоматаар Ариун Сүнсээр дүүрсэн мөн хэл байхгүй болсон” гэж заалгаж ирсэн, нэгэн охин явдаг байлаа. Түүний багш нар нь Бичээст итгэлгүй, харин ялгаагүй л сохроор итгэсэн менторуудаа сонсож явсан нь юутай гунигтай. Гэхдээ тэр орой мөнөөх

охин Библийн үгийг үзэхдээ, итгээд, тэр даруй өөр хэдэн хүний хамт Ариун Сүнсээр дүүрсэн юм.

Маргааш нь хар өглөөгүүр “хүн уулзъя гэнэ” хэмээн дотуур холбоогоор дуудсан найзын маань дуудлага намайг сэрээв. Бушуухан хувцаслаад, байрнаасаа гартал, замын эсрэг талын дотуур байранд амьдардаг нөгөө охин зогсож байлаа. Тэрбээр: “Жон, сэрээсэнд уучлаарай. Гэхдээ чамд юу болсныг хэлэх гээд тэссэнгүй” гэсээр, гялалзсаар угтав.

Үүрийн таван цагт Ариун Сүнс түүнийг сэрээгээд зүрхэнд нь залбирахыг ятгажээ. Тиймээс охин ямар нэг юм бишидсэнийг ойлгоод, хүнгүй газар очоод, хэлээр залбирч эхэлсэн байна. Тэрбээр тулаан хийж байгаагаа ойлгож, залбирал нь ч улам ширүүссээр байж. Тиймээс охин Эзэнээс хэний төлөө зуучлан залбируулж байгааг асуутал, зүрхэнд нь амьдрал үхлийн зааг дээр ирсэн, нэгэн өндөр настны төлөө гэсэн мэдрэмж орж иржээ. Тэрбээр бүтэн цагийн турш залбираад, эцэстээ зүрх нь тайвширсан байна.

Гучаад минутын дараа өрөөнийх нь итгэгч охинд утасны дуудлага ирээд, үүрийн таван цагт хайртай өвөө нь маш хүнд хэлбэрийн зүрхний шигдээс болсон ч, гайхамшгаар амьд гарсан тухай мэдэгджээ. Эмч нар өвөөг нь саяхан тогтворжуулсан бөгөөд тэр нь яг мөнөөх охины зүрх нь тайвширч, залбирахаа зогсоосон тэр цаг байжээ.

Охин баярласандаа тогтож ядаж байв. Тэрбээр итгэсэн цагаасаа л одоо хэл хэрэгцээгүй болсон хэмээн заалгасан учраас, хэлээс зайлсхийж явж. Бичээст итгээгүй хүнээс болж тэрбээр хичнээн юм алдаа вэ? Тийм боловч эдүгээ түүнийг яаж ч ятгаад дийлэхээргүй болжээ. Хэлээр залбирах нь өнөөгийн итгэгч хүмүүсийн амин зүйл гэдгийг тэрбээр нэг мөр ойлгосон байна.

Би ч үүнийг олонтаа харсан. Зуучлан залбирах хэлний хамгийн цэмбэгэр жишээ нь манай Австралийн оффис менежер Естерт тохиолдсон түүх болно. Тэрбээр мундаг ч үйлчлэгч, залбирлын ч дайчин хүн. Естер ерээд онд Библийн сургуульд байхдаа, нэг өглөө гэрээ янзалж байхдаа, гараа өргөөд: “Эзэн минь, өнөөдөд надад залбирах зүйл байхгүй. Гэхдээ Танд хэрэгцээ гарбал, би бэлэн шүү” гэж хэлжээ.

Тэгээд хэлсэн даруйд нь түүн дээр залбирлын хүнд жин даржээ. Тиймээс том өрөөндөө цээжээрээ бөхийс хийсэнд, хэлүүд ч амнаас нь сугарах шахам тургин гарав. Естер сүнс дотроо бохир шалан дээр өвдөглөж суугаад, цэвэрлэх мэт гараа тойруулан хөдөлгөж буй нэгэн Хятад хүнийг үзжээ. Тэгээд залбирахдаа, амин голоосоо: “Бос! Бос! Бос!” хэмээн хашхирсаар байж. Ийнхүү хэсэг залбирсны эцэст зүрх нь ч тавирч, Естер ч буцаад гэрийнхээ ажилд оржээ.

Ойролцоогоор таван сарын дараа Хятадад илгээлтийн эзнээр үйлчилж байсан нэгэн Шинэ Зеланд хүн Естерийн Библийн сургуульд ирээд, эх газрын Хятадын шоронд өөр нэгэн пасторын хамт хоригдсон нэгэн Хятад пасторын тухай ярьжээ. Нэг удаа мөнөөх өөр нэгэн пастор нь Хятад пастор руу хараад, Бурхан түүнийг шоронгоос суллахыг нь хэлжээ. Тэр хоёр энэ үгийг зүрхэндээ хадгалангаа, шоронгийн цэвэрлэгээний ажлаа хийсээр байж.

Удалгүй шоронгийн хуягууд Хятад пастораас бусад бүх хоригдлыг камерт нь оруулжээ. Ийнхүү Хятад пастор ганцаараа нэг өрөөний шалыг цэвэрлэж байтал, “Бос! Бос! Бос!” гэсэн маш хүчтэй дуу сонсжээ. Сонссон зүйлээ эс хэрэгсэж чадаагүй Хятад пастор босоод хаалга руу явж. Хамгийн сонирхолтой нь, хаалга нь цоожгүй байсан тул тэрбээр онгойлгоод, чанга хамгаалалттай шоронгоос ямар ч саадгүй явсаар гадаа гараад, яг үүдэн дээр нь зогсож байсан таксинд суугаад яваад өгсөн аж.

Үүнийг сонссон Естер хэдэн сарын өмнө залбирсан залбирлынх нь учир тайлагдаж байж магадгүй хэмээн хөөрсөндөө, илгээлтийн эзнийг ярьж дууссаны дараа урьд өмнө хэзээ ч уулзаж яваагүй тэр эрхэмтэй уулзаж ярилцахдаа, тэр өдөр нь түүний том өрөөндөө залбираад, залбирлын дэвтэртээ тэмдэглэж үлдээсэн яг тэр өдөр байсныг олж мэджээ.

Үүнээс гадна Библийн сургуулийнх нь өөр нэгэн багш Естер, илгээлтийн эзэн хоёртой уулзаад, ялгаагүй хэдэн сарын өмнө Ариун Сүнс түүнд бэрх байдалд байгаа нэгэн эрийн төлөө залбирах ачаа үүрүүлсэн тухай ярьжээ. Тэр багш ч бас хэлээр урсган залбирахдаа, шоронд байгаа нэгэн Хятад хүнийг тодорхой харсан аж. Илгээлтийн эзэн Хятад цуглааны нийтээрээ авахуулсан зургийг гаргаж иртэл, Библийн сургуулийн багш хэлээр залбирч байхдаа харсан хүнээ шууд заажээ. Тэр нь мэдээж нөгөө шоронд байсан тэргүүн пастор байв!

Дараа нь Естер, Библийн сургуулийн багш хоёр залбирлын дэвтэр дээрх тэмдэглэлээ тулгатал, яг л нөгөө өдөр байв! Тэд дуулгавартай залбирснаараа, Хятад пасторыг чөлөөлөх ажиллагаанд амин үүрэг гүйцэтгэснийг нь Бурхан тэдэнд батлан харуулжээ.

БИД ХЭРХЭН ИТГЭХ ВЭ?

Гэтэл Естер ч бас “хэл нь Библийн түргэн тусламжаас хасагдсан” хэмээн заалгаж өссөн бол, яана? Хүн бүр хэлээр ярих албагүй гэж сурсан бол, яана? Хичнээн хүн Библийн сургаалиас давж гардаг хүний сургаалд итгэснээсээ болоод гарынхаа салаагаар урсгаж байгаа бол?

Христэд итгэдэг үй олон хүн Бурханы Үгээр амьдралын туршлагаа залахын оронд амьдралын туршлагаараа Бурханы Үгийг тайлбарладаг нь Христийг дагасан энэ олон жилийнхээ хугацаанд миний байнга үзсэн нэгэн эмгэнэл юм. Бурхан бидний туршлагад баригдахааргүй, аугаа Бурхан!

Би Ариун Сүнсээр дүүрэх талаар судлаж байхдаа, уг нь сайн санасандаа боловч, намайг хэлээр ярихад саад хийхийг оролдсон итгэгч хүмүүстэй зөндөө тааралдаж явлаа. Есүст итгээд хэдхэн сар болж байхад минь намайг хүмүүст зориулж аврал зарын материал хэвлэж тараадаг кампусын үйлчлэлийн удирдагчтай уулзуулсан юм. Уг нь би тэр бүлгийнхэнд ихэд талархаж явдаг.

Гэхдээ тэр уулзалтан дээр би гүн цочроонд орж билээ. Ерөнхийлөгч нь удирдагч болгоноос тухайн семестрийн нэн чухал залбирлын сэдвийг нь асуув. Нэгэн залуу дунджаар “В” дүнтэй гарахын төлөө залбирч байгаа гэв. Нөгөө нь өрөөнийхөө найзын авралын төлөө залбирч байгаа гэв. Тэгээд миний ээлж ирэхээр нь би зүгээр л: “Би яг Библи дээр хүмүүс Ариун Сүнсийг хүлээж аваад, хэлээр ярьдаг шиг Ариун Сүнсийг хүлээж авмаар байна” гэж хэлэв.

Ингэж хэлэнгүүт гол удирдагч нь тэр даруй, илтэд түгшсэн байдалтай: “Жон, энэ талаар хурлын дараа ярья” гэж билээ.

Тэгээд хэзээ ч яриагүй. Гэтэл намайг Эзэн дээр авчирсан хуурай ах маань хурлын дараа намайг зайдуу аваачаад: “Жон, наадуул чинь хэлээр ярихад итгэдэггүй” гэж хэлсэн юм.

Шинэхэн итгэгч - миний бие түүн рүү бүлгийтлээ хараад: “Юу, эд Библид итгэдэггүй юм уу?” гэж асууж билээ.

Энэ явдал намайг гэдрэг ухрахад хүргэв. Учир нь, манай хуучин урсгал чиглэл доктриноо Бичээс дээр гэхээсээ илүү хүний сургаал дээр суурьлуулдаг байсан юм. Үнэндээ, өөрсдөө Библиэ уншилгүй, зүгээр л пастораараа тайлбарлуулахыг дэмждэг байсан юм. Би чуулганд арван есэн жил явахдаа, өөрийгөө тэнгэр рүү л яваа гэж бодсон ч, үнэндээ там руу чиглэж явжээ. Тиймээс хуурай ахаараа дамжуулан Бичээс дээрээс Бурханы авралын төлөвлөгөөг олох үедээ ойлгосон ч, ойлгоогүй ч хамаагүй, Бурханы Үгд итгэхээр нэг мөр шийдэв! “ЭЗЭНээс эмээхүй нь Мэргэн ухааны эхлэл” (Дуулал 111:10) гэдэг чинь энэ л байхгүй юу.

ЕРӨӨГДӨХ ҮҮ, МЭДЭХГҮЙ ЯВАХ УУ?

Танд дуулгах сайн мэдээ надад байна аа: Таныг Ариун Сүнсээр дүүргэж, тэнгэрийн хэлээр залбируулах нь танд хандсан Бурханы хүсэл! Үнэндээ, танд зориулсан Бурханы зүрхний хашхирааг үзнэ үү:

“...та бүхнийг хэл ярихуйгаар яриасай гэж хүсдэг”
(1Коринт 14:5).

“Наадах чинь Коринтчуудад хандсан Паулын үг” гэж үү?

Үгүй юм. Учир нь “Бичвэрийн нэг ч эш үзүүллэг эш үзүүлэгчийн өөрийнх нь тайлбараар ирээгүйг юуны түрүүнд мэдэгтүн” (2Петр 1:20), “Бичвэр бүр Бурханы амьсгалснаар бөгөөд заахуй, зэмлэхүй, залруулахуй, зөвд чиглүүлэхүйд тустай” (2Тимот 3:16) гэсэн байдаг. Товчхондоо, энэ нь Коринтод хандсан Паулын үг бус, харин “Учир нь та нар устах үрээс бус, харин үл устах үрээс буюу Бурханы амьд, оршин буй үгээр дахин төрсөн билээ” (1Петр 1:23) гэдэг учраас, бидэнд хандсан Бурханы Үг болой. Үнэндээ Бурхан хүүхдүүддээ “Би та нарыг бүгдийг чинь хэлээр ярихыг хүсч байна!” хэмээжээ.

Хүн итгэдэггүй зүйлээрээ ерөөгдөж чадахгүй. Энэ үгийг дахиад хэлнэ үү: “Бурхан бидний учир шалтгаан, хэрэгцээ, мэдрэмжээр бус, итгэлийн улмаас хөдөлдөг. Есүс хүмүүстээ “Итгэлээр чинь болог” хэмээн айлдахыг та байнга харна. Итгэл нь Бурхан хийнэ гэснээ хийх болно гэдэгт итгэх явдал. Итгэл нь хүний алдаатай итгэлийг бус, харин Бурханы Үгийг сонсохоос ирдэг.

Бид туршлагаа бус, үнэнийг номлож, үнэнд итгэх нь амин чухал. Туршлага нь үнэний гайхамшигтай баталгаа мөн боловч, үнэний багш биш. Ариун Сүнс л бидний Багш бөгөөд Ариун Сүнс Бурханы бичмэл Үгийн эсрэг хэзээ ч ярихгүй. Тэгвэл олон хүн эсрэгээрээ буюу эхлээд туршиж үзчихээд, дараа нь итгэхийг хүсдэг. Энэ нь дахиад л Томаст хэлсэн Есүсийн үгийг дүрсэлж байна. Бидэнд сонголт бий: итгэлээ бусдын туршлага дээр суурьлуулах уу эсвэл дараах Үгийг бичсэн Нэгэний Үг дээр суурьлуулах уу?

Бурхан бол худал хэлдэг хүн биш, Гэмшин харамсдаг хүмүүн ч бус. Тэрээр айлдчихаад, Түүнийгээ хийхгүй гэж үү? Эсвэл Тэр ярьчихаад, Түүнийгээ сайн болгохгүй гэж үү? (Тооллого 23:19)

Эцэст нь дүгнэхэд, Паул Ариун Сүнсний хэлээр ярих тухайд бид бүгдэд: “...та нар мэдлэггүй байхыг би хүсэхгүй байна” (1Коринт 12:1) гэж хэлжээ. Дараа нь Паул бидний энэ бүлгээрээ ярьсан юмсыг гүнзгийлж ярьжээ. Тэгээд эдгээрийн талаар ярьсныхаа эцэст:

“Хэрэв хэн нэг нь үүнийг мэдэхгүй бол тэр хүн өөрөө мэдэгдэхгүй болно” (1Коринт 14:38) хэмээн маш тодорхой дүгнэсэн байна.

Өөрөөр хэлбэл, Бурхан Паулаар дамжуулан “Хэлний асуудал дээр Би та нарт хүслээ тодорхой мэдүүлсэн. Та нар мэдлэггүй хэвээрээ үлдэхийг сонгобол, мэдлэггүй чигээрээ үлдээд, Миний хангамжаар ерөөгдөхгүй” л гэжээ. Бурхан Паулаар үүнийг бичүүлж байхдаа, хожим үүнийг хэлэлцүүлэг болгох (гэтэл эртний чуулганы үед үүнийг асуудал болгож байгаагүй) хүмүүсийг урьдаас хараад, гашуудсан байх даа.

Дахиад хэлье: Бурхан биднийг мэдлэггүй байдал дотроо үлдэж болно гэсэн. Гэхдээ тэгэх аваас, эцэст нь:

“Хэл ярихуйгаар ярихыг бүү хоригло” (1Коринт 14:39) гэжээ.

Энд нэгэн сэрэмж оршиж байна: Хэл рүү дайрч байгаа хүн нь шууд Эзэнд дуулгаваргүй авирлаж байгаа ажээ. Хожмын өдрүүдэд мэдлэггүй юмуу зөрүүд гөжүүд байдлаасаа болоод Өөрийнх нь хонин сүрэгт “хэлээр ярих нь Бурханаас бус, улирсан явдал” гэх үзэгдэл гарахыг Бурхан мэдэж байжээ.

Дараагийн бүлэг рүүгээ орохоосоо өмнө би дахиад нэг хэлье: Хүүхдүүддээ өгсөн Бурханы гайхамшигтай хангамжийг ойлгоод, итгэдэг хүмүүст өгдөг Ариун Сүнсний дотнослын гайхамшигтай хэлийг олж аваарай.

(Тэмдэглэгээ: Та Ариун Сүнсээр дүүрээгүй байгаа бол, Б Хавсралтыг гаргаарай. Би таныг Ариун Сүнсийг хүлээж авах залбиралд хөтөлмөөр байна.)

СУДЛАХ АСУУЛТ

1. Бүлгийн эхэнд зохиолч оюутан насныхаа балчир итгэлийг өгүүлсэн. Тэрбээр шинэ амьдарлаар амьдарч, Бичээст шамдаж байсан ч, нэг л юмаар дутагдаад байжээ. Таны амьдралд ийм явдал тохиолдож байсан уу эсвэл одоо тохиолдож байгаа юу?
2. Хэлээр ярих тухай энэхүү судлалыг үзээд, итгэл чинь хэрхэн өөрчлөгдөв? Бурхан Таныг Сүнсээрээ дүүрж, тэнгэрийн хэлээр ярихыг хүсдэг гэдэг мэдээ танд хэрхэн нөлөөлөв?
3. Та шалтгаантай болоод л энэ номыг уншиж байгаа байх. Тодруулбал: ямар нэгэн үйл явдал, туршлагын улмаас л, Бурханд ойртох нь ямар утгатай болохыг судлаж байгаа байх. Гэхдээ яг энэ судлалаар чинь дамжуулж Бурхан Өөртэй нь хэрхэн дотносохыг танд заагаад байгаа биш үү? Хувийн бөгөөд зуучлан залбирлын хэлний бэлэг нь Эзэнтэй дотно явах удаах алхам чинь байж болох уу?

Арванхоёрдугаар бүлэг

ДОТНОСЛЫН ХЭЛ



Бурханы зөвлөгөөний цэц ухаан нь гүн усан бөгөөд хүмүүний оюун ухаанд тайлагдашгүй байх нь олонтаа.

Би үүнийг ахин дахин бичсэн боловч, таны орой руу оруулахын тулд дахиж хэд ч давтахаас буцахгүй: *Бурхан тантай дотносохыг улайран хүсдэг.* Бурхан тантай нөхөрлөхийг улайран хүсдэг. Тантай харилцахаар барахгүй, тэр харилцаа нь баялаг, амьд байгаасай хэмээн хүсдэг.

БУРХАНТАЙ ӨӨРИЙНХ НЬ ТӨВШИНД НӨХӨРЛӨХ (НЭГДЭХ)

Энэ элбэг дэлбэг нөхөрлөл (нэгдэл) нь бодитоор биелэхийн төлөө Бурхан бидэнд Өөрийнх нь төвшинд нөхөрлөх арга замыг гаргаж өгчээ. Тайлбарлахыг минь болгооно уу. Бичээс:

“Хэл ярихуйгаар ярьдаг нь хүмүүст бус, харин Бурханд ярьдаг” (1Коринт 14:2) гэдэг.

Паул нийтэд хандсан хоёр төрлийн хэлний алийг нь ч хэлээгүй байна. Учир нь энэ хоёр тохиолдол дээр өгүүлэгч хүн Бурханы Үгийг өөрийн мэдэхгүй хэлээр сонсогч нарт хүргэдэг. Паул дээрх Бичээс дээр ямар үед Бурханд залбирах юмуу Бурхантай нөхөрлөх талаар өгүүлжээ. Иймд бид хэлээр *залбирахдаа*, хүнд бус, шууд Бурханд ханддаг. Түүнчлэн Паул: “Учир нь яаж залбирах ёстойгоо бид мэддэггүй юм. Харин Сүнс Өөрөө үгээр илэрхийлшгүйгээр ёлон бидний төлөө зуучлан гуйдаг” (Ром 8:26) гэсэн. Тэгэхээр, энд ч бас дахиад л Бурхантай нөхөрлөхөд (нэгдэхэд) үүсдэг хоёр онцгой саадыг хэлжээ: Бид ихэвчлэн юу залбирахаа мэддэггүй. Хоёрдугаарт - хэрхэн залбирахаа мэддэггүй.

Үүнийг дараагийн түүх яруу тод дүрсэлнэ. Надад Америкийн Нэгдсэн улсын ерөнхийлөгчтэй уулзах завшаан олдбол, би ерөнхийлөгчтэйгээ яг ерөнхийлөгчийн зиндаанд харилцаж чадах уу? Мэдээж үгүй. Ерөнхийлөгч л миний ойлголтын төвшин рүү бууж ярилцана. Энэ улсын хэрэг явдлын талаар ерөнхийлөгч надаас хавьгүй их мэдэх бөгөөд тэр дунд олон нийтийн мэдэхгүй, нууцын зэрэглэлтэй юмс ч байгаа. Ерөнхийлөгч Америк улсын төлөвлөгөө, төслийг мөн буруу гарт орбол, үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулах учир, нууцад хамааруулдаг нөхцөл, коодыг ч мэднэ.

Үүнтэй адил, би ертөнцийн Хааны албан өрөө - сэнтийн өрөө рүү хүнийхээ ойлголтоор залбиран нэвтрэх юм бол, бидний харилцаа хязгаарлагдана! Эзэн надаас хавьгүй ихийг мэддэг тул би Түүний төвшинд хүрч харилцаж чадахгүй. Эзэн л миний ойлголтын төвшин рүү бууж байж надтай харилцана. Дээрх жишээтэй адил, Бурхан ертөнцийн хэрэг явдал - энэ дундаа мөн л буруу гарт орохоос сэргийлэх зэрэг үй түмэн шалтгаанаар битүүмжилсэн нууцлалыг мэднэ. Үүнийг Паулын анхааруулгаас тодорхой харж болно:

харин бидний алдрын төлөө үеүдээс ч өмнө Бурхан урьдаас тогтоож, нууц дотор нуусан Бурханы мэргэн ухааныг бид ярьдаг. Үүнийг энэ үеийн захирагчдаас хэн нь ч мэдсэнгүй. Хэрэв тэд мэдсэн байсан бол алдрын Эзэнийг цовдлохгүй байх байсан (1Коринт 2:7-8).

Энд онцгойлон Эзэн Есүсийн цовдлол, амилал, үүний араас дагалдсан алдрын тухай өгүүлж байгаа хэдий ч, энэ нь Бурхан Өөрийнхөө цэц ухааныг буруу гараар оруулахгүй байхыг баталгаажуулж буйн нэгэн жишээ болно. Ийм жишээ олон бий (Матай 7:6). Бичээс биднийг энэхүү харанхуй ертөнцийн захирагчид, эрх мэдэл, хүчнүүд, тэнгэрлэг оршихуй

дахь ёрын муу сүнслэг хүчинтэй дайтаж яваа (Ефес 6:12) гэдэг. Жирийн дайн дээр манай талынхан ч, дайсны талынхан ч дундаа харилцаа холбооны нууц хэлтэй байдаг. Тэгвэл тэнгэрийн их цэргийн Удирдагч - хаанчлалын дайчдын хооронд ч харилцаа холбооны нууц хэл бий. Эзэн маань хүүхдүүд - биднийхээ тусын тулд бас Хаанчлалынхаа төлөө үнэхээрийн шилдэг нууц харилцаа холбоог үүсгэжээ. Биднийг хэлээр Ааваасаа юу гуйж байгааг дайсан сонсоод ч, ойлгохгүй. Чөтгөрийн хүчин бидэн рүү, бидний хайртай хүмүүс рүү довтлох төлөвлөгөө боловсруулав ч, биднийг хэлээр залбирах үед тэнгэрээс гэнэтийн нэмэлт хүч бууж, чөтгөрүүд ч алингаа алддаг байна. Ийнхүү чөтгөрүүд нэг мөр сүйрэхээсээ өмнө санд мэнд арилцгаана.

ҮНДСЭН ЗОРИЛГО

Хэлээр залбирахын үндсэн зорилго нь чухал мэдлэгийг буруу гарт орохоос хамгаалах явдал биш ажээ. Хэлээр залбирахын үндсэн зорилго нь дотносол болой. Гэргий, бид хоёр олон жил ханилахдаа, өөрсдийн гэсэн хосгүй онцгой харилцааг хөгжүүлсэн. Өрөө дүүрэн хүмүүсийн дунд бид хоёр өөр хэний ч ойлгохгүй, зөвхөн хоорондоо л ойлголцох аргаар харилцаж чадна. Бид хоёрын дунд дотнослын хэл байдаг. Ийм харилцаа дан ганц эхнэр - нөхөр гэлтгүй, ойр дотно харилцаатай бүх хүний дунд оршдог. Унаган багын найзууд, он удаан жил түншилсэн ажлын найз нөхөд, мөр зэрэгцэн тулалдаж явсан дайчин нөхөд гэх зэрэг. Товчхондоо, тэд өөр хоорондоо нөхөрлөлийн хэлийг үүсгэж хөгжүүлжээ.

Үүнтэй адил, Бурхан бидэнд Өөртэй нь хүний авралгүй ухаанаар хүрэх аргагүй, гүн гүнзгий төвшинд харилцаж, нөхөрлөх арга зам тавьж өгчээ. Магтаалч үүнийг зөгнөн хараад: “Таны хүрхрэнүүдийн дуунд Оёоргүй гүн оёоргүй гүнийгээ дууддаг. Таны давалгаа, долгио намайг нөмрөв” (Дуулал 42:7) хэмээн бичжээ. Энэ харилцааг гүн устай зүйрлэсэн байна. Есүс бидний зүрхнээс “... амьд усны гол урсахыг” айлдсан байдаг. Гэхдээ энд “Өөрт нь итгэсэн хүмүүсийн хүлээн авах” Сүнсний тухай өгүүлжээ (Иохан 7:38-39). Эзэнтэй тогтоох дотно нөхөрлөлийг (нэгдлийг) маань амьд ус урсахтай харьцуулжээ. Ариун Сүнс бидэнд ямар гайхамшгийг өгөө вэ! Бидэнд баталгаажуулсан чадварыг нь бодохоор ухаан хүрэшгүй!

За, цаашаагаа бүр сонирхолтой болж ирнэ. Паул хэлээр залбирдаг итгэгчийн тухай ингэж хэлжээ.

“...Тэрээр нууцуудыг (нууцлалуудыг) сүнсээр ярьдаг ч сонсон ухаарагч нь үгүй ажээ” (1Коринт 14:2).

Нууцлал гэдэг нь юуг хэлнэ вэ? Үүнийг Грекээр *мустерион* гэдэг. Грек Шинэ гэрээний мэргэжилтэн Даблью. Ий. Вайн энэ үгийн тухайд: “Энэ нь Шинэ гэрээнд (Англи үг шигээ) нууц юмыг илэрхийлсэн бус, харин хүний жирийн ухаанаар тайлж ойлгошгүй, гагцхүү Ариун Сүнсээр гэгээрүүлэгдсэн хүмүүст л... зөвхөн тэнгэрийн илчлэлээр л тайлагдах боломжтой байх” гэсэн утгатай үг ажээ. Хялбаршуулбал, “нууцлал” нь Бичээсийн цаг нь ирэхээр илчлэх, битүүмжлэгдсэн үнэн - мэдлэг юм” гэжээ.

Тэгэхээр, хэлээр залбирахын олон ач холбогдлын нэг нь энэ ажээ. Ариун Сүнс - Бурхан Есүсийн ч, Аавын ч оюун бодлыг мэддэг. Тэд чинь нэг Бурхан. Ариун Сүнс бас бидний мөнхийн Хань нөхөр учраас, бид юугаар дутагдаж байгааг ч мэднэ. Тиймээс бидэнд төгс хэв маягаар асууж, хайж, нөхөрлөх (нэгдэх) тэнгэрийн үгийг өгч зуучилдаг байна. Ямар сайхан бэ! *“Гэхдээ хэлээр залбирахаар чинь би юу залбирч байгаагаа мэдэхгүй шүү дээ”* гэж үү? Тийм ээ, тиймээс л Паул:

“Тиймд хэл ярихуйгаар яригч нь тайлбарлахын тулд залбираг. Учир нь би хэл ярихуйгаар залбирвал миний сүнс залбирдаг бөгөөд харин ухаанд минь үр жимс үгүй” (1Коринт 14:13-14) гэжээ.

Тиймээс хүсэлт тавихдаа ч, зуучлан залбирахдаа ч эсвэл зүгээр л Бурхантай нөхөрлөхдөө, сүнсэнд минь ямар залбирал өгч байгааг ойлгуулж өгөхийг гуйвал, Ариун Сүнс өгнө! Ийнхүү энэ нөхөрлөлд сүнс минь төдийгүй, сэтгэл минь ч баясна.

ИЛЧЛЭГДСЭН МЭДЛЭГИЙН НЯРАВ БАЙХ

Ийм нөхөрлөл дотор явахад, Эзэний илчлэлүүд нь гэнэт л Бичээсээс амилан гарч ирэх нь олонтаа бөгөөд миний бие өдий хүртэл эдгээр үнэнийг л бичиж, номлосоор ирсэн билээ. Гэхдээ миний заагаагүй үнэн ч олон бий.

Яагаад заагаагүй юм бол гэж үү? Цаг нь биш эсвэл Бурхан хүмүүстээ өөр зүйлийг онцолж хэлэхийг хүсэх гэх зэрэг олон шалтгаан бий. Бид чинь Бурханы ам хэл болсон, Хаанчлалын элчин сайдууд бөгөөд Бурханы хэлэхийг хүссэн юмс гэж байдаг бол, хэлэх цаг нь болоогүй юмс ч гэж бас байдгийг санууштай.

Би үүнийг яс махаараа сурсан юм. Бөмбөрцгийн нөгөө тал дээр нэр алдраа гийгүүлсэн Бурханы нэгэн хүнтэй уулзав аа, би. Түүний үйлчлэлийн талаар дуулаад, биширсэндээ, уулзахыг хүссэн минь тэр. Бид хоёрыг өөр нэгэн пастор зуучилж уулзуулав. Миний баярласан гэж. Тэгээд пастор, Бурханы хүн бид гурав, дээрээс нь бидний гурван гэргий - нийт зургуулаа оройн зоог барив. Хоолон дээрээ би нөгөө Бурханы хүнд гүн сэтгэгдэл төрүүлэх гэсэндээ, Бурханы надад зааж өгсөн хамгийн л нарийн нандин илчлэлийг дэлгэж орхив. (Уг нь санаатайгаар хийгээгүй боловч, одоо бодоход тийм л сэдэлтэй байснаас гарцаагүй. Даанч төлөвшилгүй байж дээ.)

Орой нь нөгөө зуучлагч пастор гэргий, бид хоёрыг зочид буудалд маань хүргэж өгөв. Урт өдрийн сүүлэн дээр гэргий, бид хоёр ихэд ядарчээ. Гэхдээ сүнсэнд минь тэглээд байгаа таагүй мэдрэмж ядарч цуцсантай маань огт холбоогүй байв. Тиймээс Эзэн надаас залбирал хүсч байгааг ойлгоод, гэргийдээ түрүүлээд унтаж бай л гэлээ. Гэргий минь ч зөвшөөрөөд, харин би ганцаараа залбирахаар өрөөнийхөө тагтан дээр гарав. Тэгээд тагтны босгоор давав уу үгүй юу, “Зэ, манай хаан өнөө орой гэрийнхээ хамаг эрдэнэсийг үзүүлэв!” хэмээн хатуу зэмлэх Ариун Сүнсний дуу хоолойг сонссон юм.

Дотор пал хийгээд л явчихав. Би гүнээ цочирдож бас нүүр улайв. Ариун Сүнс Хезекиагийн алдааг цохож буйг би мэдэж байлаа. Хезекиа зочдоо бишрүүлэх гэсэндээ:

...тэднийг хүлээн авч тэдэнд өөрийн бүх эрдэнэсийн сан, мөнгө, алт, анхилам үнэртэн, үнэт тос, зэвсгийн агуулах болон өөрийн бүх агуулахад байсан бүгдийг үзүүлэв.
Хезекиагийн гэрт болон бүх эзэмшилд нь тэдэнд түүний үзүүлээгүй нэг ч зүйл үлдсэнгүй (Исаиа 39:2).

Хамаг эрдэнэсээ дэлгэсэн хойно нь эш үзүүлэгч Исаиа Хезекиад Эзэний зэмлэлийг дамжуулсан байдаг. Гэтэл би яг ингэжээ. Тэр орой би хүнд “гайхуулах” гэсэндээ, Эзэний надад л зориулж үзүүлсэн хамаг үнэнийг буюу эрдэнэсийг дэлгэчихсэнээ мэдэж байлаа.

Тэгтэл Бурхан надад: “Хүү минь, Би чамайг дуртай үедээ дуртай газраа дэлгээд байгаарай гэж нандин үнэнээ илчлээгүй. Тэр чинь гайхуулахын төлөө өгөгдөөгүй! Чи чинь Миний чамд илчилж өгсөн юмсын нярав бөгөөд Намайг ярихаас нааш ярих ёсгүй” хэмээн айлдаж билээ.

Би газар дээрээ гэмшээд, уучлал гуйтал, дарамт ч арилж, би ч амар тайван хажуулав. Бурханы өршөөл юутай сайхан!

Ухаантай хүн хоорондын юмсаа хөндлөнгийн этгээдэд ам алдахгүй, чанга хүнийг л ойр байлгана. Дотно нөхөд нэг нэгийнхээ талаар мэддэг зүйлстээ ухаалаг ханддаг. Нууцыг чинь байнга задгайлж явдаг найзтай бол, таны юмыг нарийлж нандигнахгүй байгаа хүнд юу хэлэх, хэлэхгүйгээ бодож үзмээр. Эзэний нууцын тухайд ч ялгаагүй юм. Бурханы зүрхийг хуваалцахыг хүсч л байгаа бол, Бурхан хэзээ, хаана, юугаа хуваалцахыг хүсч байгаад мэдрэмжтэй байж сур.

БУРХАНЫ ЗӨВЛӨГӨӨГ ТАТАЖ АВАХ

Намайг залбирах юмуу Бурхантай нөхөрлөх (нэгдэх) үед санаа, илчлэл, цэц ухаан, сургаал зүгээр л толгойд бөнжийн орж ирдэг. Тухай нь, далайн гүнд дарагдсан агаар усны мандал дээр хөөсөн бөмбөлөг болон пог - пог хийхтэй адилгаж болох. Дотор хүний маань цөмөөс харвасан санаанууд оюун ухаан, ойлголт дотор маань хөөсөн бөмбөлгүүд шиг л бөнжигнөнө. Бичээс:

Хүний сүнс ЭЗЭНий дэнлүү Хамаг дотрыг нь нягталюу
(Сургаалт үгс 20:27) гэдэг.

Ариун Сүнс бидний толгойд бус, сүнсэнд өгүүлдгийг санаарай. Ариун Сүнс гэгээрлээ бидний сүнсэнд л өгдөг байх нь. Сүнс дотор залбираад, үүнийхээ тайлбарыг асуух үед Бурханы цэц ухаан юмуу зөвлөгөө зүрхнээс маань хөөсрөөд, ойлголт буюу оюун ухааны маань талбар дээр үлээгдэн гарч ирдэг ажээ. Бичээс:

“Хүний зүрхэн дэх зорилгууд (зөвлөгөө) гүний ус Ухаан
бодролт хүн үүнийг гадагш гаргах” (Сургаалт үгс 20:5) гэдэг.

Зөвлөгөө нь юу вэ? Тухайн онцгой нөхцөлд хэрэгжих цэц ухаан юм. Хүмүүс яагаад зөвлөхөд ханддаг вэ? Тухайн нөхцөлд байдалд нь шаардлагатай, өөрсдийнхөө мэдэхгүй цэц ухааныг олохын тулд.

Гүн худгаас гарах амьд устай адилтгасан Бурханы зөвлөгөөг татаж авч чадах цорын ганц хүн нь ойлголтын хүн буюу “Зөвлөхийнхөө” арга замыг мэддэг хүн байгааг тэмдэглээрэй. Ариун Сүнс Хаанчлалын бүхий л нууцлалыг (буюу илчлэгдээгүй зөвлөгөө, мэдлэг, цэц ухааныг) мэднэ. Есүсийн үгийг буцаад үзье:

Бичвэр хэлсэнчлэн Надад итгэгчийн дотроос амийн

усны гол урсах болно гэв. Есүст итгэгсдийн хүлээн авах Сүнсний тухай Тэр үүнийг хэлжээ. Есүс хараахан алдаршуулагдаагүй тул Сүнс тэнд өгөгдөөгүй байлаа (Иохан 7:38-39).

Сургаалт үгсын дагуу, зүрхнээс ундрах ус нь Бурханы зөвлөгөө буюу нууцлал бөгөөд үүний эх үүсвэр нь Бурханы Сүнс болохыг Есүс шулуухан хэлжээ. Ариун Сүнс л амьд усны оргилуур мөн (Иеремиа 2:13-ыг үзнэ үү). Одоо Паулын үгийг анхааралтай уншина уу:

“харин бидний алдрын төлөө үеүдээс ч өмнө Бурхан урьдаас тогтоож, нууц дотор нуусан Бурханы мэргэн ухааныг (*буюу зөвлөгөөг*) бид ярьдаг. ... Бурхан бидэнд бэлэглэсэн юмсыг мэдэхийн тулд бид ертөнцийн сүнсийг бус, харин Бурханы Сүнсийг хүлээн авсан юм. Бид үүнийг хүний мэргэн ухааны сургасан үгсээр бус, харин Сүнсний сургаснаар, сүнслэг зүйлсийг сүнслэгт нь тайлбарлан ярьдаг” (1Коринт 2:7, 12-13, тодруулгыг нэмэв).

Тэгэхээр, Бурханы цэц ухаан буюу зөвлөгөө нь гүн усан бөгөөд хүмүүний оюун ухаанд тайлагдашгүй байх нь олонтаа. Тийм боловч амьд ус нь Ариун Сүнсээр гарахыг Есүс хэлсэн. Хэрхэн? Паул тодорхой хэлжээ:

“Хэл ярихуйгаар ярьдаг нь хүмүүст бус, харин Бурханд ярьдаг. Тэрээр *нууцуудыг (нууцлалуудыг)* сүнсээр ярьдаг ч сонсон ухаарагч нь үгүй ажээ” (1Коринт 14:2, тодруулгыг нэмэв).

Харав уу! Ойлголтыг тээдэг хүн нь ийм маягаар Бурханы зөвлөгөөг татаж авдаг байх нь. Бичээс оньсого мэт санагдах үе надад тоймгүй олон. Хариулт байхгүй олон асуулт толгойд ширэлдсээр. Ойлголт нь миний хувьд *нууцлал* болдог. Тиймээс ихэвчлэн зүгээр л: “Ариун Сүнс ээ, би үүнийг ойлгохгүй байна. Надад харуулж өгөөч...” л гэж гуйна. Тэгээд зүгээр л хэлээр залбирах ба хэлээр залбирч дууссаны минь дараа тэр даруй юмуу эсвэл төдөлгүй оюун ухаан, ойлголт дотор минь нууцлагдсан үнэний илчлэл бөнжигнөн гарч ирдэг. Энэ гайхамшиг биш гэж үү?

Түүнчлэн номоо бичиж байхдаа мухардаад, таг зогсчих үе ч олонтаа. Цаашаа явах зүг чиг нь *нууцлал* болж хувирдаг. Тэгээд суудлаасаа

босоод, хэлээр залбирах үед голдуу хэдхэн минутын дараа цэц ухаан далан задрахтай адил яах ийхийн завдалгүй үерлэн орж ирэх бөгөөд би номоо хэдэн цагаар үргэлжлүүлэн бичдэг.

Ганц бие явахад, хэнтэй гэрлэх минь *нууцлал* байлаа. Христэд итгэсэн цагаасаа хойш би гурван охинд үнэхээрийн татагдсан бөгөөд Сүнс дотор хэсэг залбирсныхаа дараа Бурхан шууд “биш” гэж байгааг мэддэг байлаа. Тэгээд Лизатай учрахдаа, харилцааныхаа талаар сарын турш өдөр бүр гучин минут хэлээр залбирсан юм. Залбирах бүрий Бурхан надад маш чангаар “зөвшөөрч”, араас нь ч зүйл бүрийн баталгаа өгдөг байв. Гэхдээ нэг зүйлийг хэлмээр байна. Тэр олон баталгаанаас ч өмнө, хэлээр залбирч байхдаа хүлээж авсан маш тунгалаг мэдрэмж, амар тайвныхаа улмаас би Лизаг миний ирээдүйн хань гэдгийг хэдийнээ мэдсэн байлаа.

Миний өөрийн юмуу хайртай хүмүүсийн минь амьдралд тохиолдсон явдал ч миний хувьд *нууцлал* мэт байсан үе олонтаа. Тэгээд зүгээр л тухайн нөхцөл дээр цэц ухаан, үзэл бодлоо хайрлахыг Ариун Сүнснээс гуйна. Тийнхүү хэлээр хэсэг залбирсны дараа Ариун Сүнсний баттай мэдээллийг хүлээж авна.

Гэр бүлийн маань гишүүнд залбирал хэрэгтэй байгааг мэдэхгүй явах үед Бурханы Сүнс над дээр ирээд, түүний төлөө хэлээр залбируулдаг байсан бөгөөд үүгээр дамжин тэнгэрийн тусламж, аюулаас хамгаалахуй буусныг нь хожим ойлгож ухаарах ч явдал гардаг.

Нууцлал нь жирийн оюун ухаанаас битүүлэг юмс юм. Тухай нь: ямар чуулганд явах, ямар үйлчлэлд үйлчлэх, ямар байшин авах, ерөнхийлөгч, удирдагч, пасторынхаа төлөө хэрхэн үр дүнтэй залбирах зэрэг төгсгөлгүй олон асуудал байдгийг та өөрөө мэдэж байгаа байх.

БУРХАНЫ УДИРДАМЖИЙГ МЭДЭХИЙН АМАР АМГАЛАН

Дийлэнх итгэгч хүмүүсийг туйлдаадаг нэгэн нууцлал нь удирдамж юм. Үүнээс л болж хүмүүс зөвлөхөд ханддаг. Тэгвэл танд дуулгах гайхамшигт мэдээ байна! Та дахиж арга мухардах нөхцөлд хэзээ ч орохгүй. Бурхан “Харин та нарын хэн нэг нь мэргэн ухаанаар дутвал (арга мухардбал), бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно” (Иаков 1:5) хэмээн амласан. Асуухад буруу байхгүй. Тэгвэл хэрхэн асуух вэ? Нөхцөл байдлынхаа талаар хэлээр залбирч асуух. Би ч бас зөндөө л арга мухардаж явсан бөгөөд тухай бүр хэлээр залбирахаар, зүрхнээс минь тухайн нөхцөлд шаардлагатай цэц ухаан заавал хөөсрөн гарч ирдэг байв.

Бид ингэж л насан турш үйлчилдэг. Удирдамж дутагдаж, арга мухардах бүрий хэсэг хугацаанд хэлээр залбирахаар, юу юугүй л тэнгэрийн санаа урсаж эхэлдэг. Гэргий, бид хоёрын олон жилийн өмнөөс эхлүүлсэн үйлчлэлийн маань том, том шийдвэр болгон Сүнс дотор залбирсны үр дүнд л төрдөг байв. Өнөөдөр манай үйлчлэл гурван тив дээр гуч гаруй ажилтантай болоод байна (Энэ ном бичигдэж байсан үеийн тоо). Бурхан Үг, оршихуйгаараа сая сая хүний амьдралд хүрэх завшааныг бидэнд хайрласан. Арван дөрвөн жилийн хугацаанд бид нэг ч удаа мөнгө зээлээгүй бөгөөд эдүгээ Бурханы хүмүүст үр дүнтэй үйлчлэхэд шаардлагатай чинээний хөрөнгө, сантай болоод байна. Үүний учир нь Бурханы дараах амлалтад оршино:

Чиний Аврагч, Израилийн Ариун Нэгэн, ЭЗЭН Ингэж айлдаж байна. Чамд тустайг сурган Чамайг явах замаар чинь удирддаг “Бурхан ЭЗЭН чинь Би байна. Тушаалуудад минь анхааралаа хандуулдаг ч болоосой, чи! Тэгвэл амар тайван чинь гол мэт, Зөвт байдал чинь далайн давалгаа мэт байхсан (Исаиа 48:17-18).

Бидний амар тайван яг л гол мөрөн шиг урссаныг би үнэн голоосоо гэрчилж чадна. Үнэхээрийн арга мухардмаар, бэрх нөхцөл байдалд бид зөндөө орж явсан. Гэхдээ хэлээр залбираад, Бурханд ажлаа даатгамагц, амьдралыг минь амар тайван нөмрөөд л авдаг. Хэлээр залбирах тал дээр:

Үнэхээр Тэр энэ ард түмэнд хандаж Шулганасан уруул, харь хэлээр дамжуулан ярих болно. Тэр тэдэнд “Энд амралт байна. Эцэж туйлдагсдад амралтыг өгөгтүн. Энд тайван байна” гэсэн боловч Тэд сонсохгүй байх юм (Исаиа 28:11-12) гэжээ.

Амар тайвангүй хүмүүс нь амралтгүй хүмүүс юм. Дээрх эшлэл дээр Бурханы өгүүлсэн амралт нь гол мэт урсах амар тайвны үр дагавар ажээ. Би үүнийг батлах олон гэрчлэл хэлж чадах ч, нэгийг онцлон ярьмаар байна. Нөхцөл байдал маань тун горьгүй байсан тул би амар тайвнаа алдахын даваанд тулаад байсан үе л дээ. Тэр явдал намайг Сайн мэдээний аян дээр номлохоор Мексикт зочлох үед болсон юм. Би Монтерэйд ганц удаагийн оройн цуглаан дээр номлохоор очоод байлаа. Цуглаан хотын төвийн, том зааланд болохоор байв. Тэр өдөр би

өдөржин хэлээр залбирахдаа, тэнгэрээс нэгэн хурц гэрэл цуглаан болох заалны орой руу чиглэн буухыг үзэв. Эзэн ч зүрхэнд минь: “Энэ бол өнөө орой үзүүлэх Миний алдар” хэмээв.

Орой нь цуглааны гол зохион байгуулагч - пастор, бид хоёр зааландаа догдолсоор орж ирэв. Чуулган ч Сайн мэдээний аяндаа сайтар бэлтгэжээ. Цуглаан эхлэхээс арван таван минутын өмнө орж ирэхдээ би, зэвсэгтэй хоёр цэрэг дагуулсан, догшин царайтай нэгэн эрхэм зохион байгуулагч - пастортай уулзахыг нь анзаарав. Тэрбээр Испаниар ярьж байсан ч, таатай юм ярихгүй байгаа нь илэрхий байлаа. Тэгтэл пастор над дээр хүрч ирээд: “Жон, та өнөөдөр номлож болохгүй нь” гэв.

Би ч: “Яагаад?” л гэлээ.

Пастор: “Саяын хүн төрийн өндөр албан тушаалтан. Мексикийн иргэнээс өөр хүн Мексикт Сайн мэдээ номлож болохгүй гэсэн хууль байдаг юм байна. Энэ хуулийг ер нь сахидаггүй боловч, энэ хүн хуулиар далайлгаад байна. Дагахгүй бол, та л асуудалд орох бололтой. Үнэндээ, энэ хүн тантай ч уулзахыг хүсч байна” гэв.

Надад ч шууд л Сайн мэдээ номлохыг хориглосон удирдагч нарынхаа Бурханы Үгийг зөрчсөн тушаалыг нь сахилгүй өнгөрөөсөн Петр, Иохан хоёр санагдлаа. Тиймээс би пасторт: “Энэ орой Бурханы болно хэмээн харуулсныг энэ хүн зогсоож чадахгүй! Энэ бүхэн танай чуулганд нөлөөлөх үү? Нөлөөлөхгүй гэвэл, би энэ хүнийг явсны дараа зүгээр л номлоно. Би юу ч хийлгүй, зүгээр суух гэж тэр холоос ирээгүй. Харин та нарт хортой үр дагавартай бол, яахав номлохгүй” гэв.

Пастор: “Жон, энэ хүн чуулгануудад үргэлж түвэг болдог. Тиймээс хэлснээр нь хийх нь дээр байх” гэлээ. Би ч пасторын зөвлөгөөг хүлээж аваад, албан тушаалтантай уулзахаар очлоо.

Албан тушаалтан намайг харуугаа, хамгийн түрүүнд: “Испаниар ярьдаг уу?” хэмээн зандрангуй асуув.

“Ярьдаггүй, эрхэм ээ” л гэлээ.

Тэгтэл: “Нэг л юм хэлье. Та энэ хүмүүст аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагааны талаар л ярина” гэв. Тэгээд эргээд, нөгөө пасторт Испаниар юм яриад явчих хооронд зэвсэгтэй цэргүүд нь бидэн рүү их л сүрдэм царайгаар цоо ширтэж байлаа. Ийнхүү нөгөө албан тушаалтан анхааруулж, анхааруулж л, яваад өгөв.

Цочирдсон пастор ч надад үйлчлэх боломж гаргаж өгч чадахгүйдээ уучлал эрээд, цуглааныхаа үлдсэн жижиг сажиг бэлтгэлийг базаахаар заал руу орлоо.

Миний гонсойсон гэж. Надад Бурханы зөвлөгөө хэрэгтэй байв - цаашид яах ёстой нь миний хувьд нууцлал байв. Тиймээс би танхимаас

гараад, залбирч болохоор, хүнгүй шахам газар очив (Хотын төвд хүнд гав ганцаараа байх газар олддоггүй шүү дээ.) Сүнсээр залбирснаар л Бурханы зөвлөгөөг олж авахыг би мэдэж байлаа. Тэгээд хэлээр зоригтой залбирч гарав. Хажуугаар зөрсөн хэдэн хүн намайг нааш цааш холхингоо, өөртэйгээ ярьж байгаа гадаад хүн байна л гэж бодоо байх.

Хэлээр хэсэг залбирсны дараа сэтгэлд минь Бурханы амар тайван дүүрч эхлэв. Арван тав орчим минутын дараа гэнэт нэгэн бодол зүрхнээс минь өөдөө хөөсөрсөөр, би “Библиэ далд хийгээд, хүмүүст Мексикт айлчилсан хамгийн аугаа Жуулчны талаар ярьж өг” гэхийг сонсов.

Би ч баярласандаа дэвхцээд: “Нээрээ, тийм шүү дээ. Тэр хүн аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагааны талаар ярьж болно гэсэн! Би хүмүүст Мексикт айлчилж ирсэн, хамгийн аугаа Жуулчин - Есүс Христийн тухай ярьж өгье” хэмээн дуу алдлаа.

Тэгээд бушуухан заал руугаа буцав. Цуглаан ч эхэлж, пастор тэргүүн эгнээнд зогсоод, зочидтой мэндчилж байлаа. Тэгтэл заалны ард зогсож байсан гэргий нь: “Жон, пастор таныг урагшаа хүрээд ирээрэй гэнэ” хэмээв.

Урагш очтол, пастор намайг үзээд: “Бурхан Өөрийнх нь зааврыг л дагаарай гэж танд хэлүүлж байна” хэмээн шивэглэлээ.

Би ч хүмүүст хандан: “Найзууд аа, төрийн албан тушаалтан надад та бүхэнд зөвхөн аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагааны талаар л ярихыг зөвшөөрсөн. Тиймээс би та бүхэнд Мексикт айлчилсан, хамгийн аугаа Жуулчны талаар ярьж өгмөөр байна. Тэр бол Есүс” гэлээ.

Танхимд сууж байсан итгэгч хүмүүс баярлан хашхиралдав. Тэгээд би жаран минутын турш Бурханы Үгийг номлосон юм. Номлож дуусаад, хуучин амьдралаа орхиж, Есүст амьдралаа захируулах хүсэлтэй хүмүүсийг урагш урив.

Хүмүүсийг бөөнөөрөө урашлахтай зэрэгцэн заалны ард явж байсан цагдаа шууд л тайз руу чиглэхийг анзаараад, дотроо “*Баривчлагдахаасаа өмнө амжиж энэ хүмүүсийг авралд хүргэх ёстой*” л гэж бодлоо. Үзэсгэлэнт хаалганы дэргэд номлоод, хүмүүст хэрхэн аврагдахыг нь ч зааж амжилгүй баривчлагдсан Петр, Иохан хоёр л бодогдоод байлаа. Тиймээс урагшаа гарч ирсэн хүмүүсийн авралын төлөө бушуухан шиг залбирав. Залбирсныхаа дараа нөгөө цагдаа хажуугаар явсаар намайг өнгөрөөд, тайзны хөшигний араар орсон байхыг үзэв. Тэгээд хүмүүст үйлчлэх боломж олдсонд, жаал уужирсан юм.

Дараа нь хүмүүсийг илүү нарийн үйлчлэл үзүүлэх зөвлөхүүд рүү чиглүүлэв. Хүмүүс ч тайзнаас буух хооронд нэгэн хөл муутай хүн нүдэнд туссан бөгөөд Ариун Сүнс зүрхэнд минь: “Би энэ хүнийг хамгийн

түрүүнд эдгээмээр байна. Түүнийг зогсоогоод, даруй залбирч өг” гэв.

Би ч шууд л хэлснээр нь хийж, тэр хүний төлөө залбирч дуусаад: “Эрхэм ээ, одоо таягаа хая” гэлээ.

Тэрбээр над руу би чадахгүй шүү дээ гэсэн аятай харсан ч, миний тууштай ятгалгад автан, үгэнд оров. Тэгээд гараас бариад, хамтдаа алхлаа. Удаанаар эхэлсэн боловч, яваандаа хурдалсаар, сүүлдээ бүр хамт гүйв.

Танхим ч доргиод л явчихлаа. Хүмүүс энд тэндээс түрсээр, тайзан дээр зуу зуун хүн пиг дүүрэв. Олон хүн Ариун Сүнсний хүчээр эдгэрэв. Заримаас нь дурьдахад: Нэгэн дүлий эмэгтэйн төлөө залбиртал, Эзэн чихийг нь нээв. Тэрбээр бүдэг цэнхэр цамцаа тод цэнхэр болон шалчийтлаа нортол нь асгаран уйлав. Бурхан өөр нэг эмэгтэйн нүдийг эдгээж бас нэг хүний хорт хавдрыг эдгээв.

Дараа нь бид таван настай хүүхдийн төлөө залбиртал, тэр эдгэрэв. Ийм маягаар хүмүүст цаг гаруй үйлчилж, олон хүн баярын нулимс асгаруулсан, үзэсгэлэнтэй өдөр байв. Зарим хүн зураг авч байсан ч, би тоогоогүй ээ.

Маргааш өглөө нь Мексикээс Америк руугаа нисэв. Долоо хоногийн дараа нөгөө пастор надтай уулзахаар Америкт ирээд: “Жон, юу болсныг нүүр нүүрээ харж байгаад хэлэхгүй байж чадсангүй” гэлээ. Тэгээд нөгөө төрийн өндөр албан тушаалтан чинь тэр орой намайг номлобол баривчлуулахаар хоёр нууц тагнуулаа цуглаан руу илгээсэн тухай ярив.

Тэд намайг хөл муутай хүний залбирч байхад ирсэн юмсанж. Нөгөө хүн явахыг үзээд, нэг нь нөгөөдөө: “Энэ үнэн болов уу?” гэжээ.

Нөгөө нь: “Мэдэхгүй юм. Ойроос шалгаж үзэх үү?” гэж. Тэдний дэргэд зогсож байсан угтагч яриаг нь сонсоод, пастортаа дуулгасан юмсанж.

Албаны хоёр хүн урагшаа ирээд, гайхамшигийг гэрчлэн харжээ. Эмэгтэйн чих нээгдэхэд, нэг нь: “Үнэн юм шиг байна” гэж.

Дараа нь тэд Бурханы хүчээр эдгэрсэн таван настай хүүг хараад бие бие рүүгээ харснаа: “Үнэн байна!” гэжээ.

Дараа нь пастор надад: “Жон, таныг баривчлахаар ирсэн хоёр хүн танаар залбируулахаар урагшаа гарч ирээд, аврагдсан!” гэв.

Пастор, бид хоёр манай өрөөнд яаж баярласныг хэлэх илүүц биз. Гэхдээ бас болоогүй ээ. Тэрбээр дараа нь хотын сонинг гаргаж ирээд, цуглааны маргааш хэвлэгдсэн нийтлэлийг үзүүлэв. Сонин дээр албаныхан намайг тэр улсаас хууль бусаар мөнгө гаргадаг, залилан хийгч этгээд хэмээн үндэсгүй гүтгэсэн байснаас биш, цуглаан дээр хүмүүс эдгэрсэн тухай юу ч бичээгүй байв. Хамгийн сонирхолтой нь,

миний онгоцны тасалбарыг манай байгууллага төлсөн бөгөөд би тэр цуглаанаас өргөл авмааргүй байсан юм. Тиймээс би тэр улсаас нэг цент ч гаргаагүй болно.

Ариун Сүнс ийм л гайхамшигтай. Ийм цаг үед хүн Ариун Сүнсний удирдамжгүйгээр яаж амьдрах юм бэ? Тэр өдөр би өрөөндөө, орой нь тугны шонгийн дэргэд хэлээр залбираагүй байсан бол, Мексикээс Бурханы төлөвлөгөөг биелүүлж чадалгүй, тун гонсгор буцах байж. Пастор ч төрийн өндөр албаны хүнээс сүрдсэндээ, надаар номлуулахгүй байх байв. Гэтэл хэлээр залбирснаар, бидний хувьд нууцлал байсан Бурханы цэц ухаан, хүсэл илэрхийлэгджээ. Би Бурханы хүслийн дагуу пасторын төлөө зуучилсан нь түүнд Бурханы дуу хоолойг хүргэсэн бол, надад Эзэн эсэргүүцлийг хэрхэн даван туулах цэц ухаанаа хайрлажээ. Бурхан мандтугай!

Дайсан тэр цуглаан дээр яаж үзэлцсэн гэж бодно. Хэлээр залбирахуй нь Бурхан - ариун хүмүүсийн шууд холбоо бөгөөд тэр шугамаар ямар мэдээлэл дамжиж байгааг чөтгөрүүд мэдэхгүй болохоороо, ихэд айна. Зүрхнийхээ хүслийг өөрийнхөө ойлголтоор илэрхийлж болох цаг, нөхцөл байдаг ч, өөрийнхөө ойлголтоор илэрхийлж чадахгүй, Ариун Сүнсний үгийн тусламж хэрэгтэй үе бүр ч олон. Иймээс л Паул: “Тэгвэл яах вэ? Би сүнсээр залбирах болно, бас ухаанаар залбирах болно. Би сүнсээр дуулах болно бас ухаанаар дуулах болно” (1Коринт 14:15) гэжээ.

ДОТООД ХҮНЭЭ БОСГОН БАЙГУУЛАХ

Ийм учраас би ойрноос Бурханы хүмүүс Ариун Сүнсстэйгээ улам дотносохын төлөө энэлэн шаналан залбирдаг болоод байгаа. Бурханы дотносох дуудлагад хариулах эсэх маань чухам амь, үхлийг шийдэх хэмжээнд тулаад байна. Цаг хугацааны явцад, дан Бичээсийн мэдлэг хангалтгүй болно. Фарисай нөхөд ч Бичээсийг мэддэг байсан. Бид Бурханы Сүнсний *хэлсэн* үгсээс гадна эдүгээ *хэлж буй* үгд мэдрэмжтэй байхад суралцбал зохино. Есүс ч ингэж л амьдарсан. Тэрбээр “Би юуг ч Өөрөөсөө үйлдэж чадахгүй. Би сонссоноороо шүүх (*шийдвэр гаргах*) бөгөөд шүүлт минь шударга. Учир нь Би Өөрийнхөө хүслийг бус харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг” (Иохан 5:30, тодруулгыг нэмэв) гэсэн. Үүнийг Амплифайд Библи бүр ч тодорхой хэлжээ:

“Би Өөрөөсөө юу ч хийж чадахгүй (Өөрийнхөө хүслээр, бие дааж бус, харин зөвхөн Бурханы зааж өгснөөр бөгөөд Түүний

тушаалыг хүлээж авснаар л хийх.) ...(Хэрхэн шийдвэрлэ хэмээн тушаасны дагуу л Би шийднэ. Надад ямар дуу хоолой ирнэ, түүний дагуу л шийдвэрээ хэлнэ) (Иохан 5:30).

Есүс Ариун Сүнсний удирдамж, дуу хоолойд дэндүү мэдрэмжтэй байж, Түүнээс хамаарах хамаарлаа байнга хүлээн зөвшөөрдөг байсан. Есүс: “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Эцэгээс хийж харуулсныг нь л Хүү хийхээс Хүү юуг ч Өөрөөсөө хийдэггүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээрийг түүнчлэн хийдэг” (Иохан 5:19) гэсэн. Мөн: “Миний та нарт хэлж байгаа үгсийг Би Өөрөөсөө хэлээгүй” (Иохан 14:10) гэсэн. Дагалдагч болсон бидэндээ ч ямар ч болзолгүй: “Түүний дотор оршдог гэж яригч нь Түүний явсанчлан өөрөө бас тийн явах учиртай” (1Иохан 2:6) гэжээ.

Бид ч бас Есүстэй адил Бурханы Сүнсэнд мэдрэмжтэй байх ёстой. Бурхан үнэндээ биднийг эргэн тойрныхоо бодит ертөнцийг таньж мэдэхээсээ илүү Өөрийнх нь талбарыг таньж мэдээсэй хэмээн хүсдэг хэмээн би итгэдэг. Хэлээр залбирахуй нь биднийг Ариун Сүнсэнд улам мэдрэг болгохын төлөө дотор хүнийг маань босгон байгуулдаг юм.

Хэл ярихуйгаар ярьдаг нь өөрийгөө босгон байгуулдаг
(1Коринт 14:4, тодруулгыг нэмэв) хэмээн дахин хэлж байна.

Босгон байгуулахыг Грекээрээ *ойкодамео* гэдэг. Энэ нь зүгээр л “байшин барих” гэсэн үг. Бидний бие Ариун Сүнсний сүм гэдэг утгаар сонирхолтой байгаа биз. Паул: “Та нар Бурханы өргөө (1Коринт 3:9) хэмээн онцгойлж хэлсэн. Бид Бурханы өргөө гэр. Тиймээс хэлээр залбирах нь Ариун Сүнсний оршин суух газрыг томсгож байгаа хэрэг. Бид Ариун Сүнсэнд илүү том өрөө гаргаж өгч байгаа юм. Мэдээж бодитоор бус, зүйрлэсэн утгаараа л даа. Учир нь “үгчилсэн утгаараа юу, зүйрлэсэн утгаараа юу гэдгээсээ үл хамааран, энэ үг нь “барьж байгуулах” гэсэн утгыг л дэмжиж байгааг Даблью Ий. Вайн хэлдэг.

Тиймээс бид хэлээр залбирахдаа, Ариун Сүнсний оршихуй, хүчийг амьдралдаа тээх хүчин чадлаа нэмэгдүүлдэг байна. Бодит ухаанаараа бус, харин Бурханы Сүнсээр саадгүй удирдуулж сурахын төлөө дотоод хүнээ бэхжүүлдэг ажээ.

Түүнчлэн “итгэгч хүмүүсийн зан чанарын сүнсний өсөлт, хөгжлийг дэмжих” гэдэг утгаараа энэ үгийг зүйрлэлээр хэрэглэдгийг Ноён Вайн мөн хэлсэн байдаг. Иуда ч захидалдаа ижил утгатай үг хэлжээ:

Хайртууд минь, харин та нар хамгийн ариун итгэл дээрээ өөрсдийгөө сүндэрлүүлж, Ариун Сүнсээр залбиран...
(Иуда 20).

Энэ эшлэл дээрх сүндэрлүүлэх гэдэг үг нь *эпйкодомео* гэдэг Грек үг юм. “Дээр нь барих” гэсэн утга бүхий үг. Мөн л сүнсээ барьж босгох үргэлжилсэн үйл явцыг өгүүлж байна. Паул итгэгч хүмүүсийг Бурханы барилга байгууламж мөн бөгөөд өөрөө Бурханы нигүүлслээр тэднийг Христ рүү авчрах суурийг тавьсан боловч, дараа нь “...түүн дээр яаж барихаа хүн бүр анхаарагтун” (1Коринт 3:10) хэмээжээ.

Өнөөдөр Христэд итгэдэг олон хүн дотор хүнээ барьж байгуулаагүй учраас, дорой сүнстэй явдаг. Тэд юмсыг зүрхнийхээ мэлмийгээр харахаасаа урьдаар махан нүдээрээ хардаг. Тэд Бурханы Сүнсний Үгийг зүрхээрээ сонсохоосоо урьдаар махан чихээрээ сонссондоо итгэдэг. Гадаад хүн нь хамаг амьдралыг нь ноёлж, дотоод хүн нь өдөржин буйдан дээрээ лаглайгаад, чийпс идэж, зурагт үздэг этгээд шиг л амьдардаг. Тэд амьдрал, үйлчлэлдээ хичээнгүй байж болох ч, дотоод хүнээ ор тас хаяжээ. Тэгэх аглаа: “Би яагаад Бурханыг бараг сонсдоггүй юм бэ?” гэж байнга ярьдаг. Ойлгомжтой шүү дээ. Бурхан бидний тархитай бус, зүрхтэй харилцдаг учраас л тэр. “Хүний сүнс ЭЗЭНий дэнлүү Хамаг дотрыг нь нягталюу” (Сургаалт үгс 20:27). Дотор хүн маань бэхжээгүй бол, бид тодорхой сонсож чадахгүй.

Паул Еврей итгэгч нарт: “Энэ талаар ярих зүйл бидэнд их байна. Харин та нар хатуу чихтэй болсон тул тайлбарлахад бэрх байна” (Еврей 5:11) гэжээ. Тэр хүмүүст чихний аппарат хэрэггүй. Зүгээр л дотор хүнээ сүнсний юмст мэдрэмжтэй болгох хэрэгтэй. Тэд барьж байгуулаагүй учраас л, Эзэний Үгийг зүрхэндээ хүлээж авах чихгүй болжээ. Энэ зарчим дотор хүнээ байгуулахад анхаардаггүй хүн бүрт хамаатай. Дотор хүн хүчгүй бол, Бурхантай дотносоход саадтай! Энэ шалтгаанаар л Паул: “Би та бүгдээс илүүгээр хэл ярихуйгаар ярьдаг тул Бурханд талархдаг” (1Коринт 14:18) хэмээн чанга мэдэгджээ. Тэрбээр Еврей дээр цааш нь:

Харин бор хоол нь төлөвшсөн (*сүнсээр төлөвшсөн*) хүмүүст зориулагддаг. Учир нь тэдний сэрэхүй сайн мууг ялгахад *дасгалжсан* байдаг (Еврей 5:14, тодруулгыг нэмэв) гэв.

Паул тэдний мэдэрхүйн талаар хэлсэн байгааг тэмдэглээрэй.

Бурханд ойрт

Эдгээр нь гадаад бус, дотоод мэдэрхүй юм. Түүнчлэн эдгээрийг дасгалжуулснаараа, бид юу нь Бурханых, юу нь чөтгөрийнх болохыг таних мэдрэмжээ бэхжүүлнэ хэмээснийг нь тэмдэглээрэй.

Хүн биеийн таван мэдэрхүйтэй байдаг шигээ сүнсний ч таван мэдэрхүйтэй байдаг. Бичээс жишээ өгдөг. Дараахыг уншаад, доорх юмсыг биеийнхээ мэдэрхүйгээр хийж чадах эсэхийг өөрөөсөө асуугаарай. Энэ нь бичээч нар биеийн мэдэрхүйн талаар бус, сүнсний мэдэрхүйн талаар ярьж байгаа гэсэн дүгнэлтэд хүрэхэд чинь тусална:

Амтлах —

ЭЗЭН сайн гэдгийг *амсацгаа...*! (Дуулал 34:8, тодруулгыг нэмэв)

Таны үг *амтлахад* минь ямар чихэрлэг вэ! Миний аманд зөгийн балаас ч илүү чихэрлэг! (Дуулал 119:103, тодруулгыг нэмэв).

Үгс тань олдоход би тэднийг *идсэн* билээ. Таны үгс надад баяр хөөр болон Зүрх сэтгэлийн минь таашаал болсон билээ (Иеремиа 15:16, тодруулгыг нэмэв).

Хүрэлцэх —

Тиймээс тэдний дундаас гарч тусгаар бай гэж Эзэн айлддаг. «Бузар юманд бүү *хур* (2Коринт 6:17, тодруулгыг нэмэв).

Яв, яв. Тэндээс гар! Бузар юманд бүү *хур*! Тэндээс гараад, цэвэр бай! ЭЗЭНий сав суулгыг тээгчид ээ... (Исаиа 52:11, тодруулгыг нэмэв).

Үнэртэх —

Биднийг Христ дотор ямагт ялуулдаг бөгөөд Түүний тухай мэдлэгийн *анхилуун үнэрийг* хаа сайгүй биднээр түгээдэг Бурханд харин талархал нь байг. Учир нь аврагдаж буй болон мөхөж буйчуудын дунд бид, Бурханд зориулсан

Христийн *анхилуун үнэр* юм. Нэгэнд нь аминаас амь дахь *үнэр*, нөгөөд нь үхлээс үхэл дэх *үнэр* авай. Хэн эдгээрт чадвартай вэ? (2Коринт 2:14-16, тодруулгыг нэмэв).

Христ та нарыг хайрласан бөгөөд Өөрийгөө бидний төлөө Бурханд *анхилуун үнэрт* өргөл ба тахил болгон өргөсний адил хайр дор яв (Ефес 5:2, тодруулгыг нэмэв).

Гэвч би бүгдийг хүлээн авч хангагдсан. Би Елафродитоос та нарын юмсыг хүлээн аваад дүүрэн байна. Бэлэг чинь Бурханд таашаагдах тааламжит тахил ба *анхилуун үнэр* юм (Филиппой 4:18, тодруулгыг нэмэв).

Харах —

Танд амийн ундарга бий. Таны гэрэл гэгээнд л Бид гэрэл гэгээг *хардаг* (Дуулал 36:9, тодруулгыг нэмэв).

... зүрхний чинь *мэлмийг* гийгүүлээсэй! Ингэснээр та нар Түүний дуудлагын найдварыг мөн ариун хүмүүс дэх Түүний өвийн алдрын баялгийг бас итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын яндашгүй аугааг мэдэх болтугай. Энэ нь Түүний хүч чадлынх нь хүчний үйлдэл билээ (Ефес 1:18-19, тодруулгыг нэмэв).

Та бүх юмсыг [түүний] хөл дор оруулсан” гэжээ. Харин эдүгээ бүх юм түүний эрхэнд орсныг бид хараахан үзээгүй л байна. Харин ... Есүсийг *хардаг* (Еврей 2:8-9, тодруулгыг нэмэв).

Нүд бол биеийн дэнлүү мөн. *Нүд* чинь саруул аваас бүтэн бие чинь гэрэлтэй байна. Харин *нүд* чинь ёрын муу аваас бүтэн бие чинь харанхуй болно. Хэрэв доторх гэрэл чинь харанхуй байх аваас тэрхүү харанхуй ямар их вэ! (Матай 6:22-23, тодруулгыг нэмэв).

Сонсох —

Елиа, Ахабт — Аадрын нүргэлсэн дуу *чимээ* ойртон ирж буй тул явж, идэж уугтун гэв. Ахаб идэж уухаар явлаа. Харин Елиа Кармелын оройд гарлаа. Тэрээр газарт суун бөхийгөөд, толгойгоо өвдгөн завсраа хавчуулав (1Хаад 18:41-42, тодруулгыг нэмэв).

Сонсох чихтэй нь *сонсогтун* гэж айлджээ (Лук 14:35, тодруулгыг нэмэв).

Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй нь *сонсогтун* (Илчлэл 2:7, тодруулгыг нэмэв).

Дотоод хүн маань хөшиж, Бурханы Сүнсэнд мэдрэмжгүй болох тухайд Есүс тодорхой айлдруун:

Тэд харавч (*гадаад хүн*) эс ухааран (*дотоод хүн*), сонсовч (*гадаад хүн*) үл сонсдог (*дотоод хүн*) агаад ойлгодог ч үгүй тул Би тэдэнд сургаалт зүйрлэлээр ярьдаг. Тэдэнд Исаиагийн эш үзүүллэг биелдэг юм. Юу гэвэл тэр “Та нар сонсон сонсовч (*гадаад хүн*) хэзээ ч ойлгохгүй (*дотоод хүн*), Харан харавч (*гадаад хүн*) огт ухаарахгүй (*дотоод хүн*). Учир нь энэ ард түмний зүрх нь хатуурч (*дотоод хүн*), чих нь дүлийрэн хатуурч (*дотоод хүн*), нүдээ аньжээ (*дотоод хүн*). Эс бөгөөс тэд нүдээрээ харж (*дотоод хүн*), чихээрээ сонсож (*дотоод хүн*), зүрхээрээ ухаарч (*дотоод хүн*), эргэнэ. Би тэднийг эдгээх байсан” гэсэн байдаг (Матай 13:13-15, тодруулгыг нэмэв).

Сүнсээр төлөвшсөн нь сүнсний юмсыг ялгаж таних буюу юу нь Бурханаас, юу нь үгүй болохыг таних дотоод мэдэрхүйгээ хөгжүүлдэг. Энэ хөгжил нь итгэгч хүн мэдэрхүйгээ хэр зэрэг дасгалжуулснаар буюу хэрэглэснээр нь л шийдэгдэх юм. Бүх хүн биеийн мэдэрхүйтэй бөгөөд зарим хүн аль нэг мэдэрхүйгээ дасгал сургууль хийх замаар бусдаас илүү хөгжүүлсэн байдаг. Жишээ нь: зарим хүн дарсны чанарыг тодорхойлох амталгааны мэдэрхүйгээ өндөр хөгжүүлдэг. Тэд урт удаан

дасгал сургуулийнхаа ачаар аливаа дарсыг амтлаад л насыг нь, эрт ургацынх уу, хожуу ургацынх уу, тухайн жилийн хур тунадасны хэмжээ зэргийг нь тодорхойлох чадвартай болжээ.

Зарим нь үнэт чулууг оношилж, үнэ цэнийг нь тодорхойлох хараагаа хөгжүүлсэн байх. Туршлагагүй нүдэнд өөгүй харагдаж байгаа чулууг туршлагатай нүд хараад л, зүсэлтийнх нь чанар, өнгө, том жижиг өө сэвийнх нь тоо, шижир чанарынх нь зэрэглэлийг тогтоож чадна.

Саунд техникч, хөгжимчин, удирдаач тэргүүтэй хүмүүсийн хөгжмийн эгшиг авиаг сонсох чих нь хөгжсөн байдаг. Тэд хөггүй зэмсгийг бүхэл бүтэн найрал хөгжим дундаас ч таньж чадна. Тэд олон жилийн дасгал сургуулийнхаа ачаар хөгжмийн гармонийг таних мэдрэмжээ хөгжүүлжээ.

Зарим нь үнэрлэх чадвараа хөгжүүлдэг. Тэд танд үнэрийн дээд өнгө, ууслыг хэлж өгч, ямар ч сүрчиг доторх анхилуун ногоо, цэцэг, жимс жимсгэнийг нэрлэж чадна.

Дээрх хүмүүс биеийнхээ мэдэрхүйг хөгжүүлжээ. Тэд бусдаасаа онцгой гэхээсээ илүү, зүгээр л байгаа юмаа тултал анхаарч хөгжүүлснээс бус, гэнэт л гоц чадвартай болчихоогүй.

Яг одоо та гадаад мэдэрхүйгээ хөгжүүлэх түмэн жишээ бодож суугаа байх. Тэгвэл сүнсний тал дээр ч ижил зарчимтай. Та олон жил итгэсэн хэрнээ сүнсээ хөгжүүлээгүй байж болно. Бичээс Иохан Баптистыг “Хүүхэд өсөж, сүнсээр хүчирхэг болсон” (Иохан 1:80) гэдэг. Паул Тимотод: “”Ахиц дэвшил чинь бүгдэд илэрхий байхын тулд” сүнснийхээ өсөлт хөгжилд өөрийгөө бүрэн зориул” (1Тимот 4:15) гэдэг. Тэгвэл дотор хүнээ хэрхэн барьж байгуулах вэ? Бичээс тодорхой хэлсэн: Бурханы бичмэл Үгээр (1Петр 2:2; Үйлс 20:32), Түүний Үгд дуулгавартай байх (Еврей 5:9), хэлээр залбирах (1Коринт 14:4, Иуда 20).

СҮНСЭЭ ХӨГЖҮҮЛЭХ НЬ ЧУХАЛ

Дотор мэдэрхүйгээ хөгжүүлэх нь яагаад тийм чухал юм бэ? Сүнсний мэдэрхүй маань хөгжсөн бол, бид Ариун Сүнсэтэй хамаагүй чөлөөтэй нөхөрлөнө (нэгдэнэ). Ариун Сүнс бидэнтэй бүх төвшинд хамаагүй дотно ярилцана. Үүнийг тайлбарлахын тулд дахиад л жирийн амьдралыг үзье. Таван мэдэрхүй нь бүгд ажиллагаагүй хүнтэй харилцах боломжгүй. Хашхирч болох ч, тэр сонсохгүй. Мөрөн дээр нь товшсон ч, мэдрэхгүй. Тэмдэг барьсан ч, харахгүй гэх зэрэг.

Ная гарсан аав минь сонсголын аппарат зүүх шаардлагатай болсон

ч, өөрөө зүүх дургүй байв. Гэр бүлээрээ хооллож байхад, аав минь өөр газарт байгаа юм шиг л харагдана. “Аав аа, сонссон уу?” хэмээн дуугаа чангалахаар, аав өдөөс: “Айн?” гэх шиг л гайхан харна. Тэр үед би аавын сонсох мэдэрхүй нь муудсан учраас, харилцаанаас бүрэн тасарсныг ойлгож билээ. (Гэхдээ, аав минь одоо сонсголын аппарат зүүж байгаа!) Сүнсний тал дээр ч ялгаагүй. Мэдэрхүй чинь хатингаршсан бол, яриа тасалдаж л хүрнэ! Хүмүүс: “Бурхан надтай дотно ярьдаггүй” гэдэг л дээ. Яахав дээ. Дотор мэдэрхүй нь л сулхан хөгжилтэй байгаа байх. Нэг зүйлийг тогтоогоод аваарай: Бид Бурханыг сонсохыг хүсэхээс илүүтэй Бурхан бидэнтэй ярихыг хүсдэг нь үнэн боловч, мөнөөх Еврей итгэгч нартай адил бидний чих хатуурчих тал байдаг (Еврей 5:11).

Хүн хэрэглэдэг юмаа бэхжүүлж, хэрэглэдэггүй юмаа сулруулдаг. Сүнс дотор залбирахад, дотоод хүн маань залбирч, махан бие буюу ойлголт маань номхордог. Энэ нь Бурхантай саадгүй нөхөрлөхийн (нэгдэхийн) төлөө бодит амьдрал дээрх үндэслэлээ номхруулж буй хэлбэр юм. Би таныг Сүнс дотор залбираад зогсохгүй, тайлбарыг нь Бурханаас асууж дадахыг ятгаж байна.

Би ихэвчлэн өглөө бүр цаг орчим зөвхөн хэлээр залбирдаг. Тийнхүү нэн түрүүнд Бурханд магтаал өргөх юмуу зүрх сэтгэлээ уудлах маягаар жолоогүй тэнүүчлэх оюун бодлоо хялбархан төвлөрүүлж сурсан юм. Ер нь бол, Эзэн хамт байгааг мэдрэх мэдрэмж нь амьдралын янз янзын зовнил, үүргийг дарангуйлдаг. Энэ үед ойлголт дотор Бурханы санаа, илчлэл, цэц ухаан хөөсрөн гарч ирнэ. Эдгээр санааг бушуухан тэмдэглэж авах нь ухаалаг бөгөөд ингэсний дараа Ариун Сүнс дараагийнхаа зүйл рүү нүүдгийг би сурсан.

Би анх Сүнсээр залбирдаг байхдаа, нэг л мэдэхнээ өөр юмс руу гулгаад явчихдаг байсандаа, ихэд бухимддаг байлаа. Жишээ нь: залбирч байтал шинэ номын гарчиг орж ирээд л... ойрд уулзаагүй хүмүүстэйгээ ярих хэрэгтэй юм байна... уулзахдаа ямар бэлэг өгдөг билээ... ингэхэд үйлчлэлийнхээ санхүүг хэрхэн захиран зарцуулж байгаа билээ... гээд л урсгаж өгнө. Гэхдээ иймэрхүү юмс нь ихэвчлэн Ариун Сүнсний онгод, удирдамж байх талтайг хожим ойлгож билээ. Тиймээс би төрсөн санааг тэмдэглэж эхэлсэн бөгөөд тэмдэглэсний дараа тэр санаа арилаад, шинээр өөр санаа үүсдгийг анзаарсан юм. Дараа нь санаагаа үйл хэрэг болгохдоо, Бурханы ерөөл дагалдаж буйг үзнэ. Хэлээр залбирахад Ариун Сүнс надад улс үндэстэн, хүмүүсийг сануулахаас гадна надаар хийлгэхийг хүсч байгаа юмс руугаа чиглүүлж өгдөг. Энэ нь мөн л Бурхантай хавьгүй өндөр төвшинд харилцах арга зам ажээ.

СҮНСНИЙ ТАЛБАРТ АМЬДРАХ

Би л хувьдаа, Паул ч дийлэнх захидлаа ингэж л бичсэн байх гэж итгэдэг. Тэрбээр “Хэдийгээр би биеэрээ байхгүй байгаа боловч журамтайг чинь болон Христ дэх итгэлийн чинь баттайг *хараад*, баярлан сүнсээрээ би та нартай хамт байна” (Колоссай 2:5, тодруулгыг нэмэв) гэх зэргээр ярина. Паул бодит нүдээр хараагүй. Учир нь Паул тэнд биеэрээ байгаагүйгээ тодорхой хэлсэн. Мөн Коринтчуудад ч: “Миний хувьд, би биеэрээ байгаагүй, сүнсээрээ та нартай байж, дунд чинь байж байсан мэт үүнийг үйлдэгчийг хэдийнээ шүүсэн” (1Коринт 5:3) хэмээн мэдэгдсэн байдаг. Паул биеэрээ байхгүй атлаа яаж Коринтын болоод Колоссайн итгэгч нарын хийж, хэлж байгаа юмсыг дэргэдээс нь хардаг билээ? Бид сүнслэг оршигсод бөгөөд Бурханы Сүнсний талбарт орон зай, саад гэж байдаггүй. Эзэний дотор бэхэжсэн сүнстэй хүмүүс нь аливаа хэрэгцээний төлөө үр нөлөөтэй залбирдаг байхын тулд Эзэнээс дамжуулагдах долгионд мэдрэг байх хэрэгтэй. Өнгөрсөн бүлэг дээр манай Австралийн оффис менежерийн Библийн сургуулийн багш нь зураг дээрх олон хүний дундаас хэзээ ч харж яваагүй Хятад пастораа зааж чадсаныг бүү мартаарай!

Паул зүгээр л хэлээр залбирахдаа, олон янзын чуулган дотор өрнөж байгаа юмсыг сүнс дотроо хараад, дараа нь энэ тухай захидалдаа бичээд, усан онгоцоор илгээдэг байжээ. Би ч мөн аяллаар явах хугацаандаа хэлээр залбирахдаа, гэр бүл, ажилчдынхаа нөхцөл байдлыг харах үе байдаг. Тэгээд гэр тухай утсаар дуулахаасаа ч өмнө хэдийнээ мэдчихсэн байдаг. Би Сүнс дотор залбирсныхаа ачаар тухайн асуудал дээр юу хэлэх, хэрхэн шийдвэрлэхээ хэдийнээ шийддэг.

Миний танил Африкийн Кени овгийн нэгэн дайчин эр бий. Тэрбээр хэдэн жилийн өмнө Есүст итгээд, эдүгээ хүмүүсийнхээ дунд итгэмжтэй үйлчилж яваа. Иохан гэдэг итгэлийн нэртэй мань залуу үе үе Африкаас гадуур аялж үйлчилнэ. Саяхан Америкт зочлохдоо, миний таньдаг хосынд байрласан юм. Тэнд гурван долоо хонохдоо, Африк дахь ар гэрийнхээ тухай байнга ярьдаг байж. Түүнийг гэртээ хүлээж авсан гэр бүлийн хоёр гайхаад, ар гэр, гэргийд нь юу тохиолдож байгааг яаж мэдээд байгааг нь лавлаж л дээ. Учир нь Африк дахь гэрт нь байтугай, үнэндээ тосгонд нь ч утас байхгүйг Америк хос мэддэг байжээ. Тэгтэл мань хүн нэг иймэрхүү утгатай үг хэлсэн юмсанж: “Паул Азийн чуулганууд дундаа ингэж л ажилладаг байсан. Паул тэднийг сүнсээр төрүүлсэн учраас, тэд ч Эзэн дотор Паулын гэр бүл нь болсон. Тийнхүү Паул холоос залбирахдаа,

тэдэнтэй сүнсээрээ хамт байж, заавар өгч, хэрэг явдлынх нь талаар ч бичдэг байж. Миний хувьд, Ариун Сүнсний хүчээр Бурханы үйлдэх чадварт итгэдэг хүн бүрт хайрласан чадварыг л ашигласан төдий. Би гэрээсээ хол явах бүрийдээ, ар гэрээ ингэж л авч явдаг.”

Иоханы энэ гэрчлэл Бурханы Үгтэй төгс зэрэгцэж байгаа учраас л, би ярилаа. Үүнд яагаад гайхах ёстой гэж? Паул энэ тухай Шинэ гэрээнд нэг бус, харин хэд хэдэн удаа дурьдсан. Тэр Африк залуу манай Америкчууд шиг Бичээс өөрчлөгдсөн юмуу үеэ өнгөрөөсөн гэж заалгаж өсөөгүй ажээ. Бидэнд л өгөхийн төлөө Есүсийн өндөр үнээр худалдаж авсан зүйлээс бид яагаад ухарна вэ? Ямар учраас бид Аврагч Эзэнийхээ илүү чанартай зарц, хайртай үр хүүхэд нь байхын төлөө дотоод хүнээ эс байгуулна вэ?

Гэхдээ оройтоогүй ээ! Та аравтай байна уу, наятай байна уу, саяхан дахин төрсөн байна уу, арван жилийн өмнө дахин төрсөн байна уу, хамаагүй - хэлээр залбирснаараа, дотоод хүнээ бэхжүүлэхээс гадна Ариун Сүнсний тогтоох гайхамшигтай нөхөрлөлийн (нэгдлийн) ач тусыг бүрэн ойлгохын тулд хэлнийхээ тайлбарыг асуух бүрэн эрхтэй. Бурхан танд маш ихийг илчлэхийг хүсдэг. Та гадаад хүнээ номхруулж, бүхнийг мэддэг Нэгэн рүү зүрхээрээ ойртох л хэрэгтэй. Энэ сайхан урилгыг бүү алдаарай!

СУДЛАХ АСУУЛТ

1. Та хэлээр залбирсныхаа ачаар, Бурхан амьдралд чинь хэрхэн ажиллаж байгааг тод томруунаар харж ойлгосон тохиолдол байгаа юу? Үүнээс ямар гэгээрэл, амар тайван, сэргэлт хүлээж авсан бэ?
2. Зохиолч Хезекиагийн жишээгээр (Исаиа 39:2) болоод нэрт пастортай уулзсан өөрийнхөө түүхээр Бурханы илчилсэн нууцлалыг зүй зохистой захиран зарцуулах тухай ярьсан. Танд Бурханы илчилсэн зүйлийг бусдад илчлэх зөв зүйтэй цагийг хүлээх нь таны хувьд хэр чухал вэ? Танд бусдад гайхуулах гэсэн дотор хүслээ хянах шаардлага байдаг уу?

Арван гуравдугаар бүлэг

ИТГЭЛИЙН БҮРЭН БАТАЛГАА



Бурхан бидний хэрэгцээнд бус, итгэлд хариулна!

Ариун Сүнсээр дүүрсэн, Бурханыг хайрлан эмээж явдаг, нүглээс зайлсхийдэг, цэвэр итгэлтэй хүмүүс: “Би яагаад Бурханыг сонсдоггүй, Түүний оршихуйг мэдэрдэггүй юм бэ?” гэж ярихыг нь би зөндөө сонсож явсан. Тэр ариун хүмүүс мэддэг чаддаг бүхнээ л үйлдээд байхад, залбирал нь холбогдож өгөхгүй байгаа юм чинь гонсойлгүй яах вэ дээ. Тэгээд тэдэнтэй хэдхэн үг солихдоо, зөрчлийнх нь цаад шалтгааныг илрүүлдэг юм. Хариулт нь ихэвчлэн дараах эшлэлд оршино:

Иймд ах дүү нар аа, бидэнд Есүсийн цусаар, махбод болох хөшгөөрөө дамжуулан Түүний нээсэн шинэ, амьд замаар ариун газарт нэвтрэн орох *итгэл (эр зориг)* байгаа тул... мөн бидэнд Бурханы гэр дэх аугаа Тахилч байгаа тул хилэнцэт мөс чанараас цэвэрлэгдэхийн тулд зүрхэндээ цацуулж, биеэ ариун усаар угаалган, *итгэлийн дүүрэн баталгаатай*, үнэн

Бурханд ойрт

зүрхээр *ойртон очигшооё*. Найдвараа хүлээн зөвшөөрснөө гуйвалгүй бат баримталцгаая. Учир нь Амлагч нь итгэмжит билээ (Еврей 10:19-23, тодруулгыг нэмэв).

Нэгдүгээрт - бичээч биднийг Эзэний орших Ариунаас ариун газарт орж чадна гэжээ. Есүсийг загалмай дээр Сүнсээ тавихад, сүмийн хөшиг дээрээсээ доош цуу урагдсаныг санаарай. Бурхан тэндээс нүүж гараад, шинэ сүм рүүгээ нүүж ороход бэлэн болжээ. Тиймээс, эдүгээ бид хүрэшгүй холын сэнтийн өрөөнд нэвтэрч байгаагаа сохроор төсөөлөхийн оронд Бурхан руу ойртохоор дотогшоогоо өнгийдөг болсон. Учир нь Бурханы Сүнстэй дотуураа холбогдох нь Бурхан Аав, Эзэн Есүс хоёртой сэнтийн өмнө уулзахтай л адил юм.

Бичээч биднийг *эр зоригтой* хүрч очоорой гэсэн байгааг тэмдэглээрэй. Яаж тэгэх юм бэ? Есүс Калвари дээр урсгасан Хаан язгуурын цусаараа биднийг Өөрийнхөө оршихуйд оруулах зам татаж өгсөн учраас л тэр. Ухамсар маань нүглээс улбаатай ялын хар дарамтаас цэвэрлэгдсэн бөгөөд эдүгээ бид Түүний оршихуй руу итгэл дүүрэн орох эрхтэй болжээ.

Энэ нь “бүтэж ч магадгүй, бүтэхгүй ч байж магадгүй” гэдэг дүр зураг *биш* юм. Үнэндээ, биднийг ойртох юм бол, Бурхан бидэн рүү ойртоно гэсэн! Гэхдээ дийлэнх хүмүүсийн зөрчлийн гол шалтгаан “итгэлийн бүрэн (дүүрэн) баталгаа” гэдэг үгд нуугдах. Бид итгэл дотор ирэх ёстой! Учир нь Бичээс:

“Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь *Бурханд ойртон* буй нь Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгчдад Тэр Шагнагч нь болдог гэдэгт (зайлшгүй) итгэх ёстой” (Еврей 11:6, тодруулгыг нэмэв) гэдэг.

Дахиад нэг сонсоно уу: “Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй.” Хэсэг азнаад, наад үгээ зүрхэндээ уусгана уу.

“БИ ИТГЭХ ХҮНИЙГ Л ХАЙЖ БАЙНА!”

Эзэнд итгээд хэдхэн л нас хүрч байгаа, Хойд Каролинад аж төрдөг, ганц бие залуу явсан үеэ би хэзээ ч мартажгүй байх.

Нэг өглөө би дуг нойрондоо ид дугжирч байснаа гэнэт босоо харайгаад, орон дээрээ шовойсноо: “Би итгэх хүнийг л хайж байна!” хэмээн дуу алдаж билээ.

Цагаа харгал, үүрийн дөрвөн цаг болж байв. Нам унтаж байсан болохоороо, өөрийгөө хаана байгааг, сая юу болсныг дахин шалгах хэрэгтэй болов. Орны дэргэдийн гэрлээ асаахдаа, ямар ч өвчин, халуун байхгүй атлаа усан хулгана шиг хөлөрсөн биеэс минь авалцсан хэвтэр маань шалба норсон байхыг үзэв. Дөнгөж сая Бурхан миний амаар дамжин өгүүлснийг ухаарахдаа, айж гайхах зэрэгцсэнээ: “*Яагаад илүү нарийн юм хэлээгүй юм бол? Бурхан итгэх хүмүүсийг хайдгийг нь би мэднэ шүү дээ*” хэмээн бодлоо. Тэгээд ядарсандаа, дороо эргээд унтчихав.

Өглөө сэрснээс хойш “*Би итгэх хүнийг л хайж байна!... Би итгэх хүнийг л хайж байна!... Би итгэх хүнийг л хайж байна!...*” хэмээн зай завсаргүй толгойд тоглогдсон үг үдийн алдад гэнэт орой руу орох нь тэр. Тэгээд би чангаар: “Энэ чинь нарийн утгатай үг байна!” хэмээн дуу алдаж билээ.

Тэр цагаас хойш би дараах хоёр асуултыг эргэцүүлж эхэлсэн юм: *Юу Есүсийг хамгаас гашуудуулдаг байсан бэ? (Энд Есүсийг хамгаас хилээнүүлдэг байсан хоёр нүүрт Фарисайчуудын талаар яриагүй шүү.) Юу Есүст хамгаас таалагддаг байсан бэ?* Нэгдүгээрт - Есүсийг хийнэ гэсэн зүйлээ хийнэ гэдэгт нь итгэхгүй байгаа хүмүүс Түүнийг хамгаас гашуудуулдаг байсан. Энэ нь үнэндээ итгэлийн асуудал бөгөөд итгэл нь Бурхан хэлсэн л бол хийдэг, хийх зүйлээ л хэлдэг гэдэгт итгэх явдал юм. Бурхан хүн шиг бурахгүй, харин хэлсэн Үгээ Нэр хүндээрээ даадаг байна. Түүний нэр хүндээс өндөр зүйл байхгүй учраас, Бурхан ийн Нэр хүндээрээ тангарагладаг ажээ. Тиймээс Бурханд эргэлзэх нь Түүний ёст чанарыг доромжилж байгаа хэрэг болно.

Есүсийн сэтгэл дундуур байдлыг дараах Бичээсээс үзэж болно. Матай номоос цөөн хэдэн жишээ толилуулъя:

... өчүүхэн итгэлтнүүд ээ? (Матай 6:30-31).

Тэд ирж, Түүнийг сэрээгээд —Эзэн авраач, бид сүйрлээ гэхэд нь Есүс тэдэнд —Юунд айцгаана вэ, өчүүхэн итгэлтнүүд ээ? гээд Тэр босож, салхи болоод нуурыг зандарчээ (Матай 8:25-26).

—Өчүүхэн итгэлтэн минь ээ, чи юунд эргэлзэв? (Матай 14:31).

Бурханд ойрт

—Өчүүхэн итгэлтнүүд ээ, та нар юунд талхгүй байгаагаа дундаа эргэцүүлэн ярина вэ? (Матай 16:8)

Эшлэл тус бүр дээр Есүс хичнээн сэтгэл дундуур, гунигтай байхыг өнгө дуунаас нь харж байна уу? Гэхдээ дагалдагч нар нөгөө татаж унадаг хүүгээс чөтгөрийг хөөж чадалгүй, бүтэлгүйтсэн түүх л хамгийн сонирхолтой. Үүнээс болоод, Есүс дагалдагч нартаа юу хэлснийг үзнэ үү:

Есүс —Итгэлгүй, завхарсан үеийнхээн. Хэдий хүртэл би та нартай хамт байх юм бэ? Хэдий хүртэл Би та нарыг тэвчих юм бэ? Түүнийг Надад аваад ир гээд, Есүс түүнийг зандарсанд чөтгөр түүнээс гарч, хүү тэр мөчид эдгэрэв (Матай 17:17-18).

Есүс мэдрэмжээ огтоос нуугаагүй. Гонсойхоор барах уу, бүр зөвтөөр хилэгнэн гашуудаж, жигшив!

Хожим нь дагалдагч нар юунаас болоод чөтгөрийг хөөж чадаагүйгээ асуухад, Есүс зүгээр л:

“Та нарын итгэл өчүүхнийх” (Матай 17:20) хэмээн хариулжээ.

БУРХАН ИТГЭЛД ХАРИУЛДАГ

Бид бүх юмыг Эзэнээс итгэлээр хүлээж авдаг. Христийн бие доторх олон хүний огт мэддэггүй нэгэн үнэн нь “Бурхан бидний хэрэгцээнд бус, итгэлд хариулдаг!” гэдэг үнэн болой. Түр зогсоод, энэ мэдэгдлийг эргэцүүлнэ үү. Үүнийг Бичээсийн олон жишээгээр дүрсэлж болох ч, хоёр дээр л тогтёе. Нэгдүгээрт - Есүс нэгэн айлд баахан удирдагч нарт сургаал зааж байх үеэр:

Эдгээлтийн төлөө Эзэний хүч Түүнд өгөгдсөн байв (Лук 5:17) гэдэг.

Тэнд Бурханы хүч тэр удирдагч нарыг эдгээхийн төлөө байсан гэдэг үгд би хайртай. Энэ нь тэнд эдгэрэл шаардлагатай нэг юмуу хэд хэдэн удирдагч байсан боловч, нэг нь ч эдгэрээгүй гэсэн үг. Яагаад? Яагаад гэвэл хүлээж авах итгэл хэнд нь ч байсангүй.

Гэтэл нөгөөтэйгүүр, хэсэг эрчүүд нэгэн саажсан хүнийг дамнуурган дээр өргөөд, нөгөө айлын гадна авчирсан хэдий ч, шавсан олон хүнээс болоод дотогш нэвтрэх аргагүй байсан тул дээвэр дээр гаргаад, дээврийн хэсэг хавтанг хуулж байгаад, саажсан хүнийг Есүс рүү буулгажээ.

Итгэлийг нь харсан Есүс —...Би чамд хэлье. Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь гэв. Тэр даруй тэр тэдний өмнө босоод, хэвтэж байсан юмаа авч Бурханыг алдаршуулсаар гэрийн зүг явжээ. Тэд бүгдээрээ гайхан цочирдож, Бурханыг алдаршуулж —Бид өнөөдөр мөн ч хачин юм үзлээ гэгцгээн бүгд айдаст автсан байлаа (Лук 5:20-26, тодруулгыг нэмэв).

Есүс тэдний итгэлийг харсан. Саажсан хүн ч, зөөсөн хүмүүс ч Эзэнийг Үгээр нь мэддэг байжээ. Тэд Бурханы хүмүүстээ хэдийн айлдсан “Сэтгэл минь ээ, ЭЗЭНийг магтаж, Ач тусыг нь ч бүү март. Тэрээр бүх хилэнцийг чинь уучилж, Бүх өвчнийг чинь илааршуулдаг” (Дуулал 103:2-3) гэдэг үгийг мэддэг л байсан байх. Гэтэл мөнөөх удирдагч нар саажсан хүн эдгэрээд, Бурханыг магтаж байхыг нь үзээд, эрүүгээ мултаргал гайхснаас бус, өөрсдөө эдгэрч чадаагүй. Яагаад? Яагаад гэвэл, Бурхан бидэнд өгөхийг хүсч байсан ч, бид итгэлээрээ хүлээж авахгүй л бол, хүлээж авч чадахгүй! Бурхан Аав тэр өвчтэй удирдагч нарыг эдгээхийг хүссэн ч, тэд эдгэрээгүй! Биднийг Өөрийнх нь хэлсэн үгд итгэж, ойртох үед л Бурхан хариу үйлддэг юм.

Хоёр дахь түүх нь Есүс дээр ирсэн Грек хүүхний түүх болой. Тэрбээр чөтгөрт дарлуулж яваа охиноо эдгээж өгөхийг Есүсээс царайчлан гуйсан ч, Есүс түүнд:

“Эхлээд хүүхдүүдээ цатга. Учир нь хүүхдүүдийн талхыг авч ноходод хаях нь сайн биш” (Марк 7:27) хэмээн хариулжээ.

Үндсэндээ нохойгоор нь л дууджээ. Хүүхэн гомдоод, хялам зэхэн хийгээд, хаяад явж болох л байсан. Гэтэл хүүхэн яаж гэдгийг нь мэдэхгүй - ямар ч байсан Есүсийн занг мэддэг байжээ. Тиймээс Есүст шууд ингэж хариулж:

Тийм ээ, Эзэн. Гэвч ширээн доор байгаа ноход ч хүүхдүүдийн үйрүүлснийг иддэг шүү дээ (Марк 7:28).

Бурханд ойрт

Эмэгтэй Бурханы Хүүгийн оршихуйд зогсож байгаага мэдсэн бөгөөд Есүсийг хүч дутахыг мэдэхгүй, сайн Бурхан гэдэгт нь бат итгэжээ. Хүүхэн хүсэлтээсээ няцалгүй, гүрийж байж л хариултаа авна хэмээн шийдчихсэн байв. Тэрбээр итгэл дотроо үлджээ. Учир нь Есүс эцэстээ:

“Үгийнхээ дагуу яв. Охиноос чинь чөтгөр зайлсан”
(Марк 7:29) хэмээн айлдсан байдаг.

Эмэгтэй хариад, цовоо хөөрхөн охин нь цоо эрүүл сууж байхыг үзжээ. Эмэгтэй эхлээд хүсэлтээ няцаалгасан ч, Есүст итгэлээр дүрэлзсэн хариулт өгсөн тул Есүс түүний итгэлд эргэлзээгүй хариулсан байна.

БҮГДИЙГ ХҮЛЭЭЖ АВАХ ТҮЛХҮҮР

Энэ зарчим Хаанчлалын юм болгонд хамаатай. Үнэндээ, Бурханд залбирахдаа бид дараах маягаар үйлдэх ёстойг Иаков хатуу хэлжээ:

“Харин тэр ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг. Учир нь эргэлзэгч нэгэн бол салхиар туугдан давалгаалах тэнгисийн долгио мэт ажээ. Тийм хүн Эзэнээс юм авна гэж бүү санаг” (Иаков 1:6-7).

Янзтай. Дахиад сонсоно уу: “Тийм хүн Эзэнээс юм авна гэж бүү санаг.” Хэсэг зогсоод, *юу ч хүлээж авахгүй* гэдэг үгийг бодно уу. Ямар ч найраагүй, түс тас мэдэгдэл байна! Бурхан үүнийг алдахын аргагүй чанга мэдэгджээ. Бурхан итгэлээс өөр юунд ч хариулахгүй!

Өнөөдөр олон хүн итгэлээр гуйдаггүй учраас, Ариун Сүнснийг хүлээж авдаггүй. Бичээс биднээс:

“Та нар... сонссондоо итгэсэнээр үү? Зөвхөн үүнийг л та нараас мэдэхийг би хүсэж байна” (Галат 3:2, тодруулгыг нэмэв) хэмээн асуужээ.

Энэ ч Иаковын үгтэй таарч байна. Бид Эзэн дээрээ Бурханы Сүнтэй хамт итгэлээрээ явж очихоос нааш *юу ч хүлээж авахгүй*. Ангаж цангасан атлаа хэлээр ярьдаггүй итгэгч хүмүүстэй би зөндөө уулздаг. Тэд ямар нэгэн том зүйлээр цангаад, хайгаад байгаа хэрнээ Ариун Сүнсээр

дүүрэх тухай хэлж өгөхөөр: “Би нэг удаа залбирсан. Бүтээгүй шт!” гэж хариулдаг. Эсвэл “авсан ч яахав, аваагүй ч яахав” гэсэн хандлагаар залбирна. Тэдэнд мөнөөх Грек эмэгтэйнх шиг улайрал байдаггүй. Тэд итгэлийн бүрэн баталгаа тээж ирдэггүй! Бурхан бидэнд “Тиймээс бүү мунхаг бай. Харин Эзэний хүсэл юу болохыг ухаар” (Ефес 5:17) гэдэг. Тэгэхээр, Бурхан хүмүүстээ хүслээ мэдүүлэх дуртай бөгөөд Бурханыхаа хүслийг мэдсэн хүмүүс нь итгэлээр, зоригтойгоор гуйдаг байгаасай хэмээн хүсдэг ажээ.

Энэ зарчим Бурхантай дотносох тал дээр ч хэрэгжинэ. Итгэгч хүмүүс “энэ удаа холбогдоосой” гэсэн горьдлогоор Эзэн дээр ирэх нь олонтаа. (Энэ чинь Библийн “итгэл дүүрэн хүлээлтээс” тэс ондоо хандлага байгаа биз дээ?) Итгэгч хүмүүс Бурханы сонорт хүргэчих юмсан гэсэн горьдлогоор агаарт үгээ хий цацдаг. Энэ нь итгэлийн үйлдэл биш учраас, Эзэний оршихуйд хүрэхгүй. Бичээс мөн “Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурханд ойртон буй нь *Тэр байдаг* гэдэгт болон Өөрийг нь хайгчдад Тэр Шагнагч нь *болдог* гэдэгт итгэх ёстой” (Еврей 11:6, тодруулгыг нэмэв) гэдэг. Өөрөөр хэлбэл, Бурхан хамт байна, сонсоно, хариулна гэдэгт итгэх!

Иаков “Тийм хүн Эзэнээс юм авна гэж бүү санаг. Хоёр санаатан нь бүх үйлдээ тогтворгүй байдаг юм” (Иаков 1:7-8) гэсэн. Хоёр санаатай хүн нь Бурхан дээр очих атлаа Түүний оршихуйд орсон эсэхдээ эргэлздэг. Тэр бүү хэл, Бурхан өөрийг нь тоож байгаа эсэхэд ч эргэлздэг.

Бодлоороо шарвах нь хоёр санаатай байгаагийн шинж. Тайлбарлая. Цуглаан дээр номлосныхоо дараа би урагш гарч ирсэн хүмүүсийн төлөө залбирахдаа, хөгжимчдийг түр чимээгээ азнахыг хүсдэг. Учир нь, хөгжим хэдий дайчин зэмсэг ч, хүмүүс мэддэг дууныхаа үгийг аялаад, Эзэн дээр төвлөрөхгүй байх талтай. Иаков “Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Нүгэлт та нар гараа цэвэрлэ. Хоёр санаат та нар зүрхээ ариусга” (Иаков 4:8) гэсэн. Бодлоороо төвлөрч чадахгүй байж, Бурханыг эрэлхийлж чадах уу даа? Найздаа ингэж хандбал, ямар байх уу?

Хүмүүс Бурхан руу ойртохдоо, холбоо тогтоогоосой билээ хэмээн горьдож очдог учраас, дорхноо сатаардаг. Ингэж болохгүй. Та Бурханд итгэх ёстой. Бурхан *хамт байгаа* гэдэгт итгэх ёстой. *Сонсож байгаа, хариулна* гэдэгт итгэх ёстой. Ингэсэн нөхцөлд л Бурхан дээр бүрэн анхаарна. Бурхан танд бүрэн *анхаарч байгааг* итгэл чинь баталгаажуулна. Учир нь, таныг ойртох аваас, эргээд тан руу ойртохоо Бурхан амласан бөгөөд Тэр худал ярьж чаддаггүйг та мэднэ. Бүр баярлаад байх юм! Бид ямар сайн Бурханд үйлчилнэ вэ! Түүн рүү итгэлээр очих аваас, Тэр хариулна!

ХЭРХЭН ИТГЭЛТЭЙ БОЛОХ ВЭ?

Одоо бүгдээрээ “Итгэлээ хэрхэн өсгөх вэ?” гэдэг асуултанд хариулах ёстой. Энэ асуулт эрт дээр үеэс буюу үнэндээ дагалдагч нараас эхтэй:

Элч нар Эзэнд —Итгэлийг маань нэмээч гэхэд Эзэн —Та нарт гичний үр төдийхөн итгэл байхад л, энэ ялам модонд “Үндсээрээ сугарч, тэнгист урга” гэсэн ч тэр дагах л болно (Лук 17:5-6) гэжээ.

Есүс эхлээд “гичний үр төдий итгэл байхад л” гэсэн байгааг тэмдэглэнэ үү. Үр өчүүхэн боловч, аварга том мод болж ургах хүчин чадлыг тээдэг. Тиймээс сагсайсан үр жимстэй, аварга том мод болтлоо боловсрох итгэлийн талаар ярихаасаа өмнө эхлээд хаанаас үртэй болох тухайгаа ярих хэрэгтэй. Хариултыг нь дараах эшлэлд тодорхой заажээ:

Тиймээс итгэл нь *сонсохоос, сонсох нь* Христийн үгээр ирдэг (Ром 10:17, тодруулгыг нэмэв).

Тун энгийн ажээ. Итгэлийн үр нь Бурханы Үгийг сонсохоос ирдэг. Түүнчлэн *сонсохоос бөгөөд сонсох нь* гэсэн байгааг тэмдэглэнэ үү. Үр нь ганц удаа сонсохоос бий болох тохиолдол байдаг ч, ихэвчлэн ахин дахин сонсох үед зүрхэнд суулгагддаг. Тиймээс л өлсөж цангасан итгэгч хүмүүс Бурханы Үгийг ахин дахин сонсох юмуу уншдаг. “Би таны номыг хэд хэд уншсан” гэх юм уу “Таны номлолыг таван удаа сонсоод, тав дахь дээрээ нүд онгойсон” гэж хүмүүс хэлдэг дээ. Яг тэр үед нь л үр суулгагдан, үндэслэж!

Гэтэл бид ийм хялбар зүйлийг ээдрээтүүлснээрээ, алддаг. Ердөө л Ариун Сүнсний хэлсэн юмуу бичсэн Бурханы Үгийг сонсох үед л итгэлийн үр бий болдог. Өнөөдөр бид нэг л их номлол, номтой болсноос биш, яг Бурханы Үгийг тун жаахан ярьж байгаа нь нэн харамсалтай. Миний анхны номыг “хэт номлолч” хэв маягтай гэдэг шалтгаанаар нэгэн томоохон хэвлэлийн газар хэвлэхээс татгалзаж байлаа. Хэт их Бурханы Үгтэй, хэт их Бичээстэй гэнэ! Тэд хүний сэтгэл мэдрэмж, биед тааламжтай зүйлийг л хүсчээ.

Өнөөдөр олон номлогч энэ дарамтанд автагдаж байгаа нь харамсалтай. Өнөөдөр бид Библи шаардагдахгүй учраас, хүмүүс нь

Библиэ авчирдаггүй, “эрэлчдэд ээлтэй” чуулгантай болсон. Хүмүүс нь баруун солгойгүй таашаалтай хөөцөлддөг амьдралыг нь дэмжиж өгдөг, хөнгөн хөгжилтэй “номнолд” автана. Барууны чуулганы энэ дүр төрх нь сүүлийн хоёр жил Бурханы Үгээр цангасан Хятадын нууц чуулган даяар тавин мянган ширхэг Библи илгээсэн над мэтийн хүний хувьд наадгай мэт санагдах. Хятадад Библи олдошгүй бөгөөд эрх баригч нар Библийг нь хураасан тохиолдолд чуулганы удирдагч нар нь Бурханы Үгийг цээжээр ярьж чаддаг байлгахын тулд ахлахууддаа Шинэ гэрээг хуудас хуудсаар нь тарааж өгөөд, тогтоолгодог байна. Тэд - эр, эм гэлтгүй - Бурханы бичмэл Үгийн үнэ цэнийг мэддэг хүмүүс ажээ.

Гэтэл Барууны чуулганыхан - бид махан биеийг мөхөөж, сэтгэлийг өөрчлөх Бурханы Үгийг хэлэхийн оронд сэтгэлд зугаа, биед тайтгарал болох үгийг л сэдэхийг хичээх. Бид зугаатай түүхэнд нь баясч, өрөвдөлтэй түүхэнд нь уйллаа ч, нүгэл амьдралын маань хаалгыг тогших үед, яах вэ? Сөрөх хүчтэй байж чадах уу? Эгзэгтэй үед Бурханы хүслийг мэдэх шаардлага гарбал, яах уу? Яаж залбирахаа мэдэх үү? Юуны төлөө залбирахаа мэдэх үү? Сайн мэдээг хүлээж авсан хүний итгэлтэй байх уу? Гэх зэрэг.

Нөгөө хэвлэлийн газар миний номыг хэвлээгүйд, өнөөдөр би баярладаг. Учир нь, хэвлэхийг зөвшөөрсөн бол, хянан тохиолдуулагч нар нь номын минь үгийг гөлчийтэл нь цавчаад, Бурханы Үгээр хүчирхэгжих ёстой байсан олон хүний ганзагыг хоослох байсан. (Тэр ном маань эцэстээ хэвлэгдсэн.) Хамгийн сонирхолтой нь, хэвлэлийн компаний эзэн нь нөгөө даргыг халаад, оронд нь Бурханы зүрхтэй хүнийг тавьсан байдаг. Шинэ дарга нь ч ялгаагүй, хүмүүст Бурханы Үгийг хүргэх хүсэлтэй хүмүүсийг ажилд авсан байдаг. Тэр шинэ дарга надтай уулзаад, миний дараагийн номыг хэвлэх санал тавьж билээ. Бид нийт таван ном хамтарч гаргасан бөгөөд дөрөв нь бэстселлер болсон. Гэхдээ үүнээс чухал нь бид өөрчлөгдсөн амьдрал, гэр бүл, чуулганы гэрчлэлийг өнөөг хүртэл хүлээж авсаар л байна. Бүх алдар нь Бурханд л байг!

Амос дээр: “талхаар өлсөх, усаар цангах бус, Харин ЭЗЭНий үгийг сонсохын төлөө өлсгөлөн байх” (Амос 8:11) өдрүүд айсуу гэсэн учраас л, би үүнийг яриад байна. Америк чуулганд Бурханы Үг ховорджээ. Тийм ээ, бидэнд үй түмэн ном, видео, аудио хуурцаг байгаа ч, яг Бурханы Үг машид ховорджээ. Ямар учраас Америкчууд - биднээс хол дутуу ном материалтай Африк, Ази хүмүүс Бурханаас ямар ч саадгүй хүлээн авч, тэр хэрээрээ амьдрал нь ч арвин итгэл, үр жимстэй байдаг юм бэ? Тун энгийн. Тэд “эрэлчдэд ээлтэй” юмуу хуульчилсан үгийг бус, Эзэний үгийг сонсдог!

Миний бие Бурханы Үгийг ярихын оронд хүмүүст таатай үгийг ярих дарамтанд хэзээ ч автахгүйгээ Бурханд амласан. Паул “би хүмүүсийн тааллыг эрж байна уу? Эсвэл Бурханыхыг уу? Эсвэл би хүмүүст таацуулах уу? Хэрэв би эдүгээ хүртэл хүмүүст таацуулсаар байсан бол би Христийн зарц биш байх байсан” (Галат 1:10) гэсэн. Анх Бурханд үйлчлэхээр эхлээд, эдүгээ чуулганыхаа юмуу хүмүүсийнхээ боол болчихсон хүмүүс хэр олон бол? Тэд удирдах ёстой хүмүүсийнхээ хүссэн зүйлийг нь бэлтгэж өгөх дарамтанд автжээ.

Итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн Үгээр. Бурханы Үг л бидний зүрхэнд итгэлийн үрийг суулгадаг. Удирдагч - бид Эзэний хүмүүст хэрэгтэй гэж үзсэн зүйлийг нь бус, харин яг хэрэгтэй зүйлийг нь өгөх ёстой. Бид тэднийг Бурханы өв авчирдаг, барьж байгуулдаг мөнхийн Үгээр тэжээх ёстой (Үйлс 20:32).

Олон удирдагч урагш алхаад, хольцгүй, Бурханы цэвэр үгийг тунхаглаж эхэлж байна. Хүнд таалагдах урхинд унаад байсан зарим нь эдүгээ чөлөөлөгдөж байгаа бол, зарим нь цоо шинээр гарч ирж байна. Тэд Бурханы хүмүүсийг дахин Бурхан руу нь чиглүүлж байна! Бурхан яагаад өнөөдөр Өөртэйгээ ойр дотно байхыг юу юунаас илүү цохно вэ? Хариулт нь энгийн. Та итгэлгүйгээр Бурхантай ойр дотно байх боломжгүй учраас, Бурхан таныг Өөртэйгээ халуун дотно харилцаа тогтоолгох үүднээс итгэлтэй байлгахыг хүсдэг. Бурхан хүмүүсээ ойр дотно бай гэдэг үгээрээ үрслүүлж байна. Нэн сайхан!

ИТГЭЛЭЭ ХЭРХЭН ӨСГӨХ ВЭ?

Ийнхүү бид итгэлээ хэрхэн өсгөх асуулт дээр тулж ирлээ. Есүс дагалдагч нартаа ийн өгүүлрүүн:

—Та нарт гичний үр төдийхөн итгэл байхад л, энэ ялам модонд “Үндсээрээ сугарч, тэнгист урга” гэсэн ч тэр дагах л болно. Гэвч та нараас хэн нэг нь тариаланг чинь эрхэлдэг юмуу малыг чинь хариулдаг боолтой байгаад боолоо талбайгаас ирэхэд нь “Даруй орж, хооллохоор суу” гэж хэлэх үү? Харин ч түүнд “Надад идэх юм бэлтгэ. Бүсээ бүсэлж, намайг идэж ууж дуустал үйлчил. Дараа нь чи идэж ууна биз” гэж хэлэхгүй гэж үү? Тушаасныг нь гүйцэтгэсэнд боолоо тэр илүүгээр таалдаггүй биз дээ? Түүнчлэн та нар ч мөн адил, та нарт тушаасан бүхнийг

гүйцэтгээд “Бид тусгүй боолууд. Бид зөвхөн юу хийх ёстойгоо л хийсэн” гэж хэл гэжээ (Лук 17:6-10).

Есүс үрийн чинээ итгэлийн тухай өгүүлж байснаа эзнийхээ өмнө хүлээх зарцын үүрэг рүү хальтирсанд би гайхдаг байлаа. Өнгөц харбал, орон гаран ч юм шиг. Гэхдээ Есүс тийм биш гэдгийг би мэднэ. Тэгтэл нэг өдөр Ариун Сүнс мэлмийг минь нээв ээ.

Нэгдүгээрт - итгэл нь үрийн хэлбэрээр ирдгийг Есүс хэлжээ. Үр нь өчүүхэн атлаа аварга том мод болтлоо ургах хүчин чадлыг агуулдаг. Тиймээс үрийг тариалахаас гадна хүчин чадалд нь тулгал нь өсгөхийн тулд боловсруулах хэрэгтэй аж. Хариултынх нь хоёрдугаар хэсэг нь ялам модыг үндэслүүлж, уулыг нүүлгэж, биднийг Бурханы Өөрийнх нь оршихуйд нэвтрүүлэх чадалтай итгэлийн үрийг ургуулах түлхүүрийг агуулах аж!

Зарц эзэндээ зүтгэж, аж ахуйг нь эрхэлж, мал сүргийг нь хариулах нь эцсийн эцэст юуны төлөө вэ? Энэ бүх хүчин зүтгэлийн эцсийн зорилго нь эзнийхээ ширээг хоол хүнстэй байлгахын төлөө юм. Есүс: “Зарц яагаад тариан талбайгаас юмуу малын бэлчээрээс ирчихээд, эзнийхээ ширээн дээр хоолыг нь тавих ажлаа дуусгахгүй байх билээ?” хэмээн асуужээ. Зарц ажил үүргээ амжилттай дүүргэхийн тулд эзнийхээ даалгасан *бүхнийг* бүрэн гүйцээх ёстой. Ажлаа дуусгахгүй байх нь үрээ суулгаж, усалж, бордчихоод, ургацаа авахын даваан дээр тариан талбайгаа тоохгүй хаячих юмуу хатаагаад алчихтай л адил юм.

Есүс биднийг Өөрт нь дуулгавартай байх талаар ярьсан. Есүс бидний Эзэн бол, бид - Түүний талбай дээрх зарц нар нь билээ. Итгэлийн үрээ ургуулж, үр жимс авахыг хүсч байгаа л бол, дуулгавартай зарц байж, даалгавраа гүйцэлдүүлэх хэрэгтэй. “Түүнчлэн та нар ч мөн адил, та нарт тушаасан бүхнийг гүйцэтгээд...” гэдэг үгийг тэмдэглэнэ үү. Үүгээрээ Есүс биднийг дуулгавартай байх талаар ярьсан бөгөөд дуулгавартай байхуй нь итгэлээр өсөхийн үндсэн түлхүүр болохыг баталж байна.

ДУТУУ ДАГАХ НЬ ДУУЛГАВАРГҮЙ ЯВДАЛ МӨН

Дутуу дагах нь ч хангалтгүй, дуулгавартай эхэлсэн атлаа хожим эргэж буцах нь ч хангалтгүй. Библийн олон баатар яг энэ алдаанд унасан байдаг. Тэдний нэгэн жишээ нь Саул хаан болно. Эзэн түүнд Амалекийг газрын хөрснөөс арчиж, хүн ардыг нь хүүхдүүд, хүүхнүүдтэй нь, мал адгуустай нь бүгдийг нь алахыг тушаажээ. Амьсгаатай амьтан үлдээж болохгүй байв.

Саул “Чадахгүй!” гэж хариулаагүй. Бид дуулгаваргүй байдлыг эрээ цээргүй эсэргүүцлээр л төсөөлж ойлгодог. Гэтэл үгүй ажээ. Гэхдээ Саул бас үг дуугүй “за” хэмээн ёслоогүй бөгөөд үүнээсээ болоод хожим зангаа хувиргасан юм. Бид ийм төрлийн дуулгаваргүй занг сайн ойлгодог. Саул Бурханы тушаалыг нэн тэргүүнд тавилгүй яваад, хожим хайнга юмуу мартамхай зандаа автаад биелүүлээгүй юм биш ээ. Олонх маань ийм занг дуулгаваргүй явдал мөн болохыг нь зөвшөөрдөг атлаа “уг нь ч зөв л санаалсан” гэдэг шалтгаанаар түрүү барьдаг. Ийм үйлдэл нь дуулгаваргүй явдлын жишээ мөн гэдэгтэй хүмүүс санал нийлэх байх. Гэхдээ бүгдээрээ Саулын үйлдэл рүү анхаарлаа хандуулъя.

Саул тэр даруй их цэргээ цуглуулан, довтолгоонд оржээ - эр, эм ардууд, нялх, нярай хүүхдүүдийг бүгдийг нь хядсан. Саулын их цэргийн илдний ирэнд хэдэн арван мянган хүн амиа алджээ. Гэтэл Саул Амалекийн хааныг нь өршөөв. Яах гэж? Би л хувьдаа, тухайн үеийнхээ ёсыг дагасан гэж үздэг юм. Тэр үед аль нэг улсыг байлдан эзлэхдээ, хааныг нь амьдаар нь олзлоод, ордондоо боол болгох нь алдар гавьяаны амьд одон болдог байжээ.

Түүнчлэн Саул олон мянган малыг нь алсан атлаа тарга хүч сайтай хонь, үхэр, төлийг нь “бичээсийн дагуу” Бурханд тахил болгуулахаар ард түмэндээ өгчээ. Хааныхаа энэ их хишгийг үзсэн ард олон нь яасныг төсөөлж байна уу? Хүмүүс тэр малыг Иеховад өргөж байхдаа “Хаан маань Эзэнийг оройлон дээдэлдэг, юутай бурханлаг хаан бэ?” хэмээн сүсэглээ байх.

Гэтэл Бурхан үүнийг нь өөрөөр үзэв. Бурхан Самуелд “Би Саулыг хаан болгосондоо харамсаж байна. Учир нь тэр Намайг дагахаас буцан эргэж, Миний үг зарлигийг үл сахив” (1Самуел 15:11) хэмээн гашууджээ. Саул хэдэн арван мянгыг алаад, нэгийг л амь өршөөсөн. Саул тушаалын 99.9 хувийг биелүүлсэн. Дийлэнх хүн үүнийг амжилт гэж үзэх бол, Бурхан дуулгаваргүй байдал хэмээн үзжээ. Үнэндээ, хэдхэн эшлэлийн хойно эш үзүүлэгчээрээ дамжуулан “тэрслэл” хэмээн нэрлэсэн юм. Тэгэхээр, дутуу дагах нь Бурханы мэлмийд дуулгавартай явдал огт биш ажээ. Үнэндээ, 99 хувийн *бараг* л төгс гүйцэтгэл ч дуулгавартай зан гэгдэх нь бүү хэл, харин ч бүр эсэргүү занд тооцогдох ажээ. “Миний хийснийг яагаад хардаггүй юм? Дандаа хийгээгүйг минь л өлгөх юм” гэдэг үгийг сонсоо л байх. Саул баттай ингэж хэлэх байсан. Гэвч энэ нь хүмүүний гаргалгаа болохоос, тэнгэрийн гаргалгаа биш!

ИТГЭЛИЙНХЭЭ ХЭР ХЭМЖЭЭГЭЭР ᠕ ДОТНОСОХ

Саулын амьдарлыг цааш нь дагуулж үзбэл, итгэл нь тууштай уруудахыг харна. Түүнчлэн Эзэнээс ч аажмаар хөндийрөхийг нь үзнэ. Эзэнтэй дотносох чадвар нь итгэлээс шууд хамааралтай байдаг болохоор, Саулын Бурхантай дотносох төвшин ч суларчээ. Энэ тухай элч Иохан:

Үүгээр бид үнэнийх болохоо мэдэж, Түүний өмнө зүрхээ тайтгаруулах болно. Зүрх маань биднийг яллах ямар ч зүйлд тэгэх болно. Учир нь Бурхан, бидний зүрхнээс аугаа бөгөөд бүхнийг мэддэг. Хайртууд минь, зүрх маань биднийг яллахгүй бол бид Бурханы өмнө зоригтой байж, гуйсан болгоноо Түүнээс хүлээн авна. Учир нь бид Түүний тушаалуудыг сахиж, Түүнд тааламжтайг үйлддэг билээ (1Иохан 3:19-22) гэсэн.

Бурхантай дотносох чадвар нь шууд итгэлээс хамааралтай бөгөөд итгэл нь Бурханд дуулгавартай байхаас шууд хамааралтай. Тэгэхээр, би нэг зүйлийг голчилж хэлье. Би тэр даруй улайж, гэмшдэг дуулгаваргүй авирын талаар яриагүй. Давид Саулаас ч аймшигтай нүгэл үйлдсэн атлаа газар дээрээ гэмшсэн. Давид итгэлээ ч, Эзэнтэй дотно нөхөрлөх чадвараа ч алдаагүй бол, Саул өөрийн гэсэн юмсаа хамгаалж, арвижуулахаар амин хувийнхаа эрх ашигтай зогсолтгүй хөөцөлдсөн юм. Давид шиг Бурханы араас хөөх зүрх Саулд байсангүй.

Үүнийг амьдрал дээрх нөхөр - эхнэрийн харилцаагаар дүрсэлж болох юм. Тэдний нэг нь амиа бодоод, нөгөөдөө захирагдахгүй бол, итгэлцэл, дотносол нь алдагдана. Нөхөр нь: “Би төлбөрөө төлж, идэж уух, өмсөж зүүхийг чинь хангаж, орон гэртэй байлгаж байна. Тэгээд ганц хүүхэнтэй уулзаж болохгүй юу?” гэнэ. Нөхөр нь эхнэртээ “Хайртай” гэж хэлдэг, сайхан халамжилдаг байж болох ч, дуулгаваргүй ганц талаас нь болоод тэр хосын дотносол шалаар нэг болно.

Бид: “Эзэн минь, би чуулганаа тасалдаггүй, арван хувь, өргөлөө өгдөг, Библиэ уншиж, залбирдаг ч, яагаад ийм сул итгэлтэй байгаа юм бэ?” хэмээн асууж болох. Тэгвэл би танаас асууя: “Та эхнэртээ хэрхэн ханддаг вэ?” Бурхан: “Нөхрүүд ээ, эхнэр чинь эмэгтэй хүн тул түүнийг хэврэгхэн сав мэт үзэн, та нар ч мөн адил эхнэртэйгээ ойлголцож амьдар. Амийн нигүүлслийг хамтран өвлөгчийнх нь хувьд түүнийг хүндэтгэ.

Ингэвэл залбиралд чинь саад тотгор учрахгүй? (1Петр 3:7, тодруулгыг нэмэв) хэмээн айлдсан. Бид тал бүрээрээ Бурханд дуулгаваргүй учраас, Бурхантай тогтоох харилцаа маань ч саадтай байгаа аж. Есүс "...та нар ч мөн адил, та нарт тушаасан бүхнийг гүйцэтгээд..." гэж хэлснийг санаарай. Дутуу дагабал, "итгэл хэзээ ч өсөхгүй!" Энэ зарчим эхнэр нь нөхөртөө хэрхэн хандах, үр хүүхэд нь аав ээждээ хэрхэн хандах, аав ээж нь үр хүүхэддээ хэрхэн хандах тал дээр ч хэрэгжинэ.

Асуух ёстой өөр нэг зүйл нь: Та хэлсэн үгдээ хүрдэг хүн үү? Бичээс Бурхантай дотно байх хүн нь "өөрөө хохирсон ч андгайлснаасаа үл няцна" (Дуулал 15:4) гэдэг. Та хэлсэндээ хүрч чаддаггүй байж, ам гардаг уу? Амаараа байнга нүгэл үйлдэж явдаг атлаа итгэлээ сул байгаад гайхаж байна уу? Ингээд л асуугаад л байвал, өөр олон зүйл асууж болно.

Гол санаа нь: Бид Бурханы Үгд бүрэн дуулгавартай байхын төлөө хичээх ёстой! Учир нь бидэнд ямар ч болзолгүй:

“Бяцхан хүүхдүүд минь, та нарыг нүгэл бүү үйлдээсэй хэмээн би эдгээрийг та нарт бичиж байна” (1Иохан 2:1) хэмээн заажээ.

Олонх хүн нүглийг нэг бол үл тоох янзтай, нөгөө бол чанга хуулиар хардаг байх. Бүх асуудлыг загалмай дээр шийдээд, нигүүлсэж, өршөөсөн болохоор, эдүгээ Бурханы Үгийг зөрчиж болно гэдэг задарсан хүмүүс байна. Үнэхээр, загалмай дээр бүхнийг бүрэн шийдсэн ч гэлээ, Паул “Та нар өөрсдийгөө дуулгавартай боол болгон хэн нэгэнд өгөхдөө, үхэлд хүргэх нүгэл ч бай эсвэл зөвт байдалд хүргэх дуулгавар ч бай, дагах нэгнийхээ боол нь болдогоо мэдэхгүй гэж үү?” (Ром 6:16) хэмээснийг мартаж болохгүй. Есүс ч мөн Өөрийг нь Эзэн хэмээн дууддаг атлаа гэм нүглээ үйлдсээр байсан хүмүүст: “Би та нарыг танихгүй. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” (Матай 7:23) хэмээн айлдсан байдаг.

Тэгвэл хуульчлагч нар нь нүгэл үйлдсэн хүнийг “тэнцсэнгүй” хэмээн дүгнээд, өөрсдийнхөө “ариун явдлын клубээс” хасч хаяхтай л адил ханддаг. Ийм үйлдэл ч, ийм сэдэл ч хүнийг аливаа дуулгаваргүй явдлаас тойруулж, сахин хамгаалж чадахгүй. Гэхдээ, нүгэл итгэлийг маань хордуулаад, эргээд Бурхантай дотносоход саад хийж байгаа нөхцөлд бид нүглээс шууд зугтах ёстой! Яагаад? Яагаад гэвэл Бурхантай дотно явах шиг амин чухал юм хүнд байдаггүй.

Ийнхүү бид, Иаков Бурханд ойртох урилгынхаа өмнө бөгөөд дараа нь ингэж хэлэх болсны учрыг тайллаа:

Итгэлийн бүрэн баталгаа

Тиймээс Бурханд *захирагдагтун*. Дяволыг эсэргүүц. Тэгвэл гэр та нараас зайлна. Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. *Нүгэлт та нар гараа цэвэрлэ*. Хоёр санаат та нар зүрхээ ариусга (Иаков 4:7-8, тодруулгыг нэмэв).

Энэ бүхэн нь дуулгавартай байдлыг тойрон эргэлдэх! Яагаад? Биднийг бүрэн баталгаатай ойртож ирүүлэхийн тулд. Бүгдээрээ бүлгийнхээ нээлтийн Бичээсийг дахин нэг харья:

Иймд ах дүү нар аа, бидэнд Есүсийн цусаар, махбод болох хөшгөөрөө дамжуулан Түүний нээсэн шинэ, амьд замаар ариун газарт нэвтрэн орох итгэл байгаа тул, мөн бидэнд Бурханы гэр дэх аугаа Тахилч байгаа тул хилэнцэт мөс чанараас цэвэрлэгдэхийн тулд зүрхэндээ цацуулж, биеэ ариун усаар угаалган, *итгэлийн дүүрэн баталгаатай*, үнэн зүрхээр *ойртон очицгооё*. *Найдвараа хүлээн зөвшөөрснөө гуйвалгүй бат баримталцгаая*. Учир нь Амлагч нь итгэмжит билээ (Еврей 10:19-23, тодруулгыг нэмэв).

Бидний бүрэн баталгаа буюу итгэлтэй байдал нь Бурханы Үгийг сонсохоос ирээд, эргээд туж дуулгавартай байдлаар дамжин өсдөг. Бид нүгэл үйлдэх аваас, Аавын Өмгөөлөгчтэй бөгөөд бушуухан гэмшбэл, Есүсийн цус биднийг цаснаас ч цагаан болгож угаадаг учир, ухамсар маань ялаас чөлөөлөгдөнө. Харин нүглээ үргэлжүүлээд байвал, ухамсар маань биднийг яллах бөгөөд Бурхан бидний ухамсраас хол аугаа болой. Бид амьд Бурхан руу бүрэн баталгаатай ойртож очиход саадтай болно.

НАЙДВАР

Одоо дээрх Бичээсийн хоёрдугаар мэдэгдэлд орьё: “Найдвараа хүлээн зөвшөөрснөө гуйвалгүй бат баримталцгаая.” Найдвар гэдэг энэхүү үг нь “магадлал” тээсэн үг биш бөгөөд үүнийг бид маш буруугаар ойлгодог.

Бурхан анх Абрахамд үзэгдэхдээ “Бамбай чинь Би тул шагнал чинь агуу их” (Эхлэл 15:1) хэмээн амласан. Абрахамын хувьд, үргүй эхнэрээсээ үр хүүхэдтэй болно гэдэг *хүнийх нь найдвар* тасраад байсан тул нилээд цөхрөнгүй хариулжээ:

Абрам —Эзэн БУРХАН минь! Та надад юу хайрлахсан бол? Би үр хүүхэдгүй бөгөөд миний голомт сахих хүү бол энэ Дамаскийн Елиезер юм гэв. Абрам цааш нь —Та надад үр удам заяагаагүй. Харагтун, гэрт минь өссөн хүү миний өв залгамжлагч болно гэж хэлжээ (Эхлэл 15:2-3).

Абрахамын найдвар тун хариугүй байгаа тул Өөрийнх нь амлалтыг хүлээж авч чадахгүйг Бурхан мэдэж байв. Тиймээс орой нь Бурхан Абрахамыг гадаа дагуулж гараад, оддыг тоолуулжээ. Яг л тийм юм болсон байх. Абрахам ч хязгааргүй олон одыг тоолсоор байгаад, сүүлээрээ унтаад өгсөн байх. Маргааш нь Эзэн Абрахамыг сэрээгээд: “За, тоолов уу?” гэж асуусан болов уу.

Абрахам ч: “Тоолоогүй ээ. Тоолохын аргагүй юм байна!” гэж.

Бурхан ч хүлээж байсан хариултаа сонсоод, араас нь: “Үр удам чинь ийм олон болно” (Эхлэл 15:5) хэмээн айлджээ. Бурхан Абрахамын дотор тэнгэрийн найдвар суулгаж, Абрахамд өгсөн амлалтынхаа тод зураглал болгон үй олон хүүхдийн дүр зургийг өгчээ. Абрахам өдөө оддыг харах тоолондоо, Бурханы амлалтыг санаад, “Абрахам аав аа, Абрахам аав аа” хэмээн эргэн тойронгүй шаагилдах үй түмэн хүүхдийнхээ дуу чимээг сонсоно. Энэ талаар Шинэ гэрээ:

“Найдварын дээд найдвараар тэр итгэсэн бөгөөд “Үр удам чинь ийм олон болно” гэж урьд нь айлдсан ёсоор түүнийг олон үндэстний эцэг болгосон” (Ром 4:18) гэдэг.

Айлдсан ёсоор гэж юуг хэлнэ вэ? “Үр удам чинь тийм олон болно!” хэмээн айлдсан ёсоор. Хүмүүний найдвар замхрах үед тэнгэрийн найдвар нүдэнд үзэгдэх байдлыг арчсаар, гэгээ татуулан орж ирдэг. Тэнгэрийн найдвар нь нүдэнд илэрхий юмсыг даваад, итгэл дүүрэн хүлээлт бүхий Бурханы талбар өөд хардаг. Абрахам мэдээжийн зүйлийг тэнгэрийнхээр солихоор шийдсэн. Үнэндээ Бичээс түүнийг Бурхан “амласнаа биелүүлэх чадвартайд нь бүрэн итгэж байлаа” (Ром 4:21) гэдэг. Абрахам Бурханы амлалтыг найдвараар хүчитгэсэн итгэлээрээ хүлээн авчээ.

“Итгэл бол найддаг зүйлсийн маань бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа мөн” (Еврей 11:1).

Итгэл нь Бурханы амлалтыг буюу найдварыг биетэй болгодог. Тэнгэрийн найдвар нь хүний нүдэнд үзэгдэшгүй, Бурханы алсын хараа юмуу зураг төсөл байдгийг Абрахамын амьдралаас харсан. Тэнгэрийн найдвар нь амин чухал юм. Учир нь найдвар үгүй бол, итгэл юугаа биежүүлэх билээ. Бурханы Үг зүрхэнд итгэлийг суулгаад зогсохгүй, итгэлд маань найдвар буюу алсын хараа өгдөг.

Үүнийг мөн тоосго, цонх, хавтан, мод, цемент, блок гэх зэрэг барилгын төрөл бүрийн материалтай зүйрлэж болох юм. Бидэнд барилгын бүх материал нь байв ч, зураг төсөл нь байхгүй бол, барилгын ажил явахгүй! *Би зураг төсөлгүй барьчихна* гэж бодож байна уу? Яахав, нарийн зураг төсөл гаргадаггүй юм аа гэхэд, толгойд чинь тодорхой хэмжээний зураг төсөл заавал байдаг шүү дээ.

ХӨШИГНИЙ ЦААД ОРШИХУЙД НЭВТРЭХ

Бүгдээрээ дахиад л нөгөө дотнослын талаарх сүлд эшлэлээ харцгаая:

Иймд ах дүү нар аа, бидэнд Есүсийн цусаар, махбод болох хөшгөөрөө дамжуулан Түүний нээсэн шинэ, амьд замаар ариун газарт нэвтрэн орох *итгэл (эр зориг)* байгаа тул, мөн бидэнд Бурханы гэр дэх аугаа Тахилч байгаа тул хилэнцэт мөс чанараас цэвэрлэгдэхийн тулд зүрхэндээ цацуулж, биеэ ариун усаар угаалган, *итгэлийн дүүрэн баталгаатай*, үнэн зүрхээр ойртон очигцооё. *Найдвараа хүлээн зөвшөөрснөө гуйвалгүй бат баримталцгаая.* Учир нь Амлагч нь итгэмжит билээ (Еврей 10:19-23, тодруулгыг нэмэв).

Бичээч Эзэнд ойртох тухай тодорхой хэлжээ. “Найдвараа хүлээн зөвшөөрснөө гуйвалгүй бат баримталцгаая” гэдэг үгийг дахин харна уу. Найдвар нь хүний жирийн нүдэнд харагдашгүй зүйлийн тэнгэрийн зураглал, алсын хараа - зураг төсөл болохыг санаарай. Үүнийг санангаа дараах хэсгийг анхааралтай уншина уу:

Учир нь хүмүүс өөрсдөөсөө агуу нэгнээр андгайлдаг бөгөөд тэрхүү андгай тэдний хувьд аливаа зөрчлийг төгсгөх баталгаа нь болдог. Тиймээс Бурхан амлалтыг өвлөгчдөд Өөрийнхөө зорилгын өөрчлөгдөшгүйг үзүүлэхийг хүсэж андгай өгчээ. Өмнө маань тавигдсан

Бурханд ойрт

Найдварыг барьж авахаар хоргодох газар уруу зугтаагч бид Бурханы хувьд худал айлдах боломжгүй, өөрчлөгдөшгүй хоёр зүйлээр дамжуулан хүчтэй урам авахын тулд тэгжээ. Энэхүү найдвар бидэнд сэтгэлийн зангуу мэт бөгөөд найдвартай хөдөлгөөнгүй агаад *хөшигний дотуур нэвтрэн ордог* (Еврей 6:16-19, тодруулгыг нэмэв).

Харж байна уу? Эдгээр эшлэлийг нийлүүлээд уншбал:

Хилэнцэт мөс чанараас цэвэрлэгдэхийн тулд зүрхэндээ цацуулж, биеэ ариун усаар угаалган, итгэлийн дүүрэн баталгаатай, үнэн зүрхээр ойртон очицгооё. *Найдвараа хүлээн зөвшөөрснөө гуйвалгүй бат баримталцгаая*. Учир нь Амлагч нь итгэмжит билээ. ...Энэхүү найдвар бидэнд сэтгэлийн зангуу мэт бөгөөд найдвартай хөдөлгөөнгүй агаад *хөшигний дотуур нэвтрэн ордог* (Еврей 10:22-23, 6:19, тодруулгыг нэмэв).

Нью Ливинг Транслэйшн Библи “Энэ нь биднийг тэнгэрийн хөшгөөр Бурханы дотоод ариун газар руу хөтөлдөг” гэдэг. Бурхан Абрахамд тэнгэрийн найдварын тодорхой хараа өгсөн. Дотнослын тал дээр, газрын нүдээр харж чадахгүй юмс дээр Ариун Сүнс тодорхой хараа өгч, тэнгэрийнхээ өрөөний сэнтийд залран буй Эзэнийг Өөрийг нь харуулдаг.

Бид Бурханд ойртохдоо, дотор маань оршин байх Бурханы Сүнс рүү ширтдэг бөгөөд махан бие, хязгаарлагдмал бодлынхоо хөшгийг ярсаар яваад, Бурханы оршихуйд ордог. Ийн явсаар, тэнгэрийн дотоод ариун өрөөнд нэвтэрч, тэнд Бурхан Аавтайгаа, Эзэн Есүстэйгээ уулздаг. Тийнхүү тэр дотоод ариун газарт Алдрын Эзэнтэйгээ дотно нөхөрлөнө!

Итгэгч хүмүүс залбирахдаа, өөрийгөө сэнтийн өрөөнд орж байгаагаар төсөөлөх гэж оролддог. Гэвч Абрахам Бурханаас зураглал хүлээж аваагүй байхдаа Бурханы амлалтыг өвлөж чадаагүй шиг, бид ч Ариун Сүнсний тусламжгүйгээр Бурхантай уулзаж чадахгүй. Эзэн Өөрөө Абрахамд тодорхой зураглал өгсний дараа л Абрахам Бурханы амлалтыг өвлөсөн буюу.

Ариун Сүнс үгүй бол, дотоод ариун газарт нэвтэрч, Бурхантай дотносно хэмээн найдалтгүй. Жирийн нүдээр харж чадахгүй юмсыг Ариун Сүнс л тодорхой хараа буюу найдвар өгч байж, харуулдаг. Бид

тэрхүү үзэгдлийг даган, биднийг амьдруулахын төлөө Есүсийн асар их үнээр худалдаж авч өгсөн хувь зохиолыг эдлэхээр итгэлийн бүрэн найдвар, зориг тээн Эзэн рүү ойртоно. Есүс ээ, биднийг өнөөдөр ч, өнө мөнхөд ч Бурханы оршихуйд бүрэн итгэлтэйгээр ирүүлэхийн төлөө хаан язгуурын цусаа урсгасанд баярлалаа!

СУДЛАХ АСУУЛТ

1. Библийн найдвар - итгэл дүүрэн хүлээлт гэдэг үгийг Англи хэлд түгээмэл хэрэглэгддэг “горьдлого” бүхий найдвар гэсэн үгтэй харьцуулж үзнэ үү. Та ч бас “горьдлогоор” агаарт хий үг цацаж үзсэн үү? Үзсэн бол, энэ чинь таны итгэлийн талаар юу өгүүлж байна?
2. Итгэгч хүмүүс элч нарын үеэс л хоёр асуулт тавьсаар иржээ. Үгийн хэлбэр нь өөрчлөгдсөн байж болох ч, утга нь янзаараа:
 - Хэрхэн итгэлтэй болох вэ?
 - Итгэлээ хэрхэн өсгөх вэ?Дээрх хоёр асуултад энэ бүлгээс сурсан зүйлээрээ хариулж чадах уу?
3. Саулын дуулгавартай чанарыг Давидынхтай харьцуулахад, ямар ялгаа харагдаж байна? Энэ хоёр хүний дуулгавартай чанар нь Бурхантай дотносоход нь хэрхэн нөлөөлсөн бэ?
4. Бурхан руу зоригтойгоор ойртон очиход хүний дуулгавартай чанар хэрхэн нөлөөлдөг вэ?

Арван дөрөвдүгээр бүлэг

БУРХАНД ОЙРТОХ



Бурхан танд мөнхийн баталгаатай урилга өгсөн тул,
Бурхан руу зоригтойгоор ойртож оч

Сүүлчийн бүлгээрээ та бүхэнд биднийг дэндүү хайрласан Нэгэнтэй дотносох практик зөвлөгөө өгмөөр байна. Гэвч энэ маань ч гэрлэх гэж байгаа хүнд ор хөнжилдөө хэрхэн ойртож дотносохыг нь зааж өгөхтэй л адил юм болчих гээд байх юм. Ийм асуудал дээр чинь ерөнхий зарчмыг нь л ойлгуулахаас биш, хүн өөрөө л зүрхээрээ мэдрээд, үйлдээд явчихдаг зүйл шүү дээ. Үнэндээ, оюунаар сургагдах бус, аандаа зүрхнээс ургаж дэлбээлдэг нь л дотнослын ид шид буюу.

Эзэн рүү ойртож очихдоо, өөрийгөө Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн болохоо санаарай. Бид янз янзын сэтгэл мэдрэмжтэй байдаг шиг, Бурхан ч зүйл зүйлийн сэтгэл мэдрэмжтэй. Бид дотно хүмүүсийнхээ сэтгэлд мэдрэмжтэй байдаг шигээ, Эзэнийхээ сэтгэлд бүр ч мэдрэг байх ёстой. Жишээ нь: Заримдаа бид Эзэнийхээ оршихуйд магтаал хадаасаар орж ирдэг бол, заримдаа асгартал уйлсаар ирдэг; заримдаа зоригтой ирдэг бол, заримдаа чичирсээр ирнэ. Заримдаа инээд алдана, заримдаа мэгшин

уйлна, заримдаа Бурханы тусаар харын хүчтэй дайтна, заримдаа Түүний ер бусын оршихуй дотор эгэлгүй амар амгаланд умбана.

Тэгэхээр, хамгийн сүүлд авсан жишээг тонгоруулах хэлбэрээр, энэ бүх нөхцлийг тайлбарлах гэж оролдъё. Жишээ нь: Нэгэн гэр бүлийг гэртээ сайхан амарч суутал, дээрэмчид гэрийг нь ухахаар, арын хаалгыг нь эвдээд, юу юугүй орж ирэх нь ээ. Яг тэр үед нэг хүү нь зэвсгээ хайж байгаа аав дээрээ очсоноо: “Аав аа, та хамгийн мундаг аав. Та биднийг юугаар ч дутаадаггүй. Хөгжилтэй, ухаантай...” гээд унажээ.

Гэтэл аав нь: “Хүү минь, ийм юм ярьж байх цаг нь биш. Бэйсбоолын цохиураа аваад, арын хаалга руу явцгаая!” хэмээн яриаг нь тасална.

Есүс Христийн чуулган - бид чинь Бурханы гэр гэдгийг санаарай. Дайсан бодитой. Тиймээс заримдаа намайг залбирч байхад, Ариун Сүнс тулаанд шавдуулдаг бөгөөд тулалдуулах хэлбэр нь ч өөр өөр байдаг. Заримдаа Үгээ тунхаглуулна, заримдаа Сүнс дотор хүчтэй залбируулна, заримдаа хүчирхэг магтаалаар ч тулалдуулна (2Шастир 20:20-24 дээр Иехошафат тэргүүтэй их цэрэг яг ийм аргаар тулалдсан байдаг.) Бид уур амьсгалаа мэдрэхээс гадна Бурханы хүслийг хэрхэн гүйцэтгэх дээрээ анхаарах ёстой.

За, буцаад жишээ рүүгээ оръё. Энэ удаа түүхээ дахин тонгоруулж үзье. Нөгөө гэр бүл чинь амар жимэр амьдран сууж, аав нь галынхаа дэргэд амарч хэвтгэл, хүү нь толгойдоо дуулга углаж, гартаа цохиур барьсаар аав дээрээ хүрч ирээд: “Аав аа, дээрэмчдэд үзүүлээд өгье!” хэмээн хашхирна.

Аав нь хүүгээ хараад: “Хүү минь, тайвшир. Юу ч болоогүй байна. Аавынхаа дэргэд суугаад, аятай цагийг өнгөрөө” гэж хэлнэ.

Энэ мэтчилэн бид ойр дотныхоо хүмүүстэй янз янзаар харилцдаг шиг, залбирлын янз бүрийн цаг, улирал бий. Дээр дурьдсан бас дурьдаагүй олон жишээ нь бүгд Бичээс дээр байдаг. Хамгийн гол нь яг тухайн эгшинд Бурхан ямар санаа, зүрхтэй байгааг л олж мэдэх.

БУРХАНЫ АШИГ СОНИРХОЛ

Найз чинь танд зөвхөн өөрийнхөө л ашиг сонирхлыг тулгаад байвал, ямар вэ? Хүүхдүүд нь ааваасаа юм салгахын төлөө л уулздаг байвал, аавд нь ямар байх уу? Амиа хичээсэн, өрөөлийг энэрч хайрлахыг мэддэггүй хүмүүст та зүрхээ нээх үү? Эзэний зүрхний чавхдасыг хөндмөөр байгаа бол, хүсэл, хэрэгцээг нь олж мэдэх ёстой. Тийм ээ, хэрэгцээг нь! Бурхан бүхнийг чадагч, бүгдийг эзэгнэгч, юугаар ч гачигдашгүй Нэгэн мөн

Бурханд ойртох

боловч, хүн төрөлхтөнд чөлөөт хүслийг хайрлаж, дэлхийд тодорхой хэмжээний эрх чөлөө олгосон билээ. Үүгээрээ Өөрийгөө ч эрсдэлд оруулсан. Учир нь хүний нүглээс болж төөрөлдүүлэгч, урхидагч, тамлагч харанхуйн хүчинтэй хамт хүн төрөлхтөн гачигдал, уй зовлонд унасан юм. Бурхан тэр хүмүүсийн төлөө үйлдэхийг хүсдэг тул, тэдний төлөө чин зүрхнээсээ санаа тавих, залбирах хүмүүсийг хүлээдэг. Иймээс ч Бурхан зуучлан залбирлаараа зовогсод Бурханы нигүүлслээр тусламж түгээдэг хүмүүст ойр байдаг. Есүс шүүх сэнтий дээрээсээ айлдруун:

Учир нь өлсөж байхад минь та нар Надад идэх юм өгсөн. Цангаж байхад минь уух юм өгсөн, харь хүн байхад минь урьж оруулсан, нүцгэн байхад минь Намайг хувцасласан, өвчтэй байхад минь Намайг эргэж байсан, шоронд байхад минь Над дээр ирсэн билээ” (Матай 25:35-36).

Энд ертөнцийн хамаг эрх мэдэл, эрч хүчийг атгадаг алдрын Эзэн Өөрийнхөө хэрэгцээг уудалжээ. Бурханы хэрэгцээ нь Бурханыг хайрладаг бидний ч хэрэгцээ мөн. Учир нь Бурхан “Үнэнээр Би та нарт хэлье. Та нар энэ ах дүүсийн минь дорд нэгэнд ийн үйлдсэн бол Надад хийсэн хэрэг” (Матай 25:40) хэмээсэн. Зуучлан залбирах, бодитоор туслах, Бурханы эрх чөлөөний Үгийг тунхаглах, Бурханы хүчээр өвчнийг эдгээх гэх зэргийг үйлддэг хүмүүс нь хэн хэнээс түрүүлж Бурханы зүрхийг олно.

Бичээс дээр Бурханы хүмүүс Бурханаа хичээнгүйлэн хайсан ч, Бурхан тэдэнд “Мацаг барихыг маань яагаад Та хараагүй юм бэ? Бид номхон даруу болж байгааг яагаад Та ажиглаагүй юм бэ?” гэдэг. Үзэгтүн, мацаг барих өдрөө та нар таалал сонирхолдоо үйлчилж, Хамаг ажилчдаа мөлждөг. Үзэгтүн, та нар хэрүүл маргаан хийж, Гэмт нударгаараа цохихын тулд мацаг барьдаг. Дуу хоолойгоо өндөрт сонсгохын тулд Та нар өнөөдөр мацаг барихгүй байна” (Исаиа 58:3-4) гэжээ.

Хүмүүс тэмцэлдэн, маргалдаж байгааг хараарай. Бүгдээрээ дахиад номынхоо сүлд эшлэлийг уншъя: “Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно.” Иаков бүлгээ дараах үгээр эхлүүлжээ:

Та нарын дундах хэрүүл болон зөрчил хаанаас гарна вэ? Тэр нь эрхтнүүдэд чинь дайтаж буй хүслүүдээс чинь гардаг бус уу? Та нар шунадаг бөгөөд та нарт байхгүй болохоор нь хүн алдаг. Та нар атаархдаг бөгөөд олж авч чаддаггүй. Тиймээс та нар тэмцэлдэж, хэрэлддэг. Та нар гуйдаггүй учраас та нарт байдаггүй. Та нар гуйгаад хүлээн авдаггүй. Учир нь та нар өөрсдийн тааламжид зарцуулья хэмээн буруугаар гуйдаг байна. Завхай эмс ээ, ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгэхлээр хорвоотой ходий хэн боловч өөрийгөө Бурханы дайсан болгож байгаа юм. Эсвэл Бичвэр дэмий хоосноор “Бидний дотор Түүний нутаглуулсан сүнс нь атаархан хүсдэг” хэмээсэн гэж та нар бодож байна уу? Гэвч Тэр илүү их нигүүлсэл өгдөг. Тиймээс “Бурхан бардмыг эсэргүүцэж харин дарууд нигүүлсэл өгдөг” гэдэг. Тиймээс Бурханд захирагдагтун. Диаволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна. Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Нүгэлт та нар гараа цэвэрлэ. Хоёр санаат та нар зүрхээ ариусга (Иаков 4:1-8).

Тэгэхээр, ийм байна. Хэрэгжүүлэх ёстой эхний алхам нь: Бид Бурханы төлөө, Сайн мэдээний төлөө амиа бодсон хуучин амьдралаасаа татгалзах ёстой. Бид Бурханы хүслийн төлөө амьдрах ёстой. Бурханы хайрладгийг хайрлаж, үзэн яддагийг нь үзэн ядах ёстой. Бурханд чухал нь бидэнд чухал болж, чухал бус нь бидэнд чухал бус болох ёстой. Бид Бурханы зүрхийг тээх ёстой!

Тэгэхээр, бид амьдралын сайн сайхныг үзэхгүй гэсэн үг үү? Бурхан хүмүүстээ зугаа цэнгэлийг тас хорьдог гэж үү? Яалаа гэж! Харин ч Бичээс “харин биднийг баясгах бүхнээр арвин хангагч Бурханд...” (1Тимот 6:17) гэдэг. Зүгээр л Бурханы хүслийг үл ойшоогоод, хувийнхаа хүсэлтэй хөөцөлдөөд байвал, Бурханы зүрхтэй холбоо тасрахыг л хэлж байна.

Ядуу хүмүүст бодитоор туслахгүй бол, Бурханы хүслийг биелүүлэхгүй байна гэж итгэдэг хүмүүс бий. Энэ үнэн юм бол, Петр яагаад “Ширээнд үйлчлэхийн тулд Бурханы үгийг орхигдуулах нь бидэнд зөв зүйл биш юм. Тиймээс ах дүү нар минь, Сүнс болон мэргэн ухаанаар дүүрэн, нэр хүнд бүхий долоон эрийг та нар дундаасаа сонго. Тэгээд энэхүү үүргийг тэдэнд хариуцуул. Харин бид залбирал болон үгийн үйлчлэлээ үргэлжлүүлэ” (Үйлс 6:2-4) гэж хэлэх болов? Үнэндээ, Петр нэг хэсэг

Бурханд ойртох

нь ядуу (гачигдсан) хүмүүсийн хэрэгцээг Бурханы Үгээр хангадаг бол, нөгөө хэсэг нь бодит хэрэгцээг нь хангадгийг ойлгожээ. Гэхдээ хэн хэн нь ялгаагүй л Есүсийн “Намайг өлсөхөд, та нар хооллосон” гэдэг хэрэгцээг нь хангадаг.

Эзэний ашиг сонирхлыг зүрхэндээ тээдэг хүмүүс нь Эзэн дээр амархан ирдэг. Эзэний ашиг сонирхлыг тээж, Бурханы зүрхэнд мэдрэг байж, Бурхантай үй зайгүй нөхөрлөж, Бурханы хүмүүсийг хоньчилж явсан Мосе ч тийм л хүн байсан.

Бурхан сайн удирдагч - Иосиатай ярихдаа, түүний тухай “Тэрээр зовсон болон ядуу нэгний хэргийг шүүсэн. Тэгээд л сайн байв. Энэ нь *Намайг мэдэхийн* төлөө гэсэн үг бус уу? (Энэ чинь л *Намайг мэдэх* явдал бус уу?)” гэж ЭЗЭН тунхаглаж байна” (Иеремиа 22:16, тодруулгыг нэмэв) гэжээ.

Тусламж, төрд ажиллах, багшлах, зохион байгуулах, өгөх зэрэг ямар ч төрлийн үйлчлэлээ онцсайн гүйцэтгэж байгаа хүн нь амин хувийнхаа амьдрал - тэр бүү хэл үйлчлэлийг явуулчих санаатай нэгнээс илүү хурдан Бурхантай дотносож чаддаг. Учир нь Эзэн Өөрөө “Энэ чинь л Намайг мэдэх явдал бус уу?” хэмээн айлдсан болой.

ОЙРТООД, СОНС

Эзэнтэйгээ дотносохыг хүсч байгаа хүмүүст өгөх дараагийн практик алхам нь удаах Бичээс дээр байна:

Бурханы өргөө уруу явахдаа чи алхмаа хянагтун.
Мунхаглан тахил өргөснөөс ойртон очоод чагнасан нь дээр. Учир нь хүмүүн буруу үйлээс хэрхэн хөндийрөхөө ойлгодоггүй аж. Бурханы оршихуйд үг хэлэхэд зүрх чинь ч, хэл чинь ч бас бүү яараг. Учир нь Бурхан тэнгэрт, чи газарт байна. Иймд үгээ цөөн байлга. Зүүд зовнилоор элбэг байдаг бол мунхгийн дуу хоолой үгээр арвин (Номлогчийн үгс 5:1-3).

Эдгээр эшлэлийн эхэн хэсгийг онцольё. ЭнКэйЖэйВи Библи дээр “Мунхагийн тахил өргөсөнд орбол, сонсохоор ойрт” гэдэг. Олон хүн Бурхан руу ойртохдоо, чөлөө завгүй ярих юмуу дуулдаг. Энэ мэдээж үнэ цэнэтэй. Гэхдээ Бурхан дээр ирэхдээ, үг урсгаж, магтаал дуулахаасаа өмнө чимээгүй байж, чихээ тавих нь хавьгүй зөв болохыг би сурсан.

Би саяхан нэгэн том чуулганы тун амжилттай яваа пастортай уулзсан юм. Өдрийн хоолон дээр тэрбээр надад: “Жон, Би Эзэнд “Би өглөө болгон энэ өрөөнд орж ирэхдээ, Танаас ямар ч хариу дуулахгүй, өөртэйгээ ярьсаар, хариугүй цөхөрлөө. Тиймээс, Таныг надтай ярих хүртэл би зүгээр л өглөө бүр энд орж ирээд, чих тавих болно” гэж хэлэхдээ тултлаа аргаа баран, Эзэнийг хайсан” хэмээн ярьж билээ.

Эзэн түүний зүрхний чанарыг шалгаж байжээ. Ийм маягаар хэдэн сар үргэлжилсний эцэст, нэгэн өглөө өрөөндөө орж иртэл нь, гэнэт л Ариун Сүнс түүнтэй яриад унажээ. Энэ үеэр л Бурхан түүнд хэзээ ч үзээгүй, хүчирхэг хүчирхэг илчлэлийг өгч, нөгөө хүн ч тэдгээрийг нь олон сарын турш чуулгандаа зааж өгсөн байна. Тэр эрхмийн залбирлын амьдралд хувьсгал гарчээ.

Бурханы оршихуйд нэвтрэх хамгийн хүчирхэг нэгэн арга нь Библиэс унших явдал байдгийг би сурсан. (Ялангуяа Дуулал номоос юмуу Шинэ гэрээнээс унших.) Олон Бичээс унших бус, нэг юмуу заримдаа бүр тал эшлэл ч байж болно. Үүний дараа Эзэний оршихуй үзэгдэнэ. Тэр үед нь умшихаа зогсоогоод, Бурхан дээр анхаарч, айсуй юмсыг зааж, харуулах бүрэн эрхийг нь олгоно.

Аль ч тохиолдолд Бурханы оршихуйд ярихаасаа илүү сонсохоор ирэх нь л үр нөлөөтэй. Заримдаа цуглаанд орохдоо, оюун бодлоо тэгшитгээд, Бурханы хүсэл, ааль байдлыг мэдрэхээр дотогшоо Бурханы Сүнс рүү ширтэнэ. Мэдээж дандаа ингэхгүй л дээ. Заримдаа Бурхан дээр магтаал хадаасаар, баярлан хөөрсөөр очих ч үе байна. Яг л Бурханы Сүнс: “Урагш аа!” хэмээн уухайлах мэт. Учир нь Бичээс:

Түүний өмнө талархалтайгаар ирж, Түүнд дууллиудаар
баяртайгаар хашхирцгаая! (Дуулал 95:2),

ЭЗЭНд баяртайгаар үйлчил! Түүний өмнө баясалтайгаар
дуулан ирэгтүн! (Дуулал 100:2) гэдэг.

Тэгэхээр, өмнөх Бичээс бидэнд чих тавьж, сонсохыг үүрэгдсэн бол, энэ Бичээс Эзэний оршихуйд дуулж хуурдан, баярлан талархаж нэвтрэхийг ятгажээ. Гол нь Бурханд мэдрэг байх! Эр, эм хоёр хэрхэн дотносохыг алхам алхмаар заах боломжгүйтэй адил, Эзэнтэй дотносохыг ч нэг бүрчлэн сургах боломжгүй.

Эр хүн шинэхэн гэргийтэйгээ харилцаанд орохдоо, “алхам алхмаар” гэдэг гарын авлага гаргаж ирээд уншаад унабал, яах уу? Тэгээд эхний

хуудсаа нээгээд, “нэгдүгээр алхам - эхнэрийнхээ хөөрхөн сайхныг магт хэмээн дуудаж умшина. Хоёрдугаар алхам - үсийг нь илбэ. Гуравдугаар алхам - гэрлээ унтраа. Дөрөвдүгээр алхам... (Өө, юу ч харагддаггүй ээ. Утасныхаа гэрлийг л асаахаас...) гэвэл, яах уу? Шал хөгтэй! Гэтэл зарим хүн яг л ийм хөгтэй залбирал үйлддэг. Тэд Бурханыхаа зүрхийг мэдэрдэггүй, зүрхэнд нь ч хүрдэггүй. Намайг буруу ташаа ойлгуузай. Бичээсээс дагах ёстой, тодорхой чиглүүлэх байх нь байдаг ч, Бичээс “Учир нь үсэг хөнөөдөг бол, Сүнс амь өгдөг” (2Коринт 3:6) хэмээн тодорхой хэлсэн тул, Бурханы Сүнсний туслалцааг л ав. Тийнхүү Бурханы Сүнс зуучлах, дуулах, хашхирах, орь дуу тавих, дуугаа хураах гэх зэрэгт чиглүүлнэ.

Хойш тавих ёстой өөр нэгэн зүйл нь яаран хүсэлт тавьж, үг хэлэхгүй байх. Энэ зарчим жирийн харилцаан дээр ч хэрэгждэг. Хүн чалчаа хүнээс анхаарлаа буруулдаг бол, мэргэн үгтэй хүнийг ярих бүрийд нь улам анхаарч сонсох. Иймээс би залбирахдаа, нэг бол дуугүй байдаг, нэг бол хэлээр ярьдаг, нэг бол Бурханы Үгийг хэлдэг.

Би хэлээр ярихдаа, Бурханы төгс хүслийг залбирдаг. Есүсийн нэрээр Аавд хэлэх үгийг Ариун Сүнс надад өгдөг. Сүнс дотор байгаа хүн буруу юмуу дэмий үг залбирахгүй! Харин Бичигдсэн Үгээр залбирах үед оюун санаа тэргүүтэй бүх бүтэц маань боловсорч байдаг. Гиймээс ухаанаараа залбирах нь ч ялгаагүй чухал.

Гэхдээ Бурханы оршихуйд байгаагаа мэдээд, сонсох үед илчлэл, ойлголт, цэц ухаан ирдэг. Бид Эзэнийг яриулах нь тун чухал. Уулзсан хүн чинь танаар ганц үг хэлүүлэлгүй, өөрөө зогсоо зайгүй ярьсаар байгаад, яваад өгбөл, яах уу? Заримдаа бид Ариун Сүнсэнд яг л ингэж ханддаг. Бид ярьдаг шигээ бас сонсох хэрэгтэй. Залбирал нь илтгэл бус, харилцан яриа болохыг санаарай!

ОЛОН ЗАМААР ХАРИЛЦАХ

Бурхан бидэн рүү ойртохдоо, Өөрийгөө ч, замуудаа ч илчилдэг. “...чиний мэдэхгүй аугаа хүчит зүйлийг Би чамд ярина” (Иеремиа 33:3). Эндээс бид Бурхан бидэнтэй олон замаар харилцдаг гэдгийг ойлгож авах ёстой. Заримдаа бид Түүний ярихыг сонсоно. Энэ нь зүрхэнд тусах хүчирхэг дуу хоолой байх агаад бусад замтайгаа адил Бурханы дотоод амар тайвныг дагуулахаас гадна Бичээстэй эгнэдэг. Заримдаа Бурхан бидэнтэй итгэгч хүнээр юмуу удирдагч хүнээр дамжуулж харилцах бөгөөд тэднийг үг хэлэхэд нь бидний зүрхэнд тэсрэлт болдог.

Заримдаа Бурхан үзэгдлээр юмуу зүүдээр дамжуулж ярина. Заримдаа бид өмнө мэдэхгүй байсан юмаа зүгээр л гэнэт ойлгодог бөгөөд Бурхан надтай ийм замаар их харилцдаг. Түүнчлэн Бурхан Үгээ бидний дотор урьдчилж суулгаад, ярих хүртэл маань битүүмжлэх нь олонтаа. Тэгээд биднийг амаа нээгээд, ярих үед гэнэт гэгээрэл тусдаг.

Яг ийм явдал Пентекост өдөр Петрт тохиолдсон юм. Бурханы оршихуй бууж ирэхээс өмнө Петр үндсэндээ “Есүс бол Христ” (Матай 16) хэмээн Бурханы Өөрийнх нь зааж өгсөн ганц илчлэлийг эс тооцбол, Бурханы Үгийн мэдлэг бүдүүн баараг, овойж оцоих гойд юмгүй, сүнсний юмс дээр юм л бол буруутаж явдаг хүн байв. Дээд өрөөнд байхдаа ч Петр “Иудасын орны хүнийг томилох” сүнсний ажиллагаа явуулах гэж оролдсон ч, сонгож томилсон хүн нь цаашид сураг тасарнаас гадна харин хожим Паул өөрийгөө “дутуу төрсөн мэт надад” (1Коринт 15:8) гэж хэлснээс үзбэл, Петр гаргасан үр жимсээрээ өөрийгөө хэр зэрэг түүхий байсныг л батлан харуулсан гэмээр. Бурхан Иудасын оронд шодох гэх мэт зохимжгүй аргаар Петрийн сонгож томилсон хүнийг бус, харин Паулыг сонгосон байжээ.

Үндсэндээ, сүнсний тал дээр Петр дандаа алхаа зөрдөг байж. Гэтэл Бурхан Петрт ойртох үед Петр тэр дороо тэдний 120 хүнд юу тохиолдсон талаар Иоел, Дуулал номоос маш хүчирхэг, гүн тайлбар бүхий номлол хэлжээ. Петр хүмүүсийг бөөгнөрөн бүчиж авахаас өмнө тийм мэргэн сургаал бэлтгэх ямар ч боломжгүй. Тэрбээр зүгээр л өөрт хэзээ ч байгаагүй мэдлэгийг эгшин зуурын дотор олжээ. Тэр өдөр Бурханы оршихуй дээрээс нь асгах үед ганц Петр гэлтгүй, зуун хорь маань бүгдээрээ “Бурханы аугаа үйлсийг” (Үйлс 2:11) ярьцгаажээ.

Тэгэхээр, Бурхан бидэн рүү төрөл бүрийн аргаар ойртдог боловч, Бурханыг бууж ирэх бүрий бид мөнхөд өөрчлөгддөг нь бат үнэн болой.

ТӨГСГӨЛД НЬ

Ном маань аргачлал заадаг гарын авлага биш болохыг номынхоо эхний бүлэгт хэлсэн билээ. Дотнослыг аргалахгүй. Энэ номыг Бурханы зүрх рүү дагуулах эрдэнэсийн газрын зураг гэвэл зохино байх. Бурханы улайрч, хайрлаж, хүсдэг хүмүүс - бидэнд зориулсан Бурханы эш үзүүллийн үг, зүрхний дуудлага гэвэл зохино байх. Энэ ном дээр тайлсан Бурханы Үгийн газрын зургийг цаг, хүчээ зориулан байж дагасан хүн Бурханы оршихуйг ч, зүрхийг ч лавтай олно. Учир нь Бурхан ойртох амлалтаа хүн нэг бүрт өгсөн бөгөөд түрүүлж Бурхан руу ойртсон хүн

Бурханд ойртох

нь Түүнтэй уулзаж ч магадгүй, уулзахгүй ч байж магадгүй гэдэг бүрхэг урилга бус, харин хүрэлцэн ирсэн хүн бүрийг хэзээ ч няцаалгүй, үргэлж хүндэтгэлтэй хүлээн авна гэсэн баталгаат урилга болно.

Бурхан руу ойртоход чинь зоригжуулах үүднээс номынхоо төгсгөлд дахин хэдэн эшлэл өгмөөр байна:

Бусармаг нэгэн нь ЭЗЭНд жигшил Чигч шударга нэгэнтэй
Түүний андлал (Сургаалт үгс 3:32).

Харин Бурханд ойр байх нь надад сайн (Дуулал 73:28).

ЭЗЭН Өөрийг нь дуудагч бүхэнд, Өөрийг нь үнэнээр дуудагч бүхэнд ойр билээ. Тэрээр Өөрөөс нь эмээгчдийн хүслийг биелүүлдэг. Тэдний хашхирахыг нь бас сонсдог, тэднийг авардаг. ЭЗЭН Өөрийг нь хайрладаг бүгдийг сахидаг, Харин бүх буруутыг Тэр устгана (Дуулал 145:18-20).

“Би түүнийг ойртуулахад Над уруу тэр дөхөж ирнэ. Над уруу дөхөж ирэхээр Хэн амиараа аз туршиж зүрхлэх билээ?” гэж ЭЗЭН тунхаглаж байна (Иеремиа 30:21).

Та Бурхан дээр зоригтой очиж болно. Бурхан Өөрөө танд мөнхийн урилгаа өгсөн. Тиймээс Бурханы оршихуйд амьдардаг нэгэн байхын төлөө хичээ. Бурхан таныг хүлээж байна. Юугаа хүлээнэ вэ? Бурханд ойрт!

Та нарыг бүдрэхээс хамгаалж,
Өөрийнхөө алдрын оршихуйд
үлэмжийн баяр хөөртэйгөөр,
өө сэвгүйгээр зогсоож чадах Түүнд,
бидний Аврагч болох цорын ганц Бурханд,
бидний Эзэн Есүс Христээр алдар суу,
сүр жавхлан, сүр хүч, эрх мэдэл нь
бүх цагаас өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай.
Амен (Иуда 24-25).

СУДЛАХ АСУУЛТ

1. Энэ бүлгээс өмнө Бурханд “хэрэгцээ” гэж байдгийг мэддэг байв уу? Бурханы хэрэгцээнд ямар арга замаар үйлчилж болох вэ?
2. Таны хувьд, Ариун Сүнсний яриаг сонсох нь хэр чухал вэ? Магтаалын дуу дуулмаар, Бичээсээс тунхагламаар байвч, Бурхан дээр чимээгүй очиж үзсэн үү? Энэ дасгалыг хийж үзээд, сурсан зүйлээ бусадтайгаа хуваалцана уу.
3. Нэгдүгээр бүлэг дээр зохиолч энэ номоо аргачлал зааж өгдөг гарын авлага бус, харин Бурханы зүрх рүү хөтлөх эрдэнэсийн газрын зураг хэмээн дүрсэлсэн. Сурсан зүйлээ тунгааж үзбэл, та ямар нэгэн эрдэнэс олж авсан уу? Цаана нь олж аваагүй ямар ямар эрдэнэс байна?

Хавсралт А

ХҮН АВРАГДАХ ЁСТОЙ



Амьдрал хоёр жишигтэй: нэг нь нийгмийн тогтоож өгсөн жишиг, нөгөө нь Бурханы тогтоож өгсөн жишиг. Нийгмийн соёл таныг өөрийнхөө параметрээр хэмжээд, “онц” гэж дүгнэж болох ч, Бурхан юу гэж үнэлж байгаа бол? Бурханы зөвийн жишигт хүрэх хүн байдаггүйг Бичээс хэлдэг: “Зөвт хүн алга, ганц ч алга” (Ром 3:10), “Бүгд нүгэл үйлдсэн тул Бурханы алдар сууд хүрдэггүй” (Ром 3:23).

Нүгэл үйлддэг гэдэг нь бүгд Бурханы жишигт хүрч чаддаггүй гэсэн үг. Хүн нүгэлтэн байхаар бүтээгдээгүй боловч, Адам энэ замыг сайн дураараа сонгосон. Бурхан анхны хүн Адамыг өвчингүй, эмгэггүй, ядууралгүй, байгалийн гамшиггүй, үзэсгэлэнт дэлхий дээр л суурьшуулсан. Тэнд айдас, үзэн ядалт, тэмцэл, атаарал зэрэг нь байгаагүй. Бурхан тэр газрыг Бурханы Өөрийнх нь цэцэрлэг - Еден хэмээв.

Адам Бурханы тушаалыг дагахгүй байхыг сонгохдоо, биеэр хэдэн зуун жилийн дараа үхсэн хэдий ч, сүнсээр тэр даруй үхжээ. Зүрх нь харанхуйлсан бөгөөд сүнсний үхэл нь биеийн үхлээс өөр байдаг. Хүн биеэрээ үхэх үед бие нь замхардаг бол, сүнсний үхэл нь амийг түгээгч эх ундарга болох Бурханаасаа таслагдах явдал гэвэл, онох байх.

Адамын болоод үр удмынх нь амьдралд нүгэл нэвчив: “Адам зуун гучин жил амьдраад өөрийнхөө төрхтэй, өөрийнхөө дүртэй адилхан хүү төрүүлж...” (Эхлэл 5:3).

Хүү нь аав Адамынхаа мөн чанарыг өвчиж төрсөн бөгөөд түүнээс хойшхи хүмүүн болгон аав ээжээрээ дамжуулан, Адамын нүглийн дүр төрхөөр төрцгөөжээ. Адам өөрийгөө ч, үр удмаа ч шинэ эзэн болох Сатаны гарт хүлээлгэж өгсөн ба байгаль дэлхий ч түүний тогтоолоор өрнөх болов. Бурханы хайртай бүтээлийн толгойг эдүгээ харгис шинэ эзэн нь мэдэх болжээ. Үүнийг ч удаах эшлэл тодорхой хэлж: “Дараа нь тэр Түүнийг дээш аваачаад, хоромхон зуур ертөнцийн бүх хаанчлалыг үзүүлэв. Тэгээд диавол, Түүнд —Энэ бүх эзэмшил болон эдгээрийн сүр хүчийг би Чамд өгье. Учир нь энэ бүгд надад өгөгдсөн юм. Би хүсвэл хэнд ч үүнийг өгч чадна” (Лук 4:5-6, тодруулгыг нэмэв).

Сатанд өгөгдсөн гэж байгааг тэмдэглэнэ үү. Хэзээ тэр вэ? Цэцэрлэгт байхад. Учир нь газар дэлхийг ноёрхох эрхийг Бурхан анх хүмүүнд өгсөн (Эхлэл 1:26-28) байтал, Адам өөрийгөө болоод үе үеийн хөвгүүдээ бүгдийг нь хөсөрдүүлжээ. “Бид Бурханых, харин бүх ертөнц нь ёрын нэгэн дор байдгийг мэднэ” (1Иохан 5:19).

Бурхан Адамыг цэцэрлэгээс гаргахаасаа өмнө нэгэн зүйлийг амласан нь “Чөлөөлөгч гарч ирээд, хүн төрөлхтнийг боолчилсон хүлээс, дарлалыг тасар татах” тухай амлалт байв.

Тэр Чөлөөлөгч нь дөрвөн мянган жилийн дараа Мариа гэдэг онгон бүсгүйгээс мэндэлсэн болой. Есүсийг Ариун Сүнс л Мариагийн умайд бүрэлдүүлэн бий болгосон учраас, Мариа эр хүнтэй хавьтаж үзээгүй, онгон бүсгүй байх учиртай байжээ. Есүс дан хүмүүний хүү болж мэндэлсэн бол, Адамаас өвлөгдөж ирсэн боолчлол дор төрөх байв.

Гэтэл Есүс Бурхан Аавд, хүмүүн ээжид төрсөн. Үүгээрээ Есүс төгс Бурхан, төгс хүмүүн болжээ. Бидний эрх чөлөөг хүмүүний хүү төлөх ёстой байв. Иймээс л Есүс байнга Өөрийгөө “Хүний Хүү” гэдэг байжээ. Тэрбээр анхнаасаа л Аавынхаа дэргэд байсан ч, тэнгэрийн эрх ямбаа тайлаад, нүглийн тахил болохоор хүн биеэр ирсэн юм.

Есүс бидний нүглийн төлөөсийг Өөр дээрээ аваад, бидний өмнөөс загалмай дээр гарч алуулжээ. Бичээс: “Биднийг нүгэлд үхүүлж, зөвт байдалд амьдруулахын тулд Тэр Өөрөө бидний нүглийг модон дээр биедээ үүрсэн. Учир нь та нар Түүний шархаар эдгээгдсэн” (1Петр 2:24) гэдэг.

Юу хэлэхээ ч мэдэхгүй юм: Хүн Бурханы эсрэг нүгэл үйлдсэн ч, хүний үхлийн ялтай тэр алдааг (махан биеэр ирсэн) Бурхан төлжээ. Библи: “Иймээс бид Христийн төлөөх элчин сайд юм. Бурхан биднээр

дамжуулан ятгаж байгаачлан Христийн төлөө та нараас бид гуйя. Бурхантай эвлэрцгээ. Нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө Тэрээр нүгэл болгосны учир Түүний дотор бид Бурханы зөвт байдал болох юм” (2Коринт 5:20-21) гэжээ.

Биднийг зөвт болгох боломжтой гэснийг тэмдэглээрэй. Гэхдээ “Есүс бидний төлөө үхээд, үхлээс амилуулагдсан” гэдэгт зүрхнээсээ итгээд, “Есүс - миний Аврагч Эзэн” гэдэгт итгэхээс нааш, бид Есүсийн олж өгсөн эрх чөлөөг хүлээж авахгүй. Бичээсийн дагуу: “Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэгчдэд Тэрээр Бурханы хүүхэд болох эрхийг өглөө. Тэд цусаар биш, махбодын хүслээр ч биш, хүний хүслээр ч биш, харин Бурханаар төржээ” (Иохан 1:12-13).

Бид Есүсийг амьдралынхаа Аврагч, Эзэн болгох үедээ үхээд, сүнсээр дахин төрдөг. Сатаны хаанчлалын боолууд явсан бид үхээд, Бурханы Хаанчлалын цоо шинэхэн хүүхдүүд нь болж төрдөг. Энэ бүхэн хэрхэн өрнөдөг вэ? Маш энгийн. Энэ бүхэнд зүрхнээсээ итгэж байгаа бол, “Есүс миний Эзэн!” гэдэг үгийг амаараа тунхаглаад л бид дахин төрдөг. Бичээс ч үүнийг баталдаг: “Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ” (Ром 10:9-10).

Ийм энгийн! Бид сайн үйлсээрээ аврагдахгүй. Үйлс маань яагаад ч биднийг Бурханы Хаанчлалд оруулж чадахгүй. Чадах байсан бол, Христ шал дэмий үхэж. Бид чинь Есүсийн нигүүлслээр аврагддаг. Аврал нь хүний хувьд юугаар ч олж авч чадашгүй, үнэгүй ирсэн бэлэг юм. Гагцхүү хар амиа бодож, дураараа амьдрахаа болиод, амьдралаа Эзэндээ буюу Эзэнтэндээ өргө. “Тэрээр бүгдийн төлөө үхсэн учраас амьд байгсад цаашид өөрсдийн төлөө бус, харин өөрсдийнх нь төлөө үхээд, амилуулагдсан Түүний төлөө амьдрах ёстой” (2Коринт 5:15).

Тиймээс, Христ таны төлөө үхсэн гэдэгт итгэж байгаа бол, цаашид хар амиа бодож, дураараа амьдармааргүй байгаа бол, амьдралаа Христэд өргөөд, дараах залбирлыг залбирах аваас, та Бурханы хүүхэд болно.

Тэнгэрийн Бурхан минь ээ, би Таны зөвийн жишигт хүрэшгүй, нүгэлтэй хүн. Би нүглээсээ болоод мөнхөд яллагдбал таарах хүн. Гэхдээ намайг энэ чигээр минь хаяагүйд баярлалаа. Учир нь Та миний нүглийг төлүүлж, миний оронд үхүүлэхээр онгон Мариагаас төрүүлж авсан, цорын ганц хайртай Хүү - Есүс Христээ дэлхий рүү илгээсэн

Бурханд ойрт

гэдэгт чинь би итгэж байна. Есүс гурав дахь өдрөө үхлээс амилуулагдсан бөгөөд эдүгээ миний Эзэн бөгөөд Аврагч болон Таны баруун гарт залран суугаа гэдэгт би итгэж байна. Тиймээс яг одоо би хамаг амьдралаа Есүс Эзэнийхээ эрх мэдэлд өргөж байна.

Есүс ээ, Та миний Аврагч бөгөөд Эзэн мөн! Амьдралд минь Сүнсээрээ залраад, намайг Бурханы хүүхэд шиг хүүхэд болгон өөрчлөөч. Би харанхуйн юмстай тогтоож явсан, хуучин холбоо сүлбээгээ бүгдийг нь тасалж, өнөөдрөөс эхлэн өөрийнхөө төлөө бус, харин мөнх амьдрахын тулд Таны төлөө амьдарна.

Эзэн минь, баярлалаа. Амьдралаа Таны мутар, зүрхэнд бүрэн даатгалаа. Та намайг хэзээ ч ичгүүрт оруулахгүй хэмээн амласан.

Ийнхүү та аврагдаж, Бурханы хүүхэд боллоо. Яг одоо тантай хамт тэнгэрс баярлаж байна! Гэр бүлдээ тавтай морил!

Хавсралт Б

АРИУН СҮНСЭЭР ДҮҮРЭХ ТУХАЙ



Ариун Сүнсийг хүлээж авах нь Есүст итгэхтэй л адил амархан. Гэтэл хүмүүс гуйхаасаа өмнө Бичээсийн үндсэн зааврыг дагаагүйнхээ улмаас Ариун Сүнсийг хүлээж авахгүй байх юмуу хүлээж авах учраа олохгүй зөрчилдөж, урам хугарах нь олонтаа. Тиймээс залбирахаасаа өмнө эхлээд Бурханы Үгийг мэдүүлэх нь хүмүүсийн итгэлийг боловсруулах хамгийн зөв арга зам болохыг би сурсан. Тиймээс залбирахаасаа өмнө товч заавар өгмөөр байна. (Жич: Цааш явахаасаа өмнө 11-ээр бүлгийг бүрэн уншсан байх нь чухал шүү.)

Юу юуны түрүүнд та Эзэн ба Аврагч Есүс Христэд итгэсэн байх ёстой (Иохан 14:17).

Амьдралд чинь ямарваа нэгэн дуулгаваргүй байдал байх ёсгүй. Бурхан Сүнсээ “Түүнд дуулгавартай байгсдад өгдөг” (Үйлс 5:32). Үүнд нэн ялангуяа үл уучлах явдал ордгийг би амьдралаас сурсан билээ. Цуглаан дээр зуу зуун хүн Ариун Сүнсийг шууд л хүлээж аваад, шууд л хэлээр ярьж байхад, цөөн тооны, хэдэн арван хүн нь зүгээр л гайхсан

янзтай харж зогсдог. Тэр үед Эзэн мөнөөх хүмүүсийн тайлагдаагүй гомдлын асуудлыг шийдвэрлэх зааварчилгаа өгдөг. Тэгээд уучилсан хүмүүс нь Ариун Сүнснийг шууд л хүлээн авч, шууд л хэлээр ярьдаг. Тиймээс яг одоо хамт залбиръя.

Аав аа, Та намайг нягтлаад, зүрхэнд минь ямар нэгэн дуулгаваргүй чанар байгаа эсэхийг харуулаач. Уучлаагүй хүн байгаа эсэхийг харуулаач. Таны илчилсэн болгоныг дуулгавартай дагаж, уучилмаар байна. Есүсийн нэрээр гуйж байна. Баярлалаа!

Ариун Сүнснийг хүлээж авахын тулд мэдээж гуйх ёстой! Есүс “Хүүгээ загас гуйхад оронд нь могой өгдөг хүн та нарын дунд байна уу? Эсвэл өндөг гуйхад нь хилэнцэт хорхой өгнө гэж үү? Та нар ёрын муу атлаа хүүхдүүддээ сайн бэлэг өгөхөө мэддэг бол тэр тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь гуйгсдад Ариун Сүнснийг өгөх нь лавтай бус уу?” (Лук 11:11-13) гэжээ. Хүүхдүүд нь юм гуйж байхад, өөдөөс нь хор өгдөг хүн байдаггүйг Есүс хэлж байна. Үүнтэй адил, Ааваас Сүнснийг нь гуйх үед Аав муу ёрын сүнс өгөхгүй. Зүгээр л Есүсийн нэрээр Ааваасаа гуйхад л Ариун Сүнснийг хүлээж авна.

Та итгэлээр асуух ёстой. Итгэлгүйгээр Бурханаас хүлээж авах боломжгүйг Шинэ гэрээ хэлдэг. Иаков 1:6-7: “Харин тэр ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг. Учир нь эргэлзэгч нэгэн бол салхиар туугдан давалгаалах тэнгисийн долгио мэт ажээ. Тийм хүн Эзэнээс юм авна гэж бүү санаг.” Тиймээс яг одоо “Би хэзээ хүлээж авах вэ? Хэлээр яриад унангуугаа хүлээж авах уу? Эсвэл гуймагцаа хүлээж авах уу?” гэж асуу. Хариулт нь: гуймагцаа! Учир нь Хаанчлал дотор итгэсэн бол, хүлээж авдаг. Итгэлгүй хүмүүс “Харуул, тэгвэл итгэе” гэдэг ч, Есүс “Тийм учир Би та нарт хэлье. Та нар юуны төлөө залбиран гуйна, түүнийгээ авсан гэдэгтээ итгэгтүн. Тэгвэл тэр чинь ёсоор болно” (Марк 11:24) гэдэг. Хүн эхлээд итгэбэл, гуйсан зүйлээ хүлээн авдаг гэснийг тэмдэглээрэй.

Үйлс 2:4 дээр “Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв” (Үйлс 2:4) гэжээ. Ариун Сүнс бус, харин хүмүүс хэлээр ярьсан байгаа биз. Тэгэхээр захирагдах ёстой байна! Хүн урсгалтай голын өмнө зогсов ч, хөлөө өргөөд, гол руу орохгүй бол, урсгалтай хамт хөвөхгүй. Тиймд, захирагдах ёстой тал нь: нэгдүгээрт - ам. Амаа нээхгүй бол, Англи

байна уу, гадагад байна уу, тэнгэрийн байна уу, ямар ч хэл орж ирэхгүй. Хоёрдугаарт - хэл. Хэлээ хөдөлгөхгүй бол, ярихгүй. Гуравдугаарт - дуу хоолой. Уушгинаасаа улаан хоолойгоороо агаар нэвтрүүлэхгүй бол, ярьж чадахгүй.

Даапаалж байна гэж бодож байгаа бол, үгүй шүү. Хүмүүс Ариун Сүнс ам, хэл, хоолойг нь оролдоод л, хүчээр яриулах юм шиг санахыг би энэ олон жилийн хугацаанд зөндөө харсан. Тийм юм байхгүй. Ариун Сүнсийг дохиход, бид өөрсдөө ярьж эхэлнэ.

Есүс “Бичвэр хэлсэнчлэн Надад итгэгчийн дотроос амийн усны гол урсах болно гэв.

Есүст итгэгсдийн хүлээн авах Сүнсний тухай Тэр үүнийг хэлжээ. Есүс хараахан алдаршуулагдаагүй тул Сүнс тэнд өгөгдөөгүй байлаа” (Иохан 7:38-39) гэжээ. Ариун Сүнснээс гуйх үед толгой дотор чинь авиа хөөсрөх юмуу хуйларч эхэлдэг. Үүнийг итгэлээр гаргаж хэлбэл, цаанаас нь хэл задгай далан шиг л чөлөөтэй асгана. Би үүнийг үзүүр нь таны хэлнээс хэлхээтэй, хэвэл дотор чинь байгаа дамартай утсаар төсөөлдөг бөгөөд таныг (татаж) ярьж эхлэх үед үлдсэн утас нь эргэлдэн гарч ирнэ. Зарим хүн толгой дотор нь цогц хэл бүрэлдэн бий болсны дараа ярина гэж боддог. Үгүй ээ. Итгэлээр л ярина.

Гэргий маань Ариун Сүнсийг хүлээж авахдаа, хэсэг хугацаанд хэлээр ярихгүй байснаа, хэдэн долоо хоногийн дараа найзуудтайгаа залбирч байхдаа, хэлээр ярьж эхэлсэн юм. Тэгээд “Сүүлийн хэдэн долоо хоног толгой дотор нэг авиа эргэлдээд байсан ч, би таг дарж байгаад, өнөөдөр гаргачихлаа” гэж билээ. Олон хүн яг л ингэдэг. Гуйдаг, хүлээж авдаг... гэхдээ ярьдаггүй.

Бичээс “Эш үзүүлэгчдийн сүнс эш үзүүлэгчдэд захирагддаг” (1Коринт 14:32) гэжээ. Энэ нь Ариун Сүнс хэнийг ч хүчилдэггүй, бид өөрсдөө л ярих ёстойг хэлж байна. Миний хувьд, Ариун Сүнсээр дүүрснийхээ маргааш нь яаж дахиж ярихаа мэдэхгүй байж билээ. Тэгээд бэлтгэлийн зааланд байгаа найз дээрээ очоод: “Яаж дахиж ярих вэ?” гэж асуутал, тэрбээр: “Жон, зүгээр л ярь!” гэсэн юм. Би ч гүйхээр гараад, гүйж явахдаа хэлээр ярьж эхэлсэн. Миний баярласан гэж. Ариун Сүнс хөдлөхөд хэзээд бэлэн байдаг ч, бид Түүнд захирагдах ёстойг бүү март. Усан оргилууртай л адил. Ус нь байж л байдаг. Гарыг нь эргүүлээд л, усыг нь оргилуулах хэрэгтэй. Тиймээс хэлээр байнга залбир!

За, Бичээсийн үндсэн заавартай танилцсан болохоор, итгэж байгаа л бол, залбирахдаа, Ариун Сүнсийг хүлээж авна. Өө, эцэст нь бас нэг юм хэлье: Хүн Англиар ч, Испаниар ч нэгэн зэрэг, давхар ярьдаггүйтэй адил төрөлх хэл, тэнгэрийн хэл хоёроороо нэгэн зэрэг давхар ярихгүй.

Бурханд ойрт

Тиймээс зүгээр л итгээд, захирагд!

За, залбирах уу:

*Аав аа, хүү чинь Тан дээр Есүсийн нэрээр ирж байна.
Намайг гуйвал, Ариун Сүнсээ өгөхөө Та амласан. Тиймээс
би итгэлээр гуйж байна. Яг одоо намайг Ариун Сүнсээрээ
булхаж, дүүргээч. Би хэлээр ярихаас авахуулаад, Таны
өгссөн бүгдийг хүлээж авъя. Яг одоо итгэлээр хэлээр ярих
болно! Амень!*

ӨНӨ МӨНХӨӨР ХӨТЛӨГДӨХҮЙ

*Өнөөдөр ч, үүрд мөнхөд ч
үнэ цэнэтэй байх амьдрал*



Энэ амьдралын нөгөө талд юу ч байхгүй гэж хүмүүс боддог. Гэтэл Бичээс “Хүн энэ ертөнцөд хэрхэн амьдарснаараа нөгөө ертөнцөд хэрхэн амьдрахаа шийднэ” гэх. Энд л хэрхэн амьдарснаараа, тэнд авах шагнал, шийтгэлээ шийдүүлнэ.

Жон Бивэр бидэнд 2Коринт 5:9-11 дээрх зарчмыг сануулаад, хүн бүр Христийн өмнө үйлсийнхээ дагуу шүүгдэж, олон хүн мөнх насгүй зүйлд хамаг амьдралаа зориулсанаа ойлгоод цочирдохыг хэлжээ. Тэгвэл хүн яаж ач холбогдолтой амьдрах вэ? “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” ном таныг амьдралынхаа дуудлагыг олох, хүлээж авсан бүхнээ өсгөн үржүүлэх мөнхийн зарчимд сургаж, өөрийгөө өнө мөнхөд үнэлэгдэх ажилд зориулахад чинь чиглүүлнэ.

Татаж аваарай:  MessengerX.com

АФФАБЕЛ

Өнө мөнх рүү өнгийх цонх
(Сонсдог жүжиг)



“Аффабел” нь Жон Бивэрийн бичсэн сонсдог жүжиг юм. Үүнд энэ дэлхийн амьдралаас цаашхи бодит амьдралыг өгүүлэх бөгөөд үүгээр Бурханы хаанчлалын олон үнэнийг тусган харуулдаг. Итгэгч хүмүүс өнө мөнхийн хараатай амьдрах ёстой ч, олон хүн өнө мөнх гэж юу болохыг ч мэддэггүй.

Энд та Аугаа хаан Жэйлинтэй, харанхуйн хар санаат эзэн Дагонтой, Өгөөмөр, Бие даагч тэргүүтэй гол дүрүүдтэй, Аффабел хэмээх ер бусын нутагтай бас Ганц хэмээх аймшигт хөсөр газартай танилцаарай. Гол дүрүүдийн амьдралаар дамжин зүрхний чинь үнэн төрх илчлэгдэх үед та өөрийнхөө амьдралын талаар нэгийг бодох буй за. “Аффабел” сонсдог жүжиг нь сонсогчийг нэгэнт ухааруулахын төлөө бүтээгдсэн “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номын жүжигчилсэн хэлбэр болно.

Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

САТАНЫ УРХИ

*Өстөн дайсныхаа үхлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар*



“Сатаны урхи” ном нь ерөөсөө л гомдлын талаар өгүүлнэ. Гомдол нь итгэгч хүмүүсийг Бурханы хүслээс гаргахдаа тогтмол ашигладаг, дайсны хайргай урхи ажээ. Олон хүн энэ урхинд мэдээгүй явж орчихоод, орсон хойноо ч мэддэггүй.

Хүн энэ дэлхий дээр байгаа цагтаа гомдлоос дархлаатай оршиж чадахгүй ч, гомдох эс гомдохоо сонгож чадна. Гомдлыг шийдвэрлэсэн хүн л хорслыг даваад, улам хүчирхэгжиж, Бурхантай саадгүй харилцана.

Хорсол, бухимдал, хар сэр, үл итгэлцлээс чөлөөлөгдөж, Бурханы хүсэл дор алхлан, амьдралаа Бурханд бүрэн даатгаж, уучлал, эвлэрэл, баяр хөөрөөр дүүрэн амьдрахын нууцыг эндээс сураарай.

Татаж аваарай:  MessengerX.com

САТАНЫ УРХИ

*Өстөн дайсныхаа үхлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар
(Монгол бичгээр)*



“Мараната” үйлчлэл Өвөр Монгол дахь Христийн чуулганы итгэгч хүмүүсийг итгэлд бэхжүүлэхийн төлөө мөн Монгол бичгээр унших хүсэлтэй бүх хүнд зориулж зохиолч Жон Бивэрийн Монгол хэл дээрх (кирилл бичиг дээрх) номуудыг Монгол бичиг дээр хөрвүүлэн буулгаж байгаа бөгөөд анхны бүтээл болох “Сатаны урхи” номоо та бүхэнд өргөн барьж байна.

Энэ номыг CloudLibrary.org хаяг дорх “Монгол бичиг” гэсэн хэсгийг сонгоод, үнэ төлбөргүй татаж авна уу. Монгол чуулганы энэ бэлэгийг Өвөр Монгол дахь Христийн итгэл нэгт ах, эгч дүүдээ болоод Монгол бичигт нэвтэрсэн бүх хүнд түгээн дэлгэрүүлээрэй!

Татаж аваарай:  MessengerX.com

САЙНЫГ УУ, БУРХАНЫГ УУ?

Бурхангүй “сайн” сайн биш байдгийн учир



Сайн л бол, Бурханаас байх учиртай. Тийм үү? Өнөөдөр “сайн” хийгээд “Бурхан” гэдэг хоёр үгийг ижил утгатай үгс шиг хэрэглэх болжээ. Бид “сайн” гэж үздэг зүйлсээ Бурханы хүсэлтэй төгс эгнэх учиртай гэж итгэдэг. Өгөөмөр, даруу, шударга зан чанар нь сайн юмс. Амиа хоохойлох, тоомжиргүй зан, харгислал нь муу юмс. Ядах юмгүй ялгачихмаар харагдаж байна. Гэхдээ ингээд л боллоо юу? Сайныг ялгахад тийм амархан юм бол, Библи яагаад сайн, мууг ялгах хараатай бай гэж хэлсэн юм бол?

Энэ ном нь бас л нэгэн төрлийн хувь хүний хөгжлийн гарын авлага биш юм. Энэ ном танаас зүгээр нэг сайн сайхан, зөв хүн болохыг шаардахгүй. Энэ ном таны Бурхантай тогтоосон харилцааг хэзээ ч байгаагүй өндөрлөгт гаргаж, амьдралыг чинь эд эсээр нь ширхэглэн сэгсэрч, үндсээр нь эргүүлнэ.

Татаж аваарай:  MessengerX.com

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

Гэрлэлтээ авар



Эртээ урьдын цагт... Гэрлэлт бол үүрд өнө зүйл. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэйг холбож зангиддаг гэрээ бүхий харилцаа юм. Энэ холбоо тэднийг бүтээгдсэн анхны зорилгоор нь хөглөж, хүчирхэгжүүлнэ. Тэд тусдаа биш, хамтдаа байхдаа л хүчтэй. Харин энэ бүхний эхлэл нь хурим юм. Хурим нь амар сайхандаа жаргахын төлөө амьдралын босгыг давж буй, ариун нандин үйл явдал болой. Энэ амьдралын төлөөх сонголт бүр, үйлс бүр чухал. Зүрхээрээ нийлж, гараараа хөтлөлцсөн нөхөр, эхнэр хоёр тааж мэдэшгүй ирээдүйг чиглэн Бүтээгчийн хайраар амьдралаа сүндэрлүүлнэ.

Гэтэл бид энэ хайрын түүхээс хагацжээ. Тэгвэл “Гэрлэлтийн түүх” номоороо Жон, Лиза хоёр гэрлэлтэд хандсан Бурханы анхны төлөвлөгөөг дэлгэж байна. Та гэрлэсэн байна уу, гэрлэж амжаагүй байна уу, сүй тавьсан байна уу – Бурханы их хайрын түүхийн нэгээхэн хэсэг мөн болой.

Татаж аваарай:



MessengerX.com

АРИУН СҮНС

Түүнтэй танилцахуй



Анхны дагалдагч нар Есүстэй 3 жил хамт байж, Түүний заасан бүхнийг сонсож байсан. Харин загалмайд цовдлогдохынхоо өмнө Есүс: “Би явж Ариун Сүнс ирэх нь та нарт илүү дээр юм” гэжээ. Хэрэв Есүстэй өдөр бүр байсан дагалдагч нарт Ариун Сүнс амин хэрэгтэй байсан юм бол, бидэнд бүр их хэрэгтэй бус уу?

Жон Бивэр танд Ариун Сүнсийг танилцуулж, Ариун Сүнсний мөн чанар, хүч чадлыг заажээ. Таны итгэлийн төлөвшил ямар ч төвшинд байсан “Ариун Сүнс: Түүнтэй танилцахуй” ном танд Бурханыг улам ихээр дотно танин мэдүүлнэ.

КРИПТОНИТЫГ УСТГА

Хүчийг чинь сорогч зүйлийг устга



Супермэнд дайснаа дарах ер бусын хүч байдаг шиг, Христийн дагалдагч бидэнд ч тийм нэгэн хүч бий. Гэвч криптонит гэгч нэгэн бодис Супермэний хүчийг ч, дагалдагч бидний хүчийг ч ховх сордог. Мэдээж Супермэн, криптонит хоёр зохиомол зүйлс боловч, сүнсний криптонит нь жинхэнэ зүйл юм.

Анхны чуулганы итгэгч нарт байсан тэнгэрийн хүч яагаад өнөөгийн бидэнд байхгүй байгааг энэ ном тайлбарлана. Түүнчлэн криптонит гэж юу болох, яаж үйлчилдэг болох бас үүнийг хэрхэн устгахыг зааж өгнө.

Энэ номыг амьдралаа жинхэнээсээ өөрчлөх хүсэлтэй Христийн дагалдагч нарт зориулав. Уншсан шиг уншаарай!

ЭРСЛЭН СЭРЭВ

Сэрээд, ертөнцөө өөрчил



Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаана биднийг өөр хоорондоо хэвэнд нутгагдчихсан мэт ялгаралшгүй байлгахаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтолж байдаг дайсан бий. Бид энэ тойрогт орохдоо дотно харилцаа холбооноосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзэж, зорилгоо гээдэг.

Өрсөлдөөнийг өөртөө ашигтайгаар эргүүлж, өөрийнхөө шилдгийг гарга. Өөрийнхөө тухай ярианаас бүү зугт. Эмэгтэйчүүд таарахгүй, тэнцэхгүй, гэнэдүү, гэнэн гэдэг маргаанд хариу барь. Хүйсийн өрсөлдөөнийг шийдвэрлэж, эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллахыг сур. Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ!

Татаж аваарай:



MessengerX.com

БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!

Цөл дунд зорилготой бөгөөд хүчтэй байх



Өмнө нь Бурхан ярьдаг байснаа одоо таг дуугүй болжээ. Өмнө нь та итгэлээр явдаг байсан бол, одоо Бурханы оршихуй бараа сураггүй болжээ. Тэгвэл Бурханаас амлалт хүлээж аваад, энэ амлалт биелэхийг харах хоёрын дунд оршдог дамжин өнгөрөхөд тавтай морил.

Гэхдээ энэ нь ямар ч зорилгогүй хөсөр газар биш юм. Бурхан цөлөөр дамжуулан биднийг хувь тавиланд маань бэлтгэн, боловсруулдаг - гэхдээ ганцхүү та зөв хариу үйлдсэн тохиолдолд шүү. Олон хүний боддог шиг - энэ улирлаар туулах нь зүгээр л Бурханыг хүлээгээд суух явдал биш юм. Цөл дундуур жолоогоо зөв залахад таны үүрэг оройл их. Морин тойруулгаар эргэлдэж цагаа гарздах гээгүй л юм бол, цөлийг мэддэг байх хэрэгтэй.

Нүд тайлсан энэхүү номоороо бестселлер зохиолч Жон Бивэр таныг хуурай, бэрх улиралдаа жолоогоо зөв залсаар, Бурханы зэхсэн бүхэнд нэвтрэхэд чинь туслах Библийн түлхүүр болсон ухаарал, гүн түүхээр өсгөн боловсруулж байна.

Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл



Та Бурханы Хаанчлал дотор үзэгч юм шиг мэдрэмж тээж явна уу? Үйлчилмээр байгаа боловч хэрхэн гэдгээ мэдэхгүй байна уу? Бурханд үйлчлэхийг хүсдэг ч дараах асуултад хэрхэн хариулахаа мэдэхгүй зөрчилдөж явна уу: Надад хандсан Бурханы хүслийг алдаагүй гэдгээ хэрхэн баталгаатай мэдэх вэ? Бурханы Хаанчлалын төлөө надад өгөгдсөн бэлэг авьяас ямар үүрэгтэй вэ? Бурханы өгсөн хүчин чадал дотор амьдарч байгаа гэдгээ хэрхэн баталгаатай мэдэх вэ? Би “Чуулганд” бүтэн цагаар үйлчилдэггүй. Тэгэхээр миний дуудлага чухал биш гэсэн үг үү гэх мэт асуулт танд байна уу?

Тэгвэл энэ бүх асуултад энэхүү ном хариулах болно. Бурханаас хүлээн авсан бэлэг авьяасаа үржүүлэн Түүнийг алдаршуулж амьдрахад тань энэ ном чиглүүлж тусална.

Татаж аваарай:



MessengerX.com

Хүндэтгэлийн шагнал

Мартагдсан чанарын хүчийг сануулахуй




Христэд итгэдэг хүн Бурханыг хязгаарлахыг хүсэхгүй ч, олонх маань “хүндэтгэл” хэмээх сүнсний нэгэн зарчмыг мэдэхгүйгээсээ болоод амьдралд маань хүрэлцэх Бурханы чадварыг санаандгүйгээр хумидаг байна. Хүндэтгэл нь манай соёлд мартагдах шахсан ойлголт болсон хэдий ч, энэ нь Бурханы хаанчлалыг бидний амьдралын тал бүр дээр нэвтрүүлэгч гол судас болохыг та энэ номын хуудсаас харах болно.

Хүндэтгэлийн шагнал номдоо Жон Бивэр таныг Бурханы үнэлэмжийн системтэй зэрэгцүүлж, Бурханы ерөөл бүрийг хүлээн авах байр сууринд гаргах хүндэтгэх дуудлагыг хэрхэн хүлээж авахыг зааж өгчээ. Библийн хөдлөшгүй үнэнийг эдгээр зарчмыг үйл хөдлөл болгох хүчирхэг түүхтэй хавсаргасан энэ ном танд энэхүү мартагдсан чанарыг цоо шинээр харах хараа өгөхөөс гадна хамгийн чухал нь үүнийгээ амьдралынхаа тал бүр дээр хэрэгжүүлэх гал халуун хүсэл тэмүүллийг авчирна.


Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

X MessengerX

Газар газрын хүн бүрт зориулсан дагалдагчийн аян




- 120 гаруй хэл дээр үнэ төлбөргүй үзэх боломжтой.
- App хэлбэрээр ч, онлайн хэлбэрээр ч хэрэглэх боломжтой.
- Таны өсөлт төлөвшилд зориулагдсан материал.
- Өөрийн түүх, дагалдагчийн аяныг хянах боломжтой.



Бүх төрлийн төхөөрөмж дээр үзэх, унших, сонсох боломжтой цахим ном, сонсдог ном, богино хэмжээний кино, видео сургаал, Библи зэрэг дагалдагч бэлтгэхэд нэн шаардлагатай бүх материалыг Messenger сангаас хүлээн авна уу.

MessengerX.com



Дэлхий даяар App Store болоод Google Play дээр үзэх боломжтой.

Жон Бивэр энэхүү номоороо таныг Бурханыг Өөрийг нь мэдэхгүйгээр, Бурханы тухай мэддэг Христэд итгэх итгэлийн сүүдэр дор суурьшихгүй байхыг уриалан ятгажээ. Ертөнцийн Бүтээгч бидэнд Өөрийг нь алс холоос зан үйл, үгээрээ хүндэтгэх бус, харин та Бурханы зүрхийг мэддэг, Бурхан таны зүрхийг мэддэг, утга төгөлдөр, дотно харилцаатай байх урилга өгчээ.

Бурхан тантай дотносохыг улайран хүсдэг нь магадгүй Библийн хамгийн гайхамшигт амлалт биз ээ.



ЖОН БИВЭР - Олон улсын номлогч, шилдэг борлуулалттай номын зохиолч, Бурханы Үгийг ямар ч найраагүй зоригтой заадаг багш. Жон гэргий Лизатайгаа дэлхийг өөрчлөгч Христийн үнэнч дагалдагч нарыг хөгжүүлэх зорилготой Мессенжер Интернэйшнэл байгууллагыг үүсгэн байгуулсан болно. Харин тэрбээр Колорадо дахь гэртээ байхдаа гэр бүлтэйгээ өрсөлдөөнтэй картан тоглоом тоглож, Лизаг гольф руу урвуулах гэж оролддог.



MessengerX

Үнэ төлбөргүй материал, видео дамжуулалтыг
MessengerX.com хаягаас хүлээн авна уу.

Илүүг эндээс



Энэхүү ном нь Зохиолчийн бэлэг.
ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.